### ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ БҮРИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР, ХӨТӨЛБӨРИЙН ТАЙЛАН

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч | Хөтөлбөр | Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | **МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА** | | | | | | | | | | | | | |
| | 1.1 | **70101 Монгол Улсын Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагаа** | | | | | | | | | | | | |
| | | 1.1.1 | Хариуцлагатай төр, хүртээмжтэй эдийн засгийг бэхжүүлж, үндэсний өв соёлыг хамгаалахад чиглэсэн бодлого, санаачилгыг дэмжиж ажиллана. | 1.1.1.1 | Төлөвлөсөн хугацаанд хийгдсэн байх | хувь | 2023 | 100 | 100 | 97.0% | 27,773,903.60 | 26,886,526.30 | 96.8% | Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх 2025 онд үндэсний эв нэгдэл, тусгаар тогтнол, тогтвортой хөгжил, хүний хөгжлийг дэмжих бодлого, үйл ажиллагааг тууштай хэрэгжүүлэн ажилласан. Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлж, олон улсын түвшинд Монгол Улсын нэр хүнд, байр суурийг бэхжүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллаж, гадаадын 11 улсад төрийн өндөр дээд айлчлал хийж, мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн урилгаар 5 улсын төрийн тэргүүн Монгол Улсад айлчлал хийсэн байна. |
| | | 1.1.2 | Үндэсний эв нэгдэл, аюулгүй байдлыг хангаж, хөгжилд хөтлөх гадаад бодлого хэрэгжүүлнэ. | 1.1.2.1 | Төлөвлөсөн хугацаанд хийгдсэн байх | хувь | 2023 | 100 | 100 | 97.3% | | | | |
| | | 1.1.3 | Нийгмийн хөгжил, ногоон болон хот, хөдөөгийн хөгжлийн бодлогыг дэмжиж ажиллана. | 1.1.3.1 | Тухай бүрд дэмжиж ажиллах | хувь | 2023 | 100 | 100 | 100.0% | | | | Залуучуудын хөгжил, хүний нөөцийг дэмжих бодлогын хүрээнд Ерөнхийлөгчийн илгээлт 2100 хөтөлбөрийг үргэлжлүүлэн, 2025 оны байдлаар 1032 оюутан гадаадын их дээд сургуульд суралцаж байна. Дэлхийн уур амьсгалын өөрчлөлт, байгалт орчныг хамгаалах хүрээнд Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлж, 120 сая мод тарьсан ба Монгол орны усны нөөц, нуур голуудыг хамгаалах ажлыг идэвхжүүлсэн. Хүнсний хангамж, аюулгүй байдлыг бодлогын хүрээнд Хүнсний хувьсгал, Цагаан алт хөдөлгөөнүүдийг эрчимжүүлсэн. |
| | 1.2 | **70424 Дотоод, гадаад шуурхай мэдээллийн үйл ажиллагаа** | | | | | | | | | | | | |
| | | 1.2.1 | Төрийн байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийг улс орны дотоод үйл амьдралын тухай шуурхай мэдээллээр тогтмол хангана. Олон улсын хэмжээнд болж байгаа үйл явдлын мэдээллийг олон нийтэд хүргэнэ. Монгол Улсын дотоод, гадаад бодлого, түүх, өв | 1.2.1.1 | Олон нийтэд зориулан мэдээ мэдээллийг бэлтгэн гаргах | ширхэг | 2023 | 11,765 | 12,000 | 11,980 | 6,223,265.00 | 5,445,941.52 | 87.5% | Төрийн байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийг улс орны дотоод үйл амьдралын тухай шуурхай мэдээллээр тогтмол хангаж, Монгол Улсын дотоод, гадаад бодлого, түүх, өв соёл, уламжлал, хөгжил дэвшлийг гадаад орнуудад эергээр мэдээлж, сурталчлан таниулсан. |
| | | | | 1.2.1.2 | Монгол Улсыг гадаадад сурталчлах мэдээ мэдээллийг бэлтгэн гаргах | ширхэг | 2023 | 10,988 | 11,208 | 11,200 | | | | |
| 2 | **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** | | | | | | | | | | | | | |
| | 2.1 | **70102 Хууль тогтоох, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих** | | | | | | | | | | | | |
| | | 2.1.1 | Хууль, тогтоолын төсөл хэлэлцэж, батална. | 2.1.1.1 | Байнгын хорооны болон Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулсан хууль, тогтоолын төсөл | тоо | 2021 | 521 | 270 гаруй | 218 | | | | Улсын Их Хурлаас анхдагч хууль 8, олон улсын гэрээ соёрхон батлах тухай хууль 8, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 75, хүчингүй болсонд тооцох тухай хууль 1, нийт 92 хууль болон Улсын Их Хурлын 126 тогтоолыг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн батлав. |
| | | 2.1.2 | Хууль, тогтоолын биелэлтийг хянан шалгаж, холбогдох тайлан мэдээллийг хэлэлцэж, сонсоно. | 2.1.2.1 | Хууль тогтоомжийн биелэлттэй танилцах, биелэлтийг хянан шалгах үүрэг бүхий ажлын хэсэг, ажлын хэсгийн боловсруулсан санал, дүгнэлт, шийдвэрийн төсөл | тоо | 2021 | Ажлын хэсгийн тоо-36 | 23 | 44 | | | | 2025 онд хууль тогтоомжийн биелэлтэд хяналт шалгалт явуулж, цаашид хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий нийт 44 ажлын хэсэг байгуулагдсан. |
| | | | | 2.1.2.2 | Улсын Их Хурлын гишүүнээс Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн болон Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын даргад хандан тавьсан асуулга | тоо | 2021 | Асуулга тавьсан гишүүдийн тоо-41, Асуулгын тоо-23 | 25 | 26 | | | | Хууль тогтоомжийн биелэлтийг хэрхэн зохион байгуулж, ямар үр дүнд хүрсэн талаар тодруулж 26 асуулгыг 154 асуудлаар тавьсан. |
| | | | | 2.1.2.3 | Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газар болон Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагаас хийсэн тайлан, мэдээлэл | тоо | 2021 | Чуулганы хуралдаанаар хэлэлцүүлсэн мэдээлэл-9 | 10 | 9 | | | | Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт заасан тайлан, илтгэл, мэдээллийг Улсын Их Хурлаар хэлэлцэх хүрээнд 9 байгууллагын тайланд Улсын Их Хурлын Тамгын газраас дүн шинжилгээ хийж, танилцуулгыг холбогдох Байнгын хороодод хүргүүлж, хэлэлцүүлсэн. |
| | | | | 2.1.2.4 | Хууль тогтоомжийн биелэлтийн үр дагаварт үнэлгээ хийх | тоо | 2021 | 3 | 9 | 6 | | | | Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, зөрчил, хийдлийн 6 судалгааг гүйцэтгэснээс гадна сэдэвчилсэн мэдээллийн тойм 161 бэлтгэж захиалагчид хүргүүлсэн байна. |
| | | | | 2.1.2.5 | Цахим мэдээллийн санд төвлөрүүлсэн хуулийн биелэлтийн үр дагаврын үнэлгээний тайлан | тоо | 2021 | 15 | 25 | 149 | 162,020,544.20 | 124,675,650.32 | 76.9% | Улсын Их Хурлын D-Parliament цахим системд 68 боловсруулж байгаа, 149 өргөн мэдүүлсэн хуулийн төсөлд үр дагаврын үнэлгээний тайлан гаргасан болно. |

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч | Хөтөлбөр | Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 2.1.2.6 | Улсын Их Хурлын гишүүдийг төсөв, санхүүгийн мэдээллээр хангах | тоо | 2021 | 30 | 33 | 33 | | | | Улсын Их Хурлын гишүүдийг төсөв, санхүүгийн мэдээллээр тухай бүр хангаж ажилласан болно. |
| | | | | 2.1.2.7 | Төсвийн төсөл болон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нийцсэн эсэх болон холбогдох судалгаа шинжилгээ хийх | тоо | 2021 | 4 | 6 | 4 | | | | Төсвийн төсөл болон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл'' Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нийцсэн эсэх болон гүйцэтгэлийн тайланд дүн шинжилгээ хийсэн. |
| | | | | 2.1.2.8 | Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн хүрээнд хянан шалгах түр хороонд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллах | тоо | 2021 | 0 | 3 | 3 | | | | "Агаарын бохирдлыг бууруулах хүрээнд утааны асуудлаарх бодлого, шийдвэрийн хэрэгжилтийн үр дүн, шийдэл" сэдэвт, "Халзан бүрэгтэйн" орд газрын ашиглалт, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэлийг нарийвчлан судлах сэдэвт Ерөнхий хяналтын сонсголыг тус тус зохион байгуулав. Оюу толгой" бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэхтэй холбоотой баримт бичиг, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх" Хянан шалгах түр хороог Монгол Улсын Их Хурлын 2025 оны 62 дугаар тогтоолоор байгуулсан. Хянан шалгах түр хорооны тогтоолын төслийг хэлэлцэн батлахад мэргэжил, арга зүй, техник зохион байгуулалтын туслалцаа үзүүлж ажиллалаа. |
| | | | | 2.1.2.9 | Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн хүрээнд хяналтын сонсгол зохион байгуулах | тоо | 2021 | 0 | 2 | 2 | | | | |
| | | 2.1.3 | Улсын Их Хурлын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлж, ажиллах нөхцөлөөр хангана. | 2.1.3.1 | Хуульд заасны дагуу хангагдсан байх | чанар | 2021 | Улсын Их Хурлын үйл ажиллагаанд үзүүлсэн мэргэжил, арга зүй, техник, тоног төхөөрөмж | Улсын Их Хурлын үйл ажиллагаа хэвийн, тасралтгүй ажиллах нөхцөлөөр хангагдсан байна. | тухай бүр | | | | Санхүү, төсвийн удирдлага, дотоод хяналт Улсын Их Хурлын тухай болон Төсвийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн стандарт, холбогдох бусад хууль, дүрэм, журмын дагуу Улсын Их Хурлын үйл ажиллагааны төсвийн төлөвлөлт, зарцуулалтын тооцоог тухай бүр хийж, төсвийн ерөнхийлөн захирагчийг мэдээ, тайлан, судалгаагаар шуурхай хангаж, мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа, ажиллах нөхцөлөөр хангаж ажиллалаа. |
| 3 | **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДАРГА** | | | | | | | | | | | | | |
| | | **70404 Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих** | | | | | | | | | | | | |
| | 3.1 | 3.1.1 | Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавина. | 3.1.1.1 | Өргөдөл, мэдээлэл, хүсэлтийн шийдвэрлэлт | хувь | 2021 | 100 | 90< | 100% | 5,054,604.40 | 4,994,666.50 | 98.8.% | Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд 2025 онд 236 өргөдөл, мэдээлэл, хүсэлт гомдол , тогтоол ирүүлснээс 197 буюу 83.5 хувийг шийдвэрлэж хариу өгсөн байна. |
| | | | | 3.1.1.2 | Бага суудлын хуралдаанаар гомдол шийдвэрлэлт | хувь | 2021 | 100 | 90< | 100% | | | | Үндсэн хуулийн цэцийн бага суудлын 33 хуралдаан болж, 33 магадлал албажуулсан байна. |
| | | | | 3.1.1.3 | Дунд, их суудлын хуралдаанаар маргаан хянан шийдвэрлэлт | хувь | 2021 | 100 | 90< | 100% | | | | Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын 12, Их суудлын хуралдаан 1 зохион байгуулагдаж 12 дүгнэлт, 1 тогтоол тус тус албажуулсан байна. |
| 4 | **УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ** | | | | | | | | | | | | | |
| | | **70702 Хяналтын дээд шатны шүүн таслах ажиллагаа** | | | | | | | | | | | | |
| | 4.1 | 4.1.1 | Шүүн таслах ажиллагааны чанар, тэгш хүртээмжтэй байдлыг дээшлүүлэх, шударга шүүхээр шуурхай шүүлгэх иргэний эрхийг хангаж, хэрэг хянан шийдвэрлэх дундаж хугацааг бууруулна. | 4.1.1.1 | Тухайн жилд хяналтын шатны журмаар хуулийн хугацаанд хянан шийдвэрлэсэн хэргийн эзлэх хувь | хувь | 2023 | 84.3 | 94 | 94 | 29,808,657.20 | 26,351,866.86 | 88.4% | Монгол Улсын дээд шүүх нь 2025 онд нийт 2887 хэрэг хүлээн авсан ба үүний 983 хэрэг Эрүүгийн хэргийн танхим, 1323 хэрэг Иргэний хэргийн танхим, 579 хэрэг Захиргааны хэргийн танхим , 2 хэрэг Сахилгын хэрэг тус тус байна. Танхимын нийт шүүгчдийн хуралдаанаар 2754 хэрэг хэлэлцэж, Улсын дээд шүүхийн хяналтын шатны шүүх хурлаар 470 хэрэг хянан шийдвэрлэсэн байна. Хугацаа хэтэрсэн үлдэгдэл хэрэг байхгүй болно. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар баталсан Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд 1 хөтөлбөр арга хэмжээний зорилтод түвшнийг тусгасан.Тухайн жилд хүлээн авсан нийт хэрэг хяналтын шатны журмаар хуулийн хугацаанд 100 хувь хянан шийдвэрлэсэн байна. |
| 5 | **ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА** | | | | | | | | | | | | | |
| | | **70701 Шүүхийн бие даасан, хараат бус байдлыг хангах** | | | | | | | | | | | | |
| | 5.1 | 5.1.1 | Хэрэг, маргааныг хуулийн хугацаанд хянан шийдвэрлэнэ. | 5.1.1.1 | Хэрэг, маргааныг хуулийн хугацаанд хянан шийдвэрлэлт | хувь | 2022 | 72.9 | 75.8 | 80.97% | 276,306,531.90 | 233,536,317.31 | 84.5% | Өмнөх онд нийт шийдвэрлэсэн хэргийн 72.9 хувь хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байсан бол 2025 онд 75.8 хувийг хуулийн хугацаанд шийдвэрлэх зорилтыг тавьсан бөгөөд энэ онд нийт 119747 хэргийг шийдвэрлэсэн бөгөөд үүнээс хуулийн хугацаанд 90987 хэргийг шийдвэрлэсэн нь хуулийн хугацаандаа шийдвэрлэсэн нь 75.9 хувийг эзэлж байна. Иймд 2025 онд тавьсан зорилтдоо 100 хувь хүрч ажилласан байна. |
| 6 | **ШҮҮХИЙН САХИЛГЫН ХОРООНЫ ДАРГА** | | | | | | | | | | | | | |
| | | **70714 Сахилгын хэрэг шалгах, хянан шийдвэрлэх** | | | | | | | | | | | | |
| | 6.1 | 6.1.1 | Шүүгчийн ёс зүй, сахилгатай холбоотой өргөдөл, мэдээллийг хуулийн хугацаанд шалгаж шийдвэрлэсэн байна. | 6.1.1.1 | Шүүгчийн ёс зүй, сахилгатай холбоотой өргөдөл, мэдээллийг шалгаж шийдвэрлэсэн хувь | хувь | 2022 | 96.5 | 97 | 88.00% | 5,749,797.00 | 5,271,021.41 | 91.7% | Сахилгын хэрэг шалгах, хянан шийдвэрлэх хөтөлбөрийн хүрээнд Шүүхийн сахилгын хорооны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилго, 8 зорилт, 83 арга хэмжээ төлөвлөснөөс 73 арга хэмжээ нь 100 хувь, 8 арга хэмжээ нь 80 хувь, 1 арга хэмжээ үр дүн 50 хувь, 1 арга хэмжээ үр дүн гараагүй, нийт 88 хувийн биелэлттэй байна. |

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч | Хөтөлбөр | Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | **ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ДАРГА** | | | | | | | | | | | | | |
| | | **70409 Хүний эрхийн хэрэгжилтэд хяналт тавих** | | | | | | | | | | | | |
| 7 | 7.1 | 7.1.1 | Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлнэ. | 7.1.1.1 | Хүргүүлэх илтгэл | тоо | 2023 | 1 | 1 | 1 | 13,188,397.70 | 12,485,607.21 | 94.67% | Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэлийг Комиссоос 2024 онд гүйцэтгэсэн судалгаа, дүн шинжилгээ, ирсэн гомдол мэдээлэл, хяналт шалгалтын үр дүн, зохион байгуулсан хэлэлцүүлэг, бусад эх сурвалжид үндэслэн боловсруулж, холбогдох шийдвэр гаргуулахаар 38 саналын хамт 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр УИХ-д хүргүүлсэн. Илтгэлийг УИХ-ын Хууль зүйн байнгын хороо, Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо, Төрийн байгуулалтын байнгын хороо, Ёс зүй, дэгийн байнгын хороо, Инновац, цахим бодлогын байнгын хороогоор тус тус хэлэлцүүлж, УИХ дахь МАН-ын бүлэг, АН-ын бүлгийн хуралдаанд тус тус танилцуулсан. Илтгэлийг УИХ-ын чуулганы (2025.05.01) хуралдаанаар хэлэлцэж, "Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2024 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" 7 чиглэл 40 заалт бүхий УИХ-ын 2025 оны 77 дугаар тогтоол батлагдаж, хэрэгжүүлэх чиг үүргийг Засгийн газарт даалгасан. |
| | | 7.1.2 | Хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн асуудлаарх гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэнэ. | 7.1.2.1 | Гомдол шийдвэрлэлт | хувь | 2023 | 95 | 96 | 96 | | | | Комисс 2025 онд 1461 гомдол, мэдээллийг хүлээн авч, хуульд заасан хугацаа, шаардлагыг баримтлан шалгах ажиллагааг явуулсан. |
| | | 7.1.3 | Хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн асуудлаарх хяналт шалгалт зохион байгуулна. | 7.1.3.1 | Хяналт шалгалт | тоо | 2023 | 120 | 130 | 130 | | | | Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.6 дахь заалтад "байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд дангаар, эсхүл төрийн эрх бүхий байгууллага, тэдгээрийн албан тушаалтанд санал болгосны үндсэн дээр хамтран шалгалт хийх" гэж Комиссын гишүүний гомдол, мэдээлэл шалгах бүрэн эрхийг хуульчилсан. Тайлант хугацаанд Комисс гомдлын мөрөөр 37, Комиссын гишүүний санаачилгаар 165, нийт 202 хяналт шалгалт хийсэн байна.  Хяналт шалгалтыг эрхийн төрлөөр ангилбал: сурч боловсрох эрхийн асуудлаар 10, төрийн үйлчилгээ авах эрхийн асуудлаар 3, халдашгүй чөлөөтэй байх эрхийн асуудлаар 40, хөдөлмөрлөх эрхийн асуудлаар 27, хувийн нууц хамгаалуулах эрхийн асуудлаар 8, хүүхдийн эрхийн асуудлаар 95, шударгаар шүүлгэх эрхийн асуудлаар 1, эвлэлдэн нэгдэх эрхийн асуудлаар 1, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн асуудлаар 2, Эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж үйлчилгээ авах эрхийн асуудлаар 14 хяналт шалгалт хийж ажилласан байна. |
| | | 7.1.4 | Комиссын зөвлөмж, гишүүний шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавина. | 7.1.4.1 | Зөвлөмж, шаардлага | хувь | 2023 | 85 | 90 | 90 | | | | Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.1 дэх заалтад "хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн, зөрчих нөхцөл бүрдүүлсэн байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдэд шаардлага, зөвлөмж хүргүүлэх" гэж Комиссын гишүүний гомдол, мэдээлэл шийдвэрлэх бүрэн эрхийг хуульчилсан.<br>Комиссын гишүүд нийт 26 шаардлага, 70 зөвлөмжийг гомдол мэдээллийн дагуу, хяналт шалгалтын хүрээнд, гишүүний санаачилгаар байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн. Эдгээр шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлээгүй хүний эрхийн зөрчил гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцуулах тухай 23 саналыг холбогдох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсний мөрөөр удирдах 9, гүйцэтгэх 12 албан тушаалтанд хариуцлага тооцсон. Хариуцлага тооцсон хэлбэрийн хувьд сануулах арга хэмжээ авсан 10, цалингийн хувь бууруулсан 7, ажлаас халсан 3, ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн 1 албан тушаалтан байна. |
| | | 7.1.5 | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, Хүний хувийн мэдээлэл хамгаалах, Нийтийн мэдээллийн ил тод байдлын, Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавина. | 7.1.5.1 | Хууль тогтоомжийн хэрэгжилт | тоо | 2023 | 4 | 4 | 4 | | | | 1. Комисст 2025 онд Улаанбаатар хотоос 1127, орон нутгаас 330, гадаад улсаас 4 иргэн, байгууллага гомдол, мэдээлэл ирүүлснийг хүлээн авч, хуульд заасан шалгах ажиллагааг явуулсан байна. Үүнд 1301 иргэн, 56 байгууллага, 61 хүн хамтран гомдол гаргасан бол 43 мэдээлэл бүртгэгдсэн. Хүйсийн хувьд 675 эмэгтэй, 623 эрэгтэй хүн байна. Гомдол, мэдээллийн эрхийн төрлийн хувьд Амьд явах эрх 7, Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх 38, Хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах эрх 37, Хөдөлмөрлөх эрх 307, Нийгмийн халамж хүртэх эрх 39, Эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж үйлчилгээ авах эрх 34, Сурч боловсрох эрх 30, Сонгох, сонгогдох эрх 4, Эвлэлдэн нэгдэх эрх 8, Жендерийн эрх тэгш байдал 20, Төрийн байгууллага албан тушаалтанд өргөдөл гомдол гаргах эрх 75, Халдашгүй чөлөөтэй байх эрх 175, Шударга шүүхээр шүүлгэх эрх  495, Шашин шүтэх, эс шүтэх эрх 9, Үзэл бодлоо чөлөөтэ илэрхийлэх эрх 13, Мэдээлэл хайх, хүлээн авах, түгээх эрх 11, Чөлөөтэй зорчих эрх 27, Иргэний харьяалалтай байх эрх 2, Ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх 32, Амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх эрх 16, Хүүхдийн эрх 72 байна.<br>2. Комисс 2025 онд хүний эрхийн асуудлаар нийт 1254 иргэнд 23493 минутын зөвлөгөө өгсөн байна. Үүнээс "Мэдээлэл хайх, хүлээн авах" эрхийн асуудлаар 4 иргэнд, "Ялгаварлан гадуурхалтаас ангид байх" эрхийн асуудлаар 18 иргэнд, "Жендэрийн эрх тэгш байдал"-ын асуудлаар 18 иргэнд, "Хүчирхийллээс ангид байх" эрхийн асуудлаар 45 иргэнд, "Хүүхдийн эрх"-ийн асуудлаар 63 иргэнд, "Нийгмийн халамж хүртэх" эрхийн асуудлаар 71, "Хууль зүйн туслалцаа авах" эрхийн асуудлаар 219 иргэнд, "Хөдөлмөрлөх эрх"-ийн асуудлаар 336 иргэнд хууль зүйн зөвлөгөө өгч ажилласан.<br>3. Комиссын Хүний хувийн мэдээлэл хамгалаах хэлтэст Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль зөрчсөн тухай 104 гомдол, мэдээлэл ирснээс 30 гомдлыг Комиссын гишүүний шаардлага, зөвлөмж, зөвлөх тухай албан мэдэгдэл хүргүүлж, 24 гомдлыг бусад байдлаар шийдвэрлэсэн. Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу Комиссын дэргэдэх орон тооны бус Хүний эрх хамгаалагчийн хороо 2025 онд нийт 14 хүнд "Аюул, эрсдэлийн үнэлгээ" хийж, хорооны 5 дүгнэлт боловсруулж, 12 гомдолд хуульд заасан ажиллагаа хийж шийдвэрлэсэн. |

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч | Хөтөлбөр | Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 7.1.6 | Хүний эрхийн боловсролыг дэмжиж, түгээн дэлгэрүүлнэ. | 7.1.6.1 | Сургалт | цаг | 2023 | 472 | 500 | 500 | | | | Тайлант хугацаанд хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагаа, тэдний мэдлэг хандлагыг дээшлүүлэх, чадавхжуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор 397 удаагийн 617 цагийн сургалтыг зохион байгуулж нийт 21848 хүнийг хамруулсан. |
| | | 7.1.7 | Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг Улсын Их Хуралд хүргүүлнэ. | 7.1.7.1 | Тайлан | тоо | 2023 | 1 | 1 | 1 | | | | Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны 2024 үйл ажиллагааны тайланг УИХ-ын Хууль зүйн байнгын хороонд 2025.03.28-ны өдөр хүргүүлсэн. Улмаар УИХ-ын ХЗБХ-ны 2025.04.30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, УИХ-ын 2025 оны "Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2024 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" 77 дугаар тогтоол батлагдсан. |
| | | 7.1.8 | Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай зөвлөмжийн биелэлтийг хангуулна. | 7.1.8.1 | Зөвлөмжийн хэрэгжилт | тоо | 2023 | 1 | 1 | 1 | | | | Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах хорооны зөвлөмжийг 2024–2026 онд хэрэгжүүлэх салбар дундын төлөвлөгөөг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам-наас баталсантай холбогдуулан Комиссын үйл ажиллагааг нийслэлээс гадна орон нутагт хүртээмжтэй сурталчлах, эмэгтэйчүүдийн Комиссын эрх, чиг үүрэг болон гомдол гаргах механизмын талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, хүний эрхийн зөрчлийн хохирогч болон эмэгтэйчүүдийг гомдол гаргахад дэмжлэг үзүүлэх, мөн Комиссын бие даасан байдлыг хангах хүний нөөц, техник, санхүүгийн чадавхтай холбоотой мэдээллийг хүргүүлэх чиглэл бүхий 3 заалтын хүрээнд мэдээлэл боловсруулж, 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн ТГ-01/2426 дугаартай албан бичгээр хүргүүлсэн байна. |
| | **УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР** | | | | | | | | | | | | | |
| | | **70703 Прокурорын хяналт** | | | | | | | | | | | | |
| | | 8.1.1 | Монгол Улсын хэмжээнд Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавина. | 8.1.1.1 | Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл болон эрүүгийн хэргийн хяналт, шийдвэрлэлтийн тайлан | тоо | 2021 | 1 | 1 | 1 | | | | Монгол Улсын хэмжээнд Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах, Эрүүгийн хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавих, гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэлд хяналт тавих, прокурорын байгууллагын нэгжүүдийн хэрэг бүртгэх, мөрдөх байцаах ажилллагаанд хяналт тавих ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангах, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцсон. |
| 8 | 8.1 | 8.1.2 | Ял эдлүүлэх үйл ажиллагаа хуулиар тогтоосон нөхцөл, журмын дагуу явагдаж байгаа эсэхэд хяналт тавина. | 8.1.2.1 | Хорих, хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх, тэнсэх, албадлагын арга хэмжээ, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа болон цагдан хорих, баривчлах, саатуулах шийдвэрийг биелүүлэх ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу шалгалт, судалгаа хийх, танилцах ажиллагаа | тоо | 2021 | 7407 | 7500 | 7751 | 145,718,394.30 | 142,671,236.23 | 97.90% | Хорих, хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх, тэнсэх, албадлагын арга хэмжээ, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа болон цагдан хорих, баривчлах, саатуулах шийдвэрийг биелүүлэх ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу шалгалт, судалгаа хийх, танилцах ажиллгааг хийсэн. |
| | | 8.1.3 | Монгол Улсын хэмжээнд Зөрчлийн тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавина. | 8.1.3.1 | Зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл болон хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэсэн зөрчил | тоо | 2021 | 2,698,521 | 2,650,000 | 4,831,351 | | | | Зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хууль, тогтоомжийн дагуу бүртгэж, зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагааг явуулсан. |
| | **МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА** | | | | | | | | | | | | | |
| | 9.1 | **70706 Үндэсний аюулгүй байдлыг хангах** | | | | | | | | | | | | |
| | | | Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс гарсан шийдвэрийн хэрэгжилтийг уялдуулан зохицуулах, бодлогын зөвлөгөөгөөр хангах, хяналт тавих, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүн, гишүүдийн хуулиар хүлээсэн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд үндэсний ашиг сонирхол, оршин тогтнох тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, эдийн засаг, экологийн тэнцвэртэй хөгжлийг хангах, бодлого үйл ажиллагаагаар дэмжлэг үзүүлэх, төрийн болон орон нутгийн төр захиргааны байгууллагуудад хууль тогтоомж, Зөвлөлийн шийдвэрийг бүрэн хэрэгжүүлэхэд нь бодлогын зөвлөгөөгөөр хангах, бодлого боловсруулах, үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй байгууллагуудын салбар хоорондын үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтыг мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллана. | 9.1.1.1 | Судалгаанд үндэслэсэн бодлогын зөвлөгөө гаргах | хувь | 2022 | 86 | 90 | | | | | |
| 9 | | 9.1.1 | | 9.1.1.2 | Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж боловсруулах | хувь | 2022 | 86 | 90 | | 17,394,218.10 | 16,925,672.47 | 97.0% | Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхол, оршин тогтнохын, дотоодын, эдийн засгийн, хүрээлэн байгаа орчны, мэдээллийн, хүний аюулыгvй байдлыг хангах, хүний эрх, эрх чөлөөг бэхжүүлэх төрийн нэгдмэл бодлогыг боловсруулах, аюулгүй байдлыг ханган, хууль тогтоомж, Зөвлөлөөс гарсан шийдвэрийн хэрэгжилтийг уялдуулан зохицуулах, бодлогын зөвлөгөөгөөр хангах, хяналт тавих, үндэсний аюулгүй байдлын тэргүүн гишүүдийн хуулиар хүлээсэн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд Монгол улсын үндэсний ашиг сонирхол, оршин тогтнох тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, эдийн засаг, экологийн тэнцвэртэй хөгжлийг хангах, бодлого үйл ажиллагаагаар дэмжлэг үзүүлэх, төрийн болон орон нутгийн төр захиргааны байгууллагуудад Монгол улсын хууль тогтоомж, зөвлөлийн шийдвэрийг бүрэн хэрэгжүүлэхэд нь бодлогын зөвлөгөөгөөр хангах, бодлого боловсруулах, үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй байгууллагуудын салбар хоорондын үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтыг мэргэжлийн удирдлагаар хангаж ажилласан. |
| | | | | 9.1.1.3 | Улс орны хөгжил, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг судлан дүн шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, бодлогын зөвлөгөө гаргах | хувь | 2022 | 100 | 100 | | | | | |
| | **МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР** | | | | | | | | | | | | | |
| | | **70402 Төрийн аудитын үйлчилгээ** | | | | | | | | | | | | |

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч | Хөтөлбөр | Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 10 | 10.1 | 10.1.1 | Баталгаажуулах ажлыг хараат бусаар, Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, журам, заавар аргачлалд бүрэн нийцүүлэн гүйцэтгэнэ. | 10.1.1.1 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг баталгаажуулах | хувь | 2023 | 100 | 100 | 100 | 48,415,940.30 | 47,943,847.92 | 99.02% | Төсвийн тухай хуульд заасан цаглабарт хугацаанд аудитыг бүрэн гүйцэтгэсэн. |
| | | | | 10.1.1.2 | Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудит хийх | хувь | 2023 | 100 | 100 | 100 | | | | |
| | | | | 10.1.1.3 | Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах | хувь | 2023 | 100 | 100 | 100 | | | | |
| | | | | 10.1.1.4 | Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланг баталгаажуулах | хувь | 2023 | 100 | 100 | 100 | | | | |
| | | | | 10.1.1.5 | Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах | хувь | 2023 | 100 | 100 | 100 | | | | |
| | | | | 10.1.1.6 | Дипломат төлөөлөгчийн газрын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах | хувь | 2023 | 100 | 100 | 100 | | | | |
| | | | | 10.1.1.7 | Гүйцэтгэх ажилд зориулсан хөрөнгийн зарцуулалтад аудит хийх | хувь | 2023 | 100 | 100 | 100 | | | | |
| | | | | 10.1.1.8 | Бүх шатны төсөв захирагч, тусгай сан, төсөл, хөтөлбөр, Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийх | хувь | 2023 | 100 | 100 | 100 | | | | |
| | | 10.1.2 | Шууд тайлагнах аудитыг хараат бусаар Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, журам, заавар, аргачлалд бүрэн нийцүүлэн гүйцэтгэнэ. | 10.1.2.1 | Төрийн аудитын тухай хуулийн хүрээнд Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт /АДБОУС/, Төрийн аудит MNS 6817, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, заавар, аргачлалыг мөрдөж, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны тогтоолд заасан хугацаанд гүйцэтгэж, тайлагнах | хувь | 2023 | 100 | 100 | 81.70% | | | | Төрийн аудитын байгууллага нь 2025 онд “Чадамжид суурилсан хүний нөөцийн бодлогыг төлөвшүүлэх” зорилтыг дэвшүүлэн, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний хэрэгжилт 90.86 хувьтай үнэлэгдсэн нь ТАБ-ын бодлого, төлөвлөлт, чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үр дүн, үр нөлөө нэмэгдэж, хариуцлага сайжирч буйг харуулж байна. Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны тогтоол болон МУЕА-ын тушаалаар 2025 онд 63 аудитын сэдэв батлагдсанаас 61 аудитыг гүйцэтгэсэн байна. |
| | **АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА** | | | | | | | | | | | | | |
| | | **70408 Авлигатай тэмцэх** | | | | | | | | | | | | |
| | 11.1 | 11.1.1 | Авлига, албан тушаалын гэмт хэргийг бууруулж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх эрх зүйн орчныг бэхжүүлэх, нийгмийн бүх түвшинд шударга ёсыг эрхэмлэх хандлагыг төлөвшүүлнэ. | 11.1.1.1 | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр /2023-2030/-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт | хувь | 2022 | 75.8 | 80 | 80 | | | | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай хамтран гаргаж байна. |

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч | Хөтөлбөр | Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 11.1.2 | Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд мэдүүлгийн бүрдүүлэлтэд хяналт тавина. | 11.1.2.1 | Мэдүүлгийн бүрдүүлэлт, хянагдсан хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг /ХАСХОМ/, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг /ХАСУМ/, авлига, ашиг сонирхлын зөрчил, түүнд холбогдох гомдол, мэдээллийн хяналт шалгалт | тоо | 2022 | 3,700 | 3,850 | 3850.0 | | | | ХАСХОМ-ийг шинэчлэн мэдүүлэх хуулийн хугацаанд буюу улсын хэмжээнд нийт төрийн болон нутгийн захиргааны нийт 130 байгууллагын 48,841 мэдүүлэг гаргагч мэдүүлгийг цахим санд шинэчлэн бүртгэх ажлыг улсын хэмжээнд удирдан зохион байгууллаа. Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 19,287 этгээдийн урьдчилсан мэдүүлгийг хянан шийдвэрлэж, холбогдох байгууллагад хариуг хүргүүлсэн, 2025 онд иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас албан тушаалтны авлига, ашиг сонирхлын зөрчлийг шалгуулахаар хандсан 945 гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэсэн. |
| | | 11.1.3 | Иргэн, байгууллага, албан тушаалтнаас хүлээн авсан өргөдөл, гомдол, мэдээллийг хуулийн хугацаанд шийдвэрлэнэ. | 11.1.3.1 | Өргөдөл, гомдол, мэдээллийн шийдвэрлэлт | хувь | 2023 | 98 | 98.2 | 98.2 | | | | Байгууллагын хэмжээнд 2025 онд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн 3034 гомдол, мэдээлэл хүлээн авсныг өмнөх оны мөн үетэй харьцуулбал, өргөдөл, гомдол, мэдээлэл 88 нэгжээр буюу 3,0 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Шийдвэрлэлт 98.2 хувьтай. |
| 11 | | 11.1.4 | Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигын шалтгаан, нөхцөл, хор хөнөөлийг судлах, эрсдэл тодорхойлох, хяналт тавих ажлыг иргэний нийгэм, хувийн хэвшлээр гүйцэтгүүлж, оролцоог нэмэгдүүлэх ажлыг судалгаанд суурилсан байдлаар төлөвлөн хэрэгжүүлнэ. | 11.1.4.1 | Сургалтад хамруулсан хүн | тоо | 2023 | 35,573 | 37,000 | 37000.0 | 54,995,828.00 | 51,635,923.47 | 93.89% | 2025 онд авлигын хор аюулыг ухуулан таниулах, авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах зорилгоор нийт 610 удаагийн сургалтад 41,999 хүнийг хамруулсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал, зохион байгуулсан сургалтын тоо 13.3 хувиар, сургалтад хамрагдсан хүний тоо 13.9 хувиар өссөн дүнтэй байна. |
| | | | | 11.1.4.2 | Боловсруулсан, орчуулж хэвлүүлсэн ном, гарын авлага | тоо | 2023 | 2 | 5 | 5.0 | | | | Авлигын нийгмийн хор аюулыг олон нийтэд ухуулан сурталчлах ажлын хүрээнд 12 төрлийн ном, гарын авлагыг хэвлүүлж түгээсэн. |
| | | | | 11.1.4.3 | Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр бүтээсэн контент | тоо | 2023 | 56 | 58 | 58.0 | | | | 26 төрлийн сурталчилгааны материал хэвлүүлж түгээн, сурталчилгааны дэлгэц болон facebook-т зориулсан 22 баннер, 9 постер, 25 reel видео, 13 шторк, контент хийж сурталчилгаанд ашиглалаа. Аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус 57 байгууллагатай хамтран 193 контент болон богино хэмжээтэй reel видео бүтээж, олон нийтэд түгээх ажлыг тасралтгүй хийж байна. |
| | | | | 11.1.4.4 | Улсын хэмжээнд авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан нэгдсэн арга хэмжээ | тоо | 2023 | 2 | 2 | 2.0 | | | | •Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт зориулан “Шударга байх хамгийн гоё” өдөрлөг,<br>•Өмгөөллийн “Алтаргана хуулийн товчоо” болон Боловсролын ерөнхий газар, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн Тамгын газар, Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуультай хамтран "Mock Trial 2025" эрүүгийн хэргийн шүүхийн мэтгэлцээний тэмцээн,<br>•Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Хүүхэд, гэр бүл хөгжил, хамгааллын ерөнхий газартай хамтран соён гэгээрүүлэх арга хэмжээ,<br>•Баянгол дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Сонгинохайрхан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, тус дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг төрийн 205 байгууллагын албан хаагчдыг хамруулан “Шударга нийгмийн төлөө хамтдаа” сургалт-өдөрлөг,<br>•Боловсролын ерөнхий газар, "Монголын сурагчдын холбоо" ТББ-тай хамтран "Сайн иргэн аян"-ы хүрээнд “Шударга ёсны андгай өргөх арга хэмжээ”-г тус тус зохион байгуулав. |
| | | | | 11.1.4.5 | Судалгааны тайлан | тоо | 2022 | 3 | 3 | 3.0 | | | | •Шударга байдлын үнэлгээ-2025 судалгаа;<br>•Авлигын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэг тогтоох судалгаа;<br>•Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдлын судалгааг хийсэн. |
| | **САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА** | | | | | | | | | | | | | |
| | | **70204 Санхүүгийн зах зээлийн зохицуулалт** | | | | | | | | | | | | |

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч | Хөтөлбөр | Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 12 | 12.1 | 12.1.1 | Зохицуулалттай салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгоно. | 12.1.1.1 | Хууль тогтоомжид нийцүүлэн шинээр боловсруулах журмын төсөл | тоо | 2023 | 18 | 14 | 14 | 20,920,456.90 | 18,378,244.60 | 87.80% | Санхүүгийн зохицуулах хороо нь санхүүгийн зах зээлийн эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр дараах нэр бүхий журмыг шинээр болон шинэчлэн баталсан.<br>Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд орсон  нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд  4 журмыг шинээр баталсан. Үүнд:<br>1.Хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагааны журам /2025.02.03/<br>2.Үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргах хадгаламжийн сертификатыг бүртгэх, арилжих тайлагнах журам /2025.02.03/<br>3. Гэрээний үндсэн дээр үүсгэн байгуулах хувийн хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны журам /2025.02.25/<br>4. Үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээ үзүүлэх тухай журам /2025.12.11/<br>Зохицуулалтын салбарын 14 журмыг шинэчлэн баталсан. Үүнд:<br>1.Журам, загвар, маягтыг батлах тухай /2025.01.10/<br>2."Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны журам" /2025.02.25/<br>3."Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагааны багц дүрэм" /2025.02.25/<br>4."Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагааны журам"/2025.02.25/<br>5."Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны журам" /2025.02.25/<br>6.Даатгалын багц дүрэм батлах тухай /2025.02.25<br>7."Банк бус санхүүгийн үйл ажиллагааны болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам, Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, хорогдуулах, шинээр хувьцаа гаргах, худалдах, шилжүүлэхэд мөрдөх журам" /2025.02.25/<br>8.Хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг тогтоох тухай /2025.02.25/<br>9.Хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг үе шаттай нэмэгдүүлэх хуваарь/2025.02.25/<br>10.Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам (Хэрэглээний зээлд өр, орлогын харьцааг тооцох аргачлал) /2025.02.25/<br>11.Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээс олгох зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоох тухай /2025.02.26/<br>12."Уул уурхайн бүтээгдэхүүний бирж болон биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагааны журам” /2025.03.20/<br>13.“Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаа, төлбөр, тооцоо хийх ерөнхий журам”/2025.03.20/<br>14."Мэргэшлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилох болон үйл ажиллагааг зохицуулах журам" /2025.04.11/ |
| | | 12.1.2 | Банкнаас бусад санхүүгийн салбарын эрсдэлийн үнэлгээг сайжруулах тогтолцоог бэхжүүлнэ. | 12.1.2.1 | Үнэт цаас, даатгал, бичил санхүүгийн салбарт эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийх | тоо | 2023 | 305 | 190 | 659 | | | | Санхүүгийн зохицуулах хороо нь хууль тогтоомж, бодлогын шийдвэрийн хэрэгжилтийг хангах, зохицуулалттай этгээдэд   зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах  үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажилласан.<br>Газар  дээрх хяналт шалгалтыг 659 удаа хийж гүйцэтгэв. Үүнд:<br>Үнэт цаасны салбарт- 30, Даатгалын салбарт 53, Банк бус санхүүгийн байгууллагын салбарт 378, Хадгаламж зээлийн хоршооны салбарт 28, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн салбарт 12, Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбарт 7, Үнэт металл үнэт чулууны арилжаа эрхлэгч, тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн салбарт - Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчийн салбарт 150 хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн.<br>Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын зайны хяналтын хүрээнд “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх эрсдэлийн үнэлгээний асуулга”-аар 1,175 этгээд, тайлант хугацаанд нийт давхардсан тоогоор 2,311 этгээдийн эрсдэлийг үнэлж, зайны хяналтыг хэрэгжүүлсэн. Дээрх эрсдэлийн үнэлгээний үр дүнд үндэслэн эрсдэлд суурилсан хэлбэрээр нийт 73 мэдээлэх үүрэгтэй этгээдийн үйл ажиллагаанд газар дээрх шалгалтыг гүйцэтгэв. |
| | | 12.1.3 | Санхүүгийн зах зээлийн судалгаа, шинжилгээг сайжруулна. | 12.1.3.1 | Эрдэм шинжилгээ, судалгааны тайлан | тоо | 2023 | 43 | 10 | 11 | | | | Санхүүгийн зохицуулах хороо нь олон улсын шилдэг туршлага, стандартуудыг хяналт, зохицуулалтын үйл ажиллагаанд нэвтрүүлэх, судалгаа шинжилгээнд суурилсан шийдвэр гаргах, нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх, санхүүгийн салбарын системийн эрсдэлийг урьдчилан тооцсон урт хугацааны хөгжлийн стратеги боловсруулах зэрэг зохицуулалтын бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэхээс гадна олон нийт, судлаачид, мэргэжилтнүүдэд үнэтэй мэдээлэл, судалгааны эх сурвалж болгох зорилгоор дараах нэр бүхий судалгааг гүйцэтгэсэн. Үүнд:<br>1.Валют арилжих төвийн зохицуулалт ба олон улсын туршлага;<br>2.Санхүүгийн салбарт ногоон угаалтын зохицуулалт;<br>3.Санхүүгийн нэгдлийн хяналт, шалгалтын эрхзүйн орчны судалгаа;<br>4.Санхүүгийн салбар дахь хиймэл оюун ухааны хэрэглээ ба зохицуулалт;<br>5.Улс орнуудын хадгаламж зээлийн хоршооны дээвэр байгууллагын харьцуулсан судалгаа;<br>6.Үл хөдлөх хөрөнгө зуучлалын салбарын хуулийн этгээдэд тавигдах шаардлага: Олон улсын туршлага;<br>7.Карбон зах зээлийн бүтэц, үйл ажиллагаа;<br>8.Үүсмэл санхүүгийн зах зээлийг нэвтрүүлэхэд тулгамдаж буй асуудал, түүнийг шийдвэрлэх арга зам;<br>9.Бичил санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах нь;<br>10.Финтекийн эрх зүйн орчин ба Сэндбоксын дараах зохицуулалт харьцуулсан судалгаа;<br>11.Тогтвортой ханштай койн буюу стэйблкойны зохицуулалтын олон улсын харьцуулсан судалгааг  тус тус хийж гүйцэтгэсэн. |

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч | Хөтөлбөр | Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 12.1.4 | Зохицуулалттай салбарын оролцогчийн санхүүгийн боловсролыг дээшлүүлнэ. | 12.1.4.1 | Зохицуулалттай салбарын оролцогч | тоо | 2023 | 3639 | 2450 | 3488 | | | | Санхүүгийн зохицуулах хороо нь өөрийн зохицуулалттай салбарын мэргэжлийн оролцогчдод санхүүгийн салбарын хууль тогтоомж, бодлого комплайнсын чиглэлээр тогмол мэдлэг дээшлүүлэх сургалтуудыг зохион байгуулан ажилласан.<br>Сургалтын гэрээний дагуу санхүүгийн зах зээлд оролцох эрх олгох 43 удаагийн сургалтыг зохион байгуулж, нийт 2,862 суралцагч хамрагдсанаас 2,155 нь амжилттай суралцаж гэрчилгээ авсан байна. Мөн мэргэжлийн оролцогчдод зориулсан мэргэшүүлэх 29 удаагийн сургалтыг зохион байгуулж, 626 суралцагч хамрагдсанаас 602 нь амжилттай суралцаж гэрчилгээ олгогдсон. Ингэснээр нийт 3,488 суралцагчийн 79 хувь буюу 2,757 оролцогч амжилттай суралцаж, гэрчилгээ, сертификат авсан байна. Санхүүгийн зохицуулалттай салбараар дэлгэрүүлбэл:<br>•Үнэт цаасны зах зээлийн чиглэлээр эрх олгох сургалтыг 4 удаа зохион байгуулж, 208 суралцагч;<br>•Даатгалын зах зээлийн чиглэлээр 14 удаагийн сургалтад 1,436 оролцогч;<br>•Виртуал хөрөнгийн чиглэлээр 1 удаагийн сургалтад 11 оролцогч;<br>•Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбарын зохицуулалтын чиглэлээр 16 удаагийн сургалтад 1,098 оролцогч;<br>•Үнэт металлын чиглэлээр 8 удаагийн сургалтад 109 оролцогч тус тус хамрагдсан.<br>Мэргэшүүлэх сургалтуудын хувьд:<br>•ББСБ-ын салбарт 2 удаагийн сургалтад 58 оролцогч,<br>•ХЗХ-ны салбарт 10 удаагийн сургалтад 172 оролцогч,<br>•Компанийн засаглал, комплайнсын чиглэлээр 17 удаагийн сургалтад 396 оролцогч тус тус хамрагдсан байна.<br>Гэрээт сургалтаас гадна МҮЦАЭХ-ноос үнэт цаасны зах зээлд ажил, үйлчилгээ явуулах эрх олгох сургалтыг 2 удаа зохион байгуулж, 366 оролцогч хамрагдсанаас 339 нь тэнцсэн.<br>МУТСТ хуулийг хэрэгжүүлэх, мөнгө угаах эрсдлээс сэргийлэх чиглэлээр 32 удаагийн сургалтад сургагч багш оролцож хичээл заасан байна.<br>Мөнгөн зээлийн үйл ажиллагааны хууль, журмын цахим сургалтад 2,208 иргэн хамрагдсан байна. |
| | **ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА** | | | | | | | | | | | | | |
| | | **70401 Төрийн албаны ерөнхий удирдлага, зохицуулалт** | | | | | | | | | | | | |
| | | 13.1.1 | Төрийн албаны хууль тогтоомжийн шинэтгэлийг эрчимжүүлж, сайжруулна. | 13.1.1.1 | Хууль тогтоомжийн төсөл | тоо | 2023 | Т | 1 | 1 | | | | Шинээр болон шинэчлэн батлуулсан, батлуулахад бэлэн болгосон журмууд. Үүнд: 1.Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн ажиллах, үйл ажиллагааг дүгнэх журам, 2.Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл олгох журам, 3.Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам, 4.Төрийн албан хаагчид шагнал олгох журам, 5.Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам, 6.Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам, 7.Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам зэрэг.<br>Төрийн албаны тухай хуулийн шинэчлэлд Төрийн албаны зөвлөлөөс өгөх саналыг Засгийн газрын ажлын хэсэгт 1 удаа, УИХ-д ТАЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны тайланг хүргүүлж, ТББХ-ны 2026-04-28-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлээд байна. |
| | | | | 13.1.1.2 | Дүрэм, журмын төсөл | тоо | 2023 | Т | 10 | 8 | | | | Дүрэм, журмын төсөлд санал авахаар ирүүлсэн хүсэлтүүдэд Төрийн албаны хуулийн дагуу хариу өгч хамтран ажилласан. Үүнд: 1.Стандарт хэмжил зүйн газарт "Монгол бичгийн MNS 5552:2025, MNS 6395:225, MNS 4932:2025, MNS 7004:2025" стандартуудын төсөлд 01/1767, 2.И Монгол академи УТҮГ-т "Төрийн албан хаагчийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөр"-ийн төсөлд 06/2462 дугаар албан бичгээр санал хүргүүлсэн. |
| | | | | 13.1.1.3 | Стандартын төсөл | тоо | 2023 | Т | 1 | 1 | | | | Төрийн байгууллага, төрийн албан хаагч, төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн байгууллагаас иргэдэд үзүүлэх үйлчилгээнд тавигдах ерөнхий шаардлагыг тогтоож, Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2025 оны С/12 дугаар тушаалаар "MNS 7068:2025" стандартыг батлуулан мөрдүүлж байна. |
| | | | | 13.1.1.4 | Зөвшөөрөл олгосон албан тушаалын тодорхойлолт | тоо | 2023 | 800 | 1,500 | 2,411 | | | | 2025 онд 91 төрийн байгууллагаас албан тушаалын тодорхойлолт батлах зөвшөөрөл олгох хүсэлт хүлээн авч 63 төрийн байгууллагын 7,511 албан хаагчид хамаарах 2,411 албан тушаалын тодорхойлолт батлах зөвшөөрлийг Төрийн албаны зөвлөлийн нийт 144 тогтоолоор олгосон. 2025 онд Засгийн газраас "Яам, агентлаг болон Аймгийн Засаг даргын Тамгын газрын, бүтэц, орон тоо, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн баталсантай холбоотойгоор яам, Засгийн газрын агентлаг, орон нутгийн төрийн байгууллагууд албан тушаалын тодорхойлолтоо шинэчлэн боловсруулж, батлах зөвшөөрөл олгох хүсэлт ирүүлснийг Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсэн нь өмнөх оноос 10 орчим хувиар өсөж, 2020 оноос хойш "хамгийн их"-ээр албан тушаалын тодорхойлолтод батлах зөвшөөрөл олгосон жил байлаа. |
| | | | | 13.1.1.5 | Чиг үүргийн шинжилгээ хийхэд төрийн байгууллагад өгсөн мэргэжил, арга зүйн зөвлөгөө | тоо | 2023 | 10 | 30 | 30 | | | | Чиг үүргийн шинжилгээ хийх, давхардлыг арилгах, дахин хуваарилах, оновчтой бүтэц бий болгох чиглэлээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Үндсэн хуулийн цэц, яамд, орон нутгийн төрийн захиргааны 21 байгууллагад зөвлөмж, чиглэл хүргүүлж, Төрийн албаны зөвлөлийн дэргэдэх Салбар зөвлөл, 330 сумын төрийн байгууллагын удирдлага нийт 36,357, төрийн албан хаагчид мэргэшил арга зүйн зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлж ажиллалаа. |

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч | Хөтөлбөр | Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 13.1.2 | Төрийн албанд сэтгэлгээ, дүн шинжилгээ хийх, боловсруулах, монгол хэлний ярианы болон бичгийн өндөр ур чадвартай иргэнийг сонгон шалгаруулах хэлбэр, эрх зүйн орчныг шинэчилнэ. | 13.1.2.1 | Сорил, даалгавар, асуулт, хариултын сангийн баяжилтыг чанаржуулах | тоо | 2023 | 1,000 | 3,000 | 12,500 | | | | 2025 оны 390 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн чадамжийн хүрээ”-ний агуулга, шалгуурт нийцсэн 2500 сорил, даалгавар, ярилцлагын асуулт (сорилын шалгалт-2170, бичгийн шалгалт-160, кейс даалгавар-74, ярилцлагын шалгалт-96)–ыг хүлээн авч, Төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалтын сорил, даалгаврын санд байршуулж, тохирц хийх ажлыг зохион байгуулж дууссан. Мөн Төрийн албаны шалгалтын сорил, даалгаврын санг баяжуулах ажлын сонгон шалгаруулалтыг зарлан шалгарсан эрдэмтдээр 10,000 сорил даалгаврыг боловсруулуулж, төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалтад ашиглахаар бэлтгээд байна. |
| | | | | 13.1.2.2 | Чадварт суурилсан журмыг баталж, мөрдөх шийдвэр | тоо | 2023 | Т | 1 | 1 | | | | Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын “Иргэндээ үйлчилдэг, мэргэшсэн, чадварлаг, ил тод, үр нөлөөтэй, ухаалаг төрийн албыг төлөвшүүлнэ” зорилтыг хангах хүрээнд “Төрийн албан хаагчийн чадамжийн хүрээ”-г Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 390 дүгээр тогтоолоор 4 хавсралттайгаар шинэчлэн батлав. Чадамжийн хүрээг шинэчлэн баталснаар албан тушаалд тавигдах мэдлэг, чадвар, хандлагын шалгуур, шаардлагыг оновчтой тодорхойлох, төрийн албанд чадварлаг иргэнийг сонгон шалгаруулж ажиллуулах, хэрэгцээнд нийцсэн сургалт, хөгжлийг төлөвлөх, төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг бодитой үнэлэх эх сурвалж болгон ашиглах нөхцөл бүрдүүлсэн. |
| | | | | 13.1.2.3 | Сонгон шалгаруулалт | тоо | 2023 | 1,000 | 1,500 | 4,960 | | | | Тайлант онд зарлагдсан 4,960 сул орон тооны тусгай шалгалтад нийт 3,536 иргэн өрсөлдөж, 1,999 нь буюу тэнцэж, нэр дэвшсэн сул орон тооны 40.3 хувийг нөхсөн байна. Тухайлбал, төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын 63.1 хувь, гүйцэтгэх албан тушаалын 39.6 хувь, төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн 27.5 хувь тус тус нөхөгджээ. |
| | | | | 13.1.2.4 | Цахим системийн хөгжүүлэлт | хувь | 2023 | 40 | 100 | 100 | | | | OPEN-EXAM шалгалтын системийн хэвийн ажиллагааг хангах, шинээр батлагдсан Чадамжийн хүрээнд нийцүүлэн төрийн албаны мэргэшлийн шалгалтын хэлбэр, төрөл, агуулга, даалгаврын тавилд өөрчлөлт орсонтой холбогдуулан ерөнхий болон тусгай шалгалтыг зарлах, зохион байгуулах, үнэлэх нөхцөлийг цахим системд бүрэн бүрдүүлсэн. Мөн сонгох хэлбэрийн 1 зөв хариулттай, ялгаатай оноо бүхий сорил даалгавар, нөхөх хэлбэрийн сорил даалгавар, өгөгдөлтэй ажиллах, бичих хэлбэрийн задгай даалгавар, сонсох хэлбэрийн дуу бичлэгтэй даалгавар, ярих хэлбэрийн асуулт даалгаварт хариулах нөхцөл боломжийг цахим системийн нэмэлт хөгжүүлэлтээр бүрдүүлсэн. |
| | | 13.1.3 | Хүний нөөцийн аудитын тогтолцоог бүрэн бүрдүүлж, чадахуйн зарчмын хэрэгжилтэд хүний нөөцийн аудит, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | 13.1.3.1 | Тогтоол, шийдвэр | тоо | 2023 | Т | 8 | 8 | | | | 16 яаманд хийгдсэн Хүний нөөцийн аудитын дүгнэлтийг баталгаажуулах Төрийн албаны зөвлөлийн 2 тогтоол, 17 зөвлөмж баталгаажсан. |
| | | | | 13.1.3.2 | Хүний нөөцийн аудит | тоо | 2023 | 2 | 8 | 16 | | | | Төрийн албаны тухай хуулийн 66.1.4-т заасан чиг үүргийн хүрээнд Хүний нөөцийн аудитыг 16 яамны бүтэц, хүний нөөцийн бодлого, чадахуйн зарчмын хэрэгжилтэд хийсэн. Аудитын дүгнэлтээр төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр тогтворгүй, өөрчлөлтийг жил бүр хийдэг, хууль бус томилгоо түгээмэл, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээ бодит бус, шатлан дэвшихэд тэгш бус байдал үүсгэсэн, төрийн албаны чадахуйн зарчмын хэрэгжилт хангалтгүй бөгөөд төрийн албаны мерит тогтолцоо, бодлогын залгамж чанарт сөргөөр нөлөөлөх эрсдэлийг бий болгож буй дүгнэлт гарсан. 2026 онд аудитын зөвлөмжийн биелэлтийг 16 яаманд дахин хийхээр байна. |
| | | | | 13.1.3.3 | Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмж, тайлан | тоо | 2023 | Т | 3 | 3 | | | | 1. Төрийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалт, Засгийн газрын “Журам батлах тухай” 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.8 дахь хэсгийг үндэслэн "Чадахуйн зарчим"-ын хэрэгжилтийн үнэлгээг төрийн захиргааны төв 15 байгууллага, 22 аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон Монгол Улсын Ерөнхий сайд, Тэргүүн шадар сайд, Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа 7 агентлаг, нийт 44 төрийн захиргааны байгууллагыг хамруулан үнэлгээг хийн ЗГХХГ-т хүргүүлсэн.<br>2.Төрийн албаны тухай хуулийн 66.1.9 “Төрийн албаны шинэтгэл болон сайн засаглалын зарчмыг хэрэгжүүлэх” чиг үүргийн хүрээнд яам, Засгийн газрын агентлаг, Засгийн газрын дэргэдэх үндэсний зөвлөл, хороо, комиссын 2016-2025 онд хамаарах зохион байгуулалт, орон тооны хязгаар, бүрэлдэхүүний өөрчлөлт, эрх зүйн зохицуулалтын тогтвортой байдалд тулгуурлан судалгаа, дүн шинжилгээ хийсэн.<br>3.Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэгийн удирдамжид "Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт" гэж тусгай үзүүлэлт оруулан батлуулсан. Төрийн байгууллагын удирдлага, зохион байгуулалт, хүний нөөцийн бодлого, үйл ажиллагаа, төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөн, хүний нөөцийн сонгон шалгаруулалт, шатлан дэвшүүлэх үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн гэсэн 4 бүлэг, 11 шалгуур, 40 үзүүлэлтээр нийт 150 байгууллагад үзлэг шалгалт, зөвлөн туслах ажлыг зохион байгуулж, дунджаар 89.4 хувьтай үнэлсэн. |
| | | 13.1.4 | Төрийн албаны хууль тогтоомжийн биелэлтийн үр дагаварт үнэлгээ хийж, илэрсэн зөрчлийг арилгуулна. | 13.1.4.1 | Цахим системийн нэмэлт хөгжүүлэлтийн явц | тоо | 2023 | 260/3500 | 280/4000 | 280 | | | | Төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, хяналт тавих ажлын хүрээнд төрийн байгууллагуудын нэгдсэн бүртгэл, хяналтын систем хөгжүүлэх дэд системийн хөгжүүлэлтийг хийж боловсронгуй болгож байна. Шүүхийн ерөнхий зөвлөлтэй хамтарсан уулзалт зохион байгуулж, шүүхийн шийдвэрийг цахим системээс татах, бүртгэх, хоёр байгууллагын цахим системд интеграци хийх шийдэлд хүрсэн. 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацааны захиргааны болон иргэний хэргийн анхан, давах, хяналтын шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн нийт 177 иргэн, албан хаагчид холбогдох 210 шүүхийн шийдвэрийг шүүх байгууллагаас авч, Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлд хамаарах 88 шүүхийн шийдвэрийн бүртгэлийг хөтөлж, цахимжуулсан. |

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч | Хөтөлбөр | Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 13 | 13.1 | | | 13.1.4.2 | Төрд учруулсан хохирлыг нөхөн төлөх төлбөрийн улсын төсөвт төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ | мян.төг | 2023 | 100,000 | 200,000 | 478,200 | 15,125,101.00 | 13,641,928.00 | 90% | Төрд учирсан хохирол төлөлтийг 200.0 сая төгрөгөөр баталж гүйцэтгэлээр 478.2 сая төгрөг буюу 2.3 дахин илүү төвлөрүүлсэн. |
| | | 13.1.5 | Хөгжлийн бодлого, чиг үүргийн шинжилгээнд тулгуурлан ажил үүргийн давхцалыг арилгах, чадахуйн зарчимд суурилсан чадварлаг, цомхон төрийн албыг бэхжүүлэх, төрийн албан хаагчийн ажлын бүтээмж, гүйцэтгэлийн үнэлгээний менежментийг сайжруулж, төрийн захиргааны албан хаагчдын тоог үе шаттайгаар зохистой хэмжээнд хүргэхэд дэмжлэг үзүүлнэ. | 13.1.5.1 | Бодлогын санал | тоо | 2023 | Т | 1 | 1 | | | | Төрийн албаны тухай хуулийн шинэчлэлд Төрийн албаны зөвлөлөөс өгөх бодлогын саналыг Төрийн албаны зөвлөлөөс бие даан болон Удирдлагын академи бусад судалгааны байгуулагатай хамтран хийсэн судалгаа, 330 суманд хүрч ажилласан ажлыг үр дүн, 16 яаманд хийсэн Хүний нөөцийн аудтын дүгнэлт зэрэгт үндэслэн боловсруулж, ТАЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны тайлан тусган УИХ-д хүргүүлсэн. ТАЗ-ийн тайланг ТББХ-ны 2026-04-28-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. |
| | | | | 13.1.5.2 | Судалгааны ажил | тоо | 2023 | Т | 1 | 1 | | | | Хөгжлийн бодлого, чиг үүргийн шинжилгээнд тулгуурлан ажил үүргийн давхцалыг арилгах, чадахуйн зарчимд суурилсан чадварлаг, цомхон төрийн албыг бэхжүүлэх, төрийн албан хаагчийн ажлын бүтээмж, гүйцэтгэлийн үнэлгээний менежментийг сайжруулж, төрийн захиргааны албан хаагчдын тоог үе шаттайгаар зохистой хэмжээнд хүргэх зорилгоор төрийн албан хаагчдын боловсрол, мэргэжил, мэргэшил, ажилласан хугацааны дүн шинжилгээ, байгууллагын соёл, сэтгэл ханамж, жендэрийн эрх тэгш байдлын төлөв, төрийн албаны чадавх бэхжүүлэх төсөл, хөтөлбөрийн үр нөлөө, хөгжлийн бэрхшээлтэй албан хаагчдын хөдөлмөрийн орчин, сургалтын хэрэгцээний талаарх нийт 6 судалгааны ажлыг Удирдлагын академи болон бусад судалгааны байгууллагатай хамтран зохион байгууллаа. |
| | | 13.1.6 | Төрийн албаны нэгдсэн тоо бүртгэлийг чанаржуулж, цахим мэдээллийг албан хаагчдад нээлттэй болгох замаар төрийн албан хаагчийн иж бүрэн цахим платформыг хөгжүүлж, цахим системийн аюулгүй байдлыг хангаж, мэдээллийн үнэн зөв, бүрэн гүйцэд байдлыг хангана. | 13.1.6.1 | Системийн модуль хөгжүүлэлт, нэвтрүүлэлт | хувь | 2023 | 40 | 90 | 90 | | | | ХНУМТ системд төрийн албан хаагчийн ажил эрхлэлтийн түүх бүртгэлд хавсаргаж байгаа тушаалын үнэн, зөв байдлыг хиймэл оюун ашиглан томилгооны зөрчил гарахаас сэргийлэх хяналтыг бий болгон, албан тушаалын тодорхойлолтыг цахимд шилжүүлэн төрийн захиргааны 16,000 гаруй албан тушаалын тодорхойлолтыг баталгаажуулж, Төрийн албатай холбоотой тоо мэдээллийг богино хугацаанд гаргах, судлаач нарт төрийн албаны их өгөгдөлд байгаа мэдээллийг ашиглах нөхцөлийг бүрдүүлэхээр data warehouse үүсгэж, батлагдсан маягтын дагуу тайлан мэдээг гаргах боломжийг бүрдүүлээд байна. |
| | | | | 13.1.6.2 | Цахим мэдээлэлд нээлттэй хандах албан хаагч | тоо | 2023 | Т | 227,0 | 100.35 | | | | Төрийн албан хаагч танилт нэвтрэлтийн ДАН системээр өөрийгөө баталгаажуулан ХНУМТ системд нэвтрэх боломжийг бүрдүүлж анкетны болон ажил эрхлэлтийн мэдээлэлтэйгээ танилцан баталгаажуулах ажлыг идэвхжүүлснээр Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийн тайланд системд хамрагдсан 213 611 албан хаагчаас ХНУМТ системд бүртгэлтэй төрийн улс төрийн, төрийн захиргааны төрийн үйлчилгээний ангилалын 168 000 мянган албан хаагчаас 134 644 хувийн хэргийг баталгаажуулалт хийсэн нь нийт албан хаагчидтай хаьцуулахад 80.1 хувийн биелэлттэй байна. |
| | | | | 13.1.6.3 | Мэдээллийн үнэн зөв, бүрэн гүйцэд байдал | хувь | 2023 | 60 | 100 | 80 | | | | Төрийн албан хаагч тоо бүртгэлийн мэдээллийн сан дахь анкетны болон ажил эрхлэлтийн мэдээлэлтэйгээ танилцан баталгаажуулах ажлыг зохион байгуулснаар ХНУМТ системд бүртгэлтэй төрийн улс төрийн, төрийн захиргааны төрийн үйлчилгээний ангиллын 168,000 мянган албан хаагчаас 134,644 нь цахим систем дэх мэдээллийг зөв, бүрэн гүйцэд байгааг баталгаажуулсан нийт албан хаагчидтай харьцуулахад 80.1 хувийн биелэлттэй байна. |
| | | | | 13.1.6.4 | Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ | тоо | 2023 | Т | 1 | 1 | | | | ХНУМТ системд мэдээллийн аюулгүй байдлын эрсдлийн үнэлгээг хийлгэн илэрсэн эмзэг байдлыг арилгах арга хэмжээг авч хэрэгжүүллээ. |
| | | | | 13.1.6.5 | Цахим системийн хатуу дэд бүтцийн шинэчлэлт | хувь | 2023 | Т | 100 | 100 | | | | ХНУМТ системийн аюулгүй, найдвартай ажиллагааг хангаж, нөөц серверийг нэмэгдүүлж төрийн байгууллага, албан хаагчидтай холбоотой мэдээллийн санг түүхчилсэн байдлаар урт хугацаанд хадгалах, өргөжүүлэх боломжтой болгож, гадна мэдээллийн аюулгүй байдлын хяналтыг тогтмол хийх, систем тасралтгүй хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн. |
| | | 13.1.7 | Төрийн албан хаагчийн сургалтын бодлого, чиглэлд шинэчлэл хийх, тасралтгүй сурч хөгжих таатай орчныг бүрдүүлж, сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 13.1.7.1 | Сургалтын тоо | тоо | 2023 | 10 | 20 | 20 | | | | 2025 онд ТАЗ-өөс 330 сум, 9 тосгонд ажиллан, “Бүсчилсэн хөгжил төрийн албаны манлайлал” төрийн албан хаагчдын бүсийн зөвлөгөөн зохион байгуулан нийт 20 удаагийн танхимын сургалтыг зохион байгуулсан байна. |
| | | | | 13.1.7.2 | Гадаад улсын сургалтад хамрагдсан албан хаагч | тоо | 2023 | Т | 20 | 10 | | | | Төсвийн зардлаар гадаад улсын сургалтад хамрагдсан албан хаагч байхгүй. |
| | | | | 13.1.7.3 | Дотоодын сургалтад хамрагдсан албан хаагч | тоо | 2023 | 40,000 | 80,000.0< | 66447 | | | | 2025 онд ТАЗ, УА-аас зохион байгуулсан сургалтад төрийн албан хаагчдыг дараах байдлаар хамруулсан. Үүнд:1.ТАЗ, 7:4:10 цахим сургалт- 20000, 2.330 сум, 9 тосгонд сургалт-36357, 3.“Бүсчилсэн хөгжил төрийн албаны манлайлал”төрийн албан хаагчдын бүсийн зөвлөгөөн-4450, 4.“Төрийн албан хаагчдын үндэсний чуулган”- 800, 5.УА-ийн мэргэшүүлэх сургалт -2297, 6.УА-ийн захиалгат богино хугацааны сургалт-1935, 7. “Төрийн удирдлага ирээдүйд” эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөн -150, 8.Ёс зүй, хүний эрх” сэдэвт сургалт- 268, 9.ТАЗ-аас НЗДТГ-ын, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны нийт -190, нийт 66447 ТАХ |
| | | | | 13.1.7.4 | Хувийн хэвшлийн оролцоо | тоо | 2023 | Т | 2 | 3 | | | | “Төрийн албан хаагчдын бүсийн зөвлөгөөн”-нд 3 Төрийн бус байгууллагатай сургалт зохион байгуулахад хамтран ажилласан. |

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч | Хөтөлбөр | Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 13.1.8 | Төрийн албаны судалгааны нэгдмэл, уялдаатай байдлыг хангаж, үр дүнг үйл ажиллагаанд нэвтрүүлнэ. | 13.1.8.1 | Судалгааны дүгнэлт, тайлан | тоо | 2023 | Т | 3 | 4 | | | | Төрийн албаны зөвлөл дангаар болон мэргэжлийн байгууллага, эрдэмтэн, судлаачдын оролцоотойгоор төрийн албатай холбогдсон суурь болон хавсарга 6 судалгааны ажлыг зохион байгуулж, sudalgaa.mn сайтад байршуулан нийтийн хүртээл болгосон. Судалгаанд төрийн албан хаагчийн сэтгэл ханамж, боловсрол, мэргэжил, мэргэшил, ажилласан хугацаа, хөгжлийн бэрхшээлтэй албан хаагчдын ажиллах орчин, сургалтын хэрэгцээ, төрийн албанд хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, арга хэмжээний давхардал, хийдэл, жендэрийн төлөв байдал зэрэг сэдвүүдийг хамруулж, бодлого, тогтолцоог боловсронгуй болгох, дүгнэлт зөвлөмжийг бодлого, шийдвэрт тусгах саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн. (Төрийн албан дахь жендэрийн эрх тэгш байдлыг нарийвчлан тодорхойлох судалгаа, яам, агентлагийн төрийн албан хаагчдын боловсрол, мэргэжил, мэргэшил, ажилласан хугацааны дүн шинжилгээ, Монгол Улсад төрийн албаны чадавх бэхжүүлэх чиглэлээр хэрэгжиж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний давхардал, хийдэлд хийсэн шинжилгээ, Хөгжлийн бэрхшээлтэй төрийн албан хаагчдын хөдөлмөрийн орчин, сургалтын хэрэгцээний судалгаа) |
| | | 13.1.9 | Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөнд олон нийтийн хяналт тавих чиг үүргийг Олон нийтийн хяналтын зөвлөл гүйцэтгэнэ. | 13.1.9.1 | Дүрэм, журмын төсөл | тоо | 2023 | Т | 1 | 0 | | | | Тухайн онд хэрэгжээгүй. Төсөв батлагдаагүй. |
| | | | | 13.1.9.2 | Зөвлөмж, шийдвэр | тоо | 2023 | Т | 1 | 0 | | | | Тухайн онд хэрэгжээгүй. Төсөв батлагдаагүй. |
| | | 13.1.10 | Ёс зүйн хороонд ирсэн гомдол, мэдээллийг хуулийн хугацаанд шийдвэрлэнэ. | 13.1.10.1 | Гомдол, мэдээлэл шийдвэрлэлт | хувь | 2024 | Т | 85 | 78 | | | | Ёс зүйн хороонд Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн талаар иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагаас 2024 онд 35, 2025 онд 78 нийт 113 гомдол, мэдээлэл бичгээр ирсэн байна. Ёс зүйн хороонд 2024 онд нийт 35 гомдол бүртгэгдсэн бол 2025 онд 78 болж, 43 (122.9%) өсөж, өмнөх онтой харьцуулахад 2.2 дахин өссөн байна.<br>Үүнээс: 2024 онд иргэдээс 7, төрийн албан хаагчдаас 12 гомдол тус тус ирсэн бол 2025 онд иргэдээс ирүүлсэн гомдол 19 болж, өмнөх онтой харьцуулахад 12-оор буюу (27.9%), төрийн албан хаагчдаас ирүүлсэн гомдол 27 болж, 15-аар буюу (34.9%)-р тус тус өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь иргэд болон төрийн албан хаагчдын зүгээс төрийн албан хаагчийн ёс зүйн асуудал болон хууль тогтоомжийн талаарх ойлголт, хандлага нэмэгдсэнийг илтгэж байна. |
| | | | Төрийн албанд ёс зүйн зөрчлийг үл тэвчих сэтгэлгээ, шударга байдлыг эрхэмлэхэд чиглэсэн сургалт, нөлөөллийн аяныг өрнүүлнэ. | 13.1.10.2 | Сургалт, нөлөөллийн аян | тоо | 2024 | 18 | 20 | 84 | | | | Өнгөрсөн онд төрийн албан хаагчийн ёс зүйн сургалт, зөвлөгөөн, хэлэлцүүлэгт тайлант хугацаанд давхардсан тоогоор нийт 348,191 төрийн албан хаагч хамрагдсаныг өмнөх онтой харьцуулахад 57.6 хувиар өссөн байна. Ёс зүйн сургагч багш нар төрийн албан хаагчдыг соён гэгээрүүлэх, ёс зүйн зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх сургалт, соён гэгээрүүлэх, нөлөөллийн ажлыг зохион байгуулж, зөвлөн тусалж эхэлснээр төрийн албаны ёс зүй, сахилга хариуцлага бэхжиж, байгууллагын соёл, төрийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжрахын зэрэгцээ иргэдийн төрд итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой гэж дүгнэж байна. Ёс зүйн сургагч багш нарын үйл ажиллагаанд хяналт тавих, сайн туршлагыг хуваалцан, түгээн дэлгэрүүлэх, тулгамдаж буй асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх чиг үүрэг бүхий ёс зүйн Үндэсний зөвлөх бэлтгэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаад байна.<br>ТАХ-ийн ёс зүйн соён гэгээрүүлэх, нөлөөллийн ажлын хамрах хүрээг өргөжүүлэн, Ёс зүйн хорооноос жил бүрийн 11 дүгээр сарыг “Ёс зүйн нөлөөллийн сар” болгон зарлаж, 3008 ёс зүйн дэд хороодоо нэгдсэн удирдлагаар ханган холбогдох арга хэмжээг төлөвлөн, хэрэгжүүлж хэвшсэн. |
| | | | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, ёс зүйн индекс, тогтолцоог нэвтрүүлэх олон улсын туршлагыг судална. | 13.1.10.3 | Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явц | хэрэгжил | 2024 | Т | 25 | 40 | | | | ЗГ-ын 2024-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт "Ёс зүйн хэм хэмжээг сахиулах, зөрчлийг хянан шийдвэрлэх менежментийг сайжруулж, ёс зүйн хариуцлагын тогтолцоог бэхжүүлнэ" гэсэн зорилт тусгагдсан. Төрийн албаны ёс зүйн индекс, ёс зүйн дэд бүтцийг Олон Улсын туршлагад суурилан хэрэгжүүлэхээр Олон Улсын жишигт нийцсэн төрийн албаны ёс зүйн индексээр тооцон үнэлэх аргачлалыг боловсруулж байна. Энэ хүрээнд 2025 онд Австрали болон Монгол Улсад хэрэглэгдэж буй индекс, бусад Олон Улсын байгууллагын туршлагыг харьцуулан судалсан. Төрийн албаны ёс зүйг индексээр үнэлэх нь засаглалын чанарыг сайжруулах, авлигын эрсдэлийг бууруулах, төрийн үйлчилгээний үр нөлөөг нэмэгдүүлэх, иргэдийн төрд итгэх итгэлийг бэхжүүлэх стратегийн ач холбогдолтой. Энэхүү үнэлгээ нь дан ганц сахилга бат, хууль тогтоомж мөрдөлтийн түвшнийг хэмжих бус, байгууллагын соёл, удирдлагын манлайлал, ил тод байдал, хариуцлага, шударга шийдвэр гаргалт бодитоор хэрэгжиж буй эсэхийг илрүүлэх цогц үйл ажиллагаа болно.Төрийн байгууллагын ёс зүй, сахилга хариуцлага, хууль тогтоомжийн хэрэгжилтийг  тусад нь хэмжих бус, байгууллагын соёл, удирдлагын манлайлал, ил тод байдал, шударга шийдвэр гаргалт зэргийг хамтад нь бодитоор хэрэгжиж буй эсэхийг нэгдмэл байдлаар хэмжих замаар "Ёс зүйн индекс"-ийг нэвтрүүлж, ёс зүйн засаглалын чанарын үр дүнг тооцох боломжтой болно. |
| | | | Ёс зүйн зөрчлийн талаарх гомдол, мэдээллийн бүртгэл, хяналтын цахим системийн хөгжүүлэлтийг хийнэ. | 13.1.10.4 | Цахим системийн нэмэлт хөгжүүлэлтийн явц | хувь | 2024 | 70 | 90 | 90 | | | | Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо (ХНУМТ)-ны суурь өгөгдөлд тулгуурлан “Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем”-ийг шинэчлэн загварчилж, ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтыг бүрэн цахим хэлбэрт шилжүүлсэн. Энэхүү дэд системийг нэвтрүүлснээр ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, гомдол, мэдээллийн бүртгэл, хяналтыг цахимаар хэрэгжүүлэх, ёс зүйн дэд хороодын үйл ажиллагаанд хяналт тавих, ёс зүйн төлөв байдалд дүн шинжилгээ хийх, эрсдэлийг тодорхойлох, статистик мэдээ, тайланг шуурхай нэгтгэн боловсруулж, бодлогод ашиглах нэгдсэн мэдээллийн сан бий болох юм."E-Mongolia" системээр дамжуулан төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд хариуцлага хүлээсэн эсэх талаарх лавлагаа олгох механизмыг нэвтрүүлэхээр ажиллаж байна. Уг дэд системийг ашиглан 2025 оны жилийн эцсийн байдлаар төрийн нууцад хамаарахаас бусад 2038 дэд хороо бүртгүүлж, гомдол мэдээлэл, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээ, сургалтын бүртгэл хяналтыг хөтлөн явуулж байна. |

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч | Хөтөлбөр | Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 14 | **ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА** | | | | | | | | | | | | | |
| | 14.1 | **70405 Албан ёсны статистик** | | | | | | | | | | | | |
| | | 14.1.1 | Статистикийн тухай хуульд заасны дагуу Үндэсний статистикийн хорооноос баталсан маягтаар албан ёсны болон захиргааны статистикийн мэдээллийг гаргасан байна. | 14.1.1.1 | Захиргааны статистикийн мэдээлэл, тайлангийн нэр, төрөл | тоо | 2024 | 211 | 403 | 415 | 29,907,075.20 | 27,514,085.70 | 92% | 2025 оны байдлаар 43 төрийн байгууллага, яам, агентлагаас 415 маягтаар захиргааны статистикийн мэдээллийг нэгтгэн цуглуулсан. |
| | | | | 14.1.1.2 | Аймаг, нийслэл, дүүргийн Статистикийн газар, хэлтсээс ирүүлдэг мэдээ, тайлан | тоо | 2024 | 53 | 55 | 56 | | | | 2025 онд ҮСХ-ны даргын А/178 тоот тушаалын дагуу 56 төрлийн мэдээ, тайланг сар, улирал, хагас жил, жилийн давтамжтайгаар хүлээн авсан. |
| | | 14.1.2 | Статистикийн тухай хуульд заасны дагуу бодлого боловсруулагчид, хэрэглэгчдийг Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдлын танилцуулгаар сар бүр, статистикийн эмхэтгэлийг жилээр бэлтгэж, тархаасан байна. | 14.1.2.1 | Монгол Улсын статистикийн эмхэтгэл | тоо | 2024 | 1 | 1 | 1 | | | | Монгол Улсын 2024 оны Статистикийн эмхэтгэлийг бэлтгэн гаргаж, хэрэглэгчдэд тархаасан. |
| | | | | 14.1.2.2 | Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдлын сарын бюллетень, танилцуулга | тоо | 2024 | 36 | 36 | 36 | | | | Сар бүр Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдлын танилцуулгыг Монгол, Англи хэлбэрээр 2 ширхэг, жилд 24 ширхэг танилцуулгыг бэлтгэн, хэрэглэгчдэд тархаасан. Мөн сар бүр нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдийг сэтгүүлчдэд хүргэх зорилгоор 12 удаа презентац бэлтгэн тархаасан. |
| | | 14.1.3 | Статистикийн мэдээллийн нэгдсэн санг 7 хоног, сар, улирал, хагас жил, жилийн давтамжтайгаар баяжуулж, хуульд заасан давтамжтай тооллого, судалгааны үр дүнг тухай бүр нийтэд тархаасан байна. | 14.1.3.1 | Инфографик танилцуулга | тоо | 2024 | 20 | 20 | 20 | | | | Сар бүрийн статистикийн танилцуулгад ордог салбаруудын мэдээллээр дунджаар 20 ширхэг инфографикийг хэрэглэгчдэд тархаасан |
| | | | | 14.1.3.2 | Тооллого, судалгааны үр дүн | тоо | 2024 | 6 | 10 | 11 | | | | ӨНЭЗС, АХС, Ардчилсан засаглал судалгаа, Малын хагас жилийн түүвэр судалгаа, Мал, тэжээвэр амьтдын жилийн эцсийн тооллого, Дотоодын жуулчдын түүвэр судалгаа, Нөөц ашиглалтын хүснэгт, салбар хоорондын тэнцлийн судалгаа, Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа (нэмэх), Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн судалгаа, Зохистой хөдөлмөр: 2030 он хүртэлх ТХЗ-ын хэрэгжилт, хувиараа хөдөлмөр эрхлэлтийн судалгааны үр дүнгүүдийг боловсруулж, СМНС-д байршуулж, тархаасан. |
| | | | | 14.1.3.3 | Мэдээллийн нэгдсэн сангийн тайлан /1212.мн/ | тоо | 2024 | 845 | 850 | 859 | | | | Шинэчлэн сайжруулсан СМНС (www.1212.mn)-д 56 бүлгийн 859 үзүүлэлтийг 7 хоног, 15 хоног, сар, улирал, хагас жил, жилийн давтамжтайгаар шинэчлэн тархаасан. |
| | | 14.1.4 | Статистикийн мэдээллийн арга зүй, аргачлалыг илүү боловсронгуй болгох, сайжруулах үүднээс холбогдох салбарын үзүүлэлтийн аргачлалыг шинэчлэн боловсронгуй болгоно. | 14.1.4.1 | Шинээр боловсруулах болон шинэчлэх аргачлал, ангиллын тоо | тоо | 2024 | 9 | 6 | 6 | | | | 2025 онд Хүний хөгжлийн индекс тооцох аргачлал, ДНБ-ийг хэлхээ индекс ашиглан зэрэгцүүлэх үнээр тооцох аргачлал, Байр сууцаар хангах, нийтийн хоолны салбарын статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал, Судалгааны баримт бичгийн стандартчилал, Зохистой хөдөлмөрийн статистикийн үзүүлэлтүүдийг тооцох гарын авлага зэргийг шинэчлэн боловсруулж мөрдөж байна. |
| | | 14.1.5 | Статистикийн мэдээллийн санд үндэслэн нийгэм, эдийн засгийн салбаруудын жилийн дэлгэрэнгүй танилцуулга, тооллого, судалгааны үр дүнг боловсруулж, тархаасан байна. | 14.1.5.1 | Статистикийн мэдээллийн санд суурилж, нийгэм, эдийн засгийн үндсэн үзүүлэлтээр хийх судалгаа | тоо | 2024 | 33 | 35 | 35 | | | | Статистикийн мэдээллийн нэгдсэн сангийн тоон мэдээлэлд үндэслэж, нийгэм, эдийн засгийн 35 салбарын жилийн дэлгэрэнгүй танилцуулгыг бэлтгэж, тархаасан. |
| | | 14.1.6 | Статистикийн тухай хуульд заасан Мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн тооллого, Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа, Ажиллах хүчний судалгаа, Ардчилал засаглал судалгаа, Цаг ашиглалтын судалгаа, Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа, Гэмт | 14.1.6.1 | Тооллого | тоо | 2024 | 2 | 2 | 2 | | | | 2025 онд Статистикийн тухай хуульд заасны дагуу Хүн ам, орон сууцны завсрын тооллого, Мал, тэжээвэр амьтдын жилийн эцсийн болон малын хагас жилийн тооллогыг түүвэр судалгааны аргаар амжилттай зохион байгуулсан. |
| | | | | 14.1.6.2 | Судалгаа | тоо | 2024 | 6 | 3 | 4 | | | | Статистикийн тухай хуульд заасны дагуу 2025 онд улирал бүр ӨНЭЗС, АХС, Ардчилсан засаглал судалгааг зохион байгуулсан.Мөн 2025 оны 11 дүгээр сард Дотоодын жуулчдын түүвэр судалгааг улсын хэмжээнд анх удаа зохион байгуулсан. |
| 15 | **СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДАРГА** | | | | | | | | | | | | | |
| | 15.1 | **70403 Бүх шатны сонгууль зохион байгуулах** | | | | | | | | | | | | |
| | | 15.1.1 | Сонгох, сонгогдох эрхийг хангах, сонгогчийн оролцоог нэмэгдүүлнэ. | 15.1.1.1 | Сонгогчийн боловсролыг дээшлүүлэх | багц материалын тоо | 2024 | 4 | 4 | 8 | 14,808,241.00 | 13,823,301.04 | 93.30% | Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2025 оны нөхөн сонгуулийн үеэр сонгогчдод зориулан 2 төрлийн гарын авлага, танилцуулга, 2 төрлийн сурталчилгааны материал, Сонгуулийн боловсрол сэтгүүлийн 4 дугаар, сонгуулийн хороодод зориулан гарын авлага, 4 төрлийн заавар боловсруулан хэвлэж олон нийтийн хүртээл болгосон |
| | | | | | | сургалтын тоо | - | - | 4 | 17 | | | | Хариуцлагатай сонгогч сургалтыг 17 аймагт зохион байгуулсан. Мөн нөхөн сонгууль зохион байгуулагдсан 18 аймаг, 53 суманд сонгогчийн өдөрлөгийг 2 удаа зохион байгуулав. |
| | | 15.1.2 | Сонгууль зохион байгуулах үйл ажиллагаанд оролцогчийн чадавхыг сайжруулна. | 15.1.2.1 | Байнгын бус ажиллагаатай сонгуулийн байгууллагад ажиллах төрийн албан хаагч болон даамалд зориулсан сургалт | сургалтын тоо | 2023 | 18 | 18 | 19 | | | | Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2025 оны нөхөн сонгууль бэлтгэл ажлын хүрээнд 18 аймгийн 53 суманд аймаг, сум, хэсгийн хорооны гишүүдийн болон мэдээллийн технологийн даамлын сургалтыг зохион байгуулсан. |
| | | 15.1.3 | Улс төрийн намын санхүүжилтийг ил тод болгоно. | 15.1.3.1 | Улс төрийн намын санхүүжилт, санхүүгийн тайланг ил тод болгох, чадавхжуулах | тайлангийн тоо | - | - | 7 | 28 | | | | Улс төрийн намын тухай хуулийн дагуу улс төрийн 37 намаас 28 нам 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа ирүүлсэн байна. |
| | | | | 15.1.3.2 | Улс төрийн намын мэдээллийн сан үүсгэх, нээлттэй болгох | сургалтын тоо | - | - | 7 | 37 | | | | Улс төрийн намын тухай хуульд заасны дагуу 37 улс төрийн намын мэдээллийг e-electiom.mn цахим хуудсанд байршуулсан. |
| | | 15.1.4 | Мэдээллийн сан үүсгэх, аюулгүйн болон бэлэн байдлыг хангана. | 15.1.4.1 | Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуулийн мэдээллийн сан үүсгэх | мэдээлэл | 2023 | 14 | 14 | 18 | | | | Санал хураалтын зурган файл, дүн мэдээ, хяналтын тооллогын бичлэгийг хэсэг, сум, аймгаар нь мэдээллийн сан үүсгэсэн. |
| | | | | 15.1.4.2 | Тоног төхөөрөмжийн аюулгүйн болон бэлэн байдлыг хангах | тоног төхөөрөмжийн тоо | 2024 | 3000 | 3000 | 3000 | | | | Сонгуулийн автоматжуулах системийн иж бүрдэлд техникийн иж бүрэн үзлэг, шалгалт хийсэн |
| | **ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ УЛСЫН КОМИССЫН ДАРГА** | | | | | | | | | | | | | |

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч | Хөтөлбөр | Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | **72204 Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчийг цагаатгах үйл ажиллагаа** | | | | | | | | | | | | |
| 16 | 16.1 | 16.1.1 | Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хуулийн хэрэгжилтийг хангуулж, Тагнуулын ерөнхий газрын тусгай архивт хадгалагдаж байгаа хэрэг, хөдөө орон нутгийн архивуудаас татан төвлөрүүлсэн хэрэг, өмнө нь шалгаад нотлох баримтаар тогтоогдоогүй үндэслэлээр мөрдөн шалгах ажиллагааг зогсоосон хэргүүдийг зөвлөмжийн дагуу шалгаж эцэслэн шийдвэрлэнэ. | 16.1.1.1 | Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг олж тогтоох зорилгоор шалгах хэрэг, материал | тоо | 2023 | 269 | 240 | 148 | 1,225,820.90 | 1,176,135.23 | 96% | 2025 онд мөрдөн шалгах ажиллагааны талаар тайлант хугацаанд нийт 202 хүнд холбогдох 148 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсан . Үүнд: ТЕГ-ын тусгай архивын тасагт хадгалагдаж буй 158 хүнд холбогдох 127 эрүүгийн хэрэг, иргэдийн өргөдөл гомдлоор 44 хүнд холбогдох 21 хэрэг мөрдөн шалгах ажиллагааг явуулсан. |
| | | 16.1.2 | Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчид шүүхийн шийдвэрийг үндэслэн нөхөх олговор олгоход дэмжлэг үзүүлнэ. | 16.1.2.1 | Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д заасан нэхэмжлэгчдэд шүүхийн шийдвэрийн дагуу нөхөх олговор олгох | тоо | 2023 | 5 | 10 | 7 | | | | УТХХХЦТНООТ хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.2-т зааснаар 41.0 сая болон 81.0 сая төгрөгийн нөхөх олговрыг нийт 7 иргэнд 322,000,000 сая төгрөгийн нөхөн олговрыг олгосон байна. |
| | | | | 16.1.2.2 | Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн 13-р зүйлийн 13.2-т заасан нэхэмжлэгчдэд олгох нөхөх олговор | тоо | 2023 | 314 | 8 | 7 | | | | |
| | | 16.1.3 | Соён гэгээрүүлэх олон талт үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлж, хэлмэгдүүлэлт давтагдахаас урьдчилан сэргийлнэ. | 16.1.3.1 | Хэлмэгдэгчдийн дурсгалд зориулсан ногоон төглийг 10 аймагт бий болгож хаягжуулах | тоо | 2023 | 10 | 10 | 3 | | | | Тайлант онд Улсын комиссын төсөвт энэ жилийн үйл ажиллагаанд зориулсан төсөв суугдаагүй бөгөөд 2 аймаг өөрийн хөрөнгө, бусад байдлаар "Ногоон төгөл"-өө тохижуулсан талаар тайлан ирүүлсэн байна. Харин Улсын комисс, Нийслэлийн салбар комисс, ЧД-ийн салбар комисс хамтран Хэлмэгдэгчдийн дурсгалын хөшөөний засварын ажлыг хийж гүйцэтгэлээ. Мөн СХД-ийн Хамбын овооны дурсгалт газар төрийн бус байгууллага, хувь иргэнтэй хамтран мод тарьсан талаар тайлан ирүүлээд байна. |
| | | | | 16.1.3.2 | Хуулийн хэрэгжилтийг олон нийт, иргэн, залуучуудад сурталчлах зорилгоор телевиз, радио, сонин, цахим хуудас эрхлэгчтэй хамтран ажиллах,-"Хамаг монгол бүү мартагтун" төслийг дуусгах | хувь | 2023 | 90 | 100 | 80 | | | | Хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд Улсын комиссын даргын санаачилан гаргасан богино хэмжээний нэвтрүүлэг -1, олон нийтэд хэлмэгдлийн хор уршигийг таниулан харуулах зорилготой контент-10ш , Хэлмэгдсэн Алтан ургийнханы талаарх 1, Л.Лааганы амьдрал ба хэлмэгдүүлэлт номыг хамтран гаргаж олон нийтийн хүртээл болгосон. |
| | **МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД** | | | | | | | | | | | | | |
| | | **70426 Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх** | | | | | | | | | | | | |
| | | 17.1.1 | Төрийн өмчит хуулийн этгээдийн үр ашгийг нэмэгдүүлнэ. | 17.1.1.1 | Төрийн өмчит компанийн засаглалын үнэлгээ | хувь | 2021 | 53.9 | 80 | 80 | | | | УИХ-ын 2023 оны “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” 59 дүгээр тогтоол, МУЕС-ын 2025.07.25-ны өдрийн албан даалгаврын 5.5 болон холбогдох дүрэм, журмыг баримтлан, АТГ, СЗХ, АХБ-аас ирүүлсэн саналыг тусган Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглалыг үнэлэх нийтлэг аргачлалыг боловсруулж, ТӨБЗГ-ын хурлаар батлуулсан. Засаглалын үнэлгээг хийхдээ холбогдох салбарын Сайд нарын дэмжлэгийг авч аймаг, нийслэлийн Засаг дарга нартай хамтран зохион байгуулж ажиллах талаар Засгийн газрын хуралдаанд танилцуулсан боловч тодорхой хугацаагаар хойшлогдсон болно. |
| | | | | 17.1.1.2 | Олон нийтийн шууд хяналтад оруулсан төрийн өмчит компани | тоо | 2021 | 1 | 2 | 2 | | | | УИХ-ын 2022 оны 16 дугаар тогтоол, ЗГ-ын 2022 оны 244 дүгээр тогтоолын дагуу “Төрийн банк” ХК-ийн 5.71%, “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн 34%-ийн хувьцааг биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй арилжиж IPO гаргах ажил амжилттай явагдсан. “Үндэсний давхар даатгал” ТӨХК-ийн 20%, “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн нэмэлт 30.6%-ийн хувьцааг биржээр дамжуулан арилжихаар холбогдох бэлтгэл ажлуудыг ханган ажиллаж байна. |
| | | 17.1.2 | Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулна. | 17.1.2.1 | Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн мэдээллийн нэгдсэн системийг бий болгох | хувь | 2021 | 40 | 90 | 95 | | | | Төрийн болон орон нутгийн өмчийн /ТБОНӨ--ийн нэгдсэн цахим системийг бий болгож, нэвтрүүлэх ажлыг эхлүүлж, 21 аймаг, нийслэлд сургалт зохион байгуулсан. |
| | | | | 17.1.2.2 | Улсын үзлэг, тооллогын мөрөөр авах арга хэмжээний хэрэгжилт | хувь | 2021 | 97 | 100 | 99 | | | | Засгийн газрын 2022 оны 481 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэн ажиллаж, дүнг хуралдаанаар хэлэлцүүлсэн. 21 аймаг, нийслэлээс орон нутгийн дүн, тайланг авч нэгтгэж, удирдлагад танилцуулсан. |

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч | Хөтөлбөр | Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 17.1 | 17.1.3 | Төрийн өмчид тавих төрийн хяналт сайжирч, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгоно. | 17.1.3.1 | Төрийн өмчийн хяналт шалгалт | тоо | 2021 | 38 | 35 | 24 | 2,848,141.70 | 2,598,619.00 | 95.46% | 2025 онд нийт 30 төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд хяналт шалгалт хийхээр төлөвлөснөөс 22 байгууллагад төлөвлөгөөний дагуу хяналт шалгалт хийсэн. 2025 оны төсөвт тодотгол хийгдэж, томилолтын зардлыг хассантай холбоотойгоор орон нутагт хийгдэх хяналт шалгалтын тоог багасгаж, нийт 8 хуулийн этгээдийг хяналт шалгалтын төлөвлөгөөнөөс хассан. |
| | | | | 17.1.3.2 | Хууль, эрх зүйн шинэчлэлт | хувь | 2021 | 70 | 90 | 0 | | | | МУЕС-ын 2025 оны 29-р захирамж, ЗГХЭГ-ын даргын 2025 оны 21-р тушаалын дагуу ТБОНӨТХ-ийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсэг, дэд ажлын хэсэгт ажиллаж, 7 удаагийн хуралдаанд оролцон саналаа албан ёсоор хүргүүлсэн. Уг хуулийн төслийг 2025.05.14-ний өдрийн ЗГ-ын хуралдаанд танилцуулж, 2025.06.25-ны өдөр ЗГ-аас УИХ-д өргөн мэдүүлсэн. ЭЗБХ-ны 2025.07.07-ны өдрийн хуралдаанаар ТБОНӨТХ-ийн шинэчилсэн найруулга буюу Нийтийн өмчийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, УИХ-ын тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны гишүүдийн олонхын саналаар дэмжсэн. ТББХ-ны 2025.12.30, УИХ-ын чуулганы 2025.12.31-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар “Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцэж, санал хураалт явуулахад, гишүүдийн олонх Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай анхдагч хуулийн төсөл болон Нийтийн өмчийн тухай хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжсэн. Засгийн газраас “Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хууль”-ийн төслийг 2025.01.08-ны өдөр, “Нийтийн өмчийн тухай хууль”-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг 2025.06.25-ны өдөр тус тус УИХ-д өргөн мэдүүлсэн. Хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэхээр УИХ-ын гишүүн Д.Үүрийнтуяагаар ахлуулсан ажлыг хэсгийг УИХ-ын даргын 2025.12.31-ний өдрийн 529-р захирамжаар байгуулсан бөгөөд хуулийн төсөл тус бүрд дэд ажлын хэсгийг томилж УИХ-ын гишүүн О.Номинчимэг, П.Сайнзориг нар ахлан ТӨБЗГ болон холбогдох ажилтнууд хамтран ажиллаж байна. |
| | | **72201 Жендэрийн тэгш байдлыг хангах** | | | | | | | | | | | | |
| | 17.2 | 17.2.1 | Бүх нийтэд хүний эрх, жендэрийн боловсрол олгох үндэсний тогтолцоог хөгжүүлж, жендэрийн тэгш байдлыг хангах бодлого баримтална. | 17.2.1.1 | Тухайн жилийн сургалт, сургагч багш, сургалтад хамрагдсан удирдах ажилтан /УА/, төрийн албан хаагчийн тоо /ТАХ/, салбар, | хамрагдсан УА, ТАХ-ийн тоо | 2021 | Сургагч багш-154, УА-65, ТАХ-65 | Сургагч багш-304, УА-80, ТАХ-85 | 502<br>31 | 688,571.50 | 665,488.00 | 96.65% | Салбар, орон нутгийн жендэрийн бодлогын хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явцад суралцаж, энэ чиглэлд тодорхой туршлагууд бий болсон. |
| | | 17.2.2 | Яамдын жендэрийн бодлого болон аймаг, нийслэл, дүүргийн жендэрийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангана. | 17.2.2.1 | Орон нутгийн жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлээрх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, батлуулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх | төлөвлөгөө | 2021 | 30 | 31 | 31 | | | | 2017-2022 оны хооронд нийслэл болон нийслэлийн 9 дүүрэг, 21 аймагт баримтлах жендэрийн эрх тэгш айдлыг хангах дэд хөтөлбөрийг батлуулж хэрэгжүүлсэн. Энэ хүрээнд дараах аймаг, дүүргүүдийн дэд хөтөлбөр нь дуусч, дараагийн шатны ЖЭТБХангах арга хэмжээний төлөвлөгөөгөө батлуулан хэрэгжилтийг ханган ажиллуулж байна. Үүнд: Баянхонгор, Дархан-уул, Дорнод, Дундговь, Завхан, Төв, Ховд аймгууд, Сонгинохайрхан, Налайх, Чингэлтэй дүүрэг. |
| | | | | 17.2.2.2 | Орон нутгийн жендэрийн бодлого, төлөвлөгөөний хэрэгжилтэд оролцооны хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чиглэлээр салбар хороонд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх | хороодын тоо | 2021 | 9 | 21 | 19 | | | | Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дархан-Уул, Дорнод, Дундговь, Орхон, Өмнөговь, Сүхбаатар, Хөвсгөл, Ховд,Увс, нийслэлийн Багануур, Баянзүрх, Налайх, Сүхбаатар, Хан-уул дүүргүүд дэд хөтөлбөртөө ХШҮ хийлгэсэн. |
| | | 17.2.3 | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа, судалгаа, дүн шинжилгээ хийх ажлыг зохион байгуулна. | 17.2.3.1 | Хэвлэл мэдээллийн байгууллагын жендэрийн мэдрэмжтэй редакцын бодлогыг бодитоор хэрэгжүүлэх сургалт зохион байгуулах | сургалтын тоо | 2021 | 5 | 13 | 5 | | | | Жендэрийн тэгш байдал, хүний эрхийн чиглэлээрх сэтгүүлчдэд зориулсан арга хэмжээг Хэвлэлийн хүрээлэнтэй 2025 онд хамтран зохион байгуулж, үүнд 30 сэтгүүлч хамрагдсан байна. |
| | | | | 17.2.3.2 | Сэтгүүлч, нийгмийн ажилтан, эрх зүйч бэлтгэдэг их, дээд сургуулийн хөтөлбөрт жендэрийн хөтөлбөр тусгасан сургууль | тоо | 2024 | 32 | 40 | 20 | | | | 2024 онд жендэрийн асуудлаар хөтөлбөр 1, модуль 6 боловсруулж, 15 их дээд сургууль хамрагдсан. 2025 онд эрх зүйч бэлтгэх сургуулиудын сургалтын агуулгад жендэрийн үзэл баримтлал нэвтрүүлэх сургалтын агуулгыг эрх зүйч бэлтгэдэг нийт 5 их дээд сургуульд хүргүүлэн ажиллалаа. |
| | | 17.2.4 | Эмэгтэйчүүдийн улс төрийн манлайллын сүлжээг өргөжүүлж, жендэрийн тэгш байдлын талаар улс төрийн нам, олон нийтийн ойлголт, хандлагыг нэмэгдүүлнэ. | 17.2.4.1 | Эмэгтэйчүүдийн манлайллын хөтөлбөрийг хэрэгжүүлэх санаачилгыг дэмжиж ажиллах | хөтөл | - | - | 1 | 5 | | | | Азийн хөгжлийн банкнаас санаачлан зохион байгуулдаг “Азийн эмэгтэйчүүдийн манлайллын 9 дэх удаагийн хөтөлбөр”-ийг Жендэрийн үндэсний хороо Монгол Улсад анх удаа зохион байгуулж, 2023, 2024 онд төрийн захиргааны албаны шийдвэр гаргах түвшинд ажиллаж буй 75 эмэгтэйг хамруулсан. 2025 онд 2 удаагийн хөтөлбөрөөр 50 эмэгтэйг хамруулж өссөн дүнгээр 125 удирдах түвшний эмэгтэй албан хаагчдыг хамруулсан байна. |
| | | | | 17.2.4.2 | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн сайн туршлагын талаарх сурталчилгаа | тоо | 2021 | 3 | 7 | 7 | | | | Үндэсний хэмжээнд нийт 6 сайн туршлагыг нэвтрүүлэхээр хөгжүүлэн ажиллаж байна. Мөн аж ахуйн нэгж байгууллагуудад бий болж буй жендэрийн мэдрэмжтэй ажлын байрны чиглэлээрх сайн туршлагын судалгааг хийж, нийт 27 аж ахуйн нэгж хамрагдсан. Мөн Монголын Ажил олгогч эздийн нэгдсэн холбоотой хамтран 7 аж ахуйн нэгжийн хөдөлмөрийн дотоод журамд бий болсон жендэрийн мэдрэмжтэй шинэлэг өөрчлөлтүүдийг байгууллагын цахим хуудсаар сурталчлан ажилласан. 2025 онд ЗТЯ, Дархан-Уул аймгийн ЗДТГ, Говь ХК-ны сайн туршлагыг жендэрийн мэдрэмжтэй ажлын байрны бодлогын хэрэгжилтийг дэмжих хүрээнд сурталчлан ажиллалаа. Түүнчлэн хүйсийн хосолсон удирдлага бүхий аймаг, орон нутгийг сурталчлан ажиллалаа. |

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч | Хөтөлбөр | Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 17 | | 17.2.5 | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлэх эдийн засаг, эрх зүйн баталгааг бүрдүүлэх, түүнийг боловсруулах ажлыг арга зүйн удирдлагаар хангаж, биелэлтэд хяналт тавих ажлыг зохион байгуулна. | 17.2.5.1 | Ажлын байрыг жендэрийн мэдрэмжтэй болгоход чиглэсэн бодлогыг шинэчлэн боловсруулж, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжид мөрдүүлэх арга хэмжээ | тоо | 2023 | Т | 2 | 1 | | | | Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2022 оны 38 дугаар тогтоолоор Жендэрийн мэдрэмжтэй ажлын байрны бодлогыг баталсан. Тус бодлогын хэрэгжилтийг хангах хүрээнд төв, орон нутгийн аж ахуйн нэгж байгууллагын удирдлага, хүний нөөцийн ажилтнуудыг сургалт семинарт хамруулж ажиллаж байна. Бодлогын хэрэгжилтийн талаарх хэлэлцүүлгийг УИХ-ын байнгын хороотой хамтран 2 удаа зохион байгуулж, хэрэгжилтийг эрчимжүүлэх төлөвлөгөө баталж хэрэгжүүлэх талаарх зөвлөмжийг ГБХНХЯ, Хөдөлмөр нийгмийн зөвшилцлөлийн гурван талт үндэсний хороонд хүргүүллээ. |
| | | | | 17.2.5.2 | Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын хэрэгжилтийн талаарх илтгэх хуудас | тоо | 2024 | 1 | 1 | 100 | | | | Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын хэрэгжилтийн ЗГ-ын ээлжит 10-р тайланг боловсруулах ажилд мэдээлэл, аргазүйн дэмжлэг үзүүлж ажиллалаа. Мөн тус тайланг НҮБ-ын Эмэгтэйчүүдийг алагчилах үзлийг устгах Хорооны 82 дугаар хуралдаанаар 2022 оны 6 сарын 23-24-ний өдрүүдэд цахимаар тайлагнах багт орж ажилласан. Тус конвенцын зөвлөмжийг 2024-2026 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөөнд санал өгч, нийт 16 зөвлөмжийн хэрэгжилтийг хариуцахаар төлөвлөгөөнд тусгагдаж, хэрэгжилтийнтайланг 2025 онд ГБХНХЯ-нд тайлагнаж ажиллалаа. |
| | | **71504 Газрын зураглал, кадастр** | | | | | | | | | | | | |
| | | 17.3.1 | Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа 38 хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана. | 17.3.1.1 | 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээ | хувь | 2023 | 100 | 100 | 95.7 | | | | Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар нийт 2025 онд 92 зорилтын хүрээнд 273 арга хэмжээний хэрэгжилт 95,7 буюу "бүрэн хангалттай" (арга хэмжээ оновчтой тодорхойлогдсон, зорилтот түвшиндээ хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан, эсхүл шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, үр дүн гарч эхэлсэн). Хангалтгүй хэрэгжсэн 8 арга хэмжээ нь Төрийн худалдан авах ажиллагааны дагуу олон нийтэд нээлттэй тендер зарласан боловч материал ирүүлээгүй, хангалтгүй материал ирүүлсэн, гүйцэтгэгч татгалзсан, Улсын төсөвт санхүүжилт суугдаагүй зэрэг шалтгаанаас дээрх арга хэмжээнүүд 2025 онд бүрэн хэрэгжих боломжгүй болсон байна. |
| | | 17.3.2 | GNSS-ийн суурин станцын тоог 10-аар нэмэгдүүлнэ. | 17.3.2.1 | Монгол Улсын GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын сүлжээг өтгөрүүлэх | хувь | 2023 | 43 | 61 | 53 | | | | 2025 онд GNSS-ийн байнгын ажиллагаатай 2 суурин станц шинээр байгуулах ажлын даалгаврыг боловсруулсан. Байнгын ажиллагаатай суурин станцуудаас бүрдсэн геодезийн байрлалын тулгуур сүлжээний нарийвчлалыг сайжруулах зорилгоор 2026 онд шинээр байгуулах 10 станцын төсвийн тооцоо, холбогдох мэдээллийг гаргаж улсын төсвөөр хийж гүйцэтгэх ажлын саналд оруулан ЗГХЭГ-т 2025 оны 1/2234 дугаар албан бичгээр хүргүүлсэн. ШУА-ийн Одон орон геофизикийн хүрээлэнд 2024-2025 онд шинээр байгуулсан зарим станцыг ГЗБГЗЗЕГ-ын байнгын ажиллагаатай суурин станцын удирдлагын төвд холбон сүлжээг өтгөрүүлэх ажлыг хамтран зохион байгуулах саналыг хүргүүлсэн. Ирсэн саналын дагуу Төв аймгийн Эрдэнэсант сумын станц руу зайнаас хандан ажилласан. Геодезийн үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж буй Монмэп ХХК, ГЗБГЗЗЕГ, Япон улсын Asia Air Survey компанийн санхүүжилтээр нийслэлийн Сонгинохайрхан, Хан-Уул дүүрэгт шинээр 2 GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станц суурилуулж станцын сүлжээг өтгөрүүлсэн. |
| | | 17.3.3 | Нийслэл, 21 аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг газрыг эзэмшүүлэх, өмчлүүлэх, зүй зохистой ашиглах, хамгаалах, хуваарилахтай холбоотой дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичгээр бүрэн хангасан байна. | 17.3.3.1 | Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэх /Увс, Дундговь, Завхан/ | тоо | 2023 | 15 | 22 | 20 | | | | 2024 оны байдлаар 19 аймаг газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй байснаас 2025 онд 2 аймгийн төлөвлөгөөг тодотгохоор туссаны дагуу Говьсүмбэр, Дорноговь аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийж Говьсүмбэр аймгийн ИТХ-ын 2025 оны 04 дүгээр, Дорноговь аймгийн ИТХ-ын 2025 оны 09/03 дугаар тогтоолуудаар тус тус батлуулсан. Мөн Ховд аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинээр боловсруулж аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 48 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжүүлж эхлээд байна. Ингэснээр улсын хэмжээнд өссөн дүнгээр 20 аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө бүрэн хийгдэж, 2025 оны зорилтот түвшингээс 1 аймгаар давсан гүйцэтгэлтэй байна.<br>Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөндөө нэмэлт тодотгол хийх хэрэгцээ шаардлага үүссэн Увс, Дундговь аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах ажлын зардал 2026 оны орон нутгийн төсөвт батлагдсан. |
| | 17.3 | 17.3.4 | Геопорталын хөгжүүлэлт хийгдэж орон зайн суурь 18 дэд сангийн мэдээллийг агуулсан сэдэвчилсэн зургийг хэрэглээнд нэвтрүүлсэн байна. | 17.3.4.1 | Геопорталаар дамжуулан төрийн бодлого, төлөвлөлт, шийдвэр гаргалтын "нэг газрын зураг", иргэд, олон нийт, бизнесийн зориулалттай "нээлттэй газрын зураг" цахим үйлчилгээг улсын хэмжээнд нэвтрүүлэх | хандалт | 2023 | 1,919,066 | 3,450,000 | 3,703,106 | 51,511,768.30 | 47,278,115.70 | 91.78% | Үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийн Геопортал цахим системийн өгөгдлийн санг шинэчлэн зохион байгуулах, хэрэглэгчийн програм хангамжийн хөгжүүлэлт, Орон зайн өгөгдөл мэдээллийн 5 дэд санд чанарын шалгалт хийж, баяжуулалт, атрибут мэдээг бүрдүүлэх ажлыг зохион байгуулсан. Үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийн Геопортал цахим системд холбогдсон 9 яам, 8 агентлаг, 24 бусад байгууллагын нийт бүртгэлтэй 397 хэрэглэгч, бусад эрхийн бүртгэлтэй 2,604 хэрэглэгч ажилллаж байна. Геопортал цахим системийн 18 суурь өгөгдлийн дэд сангаас 35 төрлийн үйлчилгээг нэвтрүүлсэн бөгөөд 3,703,106 хандалт бүртгэгдэж, үйлчилгээ авсан байна. |

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч | Хөтөлбөр | Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 17.3.5 | Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах, үйл ажиллагаа бүрэн цахимжсан байна. | 17.3.5.1 | Газрын тохиромжтой болон хэрэгцээт байдлын үнэлгээ, газар зохион байгуулалтын төлөвлөлт, хяналтыг боловсронгуй болгох | хувь | 2023 | 50 | 100 | 85 | | | | Газрын тохиромжтой болон хэрэгцээт байдлын үнэлгээ, газар зохион байгуулалтын төлөвлөлт, хяналтын системийн ТЭЗҮ-ийг 2020 онд Барилга, хот байгуулалтын яамаар батлуулсан. ТЭЗҮ-д туссан 4 аргачлалыг НҮБ-ийн ХХААБ-ын байгууллагын санхүүгийн дэмжлэгтэйгээр боловсруулж, батлуулан, газар зохион байгуулалтын төлөвлөлт, хяналтын дэшбоард, модулыг хөгжүүлэн хэрэглээнд нэвтрүүлсэн (https://egazar.gov.mn/nature/dashboard/plan/chart/index). Мөн урсгал төсвөөр Газар зохион байгуулалтын хот төлөвлөлтийн цахим системд нэмэлт хөгжүүлэлт хийх, хэвийн найдвартай үйл ажиллагааг хангах ажлыг 2025 оны 2025/71 дугаартай гэрээгээр гүйцэтгүүлэн тус газрын №2025/ГБЗЗ/56 дугаартай актаар хүлээн авсан. Уг ажлын хүрээнд газар зохион байгуулалтын төлөвлөлт, хяналтын системийн нэг хэсэг болох Хамгаалалтын бүсийн мэдээллийн сан байгуулах, төлөвлөгөөг цахимаар хянаж дүгнэлт гаргах, газрыг улсын тусгай хэрэгцээнд авах үйл ажиллагааг цахимжуулах модулуудыг цахим системд хөгжүүлж хэрэглээнд нэвтрүүлсэн (https://egazar.gov.mn/protection/area). Түүнчлэн ГЗБГЗЗЕГ2025/66 дугаар гэрээт худалдан авалтын хүрээнд, ТЭЗҮ-д заасан үзүүлэлтээс 1-3 дахин өндөр хүчин чадалтай хадгалах төхөөрөмж/storage/, физик серверүүдийн худалдан авалт хийж, 2025 оны 11 дүгээр сард актаар хүлээн авсан. 4 аргачлалыг боловсруулж батлуулсан, худалдан авах сервэр, сторажыг бүгдийг нь худалдан авч, системд шаардлагатай үндсэн модулаас 3-ыг нь хөгжүүлсэн. |
| | | 17.3.6 | Монгол Улсын аймаг, сумдын төвийг 1:1000-ны масштабтай байр зүйн зургаар хангасан байна. | 17.3.6.1 | Улсын хэмжээнд хот, суурин газрын төвийн 1:1000-ны масштабтай байр зүйн зураг, газар доорх шугам сүлжээний зургийг ITRF2020 солбицлын тогтолцоонд шилжүүлэх | хувь | 2024 | 95 | 100 | 85 | | | | Улаанбаатар хотын 6 дүүргийн 1:1000-ны масштабтай байр зүйн зураг, Өмнөговь аймгийн 5 суманд 160,820 га талбайд 1:1000-ны масштабтай байр зүйн зургийг ITRF2020 солбицлын тогтолцоонд шинээр хийж гүйцэтгэсэн. 2025 онд Дорноговь аймгийн 6 сум, Орхон аймгийн 2 сум, Дорнод аймгийн 5 сум, Баянхонгор аймгийн 4 сумдын 1:1000-ны масштабтай байр зүйн зургийг хийх төсөв батлагдаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж байна. |
| | | 17.3.7 | Газар зүйн орон зайн мэдээллийг нээлттэй болгож, эдийн засгийн өсөлтийг бий болгоно. | 17.3.7.1 | Хиймэл оюун ухаан, блокчэйн болон газар зүйн мэдээллийн системд суурилсан гурав болон дөрвөн хэмжээст газар, үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, үнэлгээ, татвар, төлбөрийн нэгдсэн системийг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх /Улсын хэмжээнд/ | хувь | 2024 | 10 | 12 | 11 | | | | Блокчейнд суурилсан Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим систем, орон зайн өгөгдлийн дэд бүтцийн Геопортал цахим системийн хөгжүүлэлтийг хийж, ашиглалтад оруулах - Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн хүчин чадлыг нэмэгдүүлж, ачааллыг багасгах, хуваарилах зорилгоор системийг бие даасан горимд шилжүүлэх, өгөгдлийн санг шинэчлэн зохион байгуулсан. Уг нэгдсэн цахим системд хамаарах 7 дэд системийг тус бүр бие даасан систем болгон хөгжүүлж, 7 дэд системийн өгөгдлийн сангийн хувилбарыг шинэчлэх ажлыг зохион байгуулж, 3 шатны туршилтыг гүйцэтгэж, хэрэглээнд нэвтрүүлсэн. |
| 18 | **МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД** | | | | | | | | | | | | | |
| | | **70201 Эдийн засгийн хөгжлийн төлөвлөлт** | | | | | | | | | | | | |
| | 18.1 | 18.1.1 | Дунд, богино хугацааны хөгжлийн бодлого тодорхой болсон байна. | 18.1.1.1 | Бодлого, төлөвлөлтийн баримт бичиг | тоо | 2023 | 1 | 2 | 2 | 136,537,905.90 | 26,826,652.09 | 19.65% | 1.Улсын Их Хурлын 2025 оны 109 дүгээр тогтоолоор "Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийг баталсан.<br>2.Улсын Их Хурлын 2025 оны 48 дугаар тогтоолоор "Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө"-г баталсан. |
| | | 18.1.2 | Макро эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах төсвийн бодлогын чиглэл, эдийн засгийн хэт халалт, уналтын эсрэг бодлого оновчтой тодорхойлогдсон байна. | 18.1.2.1 | Эрх зүйн баримт бичиг | тоо | 2024 | 1 | 1 | 1 | | | | Монгол Улсын Нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хууль 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдөр батлагдсан. Тус хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг 2025 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр УИХ-д өргөн барьж, хэлэлцүүлснээр 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр батлагдсан. |
| | | **70428 Оюуны өмчийн эрхийн баталгаажуулалт** | | | | | | | | | | | | |
| | 18.2 | 18.2.1 | Оюуны өмчийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх нөхцөл бүрдсэн байна. | 18.2.1.1 | Оюуны өмчийн бүтээлийн сан бүрдүүлэлт /аж үйлдвэрийн өмч, зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн гэрээ, хэлэлцээрийн баталгаажилт/ | ширхэг | 2021 | 4200 | 4200 | 6399 | 3,376,425.60 | 2,539,782.88 | 75.22% | Аж үйлдвэрийн өмчийн чиглэлээр:<br>Шинэ бүтээлийн патентын 212 мэдүүлэг, Бүтээгдэхүүний загварын нийт 413 мэдүүлэг, Ашигтай загварын 100 мэдүүлэг, Барааны тэмдэг, газарзүйн заалтын нийт 4,610 мэдүүлэг, Зохиогчийн эрхийн 1,058 мэдүүлэг, нийт 6,399 мэдүүлэг хүлээн авсан. |
| | | | | 18.2.1.2 | Оюуны өмчийн талаарх мэдээлэл, сургалт хийх, лавлагаа гаргах | ширхэг | 2021 | 70 | 70 | 370 | | | | Сургалтын хөтөлбөр боловсруулж, давхардсан давхардсан тоогоор 6 сэдвээр 41 удаагийн сургалт, хэлэлцүүлэгт 12 төрийн болон төрийн бус байгууллагын 454 хүн хамрагдсан. Мөн бусад байгууллагуудтай хамтарсан 3 удаагийн өдөрлөг зохион байгуулж, оюуны өмчийн тухай ойлголт мэдлэг мэдээлэл агуулсан 18 видео шторк, 1 бүрэн хэмжээний нэвтрүүлэг , 112 мэдээ, мэдээлэл, 21 постер бэлтгэн олон нийтэд түгээсэн. Оюуны өмчийн архивын лавлагаа иргэнд 5, хуулийн этгээдэд 365 нийт 370 лавлагаа олгосон. |
| | | | | 18.2.1.3 | Оюуны өмчийн зөрчилд хяналт тавьж шийдвэрлэх | ширхэг | 2021 | 450 | 450 | 62 | | | | 2025 онд иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн 62 өргөдөл, гомдлыг хүлээж авснаас 20 гомдол, мэдээлэлд зөрчлийн хэрэг нээж, 12 гомдол мэдээллийг хүлээж авахаас татгалзаж, 30 гомдлыг харьяаллын дагуу шилжүүлсэн. Зөрчлийн холбогдогч нар буюу 12 иргэн, 10 хуулийн этгээдэд 36,200,000 төгрөгийн торгууль оногдуулж, хууль бус орлого 7,750,000 төгрөгийг улсын орлого болгосон. |
| | | **71805 Шинжлэх ухаан, технологи** | | | | | | | | | | | | |

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч | Хөтөлбөр | Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 18.3 | 18.3.1 | Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны санхүүжилт нэмэгдсэн байна. | 18.3.1.1 | Судалгаа боловсруулалтын ажлын нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөө, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх | тоо | 2023 | 1550 | 1600 | 1666 | 104,794,211.10 | 90,696,730.97 | 86.55% | 2025 оны байдлаар шинжлэх ухаан, технологийн судалгаа боловсруулалтын ажлын нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөө, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор суурь судалгааны, технологийн туршилт зүгшрүүлэлтийн болон гадаадтай хамтарсан нийт 116 төсөлд 2.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон нь 2025 онд олгосон нийт судалгаа хөгжүүлэлтийн зардлын 52.3%-ийг эзэлж байна. Үүнд: 2025 онд үргэлжлэн хэрэгжиж буй суурь судалгааны 24 төсөлд 366.3 сая төгрөг, улсын захиалгат 15 төсөлд 369.5 сая төгрөг, цөм технологийн 1 төсөлд 12 сая төгрөг, технологийн туршилт зүгшрүүлэлтийн 8 төсөлд 42.5 сая төргөг, гадаадтай хамтарсан буюу Тайваньтай хамтарсан 3 төсөлд 202.6 сая төгрөг, ОХУ-тай хамтарсан 16 төсөлд 487.8 сая төгрөг, БНХАУ-тай хамтарсан 22 төсөлд 518.8 сая төгрөг, БНХАУ-ын Байгалийн ухааны сантай хамтарсан 10 төсөлд 319.9 сая төгрөг, Беларусьтай хамтарсан 13 төсөлд 145.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон бол 2025 онд шинээр хэрэгжсэн гадаадын байгууллагатай хамтарсан буюу Тайваньтай хамтарсан 1 төсөлд 52.5 сая төгөрг, Беларусьтай хамтарсан 4 төсөлд 80.0 сая төгрөг, БНХАУ-ын Байгалийн ухааны сантай хамтарсан 10 төсөлд 400.0 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон байна. |
| | | | | 18.3.1.2 | Эрдэм шинжилгээ, судалгааны менежментийг боловсронгуй болгож, өрсөлдөх чадварыг -дээшлүүлэх | тоо | 2023 | 12610 | 13000 | 14022 | | | | 2025 оны байдлаар шинжлэх ухаан, технологийн судалгаа хөгжүүлэлтийн менежмент тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог нэвтрүүлсэн. Үүнд: 1-рт: Төрийн өмчит улсын төсвөөс санхүүжиж буй 32 хүрээлэнгийн судалгааны үндсэн чиглэлд 2.0 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон. 2-рт: Шинжлэх ухаан технологийн өрсөлдөөнт хэлбэрийн санхүүжилттэй төсөл болох суурь судалгааны, технологийн туршилт зүгшрүүлэлтийн болон гадаадтай хамтарсан төслийг нээлттэй сонгон шалгаруулж 116 төсөлд 2.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна. Үүнд: 2025 онд шинээр хэрэгжижсэн гадаадтай байгууллагатай хамтарсан буюу Тайваньтай хамтарсан 1 төсөлд 52.5 сая төгөрг, Беларусьтай хамтарсан 4 төсөлд 80.0 сая төгрөг,БНХАУ-ын Байгалийн ухааны сантай хамтарсан 10 төсөлд 400.0 сая төгрөг, нийт 532.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. |
| | | | | 18.3.1.3 | Шинжлэх ухаан, технологийн үр дүн, оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулахад дэмжлэг үзүүлэх | тоо | 2023 | 16 | 25 | 27 | | | | Судалгаа хөгжүүлэлтийн үр дүнд шинэ бүтээл 18, шинэ технологи 29, патент 11, ашигтай загвар 14, зохиогчийн эрх 38, үйлдвэрлэлд нэвтэрсэн үр ашиг 30, нийт 140 оюуны өмчийг баталгаажуулсан байна. Уг үзүүлэлтэд зөвхөн патентын тоог тооцсон болно. |
| | | **71803 Гүйцэтгэх засаглалын удирдлага** | | | | | | | | | | | | |
| | | 18.4.1 | Хөгжлийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, холбогдох арга хэмжээг авсан байна. | 18.4.1.1 | Хөгжлийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээ сайжирч, үр дүн, үр нөлөө гарах | хувь | - | - | 100 | 100 | | | | Хөгжлийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээ сайжирсан. |
| | | | | 18.4.1.2 | Зөвлөмж, албан шаардлага, дүгнэлт, санал, мэдэгдлийг тухай бүр гаргах | тоо | - | - | 5 | 5 | | | | Зөвлөмж, албан шаардлага, дүгнэлт, санал, мэдэгдлийг тухай бүр гаргасан. |
| | | | | 18.4.1.3 | Мэргэжил, арга зүйгээр ханган, дэмжлэг үзүүлж, үр дүнг нэгтгэн тайлагнах | тоо | - | - | 1 | 1 | | | | Мэргэжил, арга зүйгээр ханган, дэмжлэг үзүүлж, үр дүнг нэгтгэн тайлагнасан. |
| | | | | 18.4.1.4 | Холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг-сайжруулах | тоо | - | - | 2 | 2 | | | | Холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг сайжруулсан. |
| | | 18.4.2 | Байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны бүтээмжийг нэмэгдүүлж, үйл ажиллагааг сайжруулсан байна. | 18.4.2.1 | Байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны үр нөлөө, үр дүн, үр ашгийг нэмэгдүүлэх | хувь | - | - | 100 | 100 | | | | 1. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон түүний харьяа Ойн газарт хийгдсэн процессын дахин инженерчлэлийн судалгаа, шинжилгээний хүрээнд бодлого, төлөвлөлтийн уялдааг хангах, салбарын эрх зүйн орчин, бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгох, төрийн үйлчилгээний чанар, бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор процессийг бууруулах, цахим шилжилтийг эрчимжүүлэх, хүний нөөцийн стратеги болон эрсдэлийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх чиглэлээр тайлан, зөвлөмж, үр дүнг боловсруулан Засгийн газрын 2025 оны 6 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаанд танилцуулж, 26 дугаар хуралдааны тэмдэглэлээр албажсан.<br>2. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагад процессын дахин инженерчлэлийн судалгаа, шинжилгээг тус салбарын бүтцийг оновчтой болгох, чиг үүргийн давхардал, хийдлийг арилгах, хүнд суртлыг багасгах, албан хаагчдын ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах судалгаа, шинжилгээг олон улсад өргөнөөр ашиглагддаг 8 арга зүй, аргачлалын дагуу сонгогдсон 11 нэгжид хийж гүйцэтгэсэн. ПДИ-ийн судалгаа, шинжилгээний тайланг ЗГ-т 2025 оны 9-р сарын 24-ний өдрийн ЗГ-ын хуралдаанд Хууль зүй, дотоод хэргийн сайд танилцуулж, ЗГ-ын 18 дугаар хуралдааны тэмдэглэлээр албажсан.<br>3.Төрийн байгууллагын төгөлдөршлийн тогтолцоог үнэлж, “Азийн загвар” байгууллага төлөвшүүлэх төслийн хүрээнд Төрийн захиргаа, төрийн үйлчилгээний нийт 4 байгууллага Азийн загвар байгууллагын гэрчилгээг Азийн бүтээмжийн байгууллагаас гардан авсан. Загвар байгууллагууд Азийн загвар байгууллагын гэрчилгээг гардан авснаар, дотоодод төдийгүй олон улсын түвшинд сайн туршлагаа түгээн нэвтрүүлэх, мэргэжил арга зүйгээр бусад байгууллагыг дэмжих чадамж, боломжийг нэмэгдүүлсэн. |

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч | Хөтөлбөр | Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 18.4 | | | 18.4.2.2 | Зөвлөмж, албан шаардлага, дүгнэлт, санал, мэдэгдлийг тухай бүр гаргах | тоо | - | - | 2 | 4 | 14,778,683.40 | 14,407,456.49 | 97.49% | 1. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон түүний харьяа Ойн газарт хийгдсэн процессын дахин инженерчлэлийн судалгаа, шинжилгээний хүрээнд байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны үр нөлөө, үр дүн, үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр 68 дүгнэлт, 54 санал, зөвлөмжийг ЗГХХГ-ын даргын 2025 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 01/685 дугаартай албан бичгээр БОУАӨЯ-д хүргүүлсэн.<br>2. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагад процессын дахин инженерчлэлийн судалгаа, шинжилгээний хүрээнд байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны үр нөлөө, үр дүн, үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр 75 дүгнэлт, 74 санал, зөвлөмжийг ЗГХХГ-ын даргын 2025/10/28-ны өдрийн 01/1061 дугаар албан бичгээр ХЗДХЯ, ЦЕГ-т хүргүүлсэн. |
| | | | | 18.4.2.3 | Мэргэжил, арга зүйгээр хангаж, дэмжлэг үзүүлж, үр дүнг нэгтгэн тайлагнах | тоо | - | - | 1 | 4 | | | | БОУАӨЯ, Ойн газар, ЦЕГ, Дотоодын цэргийн байгууллагыг процессын шинжилгээ хийх, асуудал тодорхойлох чиглэлээр мэргэжил, арга зүйгээр хангаж, дэмжлэг үзүүлж ажилласан. |
| | | | | 18.4.2.4 | Холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг сайжруулах | тоо | - | - | 1 | 2 | | | | Процессын дахин инженерчлэлийн судалгаа, шинжилгээний хүрээнд холбогдох салбарын (БОУАӨЯ, Ойн газар, ЦЕГ) хууль эрх зүйн орчинд шинжилгээ хийж, хуулийн хэрэгжилтийг үнэлсэн. |
| | | 18.4.3 | Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулсан байна. | 18.4.3.1 | Иргэн, хуулийн этгээд болон төрийн албан хаагчийн сэтгэл ханамж дээшилсэн байдал | хувь | - | - | 100 | 100 | | | | Төрийн үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 2022 онд 3.12 оноотой байсан бол 2025 онд сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ 3.36 оноо болж өссөн. Процессын дахин инженерчлэлийн ажлын хүрээнд (ЦЕГ, БОУАӨЯ, Ойн газар), судалгаа, хяналт шалгалтын ажлын хүрээнд (ГСШТ, ҮГА, ГЕГ), мөн төрийн байгууллагын цахим шилжилт, дэвшилтэт технологи нэвтрүүлэхтэй холбоотой ажлын хэсгүүдийн судалгаа, байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлэх ажлын хүрээнд (бүх яам, агентлаг, аймаг) нийт 24.2 мянган иргэн, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудыг хамруулсан. Эдгээр ажлуудын хүрээнд тус бүрийн хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үзүүлэлтийг тооцож, тухайн үнэлгээнүүдийг дундажлан нэгтгэсэн ерөнхий дүнг гаргасан болно. |
| | | | | 18.4.3.2 | Зөвлөмж, албан шаардлага, дүгнэлт, санал, мэдэгдлийг тухай бүр гаргах | тоо | - | - | 2 | 3 | | | | 1.БОУАӨЯ болон Ойн газраас иргэн, аж ахуйн нэгжид олгогдож байсан 39 үйл ажиллагааны зөвшөөрлийн үйлчилгээг зураглан процесс сайжруулах саналыг ПДИ тайланд тусгасан. 2.ЦЕГ-аас иргэн, аж ахуйн нэгжид үзүүлж байгаа 23 үйлчилгээний зураглан процесс сайжруулах саналыг ПДИ тайланд тусгасан. |
| | | | | 18.4.3.3 | Мэргэжил, арга зүйгээр хангаж, дэмжлэг үзүүлж, үр дүнг нэгтгэн тайлагнах | тоо | - | - | 1 | 4 | | | | БОУАӨЯ, Ойн газар, ЦЕГ, Дотоодын цэргийн байгууллагыг процессын шинжилгээ хийх, асуудал тодорхойлох чиглэлээр мэргэжил, арга зүйгээр хангаж, дэмжлэг үзүүлж ажилласан. |
| | | | | 18.4.3.4 | Холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг сайжруулах | тоо | - | - | 1 | 2 | | | | БОУАӨЯ, Ойн газар, ЦЕГ-т хийгдсэн процессын дахин инженерчлэлийн ажлын хүрээнд иргэн, аж ахуйн нэгжид үзүүлж буй үйлчилгээнд хууль эрх зүйн орчны шинжилгээ хийсэн. |
| | | 18.4.4 | Хууль ёсыг сахиулж, сахилга, хариуцлагыг дээшлүүлсэн байна. | 18.4.4.1 | Зөвлөмж, албан шаардлага, дүгнэлт, санал, мэдэгдлийг тухай бүр гаргах | тоо | - | - | 50 | 65 | | | | 2025 онд төрийн байгууллага, Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд болон албан тушаалтанд нийт 51 албан шаардлага, 14 мэдэгдлийг хүргүүлсэн. |
| | | | | 18.4.4.2 | Мэргэжил, арга зүйгээр хангаж, дэмжлэг үзүүлж, үр дүнг нэгтгэн тайлагнах | тоо | - | - | 1 | 39 | | | | Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан 15 байгууллагын дотоод хяналт хариуцсан 39 ажилтныг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, зөвлөн чиглүүлж ажилласан. |
| | | | | 18.4.4.3 | Холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг сайжруулах | тоо | - | - | 1 | 41 | | | | 2025 онд 27 удирдамжаар 41 байгууллагад хяналт шалгалт хийсэн. |
| | **МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД** | | | | | | | | | | | | | |
| | | **70708 Гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх** | | | | | | | | | | | | |
| | 19.1 | | | 19.1.1.1 | Шинээр байгуулагдах анги, салбар, нэгж | тоо | 2021 | - | 10 | 5 | | | | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны мн/231 тогтоолоор нийслэлийн хөрөнгө оруулалтаар Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Гал унтраах, аврах III зэрэглэлийн ангийг 4.6 тэрбум төгрөг, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Сэлэнгэ аймгийн Цагааннуур сум дахь Эрэн хайх аврах салбарыг 1.8 тэрбум төгрөг,Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь Гал түймэр унтраах аврах IV зэрэглэлийн ангийг 3.8 тэрбум төгрөг, Дорноговь аймгийн Хатанбулаг сум дахь Гал унтраах, аврах IV зэрэглэлийн ангийн барилгыг аймгийн ЗДТГ-с шийдвэрлэсэн мөн АНУ-ын буцалтгүй тусламжаар 5.4 тэрбум төгрөгөөр “Шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төв” 119 дүгээр ангийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэн Улсын комиссын гишүүдийн дүгнэлтээр тус тус ашиглалтад оруулсан. |
| | | 19.1.1 | Гамшгийн эрсдэлийг бууруулах чадавхыг нэмэгдүүлнэ. | 19.1.1.2 | Гамшгаас хамгаалах техник, тоног төхөөрөмж | тоо | 2021 | 57 | 59 | 34 | 295,098,460.40 | 282,853,282.80 | 95.85% | Онцгой байдлын байгууллагын албаны бэлтгэл, бэлэн байдлыг сайжруулах хүрээнд 2025 оны төсөвт техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, тусгай зориулалтын хувцас хэрэглэл худалдан авахад Улсын төсвийн хөрөнгө оруулалтад 16.3 тэрбум, бусад хөрөнгийн зардалд 7.6 тэрбум төгрөг нийт 23.9 тэрбум төгрөг батлагдсан. Мөн ой хээрийн түймрийн нөхцөл байдал хүндэрсэнтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын 2 удаагийн тогтоолоор нийт 11.7 тэрбум төгрөг шийдвэрлүүлэн дараах байдлаар худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. |

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч | Хөтөлбөр | Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 19 | | | | 19.1.1.3 | Гамшгийн үед ашиглах орчин үеийн дэвшилтэт технологийн хангалт | тоо | 2021 | - | 30 | 25 | | | | Эрэн хайх, аврах ажиллагаанд дулаан мэдрэгчтэй, чанга яригчтай тусгай зориулалтын хайгуулын дрон 60ш, хиймэл дагуулаас интернет хүлээн авах төхөөрөмж /Starlink/ 80ш, 220в зөөврийн цахилгаан цэнэг хураагуур /Ecoflow/ нарны хавтангийн хамт 40ш худалдан авч үйл ажиллагаанд нэвтрүүлснээр ой хээрийн түймэр болон алслагдсан бүс нутагт гамшиг ослын голомтод үүрэг гүйцэтгэж буй бүрэлдэхүүнээс мэдээг мэдээлэл шуурхай дамжуулах удирдлага арга зүйгээр тасралтгүй хангах боломж 100 хувьд хүрсэн. Мөн уснаас эрэн хайх аврах ажиллагааны робот 3 нэр төрлийн 9 ширхэгийг тус тус худалдан авч аврах, эрэн хайх үйл ажиллагаанд нэвтрүүлэхээр туршилтаар ашиглаж эхлээд байна. Онцгой байдлын байгууллагад нэвтрүүлж буй шинэ дэвшилтэд технологийн норм, стандарт, хувь тооцох аргачлалыг батлахаар судалгаа хийгдэж байна. |
| | 19.2 | **70201 Эдийн засгийн хөгжлийн төлөвлөлт** | | | | | | | | | | | | |
| | | 19.2.1 | Бүс, орон нутгийн хөгжлийг нэмэгдүүлнэ. | 19.2.1.1 | Орон нутгийн хөгжлийн индекс | оноо | 2021 | 0.532 | 0.581 | 0.541 | 5,191,978.10 | 4,327,925.80 | 83.36% | Засгийн газрын 2018 оны 20 дугаар тогтоолын дагуу орон нутгаас мэдээлэл нэгтгэн авч тооцоолол хийсэн. |
| | 19.3 | **71201 Чөлөөт бүсийг хөгжүүлэх** | | | | | | | | | | | | |
| | | 19.3.1 | Чөлөөт бүсийг эдийн засгийн эргэлтэд оруулж, хөрөнгө оруулалт татна. | 19.3.1.1 | Чөлөөт бүсүүдийн дэд бүтцийн бэлэн байдлыг хангах арга хэмжээний хэрэгжилт | хувь | 2022 | - | 100 | 82 | 14,331,383.80 | 13,409,409.50 | 93.57% | 2025 оны байгууллагын гүйцэтгэлийн тайланг 3 зорилго 8 зорилтын хүрээнд 39 арга хэмжээ тавьж ажилласан үүнээс 24 арга хэмжээ нь хангалттай буюу 90-100 % үнэлэгдэж, 4 арга хэмжээ нь 80-70 %, 7 арга хэмжээ нь 50-60 %, 4 арга хэмжээ нь хангалтгүй 0%-р үнэлэгдсэн тул хүрсэн түвшин нь 84.4 %-тай гарсан. |
| | | 19.3.2 | Худалдаан дахь техникийн саад тотгорыг арилгах, худалдааг хөнгөвчлөх, бүтээгдэхүүнд хэрэглэгчийн итгэх итгэлийг нэмэгдүүлэх, тохирлын үнэлгээний дүнг олон улс, бүс нутаг болон үндэсний хэмжээнд харилцан хүлээн зөвшөөрөх нөхцөлийг бүрдүүлнэ. | 19.3.2.1 | Итгэмжлэлийн үнэлгээнд хамруулах тохирлын үнэлгээний байгууллага | тоо | 2023 | 97 | 110 | 147 | 911,562.90 | 866,431.50 | 95.05% | Итгэмжлэгдсэн 147 сорилтын болон шалгалт тохируулгын лаборатори, 28 эрүүл мэндийн лаборатори, 40 техникийн хяналтын байгууллага болон 27 баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн жилийн хураамж 452,984,823.00 төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна. |
| | | | | 19.3.2.2 | Олон улсын стандартыг үндэсний стандартаар батлуулсан стандарт | тоо | 2023 | - | 1 | 1 | | | | Авлигын эсрэг менежментийн тогтолцоо /MNS ISO 37001:2017 стандартыг ҮИТ-с орчуулан СХЗГ-ын Стандартчилалын техникийн хороонд хүлээлгэн өгсөн. Авлигын эсрэг менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн схемийн хэрэгжүүлэхтэй холбоотой дараах баримт бичгийг боловсруулж батлуулсан.<br>-MNAS AC 08 Авлигын эсрэг менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн шалгуур-1<br>-Шалгах хуудас/ өөрийгөө үнэлэх хуудас, үнэлгээний маягт |
| | | | | 19.3.2.3 | Олон улс, бүс нутгийн итгэмжлэлийн хамтын ажиллагааны байгууллагын харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээрт зөвшөөрүүлсэн итгэмжлэлийн үр дүн | тоо | 2024 | - | 1 | 1 | | | | Монгол улс Ази Номхон далайн итгэмжлэлийн хамтын ажиллагааны байгууллага (APAC)-ын Олон талт хүлээн зөвшөөрөх хэлэлцээр (MRA)-ийн хүрээнд Авлигын эсрэг менежментийн тогтолцоо (ABMS, ISO 37001)-оор Итгэмжлэлийн хүрээгээ өргөтгөн, албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөнийг баталгаажуулж, харилцан хүлээн зөвшөөрөх хэлцэлд нэгдсэн гэрчилгээг шинэчлэн олгож, Монгол Улсын итгэмжлэлийн тогтолцооны чадавхийг олон улсын түвшинд баталгаажуулан гэрчилгээг хүлээн авсан. |
| | | | | 19.3.2.4 | ISO 37001 авлигын эсрэг менежментийн тогтолцооны стандартын баталгаажуулалтын чиглэлээр итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллага | тоо | 2024 | - | 2 | 1 | | | | Монсертф ХХК ISO 37001 авлигын эсрэг менежментийн тогтолцооны стандартын баталгаажуулалтын чиглэлээр итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллага болж 2025 оны 12 сарын 22-нд итгэмжлэгдсэн. |
| | | | | 19.3.2.5 | Хоёр талт хамтын ажиллагаатай байгууллагуудын хооронд байгуулсан "Харилцан ойлголцлын санамж бичиг"-т тусгасан үйл ажиллагааны хэрэгжилт | тоо | 2024 | 0.5 | 3 | 2 | | | | Үндэсний итгэмжлэлийн төв нь дараах байгууллагуудтай харилцан ойлголцлын санамж бичиг (MoU) байгуулах чиглэлээр идэвхтэй ажиллаж байна. Үүнд:<br>1.Хятадын Итгэмжлэлийн Байгууллага болох CNAS-тай худалдааны техникийн саад тотгорыг бууруулах, ажилтнуудыг чадавхжуулах, туршлага болон мэдээлэл солилцох зорилгоор санамж бичиг байгуулсан.<br>2.Евразийн эдийн засгийн холбооноос Монголын аж ахуйн нэгжүүд, бизнес эрхлэгчдэд зориулан зохион байгуулсан Худалдааны хэлэлцүүлгийн үеэр Монгол Улс Оросын Холбооны Улсын итгэмжлэлийн байгууллагууд хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулж, баталгаажуулсан.<br>3.Казахстаны Итгэмжлэлийн Үндэсний Төв (NCA)-тэй хамтын ажиллагааны төлөвлөгөө баталгаажуулан халал хүнсний бүтээгдэхүүний итгэмжлэлийн чиглэлээр хамтран ажиллах санамж бичгийг боловсруулж хүргүүлсэн.<br>4.Кыргызстаны Итгэмжлэлийн Үндэсний Төв (O'ZAKK)-тэй тодорхой итгэмжлэлийн чиглэлээр санамж бичиг боловсруулж хүргүүлсэн. |
| | | | | 19.3.2.6 | Хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан гадаад улс | тоо | 2024 | 1 | 2 | 1 | | | | Евразийн эдийн засгийн холбооноос Монголын аж ахуйн нэгжүүд, бизнес эрхлэгчдэд зориулан зохион байгуулсан Худалдааны хэлэлцүүлгийн үеэр Монгол Улс Оросын Холбооны Улсын итгэмжлэлийн байгууллагууд хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулж, баталгаажуулсан. |

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч | Хөтөлбөр | Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 19.3.2.7 | Үндэсний авлигын эсрэг хөтөлбөрийн хүрээнд ISO 37001 стандартыг хэрэгжүүлэх арга хэмжээ | тоо | 2024 | 1 | 3 | 3 | | | | 1. Монгол Улсын Шадар сайдын ажлын албанд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд Үндэсний Итгэмжлэлийн төвөөс 2025 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийн явцыг 2025/05/22-ны өдрийн №01/122 албан тоотоор хүргүүлсэн.<br>2.Канадын PECB сургалтын байгууллагаас зохион байгуулсан ISO 37001 стандартын сургалтын Аудиторын сургалтанд 3 мэргэжилтэн хамрагдсан.<br>3. Авлигын эсрэг менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн схемийн хэрэгжүүлэхтэй холбоотой дараах баримт бичгийг боловсруулж батлуулсан. Үүнд:<br>-MNAS AC 08 Авлигын эсрэг менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн шалгуур<br>-Шалгах хуудас/өөрийгөө үнэлэх хуудас, үнэлгээний маягтууд<br>4. Олон улсын стандартчиллын байгууллага (ISO)-ын гаргасан ISO 37001 стандартын танилцуулгыг орчуулж, "Итгэмжлэл" сэтгүүлийн 2 дахь хэвлэлд нийтлүүлж, олон нийтэд сурталчилсан. MNAS P601, MNAS P602 журамд 37001 стандартыг хэрэгжүүлэхтэй холбоотой нэмэлт өөрчлөлт оруулсан.<br>5.ISO 37001 стандартын сургалтыг Монгол Улсад анх удаа 2025/09/16-2025/09/18-ны өдрүүдэд зохион байгуулсан. Сургалтад 7 орны нийт 29 оролцогч хамрагдсан.<br>6.Монсертф ХХК-иас ISO 37001 стандартын баталгаажуулалтаар итгэмжлүүлэх өргөдөл ирүүлсэн ба ҮИТ-ийн даргын 2025/12/01-ний өдрийн 270 дугаар тушаалаар 2 шатны аудитад гэрчлэх үнэлгээ хийсэн. Итгэмжлэлийн үнэлгээ хийж, тайлан гаргаж итгэмжлэлийг шийдвэрлэхээр ажиллаж байна. |
| | | | | 19.3.2.8 | Итгэмжлэлийн лавлагаа, мэдээллийн улсын нэгдсэн сангийн программ, нэвтрүүлсэн программ хангамж | тоо | 2024 | 50 | 80 | 63 | | | | Хүсэлт гаргасан 67 тохирлын үнэлгээний байгууллагын итгэмжлэлийн үйл явцыг цахим систем ашиглан шийдвэрлэсэн. |
| | | **70407 Стандарт, хэмжил зүй** | | | | | | | | | | | | |
| | 19.4 | 19.4.1 | Нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдлыг хамгаалах, стандартчилал, тохирлын үнэлгээний бодлого үйл ажиллагаагаар дэмжлэг үзүүлэх, Монгол Улсын хэмжлийн тогтолцоо, хэмжлийн нэгжийн үндэсний эталон, хууль эрхийн хэмжил зүйн техникийн чадавхыг нэмэгдүүлнэ. | 19.4.1.1 | Шалгалт тохируулга /калибровка/-д хамруулах хэмжих хэрэгслийн тоо /мянган нэгж/ | тоо | 2021 | 8.1 | 8.1 | 10.9 | 40,525,749.80 | 39,143,874.70 | 96.57% | ААНБ-ууд үйл ажиллагааны цар хүрээгээ нэмэгдүүлж байгаа нь шалгуур үзүүлэлтийн тоог нэмэгдүүлж байна. |
| | | | | 19.4.1.2 | Загварын туршилтад хамруулан, улсын бүртгэлд бүртгэх хэмжих хэрэгслийн тоо | хувь | 2021 | 63 | 63 | 79 | | | | Загварын туршилтанд оруулахаар ААНБ-аас ирүүлж буй хэмжүүр, хэмжих хэрэгслийн тоо хэмжээ нэмэгдсэн. |
| | | | | 19.4.1.3 | Ээлжит баталгаажуулалтад заавал хамруулах хэмжих хэрэгслийн тоо /мянган нэгж/ | тоо | 2021 | 265.9 | 265.9 | 495.1 | | | | "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК нь "Ухаалаг тоолуурын систем нэвтрүүлэх төслийн II үе шат"-ны ажлын төлөвлөгөөнд тусгагдсан 1 фазын тарифт электрон тоолуур 121,502 ширхэг, 3 фазын тарифт электрон тоолуур 27,134 ширхэг нийт 148,636 ширхэг тоолуурт анхдагч шалгалт баталгаажуулалтад хамрагдсан.Мөн барилга, байшин шинээр орон сууцны конторууд болон шатахуун түгээгч станцуудын тоо нэмэгдсэнээс ээлхүүн зарцуулалтын хэмжих хэрэгслийн орлого нэмэгдсэн. |
| | | | | 19.4.1.4 | Чанарын удирдлагын тогтолцооны баталгаажуулалтад хамруулах байгууллага, аж, ахуйн нэгж | тоо | 2021 | 162 | 162 | 175 | | | | Сүүлийн жилүүдэд Монгол Улсаас БНХАУ, Иран, Арабын Нэгдсэн Эмират Улс, Казахстан, Хонгконг руу хүнс болон малын мах их хэмжээгээр экспортолж байгаагаас тохирлын үнэлгээний орлого нэмэгдсэн. |
| | | | | 19.4.1.5 | Үндэсний стандартад олон улс, бүс нутгийн дэвшилтэт стандартын эзлэх хувь | хувь | 2021 | 41.5 | 41.5 | 46 | | | | Үндэсний стандартад олон улсын стандартын эзлэх хувь нэмэгдсэн байна. |
| | **МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД** | | | | | | | | | | | | | |
| 20 | | **70410 Зах зээлийн өрсөлдөөн, хэрэглэгчийн эрхийн хамгаалалт** | | | | | | | | | | | | |

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч | Хөтөлбөр | Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 20.1 | 20.1.1 | Зах зээлийн шударга өрсөлдөөний таатай орчныг бүрдүүлсэн байна. | 20.1.1.1 | Зөрчил хянан шийдвэрлэлт | хувь | 2021 | 60 | 75 | 75 | 2,989,442.50 | 2,454,502.27 | 82.11% | Өрсөлдөөнийг хянан зохицуулах чиглэлээр холбогдох хяналт, шалгалтыг хийж гүйцэтгэлээ. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчилд 21 аж ахуй эрхлэгчдэд 52.0 тэрбум төгрөгийн торгууль оногдуулсан. Зөрчлийг арилгуулах, хуулийн хэрэгжилтийг хангуулахаар улсын байцаагчийн хугацаатай 35 албан шаардлага, 1 санал дүгнэлт хүргүүлж, гүйцэтгэлийн хяналт хийж зөрчлийг арилгуулж ажилласан.<br>“Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн ачаа тээврийн тарифын өөрчлөлтийн судалгаа, Төлбөрийн үйлчилгээний QR кодын зах зээлд давамгай байдалтай аж ахуй эрхлэгчийг тогтоох судалгаа хийж, МЭГ-ын хурлаар хэлэлцэн, 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 01 дугаартай тогтоолоор “КKТТ” ХХК-г төлбөрийн үйлчилгээний QR кодын зах зээлд давамгай байдалтай аж ахуй эрхлэгчээр тогтоосон болно. - Аж ахуй эрхлэгчдээс өрсөлдөөний асуудлаар 54 гомдол ирүүлснийг хуулийн хүрээнд хянаж, зохих хариуг албажуулан хүргүүлсэн.<br>- Тайлант хугацаанд нийт 417 аж ахуй эрхлэгчээс захиалагч 147 байгууллагаас зарласан тендер шалгаруулалтын баримт бичигт 804 гомдол ирүүлснийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд хянан шийдвэрлэж, гомдол гаргагч аж ахуй эрхлэгчдэд хариуг албан бичгээр хүргүүлж ажиллаа.<br>-Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.2.2.1 т “Бизнесийн үйл ажиллагаа, шударга өрсөлдөөнд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлийг тодорхойлох суурь судалгааг чиглэл бүрээр үе шаттайгаар зохион байгуулах” гэж тусгасны дагуу Монополын эсрэг газраас салбар бүрийн төлөөлөл нийт 112 аж ахуй нэгж хамруулан судалгааг хийж гүйцэтгэн гарын авлага боловсруулан УИХ-ын нэр бүхий гишүүд болон АТГ-т тус тус хүргүүлсэн. |
| | | 20.1.2 | Хэрэглэгчийн эрхийг хамгаална. | 20.1.2.1 | Хэрэглэгчийн гомдлын шийдвэрлэлт | хувь | 2021 | 50 | 60 | 60 | 1,292,280.40 | 936,196.28 | 72.45 | Тус газар нь 2025 онд иргэд, хэрэглэгчдээс бичгээр 180 өргөдөл гомдол хүлээн авч шийдвэрлэж, хэрэглэгчид учирсан 127.0 сая төгрөгийн хохирлыг барагдуулж, 7 аж ахуй эрхлэгчдэд 53.5 сая төгрөгийн торгууль оногдуулж ажиллалаа. “Хэрэглэгчийн мэдээллийн 115 төв”-д нийт 2,886 иргэн хандсанаас 2,493 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч, 9 иргэний гомдол, мэдээллийг судлан хариу өгөхөөр хүлээгдэж байгаа бөгөөд 16 хэрэглэгчийн гомдлыг өргөдлөөр оруулан, 121 хэрэглэгчийн гомдол хүсэлтийг саналаар хүлээн авч хариу өгөн, 13 иргэний гомдол мэдээллийг хариуцах салбарт шилжүүлж, 237 хэрэглэгчийн гомдлыг эцэслэн шийдвэрлэсэн байна. Үүнээс 237 хэрэглэгчийн 117.7 сая төгрөгийн мөнгөн хохирол барагдуулж, бараа, ажил, үйлчилгээний доголдлыг арилгуулах мөн барааг шинээр сольж өгөх, засвар үйлчилгээ үзүүлэх болон бусад байдлаар ирүүлсэн гомдлыг шуурхай шийдвэрлэн ажилласан байна. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр 5 удирдамжтай хяналт шалгалт, Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн хамтарсан 1 хяналт шалгалт, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдааны 5 дугаар тэмдэглэлийн 4 дэх хэсгээр Монополын эсрэг газарт өгсөн үүргийг хэрэгжүүлэх чиглэлээр 1 хяналт шалгалт, гомдлын дагуу 1 хяналт шалгалтыг хийж, гүйцэтгэсэн. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах, хуулийн хэрэгжилтийг хангуулахаар улсын байцаагчийн хугацаатай 22 албан шаардлага, 8 зөвлөмж, санал хүргүүлж, гүйцэтгэлийн хяналт хийж зөрчлийг арилгуулж ажиллаж, 2 сэрэмжлүүлэг гаргаж олон нийтэд түгээсэн. |
| | | 20.1.3 | Худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулна. | 20.1.3.1 | Тендер шалгаруулалтын урилгыг цахим системд нийтэлсэн байх | хувь | 2021 | 90 | 99 | 96.6 | 1,985,707.60 | 1,939,720.30 | 97.68% | Төрийн худалдан авах ажиллагааны газраас нийт 1,889.5 тэрбум төгрөгийн 87 төсөл, арга хэмжээний 497 багц ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. Энэ хүрээнд 87 төсөл, арга хэмжээний 84 төсөл, арга хэмжээний 494 багцын тендерийн урилгыг цахим системд нийтэлж, тендерийг материалыг цахимаар хүлээн авч, зохион байгууллаа. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 37, 38 дугаар зүйлээр ерөнхий гэрээ байгуулах тендер шалгаруулалтыг зохион байгуулах, цахим дэлгүүрээс захиалга хийх талаар зохицуулсан байдаг. Цахим дэлгүүрээс 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн хооронд 871 захиалагч байгууллага 419 нэр төрлийн барааг 196 аж ахуй эрхлэгчээс 87,787,447 удаагийн захиалгаар 153.4 тэрбум төгрөгийн бараа, үйлчилгээний захиалга хийсэн дүнтэй байна. |
| 21 | **МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА** | | | | | | | | | | | | | |
| | 21.1 | **70103 Гүйцэтгэх засаглалын удирдлага** | | | | | | | | | | | | |
| | | 21.1.1 | Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн мэдээлэл, хөтөлбөр, төслийн мэдээлэл болон үйл ажиллагааны үр дүнгийн мэдээлэл, танилцуулгыг төлөвлөсөн хугацаанд хийсэн байна. | 21.1.1.1 | Хууль болон журамд заасан хугацаанд тайлагнасан эсэх | тоо | 2022 | 6 | 6 | | 79,642,280.10 | 67,223,140.32 | 84% | Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн биелэлт, "Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн хэрэгжилт, Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанд, Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн 2024 оны жилийн хэрэгжилтийн талаар Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанд танилцуулсан. |
| | 21.2 | **70413 Төр, засгийн аж ахуйн үйлчилгээ** | | | | | | | | | | | | |
| | | 21.2.1 | Төр, засгийн төв байгууллага болон хэрэглэгчийн хэвийн үйл ажиллагаанд олон улсын чанарын менежментийн MNS-ISO 9001:2016 стандартыг хангаж ажиллана. | 21.2.1.1 | MNS-ISO 9001:2016 стандартын шаардлагыг хангах | хувь | 2022 | 100 | 100 | | 9,410,113.10 | 8,919,401.79 | 95% | Төр, засгийн төв байгууллагуудын үйл ажиллагааг хэвийн явуулах орчныг бүрдүүлэх нийтлэг үйлчилгээнд MNS-ISO 9001 стандартыг 2006 оноос эхлэн ханган ажилласан ба MNS-ISO 9001:2016 стандартын биелэлтэд Стандарт, хэмжил зүйн газраас стандартын гэрчилгээний баталгаажуулалтыг 2025 онд хийсэн болно. Мөн байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилтын хүрээнд үйл ажиллагаандаа MNS-ISO 45001:2018 стандартыг шинээр нэвтрүүлснээр "нэгдсэн менежментийн тогтолцоо"-той болсон. |
| | **БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД** | | | | | | | | | | | | | |

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч | Хөтөлбөр | Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | **71403 Ойжуулалт** | | | | | | | | | | | | |
| | 22.1 | 22.1.1 | Зориудаар ойжуулах, байгалийн сэргэн ургалтыг дэмжих замаар доройтсон ойг нөхөн сэргээх, ойжуулалтын ажлын үр дүн, чанарыг сайжруулж, мод тарьж ургуулахад мөнгөн урамшуулал олгох эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна. | 22.1.1.1 | Ойжуулж, нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ | мян.га | 2022 | 7.1 | 7.9 | 13 | 49,846,909.00 | 33,490,450.00 | 67% | Улсын төсвийн хөрөнгөөр:<br>1.Ойжуулалт хөтөлбөрийн хүрээнд 2025 онд доройтсон нөхөн сэргээх ойжуулах чиглэлээр Төв аймгийн Батсүмбэр суманд 400 га талбайд 1 сая ширхэг, Мөнгөнморьт суманд 400 га талбайд 1 сая ширхэг нийт 800 га талбайд 2 сая ширхэг тарьцаар ойжуулалтын ажил гүйцэтгэсэн.<br>2. Агро-ойн аж ахуйн байгуулах ажлаар Төв аймгийн Лүн суманд 50 га талбайд 280 мянган ширхэг, Баянхонгор аймгийн Богд суманд 20 га талбайд 112 мянган ширхэг, Өлзийт суманд 10 га талбайд 56 мянган ширхэг навчид модны суулгацаар шинээр агро-ойн аж ахуйн суурин байгуулсан.<br>3. Өмнөговь аймгийн Баяндалай суманд 50 га талбайд 33 мянган ширхэг навчит модны суулгацаар тариалангийн талбайн хамгаалалтын ойн зурвас байгуулсан.<br>4. Шинэ Хархорум хотын ногоон бүсийг ойжуулах ажлын хүрээнд хээрийн бүсэд ойжуулалтыг ажлыг 148.2 га талбайд 87 хяналтын ажлыг гүйцэтгэсэн. Хөвсгөл аймгийн Төмөрбулаг суманд 10 га талбайд 16,500 ширхэг навчит модны суулгацаар ойжуулалтын ажил гүйцэтгэсэн. 2025 онд Улсын төсвийн хөрөнгөөр нийт 1082.2 га талбайд 2,585,454 ширхэг тарьц, суулгацаар ойжуулалтын ажил гүйцэтгэсэн.<br>Орон нутгийн төсвийн хөрөнгөөр:<br>Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нартай хийсэн гэрээний дагуу ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээ, "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 21 аймаг, нийслэлийн хэмжээнд 13891.0 га талбайд доройтсон ойг нөхөн сэргээх, ойжуулах, хамгаалалтын ойн зурвас байгуулах, агро ойн аж ахуйг хөгжүүлэх, төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн байна.<br>Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр нийт 14,973.2 га талбайд ойжуулалт, ойг нөхөн сэргээх ажлыг хийж гүйцэтгэсэн. |
| | | | | 22.1.1.2 | Худалдан авсан таримал ой | мян.га | 2022 | - | 20 | 0 | | | | 2025 оны Төсвийн тодотголоор хасагдсан. |
| | | | | 22.1.1.3 | Дэмжлэг авсан мод үржүүлгийн газар | мян.шир | 2022 | 10 | 50 | 0 | | | | 2025 оны Төсвийн тодотголоор хасагдсан. |
| | | 22.1.2 | Ойн хөнөөлт шавжийн голомттой ойн санд тэмцлийн ажил явуулж, ойн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах менежментийг сайжруулж хомсдол, доройтлыг бууруулж, ойн төлөв байдлыг үнэлсэн байна. | 22.1.2.1 | Ойн хөнөөлт шавжтай тэмцсэн талбай | мян.га | 2022 | 165 | 230 | 247.3 | | | | Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлыг Архангай, Өвөрхангай, Баянхонгор, Хөвсгөл, Төв, Хэнтий, Увс, Завхан, Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай,Дархан-Уул аймгийн ойн санд нийт улсын төсвийн хөрөнгөөр 247.3 мян.га талбайд хийж гүйцэтгэсэн. Үүнд:<br>Ойн хөнөөлт шавжтай агаарын хөлөг ашиглан микробиологийн аргаар 160.0 мян.га, үүргийн шүршигч багаж ашиглан 63.6 мян.га, нисгэгчгүй төхөөрөмж дрон ашиглан 4.2 мян.га, гэрлэн урхи тавих аргаар 7.5 мян.га, өндөг хусаж цуглуулах механик аргаар 12.0 мян.га талбайд хийж гүйцэтгэсэн. |
| | | | | 22.1.2.2 | Ойн хөнөөлт шавжийн судалгаа хийсэн талбай | сая.га | 2022 | 2 | 2 | 2.48 | | | | Ойн хөнөөлт шавж, өвчний тархалт голомтыг тогтоох судалгааны ажлыг 16 аймгийн 130 сум, Улаанбаатар хотын ногоон бүс, Богдхан-уулын ДЦГ, Горхи-Тэрэлжийн БЦГ-ын ойн санг хамруулан 2.4 сая.га талбайд гүйцэтгэсэн. Судалгаагаар ойн хөнөөлт шавжийн тархалттай 806.6 мян.га талбай, голомттой 323.3 мян.га талбай, зайлшгүй тэмцлийн ажил гүйцэтгэх 197.0 мян.га талбай байгаа тогтоосон байна. |
| | | | | 22.1.2.3 | Ой зохион байгуулалтын ажил хийгдсэн талбай | сая.га | 2022 | 1.6 | 5 | 1.5 | | | | Төв аймгийн Алтанбулаг, Аргалант, Батсүмбэр, Баяндэлгэр, Баянжаргалан, Баян-Өнжүүл, Баянхангай, Баянцогт, Борнуур, Жаргалант, Заамар, Лүн, Мөнгөнморьт, Өндөр ширээт, Сүмбэр, Сэргэлэн, Угтаалцайдам, Цээл, Эрдэнэ, Эрдэнэсант, Баянчандмань, Архуст сумдын ойн сангийн 1388.2 мянган га, Нийслэлийн Налайх, Баянзүрх, Хан-Уул, Сонгинохайрхан, Чингэлтэй, Сүхбаатар, Багануур дүүргийн 116.3 мянган га, нийт 1.5 сая га талбайд ой зохион байгуулалтын бэлтгэл, ажил, хээрийн хайгуул судалгааны ажлыг бүрэн хийж гүйцэтгэсэн. |
| | | | | 22.1.2.4 | Түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажил хийсэн талбай | хувь | 2022 | 5 | 5 | 5 | | | | "Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай" Байгаль орчин, уур амьсгалийн сайдын өөрчлөлтийн сайдын 2025 оны 03-р сарын 10-ний өдрийн А/112 дугаар тушаалыг баталж, орон нутаг, тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаадад хүргүүлсэн. Тус тушаалын хавсралтаар хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөны биелэлтийг орон нутагуудаас авч улсын хэмжээнд нэгтгэн ажилалаа. Тушаалын биелэлтийг Улсын Онцгой комисст хүргүүлэхээр ажиллаж байна. Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх хамгаалах чиглэлээр 2025 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:<br>Хил дамнасан түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах зурваст арчилгаа хийх, шинээр байгуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Энэ ажлын хүрээн 2025 онд Увс, Завхан, Сэлэнгэ, Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгуудын хилийн хэсэг, хил давж орж ирэх, хил давж гарах түймрийн эрсдэлтэй газруудад түймрээс хамгаалах 10м өргөн 29,2 км шороон зурвасыг шинээр, 20м өргөн 160 км, 10м өргөн 1249км урт шороон зурвасыг сэргээх ажлыг тус тус гүйцэтгэсэн. Эдгээр ажлуудыг хийж гүйцэтгэснээр нэгж талбад гарсан түймрийн хэмжээг 5 хувиар бууруулж чадсан. |

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч | Хөтөлбөр | Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 22.1.3 | Ойн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулан, 4000 га-д ойн арчилгаа, 3000 га-д цэвэрлэгээний арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. | 22.1.3.1 | Ойн төлөв байдлыг сайжруулах арчилгаа, цэвэрлэгээний арга хэмжээ хэрэгжүүлсэн талбай | мян.га | 2022 | 0.3 | 4 | 5 | | | | 2025 оны ойжуулалт хөтөлбөрийн хүрээнд Архангай аймгийн Цэнхэр Булган, Сэлэнгэ аймгийн Хүдэр, Хэнтий аймгийн Өмнөдэлгэр, Жаргалтхаан, Төв аймгийн Мөнгөнморьт, Улаанбаатар хотын ойн сангаас ойн түймэр, хөнөөлт шавжийн тархалтын улмаас хатаж хуурайшсан, хүчтэй салхи шуурганы улмаас үндсээрэй булгарч унсан мод бүхий 490 га талбайд ойн цэвэрлэгээг хийж шатах материалын нөөцийг багасгаж ажилласан. Ойн арчилгааны арга хэмжээг хэрэгжүүлэх ойн төлөв байдлыг сайжруулах ажлыг нийт 512 га талбайд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг тухайн сумдын Засаг дарга нарын тушаалаар томилсон комиссын шийдвэрийг үндэслэн хүлээн авсан. Аймаг, сум орон нутгийн ард иргэдийн түлээний хэрэгжээнд зориулж, сумын болон сум дундын ойн ангиас 9000 га талбайд ойн цэвэрлэгээний талбайг тусгаарлаж ард иргэдийн түлээний хэрэгцээг хангаж ажилласан. |
| | | | | 22.1.3.2 | Хяналт шалгалт хийх | тоо | 2022 | 6 | 15 | 20 | | | | Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газар, БОУАӨЯ-ны Байгаль орчны Улсын хяналтын газраас Тэрбум модны хүрээнд ойжуулалт хийсэн талбай, ойн хөнөөлт шавжтай тэмцэл хийсэн ажлын үр дүн, ой, хээрийн түймрийн зурвас гаргасан ажил, хууль бус мод бэлтгэлийн хяналт, шалгалтыг 20 гаруй удаа хийж гүйцэтгэсэн. |
| | 22.2 | **71410 Газрын доройтлыг бууруулах, цөлжилтөөс сэргийлэх** | | | | | | | | | | | | |
| | | 22.2.1 | Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч орхигдсон 2000 га талбайд стандартын дагуу нөхөн сэргээлт хийсэн байна. | 22.2.1.1 | Биологийн нөхөн сэргээлт хийсэн жишиг талбай | га | 2022 | 773 | 1000 | 464 | | | | 2025 онд уул уурхайн олборлолтын үйл ажиллагаа явуулж буй 273 аж ахуйн нэгж нийт 1416 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн. |
| | | | | 22.2.1.2 | Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбай | га | 2022 | 2189 | 2500 | 1713 | | | | 367 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийж, Тэрум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд 2.244.590 ширхэг модыг тарьсан байна. Үүнээс "Оюу толгой" ХХК Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд хууль бус үйл ажиллагааны улмаас эвдэрч орхигдсон 5 байршилд 600.1 га талбайд нийгмийн хариуцлагын хүрээнд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж орон нутагт актаар хүлээлгэж өгсөн. |
| | | | | 22.2.1.3 | Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг эрчимжүүлэх, хяналтын тооллого зохион байгуулсан талбай | га | 2022 | 8000 | 8000< | 42076 | 3,488,220.00 | 2,143,809.00 | 61% | Улсын хэмжээнд уул уурхайн хайгуул, олборлолтын улмаас эвдрэлд оруулсан 42,076 (дөчин хоёр мянга далан зургаа) га талбай, барилга, дэд бүтэц, цэргийн бүтээн байгуулалтын улмаас эвдрэлд оруулсан 7,276 (долоон мянга хоёр зуун далан зургаа) га, хууль бус ашигт малтмал олборлолтоос үүдэж эвдрэлд оруулсан 3,143 (гурван мянга нэг зуун дөчин гурав) га, хариуцах эзэнгүй орхигдсон 2,246 га (хоёр мянга хоёр зуун дөчин зургаа) талбай тус тус эвдрэлд орсон бөгөөд улсын хэмжээнд нийт 54,744 (тавин дөрвөн мянга долоон зуун дөчин дөрөв) га талбай эвдрэлд орсон байна. |
| | | 22.2.2 | Цөлжилтийн хүчтэй, нэн хүчтэй зэрэглэл бүхий аймгуудын нутагт газрын доройтлыг бууруулах, нөхөн сэргээх, элсний нүүлтийг сааруулах арга хэмжээг 200 га талбайд хэрэгжүүлсэн байна. | 22.2.2.1 | Байгалийн ургамлыг нөхөн сэргээж, тарималжуулсан талбайн хэмжээ | га | 2022 | 50 | 100 | 70 | | | | 100 га /НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын төсөл, хөтөлбөрийн санхүүжилтээр цөлжилт, газрын доройтлыг бууруулах, нөхөн сэргээх арга хэмжээний хүрээнд Баянхонгор аймагт заган ойн байгалийн сэргэн ургалтыг дэмжиж 100 га талбайг хашиж хамгаалах, говийн баянбүрдийг нөхөн сэргээх ажлыг 70 га талбайд хийж гүйцэтгэсэн./<br>70 га |
| | | | | 22.2.2.2 | Цөлжилтийг сааруулах, элсний нүүлтээс хамгаалах, зурвас байгуулсан талбайн хэмжээ | га | 2022 | 10 | 50 | 35 | | | | |
| | | | | 22.2.2.3 | Бэлчээрийн талбайг хашиж хамгаалан, ургамлын нөмрөгийг нөхөн сэргээсэн талбайн хэмжээ | га | 2022 | - | 50 | 0 | | | | 35 га |
| | | **71404 Усны нөөц, нуур, гол мөрний менежмент** | | | | | | | | | | | | |
| | | 22.3.1 | Гол, горхи, булаг, шанд, рашааны ундаргын эхийг хамгаалах ажлыг эрчимжүүлж, гол мөрний болон хур бороо, цас, мөсний усыг хуримтлуулах, усан сан, хөв цөөрөм шинээр барих, сэргээн засварласан байна. | 22.3.1.1 | Шинээр барьсан хөв цөөрөм | тоо | 2022 | | 7 | 4 | | | | |
| | | | | 22.3.1.2 | Эх, ундаргыг нь хамгаалсан горхи, булаг шанд | тоо | 2021 | 2936 | 3900 | 328 | | | | Нэг сум-Нэг нуур /333 нуур/ хөтөлбөрийн хүрээнд баруун бүсийн гадаргын ус хуримтлуулах хөв цөөрөм байгуулах төсөл хэрэгжүүлэн Говь-Алтай, Ховд, Увс, Завхан аймгийн гадаргын ус хомсдолтой 38 суманд байгуулах 42 хөв цөөрмийн 12 багц ажлын даалгаврыг боловсруулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг ТХААГ-т зарласан.<br>2025 оны 12 сарын 01-ны өдрийн байдлаар “ССТ ОД” ХХК-ийн гүйцэтгэсэн Ховд аймгийн Дөргөн суманд бага төвөгшилтэй 920.0 м3 эзлэхүүнтэй, 2.0 м гүнтэй ус хуримтлуулах хөвийн барилга байгууламжийг 2025 оны 10 дугаар сарын 31-ны өдрийн 35/2025 дугаар комиссын дүгнэлтээр “Эко буянт” ХХК-ийн гүйцэтгэсэн Дарви сумын Хөвхөрийн голыг түшиглэн байгуулсан 55,351.1 м3 эзлэхүүнтэй, 4.0 м гүнтэй ус хуримтлуулах хөвийн барилга байгууламжийг 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 53/2025 дугаар комиссын дүгнэлтийг тус тус үндэслэн ашиглалтад оруулсан байна.<br>Завхан аймгийн Сонгино сумын “Тал булаг”-ийн хөв цөөрмийг "Манант Оргил" ХХК хийж гүйцэтгэн улсын комисст хүлээлгэн өгсөн.<br>Завхан аймгийн Шилүүстэй сумын нутагт бага оврын хөв цөөрөм байгуулах ажлыг “Манант Оргил” ХХК-ийн ажил 90 хувийн гүйцэтгэлтэй хийж, 2026 онд улсын комиист хүлээлгэж өгсөн<br>Завхан аймгийн Цэцэн-Уул сумын нутагт байгуулах хувийн ажлыг “Энх-Өргөө” ХХК,<br>Говь-Алтай аймгийн Хөхморьт сумын Хөлийн усны хөв цөөрмийн ажлыг “Оргил-Өндөр” ХХК-тай гэрээ байгуулж, үлдсэн 7 багц ажил нь оролцогчгүй байсан тул дахин зарласан. |
| | | | | 22.3.2.1 | Хүн амын унд ахуйн ус хангамжийн эх үүсвэрийг тогтоосон хот, суурин газар | тоо | 2022 | 1 | 5 | 4 | | | | Усны нөөцийг бохирдох, хомстохоос сэргийлэх зорилгоор булаг шанд, рашааны эхийг хашиж, хамгаалах ажлыг орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр, хувийн хэвшлийн хөрөнгөөр жил бүр шандын эхийг хашиж хамгаалж тохижуулж байгаа бөгөөд 2025 оны байдлаар нийт 4026 булаг шандыг эхийг хашиж хамгаалсан.<br>2023 онд - 410 булаг, шанд<br>2024 онд - 350 булаг, шанд<br>2025 онд - 330 булаг, шанд |

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч | Хөтөлбөр | Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 22.3 | 22.3.2 | Хот, суурин газрын хүн амын ус хангамжийн болон үйлдвэрлэлийн усны эх үүсвэрийн хайгуул судалгаа хийж, усны нөөцийг тогтоож, баталгаажуулсан байна. | 22.3.2.2 | Гидрогеологийн дунд масштаб /1:200000/-ын зураглал хийсэн талбай | хувь | 2022 | 15.3 | 17 | 17.8 | 14,847,782.00 | 11,623,530.00 | 78% | “Гидрогеологийн дунд масштабын зураглалын ажлыг өргөжүүлэх” зорилтын хүрээнд 2023 онд Өмнөговь аймгийн Манлай, Цогтцэций, Дундговь аймгийн Өлзийт, Дорноговь аймгийн Мандах сумын нутагт (L-48-XXXV, L-48-XXXVI), 2024 онд Дорноговь аймгийн Өргөн, Алтанширээ, Иххэт, Дэлгэрэх сумдын нутаг (L-49-XXI (бүтэн), L-49-XXVII (хагас) хавтгай)-т 1:200000 масштабтай зураглалын ажлыг улсын төсвийн хөрөнгөөр хийсэн.<br>Тус ажлын гүйцэтгэлийн тайланг Усны газарт ирүүлсэн бөгөөд ажлын үр дүнд гидрогеологийн дунд масштабын зураглал хийгдсэн газар нутгийн хэмжээг 17.8%-д хүргэсэн. |
| | | | | 22.3.2.3 | Рашааны ордын нөөцийн дахин үнэлгээ хийсэн орд | тоо | 2022 | 2 | 4 | 1 | | | | Монгол улсын хэмжээнд хайгуул судалгаа хийж, нөөцийг баталгаажуулсан 25 рашааны орд байна. Үүнээс эхний ээлжид 5 рашааны ордын нөөцийн дахин үнэлгээг хийх шаардлагатай байна.<br>Монгол орны рашааны ордуудын гидрогеологийн болон гидробиологийн судалгаа хийх, монгол орны рашааны нэгдсэн каталоги, мэдээллийн сан үүсгэх ажлыг 2024 онд “Усны нөөц, нуур, гол мөрний менежментийн хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэх төсвийн саналыг хүргүүлсэн боловч Улсын төсөв болон хөтөлбөрийн зардалд суугаагүй.<br>2025 онд Шаргалжуутын рашааны ажлын даалгаварыг батлуулж тус онд Усны нөөцийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж. 2026.01.29-ний өдөр БОУАӨС-ийн А/135 дугаар тушаалаар нөөцийг баталгаажуулсан. |
| | | 22.3.3 | Усны нөөцийг бохирдож, хомстохоос хамгаалж, гадаргын болон газрын доорх усны хяналт шинжилгээний ажлыг хэрэгжүүлсэн байна. | 22.3.3.1 | Туул голын хурдсыг цэвэрлэсэн хэмжээ | км | 2022 | - | 5 | 0 | | | | Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 53 дугаар тогтоолоор МУ-ын Засгийн Газар, АНУ-ын Мянганы сорилтын корпорацийн хооронд байгуулсан Мянганы сорилтын хоёр дахь компакт гэрээ хүчин төгөлдөр болох урьдчилсан нөхцөлийг хангах зорилгоор “Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх төлөвлөгөө”-нд тусгагдсан ажлын хүрээнд БОУАӨ яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024.08.14-ны өдрийн 03/3759 тоот албан бичгийн дагуу Усны газрын даргын 2024.08.26-ны өдрийн А/123 тушаалаар “Гол, нуурын ёроолын хурдас, лаг цэвэрлэх тоног төхөөрөмжийг ажиллагаанд оруулах, ажил эрчимжүүлэх зорилгоор ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг томилож Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэр болох Сонгиноны гүүрийн баруун талд Инженер геологи номт ХХК, Герман улсын Schauenburg MAB-ийн 2 инженер, БНХАУ-ын 1 инженерүүдтэй хамтарч 2024.10.14-18 хооронд Catfish-г тоног төхөөрөмжийг туршилтаар амжилттай ажиллуулсан. БОУАӨСайдын 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/275 дугаар "Төсвийн зардлын хуваарьт өөрчлөлт оруулж, эрх шилжүүлэх тухай" тушаалаар 2025 оны А/78 дугаар тушаалыг хүчингүй болгосноор Говийн бүсийн 3 аймгийн суурин газрын усны чанарт үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах ажлын 200 сая төгрөг хасагдаж, ажлыг зогсоосон байна. |
| | | | | 22.3.3.2 | Ус бохирдуулагчийн тоо /тооллогын мэдээ, тайлан/ | тоо | 2022 | - | 320< | 309 | | | | Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан стандартуудыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах хүрээнд Хаягдал усны дүгнэлтийг  албан бичиг болон ewater.mn цахим системээр  гаран өгч байна. Үүнд: 2023 онд 174, 2024 онд 178, 2025 онд 280 хүсэлтийг шийдвэрлэсэн. |
| | | | | 22.3.3.3 | Хяналт шинжилгээний цооног | тоо | 2022 | 309 | 344 | 345 | | | | 2025 оны жилийн эцсийн байдлаар газрын доорх усны хяналт шинжилгээний 342 цэгийн мэдээллийг www.groundwater.mn нэгдсэн сүлжээнд холбогдсон. Газрын доорх усны нэгдсэн сүлжээ www.groundwater.mn цахим хаягийг хөтөлж мэдээллийн баазыг бэхжүүлэх ажил үргэлжилж байна. Монгол орны 21 аймгийн 81 сум, Улаанбаатар хотын 9 дүүргийг хамарсан 342 цэг ажиллаж байна. Үүнд: Бүрэн автомат – 88, Хагас автомат – 252, Гар хэмжилт – 2, 2026 оны эхний хагас жилийн үр дүнгийн тайлангаар газрын доорх усны хяналт шинжилгээний 345 цэг ажиллаж байна. |
| | | | | 22.3.3.4 | Урсгал засвар хийсэн газрын доорх усны хяналт-шинжилгээний цооног | тоо | 2022 | 0 | 50 | 16 | | | | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд Улсын усны нэгдсэн сүлжээнд холбогдсон цэгүүдэд суурилуулсан хэмжилтийн багаж, төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хянах болон гэмтэл, засварын тайланг нэгтгэн гаргасан.<br>Тус ажлын хүрээнд Газрын доорх усны хяналт-шинжилгээний нэгдсэн сүлжээний гэмтэлтэй 126 цэгийн багаж тоног, төхөөрөмжийг улсын хэмжээнд засварлан шинэчлэж,  цооногийн хэвийн ажиллагааг ханган Усны газарт тайланг  хэлэлцүүлэн хүлээн авсан. 2025 онд Улсын төсвийн хөрөнгөөр газрын доорх усны хяналт-шинжилгээний багаж тоног төхөөрөмжийг засварлаагүй. |
| | | **71405 Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт** | | | | | | | | | | | | |
| | | | | 22.4.1.1 | Улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хэмжээ | хувь | 2022 | 21 | 23 | 20.8 | | | | Монгол Улсын Их Хурлын 2019 оны 41 дүгээр тогтоол, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 46 дугаар тогтоолоор улсын тусгай хамгаалалтад 33 газрыг авсан бөгөөд үүнээс  БНГ болон Дурсгалт газрын  цэнгэг усны нөөц, урсац бүрэлдэх эх болох олон улсын ач холбогдол бүхий ус намгархаг газрууд болох нийт 19 газрын хилийн заагийг Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 24-ний 106 дугаар тогтоолоор баталсан. Ингэснээр  Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 20.8 хувь буюу 32.5 сая га талбайг улсын тусгай хамгаалалтад хамруулж, нэгдсэн сүлжээг бүрдүүлээд байна. Улсын тусгай хамгаалалттай газар нутагт цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрдэх эхийн 7.2 сая га талбай буюу 50 хувь, ойн сангийн  40 хувь нь хамрагдсан байна. |

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч | Хөтөлбөр | Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 22 | 22.4 | 22.4.1 | Цэнгэг усны нөөц, урсац бүрэлдэх эх, ойн сан бүхий газар, биологийн олон янз байдлын хувьд чухал газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах судалгаа хийж, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 23 хувьд хүргэж, сүлжээг өргөжүүлсэн байна. | 22.4.1.2 | Тусгай хамгаалалтад авахаар судалгаа хийсэн газар нутгийн хэмжээ | мян.га | 2022 | 600 | 600 | 6.2 | 32,986,343.00 | 30,421,989.00 | 92% | Байгаль орчны тэнцвэрт байдлыг хадгалах зорилгоор байгалийн бүс, бүслүүрийн онцлог хэв шинж, унаган төрх, байгалийн өвөрмөц тогтоц, түүх, соёл, шинжлэх ухаан, танин мэдэхүй, экологийн хувьд онцгой ач холбогдол бүхий 21 газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авахаар Улсын Их Хурлын тогтоолын төсөл, үзэл баримтлалыг боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэн тус яамнаас тандан судалгаа, үр дагаврын үнэлгээний судалгаа хийхээр ирүүлсэн чиглэлийн дагуу мэргэжлийн байгууллагатай хамтран судалгааг хийж байна. Мөн экологийг чухал ач холбогдол бүхий ойн сан, усны урсац бүрдэх эхийн зарим газар нутгийг Улсын тусгай хамгаалалтад авах урьдчилсан жагсаалтыг БОУАӨСайдын 2025 оны А/74 дүгээр тушаалаар баталж, Хангайн бүсэд зохион байгуулагдсан Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. |
| | | | | 22.4.1.3 | Тусгай хамгаалалттай газар нутгийн экосистемийн үнэ цэн, ач холбогдлыг олон нийтэд сурталчлан таниулах үйл ажиллагаа | тоо | 2022 | 1 | 2 | 2 | | | | Хөвсгөл, Ховд аймгуудад Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаадыг бүсчилсэн байдлаар 2 удаа сургалт зохион байгуулж, нийт 120 гаруй албан хаагч оролцуулсан. “Байгаль хамгаалагчийг мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр”-ыг БНБЗГ-тай хамтран боловсруулж БОАЖ-ын сайдын 2024 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн А/189 тушаалаар батлуулсан. Уг хөтөлбөрийн дагуу Горхи-Тэрэлжийн БЦГ-т орон нутгийн 30 гаруй албан хаагч хамруулсан сургалт зохион байгуулсан.<br>- Ирвэс хамгаалах сантай хамтран 2025 оны 01 дүгээр сарын 20-21-ний өдрүүдэд "Гэмт хэргийн газарт мөрдлөг хийх CSI" сургагч багш бэлтгэх сургалтад Хөвсгөлийн БЦГ, Улаан тайгын УТХГ-ын 5 албан хаагч 06 дугаар сарын 10-12-ны өдрүүдэд “Зэрлэг амьтны хууль бус ангийн газарт үзлэг шалгалт хийх сургагч багш бэлтгэх” сургалт зохион байгуулж 4 албан хаагчид гэрчилгээ олгов.<br>- GIZ SPACES төслөөс “Сошиал медиаг үр дүнтэй ашиглах нь”сэдэвт сургалтад 11 сарын 13-14-ний өдрүүдэд 8 албан хаагчийг хамруулсан.<br>- “Зэрлэг амьтан, ургамлын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний чадавхыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд “Байгаль хамгааллын хууль сахиулах үндсэн ур чадвар”-ын сургалтад 10 сарын 05-10-ны өдөр 10 албан хаагч хамтрагдсан.<br>- KFW төслийн санхүүжилтээр 2025 оны 01 дүгээр сарын 13-17-ны өдрүүдэд Хустайн нурууны БЦГ-т “Байгаль хамгаалагчдыг мэргэшүүлэх анхан болон дунд шатанд сургалт”-д нийт 15 байгаль хамгаалагчийг хамруулан сертификат олгов. |
| | | 22.4.2 | Тусгай хамгаалалттай газар нутгийн эрх зүйн орчныг шинэчилж, олон талын оролцоотой хамгааллын менежментийг хэрэгжүүлж, чадавхыг бэхжүүлсэн байна. | 22.4.2.1 | Аялал жуулчлалын нөөц, даацыг тодорхойлох судалгаа хийсэн тусгай хамгаалалттай газар | тоо | 2022 | 10 | 10 | 10 | | | | Дархан цаазат газруудын Дорнод хамгаалалтын захиргааны "Шувуу ажиглах аялалын нөөц даацын судалгаа"-ны ажлыг хийж байна. Мөн “Тусгай хамгаалалттай газар нутгийн хурдасгуур” хөтөлбөрийн хүрээнд сонгогдсон 15 захиргаанаас зарим хамгаалалтын захиргаанд судалгааны ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. |
| | | | | 22.4.2.2 | Газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлан хэрэгжүүлсэн тусгай хамгаалалттай газар | тоо | 2022 | 11 | 12 | 12 | | | | 2026 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний саналуудыг боловсруулан 20 хамгаалалтын захиргааны 1010 нэгж талбар бүхий 1148 га газрын солбицолын хамт Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2026 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн А/115 дугаар тушаалыг батлуулсан. Монгол дагуурын ДЦГ, Говийн Их дархан цаазат газрын А, Б хэсэг, Бага газрын чулуу БНГ, Сутай хархан БНГ, Алаг хайрхан БНГ, Ээж хайрхан уул БНГ зэрэг 15 хамгаалалтын захиргааны 2025 оны менежментийн төлөвлөгөөг хянаж, сайжруулан, БОУАӨ-ийн сайдаар батлуулж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа. |
| | | | | 22.4.2.3 | Хамгааллын менежментийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлж байгаа тусгай хамгаалалттай газар | тоо | 2022 | 4 | 5 | 7 | | | | Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 32.2 дахь хэсгийн дагуу Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэхээр 7 байгууллагатай хамтын ажиллагааны менежментийн гэрээг байгуулав. Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд 1 аж ахуйн нэгжийн төлөөлөлтэй хамтын ажиллагааны санамж бичгийг байгуулсан. "Тусгай хамгаалалттай газар нутгийн хамтын менежментийн загварын судалгаа"-ны ажлыг Өнө мөнхийн Монгол хөтөлбөр төслийн багийнхантай хамтран хийж, менежментийн гэрээ хийх байгууллагуудад тавигдах шалгуур үзүүлэлтийг боловсруулав. |
| | | 71412 Хүрээлэн байгаа орчны судалгаа, шинжилгээ | | | | | | | | | | | | |
| | | | | 22.5.1.1 | Судалгаа хийсэн ургамал газарзүйн тойргийн тоо, нөөц тогтоосон ургамлын зүйл | тойргийн | 2022 | 150/2 | 300/7 | 2868.65 | | | | Дорноговийн цөлөрхөг хээр, Говь-Алтайн уулын цөлөрхөг хээр, Алтайн өвөр говийн ургамал газарзүйн тойргийн ургамалжлын судалгаа хийн, 150 зүйл ургамлын тархац нөөцийг тогтоох судалгааны ажлын зардлыг Мазаалай хөтөлбөрийн зардалд тусгасан боловч, төсөв хасагдаж ажил хийгдээгүй байна. |
| | | | | | | зүйлийн тоо | | 2 | 7 | 6 | | | | |
| | | | | 22.5.1.2 | Олон улсын улаан дансны үнэлгээгээр үнэлсэн ургамлын зүйл | тоо | 2022 | 500 | 1500 | 1500 | | | | Монгол орны гуурст 1290 зүйл, хөвд 63 зүйл, замаг 24 зүйл, мөөг 29 зүйл, хаг 30 зүйл нийт 1436 зүйл ургамалд үнэлгээ хийж улсын улаан дансны үнэлгээгээр үнэлж "Монгол орны улаан данс 4 дүгээр цуврал"-ыг хэвлүүлсэн. |
| | | | | 22.5.1.3 | Экологи-эдийн засгийн үнэлгээг тогтоосон ургамлын зүйл | тоо | 2022 | 2500 | 3000 | 3000 | | | | БОУАӨ-ийн сайдын 2025 оны А/75 дугаар тушаалаар зарим зүйл нэн ховор, ховор, элбэг ургамлын экологи эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлуулсан. |

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч | Хөтөлбөр | Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 22.5.1 | Ашиглалтад өртөмтгий ургамал, амьтны биологийн болон ашиглалтын нөөцийг тогтоож, экологи-эдийн засгийн үнэлгээг шинэчилсэн байна. | 22.5.1.4 | Нөөц тогтоосон амьтны зүйлийн тоо | тоо | 2022 | 2 | 2 | 2 | | | | 4.Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг Алсын хараа-2050, Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах конвенцын (CMS) хүрээнд хамгаалал нэн шаардлагатай нэн ховор, ховор хөхтөн амьтдыг хамгаалах төлөвлөгөөг боловсруулж, БОУАӨ-ийн сайдын 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн А/208 дугаар тушаалаар батлуулан, холбогдох талуудад хүргүүлэн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Энэ төлөвлөгөөнд Мазаалай баавгай, Хавтгай тэмээ, Тахь адуу, Монгол бөхөн, Цоохор ирвэс, Баданга хүдэр, Хулан адуу, Аргаль, Халиун буга зэрэг амьтдыг хамруулсан.<br>5.Хулан хамгаалах төлөвлөгөөний хүрээнд Өмнийн говиос зүүн тийш, түүхэн тархац нутгийн зүг чиглэсэн Хулангийн нүүдэл нэмэгдэж, төмөр замыг хөндлөн гарах оролдлого ажиглагдаж байгааг судлаач нар онцолж байна. Иймд хулангийн нүүдлийг дэмжих, бодлогын хэрэгжилтийг сайжруулахын тулд талуудын хамтын ажиллагаа, төрийн байгууллагуудын оролцоог хангахын тулд 5-р сарын 28-нд Улаанбаатар хотноо зөвлөлдөх уулзалтыг зохион байгууллаа. Уг уулзалтад БОУАӨЯам, Хил хамгаалах ерөнхий газар, Байгаль зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэг, Улаанбаатар төмөр зам, Дорноговь аймгийн ЗДТГ, Замын үүд сумын ЗДТГ, Байгаль орчны газар зэрэг байгууллагын төлөөллүүд оролцож, хулангийн нүүдлийг чөлөөтэй нэвтрүүлэх талаар хамтын ажиллагаагаа уялдуулж, хэрэгжүүлэх ажлын төлөвлөлтөө хийлээ. Уг төлөвлөгөөний дагуу ажлыг эрчимжүүлэх зорилгоор Байгаль зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэгээс Хил Хамгаалах Ерөнхий газрын #0108 дугаар анги, #0129 дугаар анги, Улаанбаатар Төмөр Зам (УБТЗ) ХНН-ын Замын 4-р анги, Дорноговь аймгийн Байгаль орчны газар, Замын-Үүд сумын Засаг даргын тамгын газар, Замын-Үүд сумын Эдийн засгийн чөлөөт бүсийн захирагчийн алба, Өргөн сумын Засаг даргын тамгын газар, Эрдэнэ сумын Засаг даргын тамгын газруудад дахин сургалт өгч, мэргэжлийн зөвлөмжөөр хангах уулзалтыг 8 дугаар сард зохион байгууллаа.<br>6.Хавтгай тэмээ хамгаалах зорилтын хүрээнд Английн хавтгай хамгаалах сантай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулав. Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд ГИДЦГ-ын орчны бүсийн Толь булагт байрлаж байгаа хавтгай үржүүлгийн төвд дэмжлэг үзүүлэн ажиллах юм. Уг ажлын хүрээнд Толь булагт Хавтгай тэмээг үржүүлэх төвийг Монголын хавтгай хамгаалах сан хариуцан ажлыг эхлүүлээд байна.<br>7.Монгол Улс дахь Цоохор ирвэсийн судалгаа, хамгааллын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагыг хэлэлцэх зорилгоор 2025 оны 9-р сарын 5-ны өдөр холбогдох талуудын хамтын оролцоотойгоор "Цоохор ирвэсийн судалгаа хамгааллын үндэсний чуулган"-ыг зохион байгууллаа. Чуулганы үр дүнд Цоохор ирвэс хамгаалах үндэсний сүлжээний ажлын хэсэг байгуулах, нутгийн иргэдэд түшиглэсэн хамгаалал зөвлөмж бодлогыг учлдуулах, шугаман дэд бүтцийн төлөвлөлтөд хамгааллын стандартыг нэвтрүүлэх, нэн ховор, ховор амьтныг хамгаалах үндэсний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад оролцогч талуудын үйл ажиллагаа уялдуулах зэрэг саналууд гарч, орон нутгийн БОГ, УТХГ-ын захиргаалал чиглэл өгч ажиллаж байна. Мөн |
| | | | | 22.5.2.1 | Хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлсэн нэн ховор, ховор амьтан, ургамал | тоо | 2022 | 5 | 4 /ургамал 2, амьтан 2/ | 4 | 1,838,441.00 | 106,866.00 | 6% | 2025 онд Ховор амьтдын нөөцийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 30 халиун бугыг Булган, Архангай аймагт сэлгэн нутагшуулах ажлыг төрийн хувийн хэвшлийн түншлэлээр, Богд хан уулын ДЦГ-аас 27 янгир ямааг Хэнтий, Архангай аймагт төр хувийн хэвшлийн түншлэлээр, Өмнөговь аймгийн Баяндалай сумаас 14 янгирыг Ноён сумын нутагт сэлгэн нутагшуулах ажлыг орон нутгийн хөрөнгөөр гүйцэтгэх ажил хийгдлээ. БОУАӨ-ийн яамнаас ШУА-ийн Биологийн хүрээлэнгээр дүгнэлт гаргуулж, дүгнэлтийг үндэслэн холбогдох зөвшөөрлийг олгож, хэрэгжилтэд хяналт тавин ажиллав. Мазаалай хамгаалах төлөвлөгөөний хүрээнд 2.7 тэрбум тэрбум төгрөгийн зардал батлагдсан боловч төсвийн тодотголоор хасагдаж, 2.2 тэрбум төгрөгийн төсвийн задаргааг 2025.09.04-ний А/707 дугаар тушаалаар баталсан. Тушаалын дагуу БОУАӨЯ-ны төрийн нарийн бичгийн даргад эрх шилжүүлсэн 23 арга хэмжээний 12 нээлттэй тендер, 11 гэрээг байгуулан 100% гүйцэтгэлтэй ажиллаж байна. Мазаалай баавгайн талаар хүзүүвч зүүх, автомат камер, уст цэг, идэш тэжээл, өвчлөлийн зэрэг цогц судалгаанууд хийгдэж, хяналт шалгалтыг сайжруулах, идэш тэжээлийн шинэ найрлага бүхий нөөц бэлтгэх, усан хангамжийг нэмэгдүүлэх, генетикийн судалгааны төхөөрөмжөөр хангах, судлаач оюутнуудыг дэмжих, хүүхэд залуус, олон нийтэд үндэсний бахархалт амьтныг таниулах олон талт арга хэмжээг зохион байгууллаа. |

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч | Хөтөлбөр | Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 22.5 | 22.5.2 | Нэн ховор, ховор амьтан, ургамлыг хамгаалах, нөхөн сэргээх, генийн санг хадгалах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. | 22.5.2.2 | Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт | хувь | 2022 | 28 | 40 | 45.15 | | | | Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, холбогдох хурмын хэрэгжилтийг сайжруулах ажлын хүрээнд НҮБХХ-ийн Биофин II төслтэй хамтран Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын зарим хэсгээр байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээний зардалд төлөвлөх, хуваарилах, санхүүжүүлэхэд тулгамдаж байгаа асуудал, тэдгээрийг шийдвэрлэх боломж сэвдээр судалгааны тайлан боловсруулсан. Мөн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний төсөв зардлын мэдээллийн сангийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой сургалтыг "Өнө мөнхийн Монгол" хөтөлбөрийн төслийн зохицуулах нэгжтэй хамтран 21 аймаг,нийслэлийн хэмжээнд зохион байгуулж төрийн болон төрийн бус байгууллагын 400 орчим хүн хамруулан зохион байгуулсан. Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн оролцогч талуудын харилцаа, хамтын ажиллагаа, итгэлцэлийг нэмэгдүүлэх, эв нэгдлийг бэхжүүлэх зорилгоор тус яам нь Дэ Нэйчэ Консерванси байгуууллагатай хамтран нөхөрлөл байгуулж нутаг усандаа эзэн болъё  уриан дор "Нөхөрлөл хөгжлийн наадам" 2025 оны 06 дугаар сарын 27-30-ны өдрүүдэд 7 бүсийн нөхөрлөлийн уулзалт, хэлэлцүүлэг Хөвсгөл аймгийн Хатгал суманд зохион байгуулсан. Тус уулзалт, хэлэлцүүлэгт Дорнод, Хөвсгөл, Хэнтий, Ховд, Говь-Алтай  аймгийн 28 сумын 320 нөхөрлөлийн  400 орчим гишүүд, TNC байгууллагын төлөөлж Азийн бүсийн 3 зөвлөх, Монгол дахь хөтөлбөрийн газраас 8 төлөөлөгч, БОУАӨЯ-аас 2 албан хаагч төлөөлөн тус тус оролцсон. Тус уулзалтаар  Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн үйл ажиллагааг бэхжүүлэх,  дамжуулан талаар дундын сангийн бүрдүүлэлт, санхүүжилтийг  харилцан туршлага солилцсон. Дэ Нэйче Консерванси байгууллага, Ирвэс хамгаалах сан, НҮБХХ-ийн Ensure төслтэй хамтран БНХМ-ийн нөхөрлөлийн үйл ажиллагааг бэхжүүлэх ажлын хүрээнд Говь-Алтай-1, Дорнод-4, Хэнтий-15, Ховд-6, Өмнөговь-2, Архангай-4, Баянхонгор-2, Завхан-7 аймгийн нийт 24 суманд Байгалийн нөөцийн хамтын менежментийн 41 нөхөрлөл шинээр  байгуулж мэдээллийг нэгтгэн цахим системд оруулахад бэлтгэн ажиллаж байна. |
| | | | | 22.5.2.3 | Генетик нөөц, түүнтэй холбоотой уламжлалт мэдлэгийг бүртгэлжүүлэх чадавхжуулах сургалтад хамрагдсан хүн | хүний тоо | 2022 | 80 | 100< | 100 | | | | Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.4 дэх хэсэгт “Өмнөх Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд хэлэлцэж батлаагүй хууль, тогтоолын төслийг хууль санаачлагчид нь буцаасанд тооцно.” гэж заасны дагуу Генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэг ашигласны үр шимийн төлбөрийн тухай хуулийн төсөл, холбогдох судалгаа, тайланг шинэчлэн боловсруулсан. Хуулийн ажлын хэсгийг 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн БОУАӨ-ийн сайдын А/851 тоот тушаалаар шинэчлэн байгуулсан бөгөөд ажлын хэсгийн гишүүдийг холбогдох судалгаа, тайлан, мэдээллээр хангасан. Генетик нөөц, генетик нөөцтэй холбоотой уламжлалт мэдлэг ашигласны үр шимийн төлбөрийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг шинэчлэн батлуулахаар 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 01/4986 тоот албан бичгээр, 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр 01/154 тоот албан бичгээр, 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдөр 01/1317 тоот албан бичгээр, 2025 оны 04 дүгээр сарын 29-ны өдөр 01/2205 тоо албан бичгээр, 2025 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 01/3679 тоот албан бичгээр нийт 5 удаа СЯ-д хүргүүлсэн. Иймд 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр үзэл баримтлалыг дахин батлуулахаар албан бичгийг хүргүүлж, 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 01/10326 тоот албан бичгээр Сайгийн сайд батлан ирүүлсэн. ХЗДХ-ийн сайдаар батлуулахаар 2025 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 01/4839 тоот албан бичгээр хуулийн үзэл баримтлалыг батлуулахаар хүргүүлсэн. Тус хуулийн ажлын хэсгийн хурлыг 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулсан. Хуулийн үзэл баримтлал, хуулийн төсөл, тандан судалгааны тайлан, зардлын тооцоог боловсруулсан. Тус хуулийн үзэл баримтлалыг 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр ХЗДХ-ийн сайд, Сангийн сайд, БОУАӨ-ийн сайд нар хамтран баталсан. Тус хуулийн төсөлд санал авахаар 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 01/6502 тоот албан бичгээр яамдуудад хүргүүлсэн. Хуулийн төсөл, үзэл бримтлал, холбогдох тайлан, судалгааг бүрэн боловсруулсан. |
| | | | | 22.5.2.4 | Харь зүйлийн эрсдэлийн үнэлгээ хийсэн тайлан | тайлан | 2019 | 1 | 1 | 1 | | | | Дорноговийн цөлөрхөг хээр, Говь-Алтайн уулын цөлөрхөг хээр, Алтайн өвөр говийн ургамал газарзүйн тойргийн ургамалжлын судалгаа хийн, 150 зүйл ургамлын тархац нөөцийг тогтоох судалгааны ажлын зардлыг Мазаалай хөтөлбөрийн зардалд тусгасан боловч, төсөв хасагдаж ажил хийгдээгүй байна. |
| | | **71406 Хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтол** | | | | | | | | | | | | |
| | | | | 22.6.1.1 | Улаанбаатар хотын агаар дахь PM2.5 тоосонцрын агууламж | мкг/м3 | 2022 | 41 | 31 | 37 | | | | Улаанбаатар хотын агаар дахь PM2.5 тоосонцрын 2025 оны жилийн дундаж агууламж 37 мкг/м3 байна. Харин 2024 онтой харьцуулахад 8 мкг/м3-ээр буюу 18 %-иар бага, зорилтот түвшнээс 6 мкг/м3 их байна. |
| | | | | 22.6.1.2 | Агаарын чанарын иж бүрэн автомат суурин харуул суурилуулсан аймаг, суурин | ширхэг | 2022 | 2 | 5 | 21 | | | | БНСУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар 2025 онд 21 аймгийн төвд 24 цагийн тасралтгүй хэмжилтийн автомат харуулыг суурилуулж хүлээлгэн өгсөн. |
| | | | Орчны чанар, төлөв байдал, бохирдолд | 22.6.1.3 | Бохирдол өндөртэй голуудад хийсэн цэвэрлэгээний ажлын хэмжээ | км | 2022 | Т | 30 | 45 | | | | Туул голын ёроолын хурдас цэвэрлэх ажил 45 км-ийн ажилд холбогдох төсөв батлагдаагүй учраас тухайн ажил гүйцэтгэлгүй байна. Харин тус ажлыг хэрэгжүүлэхээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүсэлтийг тавьснаар хөрөнгийг шийдвэрлэхээр ажиллаж байна. |

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч | Хөтөлбөр | Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 22.6 | 22.6.1 | Орчны чанар, төлөв байдал, бохирдолд нөлөөлөх хүчин зүйлийн иж бүрэн судалгааг хийж, бохирдлын эрсдэлийг бууруулсан байна. | 22.6.1.4 | Хөвсгөл нуурын бохирдлын эрсдэлийг бууруулах ажлын гүйцэтгэл | хувь | 2022 | 40 | 70 | 75 | 82,002,894.00 | 69,528,313.00 | 85% | 75 хувь /БОАЖЯ, ОБЕГ, ЗХЖШ, ШУТИС-ийн эрдэмтэн багш, цэргийн зөвлөх инженерийн бүрэлдэхүүн, Зэвсэгт хүчний 186, 234 дүгээр ангийн алба, Онцгой байдлын газрын аврагчид 2020-2023 онд Хөвсгөл нуураас татан гаргасан "Сүхбаатар" хөлөг онгоц, 7 нэгж техник хэрэгслээс 34.7 тн бохир шатахуун, тос тосолгооны материал, Сүхбаатар хөлөг онгоцны ёроол хэсгээс 13 тн бохир, нийт 47.7 бохир шатахуун, тос тосолгооны материалыг Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Хатгал тосгоны захирагчийн ажлын албатай хамтран нотломж үйлдэж, зориулалтын газарт холбогдох дүрэм, зааврын дагуу устгах ажлыг зохион байгуулсан. "Хөвсгөл нуурт живсэн тээврийн хэрэгслийг эрэн хайх, илрүүлэх, татан гаргах ажиллагаа"-ны 2023 оны тайлан, зурган цомгийг БОАЖЯ, Ажлын хэсгийн дарга болон холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгсөн./ |
| | | | | 22.6.1.5 | Хөрсний нянгийн бохирдлын судалгаа | мян.км2 | 2022 | Т | 4.7 | 4.7 | | | | Хөрсний хүнд металлын шинжилгээг 2025 онд ЦУОШГ-аас улсын хэмжээнд 400, Улаанбаатар хотод 107 цэгт шинжилгээ хийхэд 32 цэг бохирдолтой гарсан, /Хөрсний нянгийн шинжилгээг ЭМЯ, НЭМҮТ хариуцдаг./ |
| | | 22.6.2 | Байгальд ээлтэй, дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх замаар бүх төрлийн эх үүсвэрээс ялгарах, бохирдуулах бодисын хаягдал, ялгарлыг бууруулна. | 22.6.2.1 | Шинээр барьсан аюултай хог хаягдлыг түр хадгалах агуулах | тоо | 2022 | 16 | 21 | 0 | | | | Аюултай хог хаягдал түр хадгалах байгууламжийг 2 аймгийн төвд нэмж байгуулахаар төсөвлөсөн боловч 2025 оны төсвийн тодотголоор Агаар, орчны бохирдлыг бууруулах хөтөлбөрийн зардал 50% хасагдсан тул тухайн арга хэмжээг санхүүжүүлэн хэрэгжүүлэх боломжгүй болсон. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга нартай 2025 оны 02 дугаар сарын 14-нд цахим хэлэлцүүлгийг зохион байгуулж 2026 оноос өөрийн хөрөнгөөр болон татварын 1 хувийн санхүүжилтээр хариуцсан нутаг дэвсгэртээ жишиг зургийн дагуу байгууламжуудыг барих асуудлыг хэлэлцэж Төвлөрсөн хогийн цэгийн 1,2,3 дугаар зэрэглэлийн жишиг зураг болон ангилан ялгах төвийн жишиг зургуудыг батлуулан хүргүүлсэн. |
| | | | | 22.6.2.2 | Эко тэмдэг, ногоон гэрчилгээ олгож, дэмжлэг үзүүлсэн иргэн, аж ахуйн нэгж байгууллага | тоо | 2022 | 16 | 36 | 31 | | | | "Байгаль орчинд ээлтэй дэвшилтэт арга технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журам"-ийн хэрэгжилтийн хүрээнд 2019-2026 оны байдлаар нийт 41 ААН, байгууллагад ногоон гэрчилгээ, эко тэмдэг олгосоноос БОУАӨ-ийн Сайдын 2026 оны 03 дугаар сарын 12-ны А/233 тоот тушаалаар байгуулагдсан комиссийн 3 удаагийн хурлын шийдвэрээр 15 ААН-д ногоон гэрчилгээ, 1 ААН-д эко тэмдэг олголоо |
| | | | | 22.6.2.3 | Ногоон зээл авсан зээлдэгч /иргэн, аж ахуйн нэгж, байгууллага/ | тоо | 2022 | 700 | 1000< | 0 | | | | Төрийн банкнаас 2025 онд нийт 52 иргэнд 423.3 сая төгрөгийн ногоон зээл олгож хүүгийн хөнгөлөлтийн татаасанд 52.9 сая төгрөгийг зарцуулсан. 2025 оны ногоон зээлийн хүүгийн хөнгөлөлтийн татаасыг мөнгийг 2025 оны 12 сард Сангийн яам буцаан татсан тул өр үүсч, 2026 оны 6 дугаар сард дахин шинэ гэрээгээр Төрийн банк ХасБанкинд ногоон зээлийн хүүгийн хөнгөлөлтийг татаасанд зориулж 600.0 сая төгрөгийг шилжүүлээд байна. |
| | 22.7 | **71408 Ус цаг уур, орчны шинжилгээ** | | | | | | | | | | | | |
| | | 22.7.1 | Цаг агаарын урьдчилсан мэдээний чанарыг сайжруулна. | 22.7.1.1 | Цаг агаарын аюултай үзэгдлийн урьдчилан илрүүлэлт | хувь | 2022 | 88.7 | 89 | 89 | 75,894,453.00 | 74,408,556.00 | 98% | Ус, цаг агаарын гаралтай аюултай үзэгдлээс эртнээс сэрэмжлүүлэх мэдээг (СМ) энэ онд нийт 107 удаа (хүчтэй салхины СМ 38, их борооны СМ 17, цасан шуурганы СМ 29, шороон шуурганы СМ 7, цочир хүйтрэлтийн СМ 3, нойтон цасны СМ 1 удаа) гаргасан бол Гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх мэдээг (УСМ) энэ онд нийт 11 (хүчтэй салхины УСМ 3, цасан шуурганы УСМ 2, шороон шуурганы УСМ 2, цочир хүйтрэлтийн УСМ 1, их цасны УСМ 3 удаа) гаргаж, ОБЕГ, ХХААХҮЯ, УОК зэрэг шийдвэр гаргагчид, холбогдох мэргэжлийн байгууллага, олон нийтэд шуурхай хүргэсэн байна. Эдгээр УСМ-ний онч 92.0%-тай байсан. |
| | | | | 22.7.1.2 | Цаг агаарын урьдчилсан мэдээ | хувь | 2022 | 87.5 | 88.3 | 88.3 | | | | Өдөр бүр 28 хот суурингаар гаргаж байсан 5 хоногийн урьдчилсан мэдээний таарц 88.9% байсан. |
| | | | | 22.7.1.3 | Ус, цаг агаар, хөдөө аж ахуйн цаг уур, орчны шинжилгээний бүх төрлийн мэдээллийг интернэтийн сүлжээгээр тогтоосон хугацаанд бүрэн дамжуулах | хувь | 2022 | 30.3 | 100 | 100 | | | | Цаг уурын улсын сүлжээний 318 өртөө харуул хоногт 3-8 удаа, ус судлалын 154 харуул өдөрт 2 удаа, Хөдөө аж ахуйн цаг уурын ажиглалтын мэдээллийг 10 хоног тутамд гэх мэт олон төрлийн ажиглалт хэмжилийг мэдээллийг зохиох кодоор кодлон дотоодын мэдээлэл солилцоонд оруулахдаа гар утасны мессеж ажиглан дамжуулдаг байсан. Энэ үйл ажиллагааг цахимжуулах ажлын хүрээнд зөвхөн дотоод үйл ажиллагаанд ашиглах мэдээлэл солилцооны цахим системийг нэвтрүүлсэнээр мэдээллийн шуурхай байдлыг хангаж дотоодын болон олон улсын мэдээлэл солилцооны тасралтгүй байдлыг хангасан. http://192.168.100.13/currentweather Дэлхийн цаг уурын байгууллагын OSCAR/Surface платформд 75 өртөөдийн мета өгөгдлийг шинээр бүртгүүлж, олон улсын мэдээ солилцоонд улсын сүлжээний бүх өртөө буюу 138 өртөөдийн мэдээ гарч эхэлсэн. Мөн Дэлхийн тоон прогнозын загварын 4 төвд 102 өртөөдийн мэдээ гарч байна |
| | | 22.7.2 | Цаг уурын бүх өртөө, харуулыг интернэтийн сүлжээнд холбох, цаг агаарын мэдээллийг дамжуулахад үүрэн холбооны систем ашиглалтыг нэмэгдүүлсэн байна. | 22.7.2.1 | Автомат хэмжих хэрэгслээр хэмжсэн цаг агаарын мэдээллийг 1 минут тутам төв серверт дамжуулах өртөө харуулын эзлэх хувь | хувь | 2022 | Т | 100 | 100 | | | | Цаг уурын улсын сүлжээнд 318 өртөө харуул ажиллаж байгаагаас 200 орчим өртөө харуул цаг уурын автомат станцаар цаг уурын салхины хурд, чиглэл, агаарын температур, чийгшил, даралт, хур тунадас, хөрсний температурын хэмжилийг хийж ажилладаг. Эдгээр автомат станцаар хэмжсэн мэдээллийг 1 минут тутамд төв серверт буюу ЦУОШГ-ын төв байрруу 4G сүлжээ ашиглана дамжуулах шийдлийг нэвтрүүлж шуурхай үйл ажиллагаанд болон архивын цахим сан үүсгэх зорилготой Мэдээллийн нэгдсэн системыг бий болгож ажилласан. /http://202.70.33.41/ Ингэснээр цаг агаарын урьчилан мэдээний шуурхай байдал болон бодит мэдээлэлээр үйлчилчигээ, эх мэдээний цувааны тасралтгүй байдал хангагдсан. |

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч | Хөтөлбөр | Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 22.7.3 | Ажиглалт хэмжлийн цэгийн нягтаршил нэмэгдэж мэдээний цуваа уртасна. Шинээр байгуулагдах өртөө, харуулд хийгдэх цаг уурын үндсэн үзүүлэлтийн хэмжилтийн тоо нэмэгдэнэ. | 22.7.3.1 | Монгол Улсын хэмжээнд ургамлын ургалт, бэлчээрийн даац багтаамжийн мониторинг хийх | тоо | 2022 | 1 | 1 | 1 | | | | Зуншлага, бэлчээрийн ургамлын ургалтын байдлын үнэлгээг 10 хоног тутамд, гангийн эрсдэлийн үнэлгээ (туршилтаар 7 дугаар сарын 1-ний дотор), зудаас эртнээс сэрэмжлүүлэх чиглэлээр өвөл-хаврын бэлчээрийн даац багтаамж (8 дугаар сарын сүүлчийн арав хоногт), мал өвөлжилт, зудын бодит нөхцөл байдлын үнэлгээг 11 дүгээр сараас 10 хоног тутамд, зудын эрсдэлийн үнэлгээг 11 дүгээр сараас тус бүр боловсруулан цахим хуудсаар (https://weather.gov.mn/agro Ус, цаг агаар, орчны мэдээ мэдээлэл) ОБЕГ, ХХААХҮЯ, олон улсын хүмүүнлэгийн байгууллагууд, олон нийтэд үйлчилж байна. Мөн цаг агаарын нэг сарын урьдчилсан мэдээг сарын 25-ны дотор, улирлын урьдчилсан мэдээг сарын 28-ны өдөр шинэчлэн боловсруулж цахим хуудсаар (https://weather.gov.mn/forecast/mn) олон нийтэд мэдээлж байна. |
| | | | | 22.7.3.2 | Монгол Улсын хэмжээнд гангын эрсдэлийн зураглал хийх | тоо | 2022 | Т | 1 | 1 | | | | Ган, зудын эрсдэлийн ерөнхий үнэлгээний аргазүйг боловсруулж, ЦУОШГ-ын харьяа байгууллага УЦУОСМХ-ийн Шинжлэх Ухаан Технологийн зөвлөл /ШУТЗ/-ийн 2026 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн хурлаар хэлэлцүүлж, батлуулсан. Гангийн эрсдэлийн ерөнхий үнэлгээний эхний үр дүнг байгаль цаг агаарын нөхцөлтэй уялдуулан 2026 оны 07 дугаар сард гаргана. |
| | **ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД** | | | | | | | | | | | | | |
| | | **70305 Гадаад харилцааны бодлого, удирдлага** | | | | | | | | | | | | |
| | 23.1 | 23.1.1 | Монгол Улсын байр суурийг зөв тодорхойлох, аюулгүй байдал, эдийн засгийн тогтворжилт, өсөлтийг хангаж, хөгжлийн таатай гадаад орчныг бүрдүүлэх, гадаад харилцааны нэгдсэн зохицуулалтыг хангах зорилгын хүрээнд гадаад бодлогыг боловсруулан хэрэгжүүлэх, гадаад улс төр, худалдаа, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх зэрэг зорилтыг хэрэгжүүлнэ. | 23.1.1.1 | Гадаад харилцааны бодлого, удирдлагын чиглэлээр сургалт семинар зохион байгуулах | тоо | 2022 | 5 | 5 | 13 | 56,890,607.10 | 42,891,905.00 | 75.4% | Албан хаагчдын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр 2025 онд нийт 13 төрлийн сургалт зохион байгуулж 150 албан хаагчийг хамруулсан байна. Гадаад харилцааны яамны сургалтын хөтөлбөрийн хүрээнд яам болон ДТГ-ын ажилтан, албан хаагчдыг сургалтад хамруулж, мэргэшүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулав. Тухайлбал, Монгол Улсаас хилийн чанадад суугаа 2025 онд хилийн чанад дахь ДТГ-дад шинээр томилогдон ажиллах албан хаагчид болон тэдний гэр бүлийн гишүүдэд зориулсан 10 багц сургалт, жендер, Авлига ашиг сонирхлын зөрчил, гадаад хэл, олон улсын харилцаа, худалдааны чиглэлээр сургалтууд зохион байгуулав. Түүнчлэн Удирдлагын академиас жил бүр зохион байгуулдаг төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөрүүдэд тус яамны 12 албан хаагч хамрагдсан байна. |
| | | | | 23.1.1.2 | Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулах | тоо | 2022 | 30 | 30 | 27 | | | | Баримт бичиг нь улс хоорондын харилцааг өргөн хүрээнд, бодит үр дүнтэй байдлаар хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой, Засгийн газар хоорондын комиссын 6 хуралдаан зохион байгуулав. |
| | | | | 23.1.1.3 | Зөвлөлдөх уулзалт, дугуй ширээний уулзалт | тоо | 2022 | 15 | 15 | 20 | | | | Зөвлөлдөх уулзалт, дугуй ширээний уулзалт, засгийн газар болон парламент хоорондын комисс хуралдааны бэлтгэлийг ханган, хэрэгжүүлсэн нь хоёр талын харилцаа, хамтын ажллагааг шат ахиулж хөгжүүлэхэд чухал алхам ба Засгийн газар хоорондын комиссын 6 хуралдаан, ГХЯ-д хоорондын 20 зөвлөлдөх уулзалт зохион байгуулав. |
| | | | | 23.1.1.4 | Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээг хэвлэн нийтлэх | тоо | 2022 | 400 | 400 | 313 | | | | Тайлангийн хугацаанд Засгийн газрын 2016 оны 81 дүгээр тогтоолд заасан Монгол Улсын олон улсын гэрээ байгуулах ажлыг үндэсний хэмжээнд аргачлал, хяналтаар хангах, хэлэлцээ хийх, ёсчлон бэлтгэх, батлуулах, бүртгэх, үндэсний хууль тогтоомж болон олон улсын гэрээний эрх зүйн уялдааг хангах, орчуулгыг хянан баталгаажуулах, олон улсын гэрээний бүртгэл хөтлөх, хэвлэн нийтлүүлэх, биелэлтэд нь ерөнхий хяналт тавих, олон улсын эрх зүйн зөвлөгөө өгөх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлж ажиллав. Монгол Улс нийт олон талт 6 гэрээнд нэгдэн орох дотоодын процедураа хангасан бол Засгийн газар хоорондын 16 гэрээ байгуулав. Түүнчлэн, байгууллага хоорондын 108 гэрээ байгуулж бүртгэсэн бол гэрээний төсөлд санал өгөх, орчуулгыг хянах зэрэг нийт байгууллага хоорондын 137 гэрээ байгуулахтай холбоотой үйл явцад оролцов. |
| 23 | | 23.1.2 | Хоёр талт харилцаа, хамтын ажиллагаа өргөжихийн хэрээр айлчлал арга хэмжээний давтамжийг нэмэгдүүлнэ. | 23.1.2.1 | Өндөр, дээд түвшний айлчлал зохион байгуулах | тоо | 2022 | 4 | 10 | 43 | | | | Олон улсын харилцаанд үүссэн ээдрээтэй байдал, зэвсэгт мөргөлдөөн, томоохон улс, гүрнүүдийн хоорондын талцал гүнзгийрч буй нөхцөл байдалд Гадаад бодлогын үзэл баримтлалын “энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт” суурь зарчмыг тууштай баримтлах, хоёр хөрш болон гуравдагч хөрш улс орнуудад ойлгуулах, тэнцвэртэй харилцах, байр сууриа хадгалах, гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангаж, дээд, өндөр түвшний айлчлалуудыг хэрэгжүүлхэд онцгой анхаарал хандуулсан. 2025 онд өндөр дээд түвшинд 43 айлчлал арга хэмжээг хэрэгжүүлэв. Ерөнхийлөгчийн түвшинд 17, УИХ-ын даргын түвшинд 5, Ерөнхий сайдын түвшинд 3, Гадаад харилцааны сайдын түвшинд 18 айлчлал хэрэгжив. |
| | | **70301 Гадаад улс дахь дипломат үйл ажиллагаа** | | | | | | | | | | | | |
| | 23.2 | 23.2.1 | Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгжийн хууль ёсны эрх ашгийг тууштай хамгаалж, эрх зүйн туслалцаа үзүүлэх үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна. | 23.2.1.1 | Үзүүлсэн консулын болон нотариатын үйлчилгээ | тоо | 2022 | 173629 | 165200 | 163000 | 182,883,751.50 | 144,903,472.28 | 79.2% | 2025 онд Дипломат төлөөлөгчийн газруудад урсгал зардалд 182.9 тэрбум төгрөгийн төсөв батлагдсанаас 144.9 тэрбум төгрөг буюу 79.2 хувийн гүйцэтгэлтэй гарч, улмаар батлагдсан төсвийг 37.9 тэрбум төгрөг буюу 20.8 хувийн хэмнэлттэйг ажилласан байна. |
| | | 23.2.2 | Монгол Улсын иргэдийг визийн шаардлагаас чөлөөлөх хэлэлцээрийг гадаад улсуудтай үргэлжлүүлэн байгуулна. | 23.2.2.1 | Гадаад улстай хийх хэлэлцээр | тоо | 2023 | 64 | 75 | 76 | | | | |
| | | **70304 Гадаад улсад байгаа монгол иргэдэд туслах** | | | | | | | | | | | | |
| | 23.3 | 23.3.1 | Гадаад улсад байгаа Монгол Улсын иргэний гаргасан хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэнэ. | 23.3.1.1 | Гадаад улсад байгаа Монгол Улсын иргэний гаргасан хүсэлтийг шийдвэрлэх | хувь | 2022 | 100 | 100 | 100 | 600,000.00 | 545,804.50 | 91.0% | ГХЯ иргэдийн эрх ашгийг хамгаалах, иргэдийн зорчих нөхцлийг хөнгөвчлөх, консулын үйлчилгээг цахимжуулахад анхаарч, үр дүнтэй ажиллав. Гадаад улсад зорчиж буй болон оршин сууж буй иргэдэд мэдээ зөвлөмж түгээх, төрийн үйлчилгээг чирэгдэлгүй хүргэх, эрх ашиг нь хөндөгдсөн тохиолдолд дэмжлэг туслалцааг шуурхай үзүүлэхэд анхаарч ажиллав. |
| | | **70303 Олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх** | | | | | | | | | | | | |

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч | Хөтөлбөр | Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 23.4 | 23.4.1 | ЮНЕСКО-д биет болон биет бус өвийн тоог бүртгүүлнэ. | 23.4.1.1 | Өв | тоо | 2022 | 1 | 1 | 5 | 20,804,992.30 | 15,982,207.21 | 78.8% | “Хомын тал” байгалийн нөөц газрыг ЮНЕСКО-гийн Шим мандлын нөөц газруудын дэлхийн сүлжээнд бүртгүүлж,“Хүйс толгойн бичээс I”, “Хүний бүтэн биеийн бүртгэл бичвэр” гэсэн хоёр баримтат өвийг “Дэлхийн дурсамж” хөтөлбөрт шинээр бүртгүүлж,“Дорнод Монголын хээр тал” номинацыг Дэлхийн өвийн хорооны хурлаар хэлэлцүүлж, “Цайны их замын Монголын хэсэг” өвийг Дэлхийн өвийн Урьдчилсан жагсаалтад оруулах ажлыг хэрэгжүүлэв. Мөн ЮНЕСКО-гийн Суралцагч хотуудын дэлхийн сүлжээнд Монгол Улсаас анх удаа Баянгол дүүрэг болон Орхон аймаг нэгдэв. Дэлхийн өвийн хороонд 2025-2029 онд ажиллахаар сонгогдов. Түүнчлэн, манай улсын санаачилсан “Нүүдлийн соёл иргэншлийн түүх” ЮНЕСКО-гийн цуврал боть бүтээх төслийг урагшлуулах алхмыг бүрдүүлж, ЮНЕСКО-той төслийн гэрээг байгуулав. |
| | | **70302 Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх** | | | | | | | | | | | | |
| | **САНГИЙН САЙД** | | | | | | | | | | | | | |
| | | **70205 Татвар хураалт, орлого бүрдүүлэлт** | | | | | | | | | | | | |
| | | | | 24.1.1.1 | Улсын төсөвт төвлөрүүлэх татварын орлогын төлөвлөгөөний биелэлт | хувь | 2023 | 100 | 100 | 86.3 | 67,210,654.00 | 57,501,053.60 | 86% | УИХ-ын хаврын чуулганаар 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт орсноор Гаалийн байгууллага нь 7,777.8 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр батлагдсан. 2025 онд 6,713.0 тэрбум төгрөгийг төвлөрүүлж 86.3 хувийн гүйцэтгэлтэй байна. Орлогын төлөвлөгөөний биелэлт тус бүрээр авч үзвэл:<br>- Татварын орлого 7,587.8 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 6,537.3 тэрбум төгрөг, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.<br>- Хураамжийн орлого 170.0 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 157.6 тэрбум төгрөг, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.<br>-Өөрийн орлого 20.0 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 18.1 тэрбум төгрөг, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 30.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.<br>2025 онд 6,713.0 тэрбум төгрөг төвлөрүүлсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 30.5 тэрбум төгрөгөөр буурч буюу 0.5 хувийн бууралттай байна. |
| | | | | 24.1.1.2 | Эрсдэлийн удирдлагад суурилсан гаалийн хяналт шалгалтын үйл ажиллагааны хэрэгжилт | хувь | 2023 | 100 | 100 | 100 | 13,002,130.70 | 11,060,210.70 | 85.1% | 1.1 Эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн дүн шинжилгээ хийж үр дүнг тооцсон байна.<br>Эрсдэлийн удирдлагад суурилсан гаалийн хяналтын үр нөлөөг дээшлүүлэх, эрсдэлт орчныг тодорхойлох, судалгаанд суурилсан шийдвэр гаргах, гаалийн байгууллагын гүйцэтгэлийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор макро, микро түвшний 80 судалгааг хийж үр дүнг тооцон шалгуур үзүүлэлтийг боловсруулсан.<br>Үр дүн: ТЕГ, ЦЕГ, ОҮА, ГЕГ-ын БЦТ, БДШГ, харьяа гаалийн газар, хороодтой хамтран ажиллаж, Эрсдэлийн удирдлагын программд тайланд хугацаанд нийт 106 хяналтын хуудсаар 953 эрсдэлийн шалгуур үзүүлэлтийг боловсруулж, батлуулан, оруулсан.<br>1.2 Хууль сахилтын түвшингээр бүрдүүлэлтийн дараах шалгалтад хамрагдах иргэн, аж ахуйн нэгжийн мэдээллийг гарган, холбогдох нэгжид хүргүүлж, үр дүнг тооцсон байна.<br>Эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийсний үндсэн дээр 2025 онд 46 ААНБ-д шалгалт хийх удирдамж батлагдсан. Дээрх 46 ААНБ-ын 30 ААН-д төлөвлөгөөт, 16 ААН-д төлөвлөгөөт бус шалгалтыг хийсэн. Төлөвлөгөөт бус 1 ААН-д хийх шалгалт татан буугдсан үндэслэлээр цуцлагдсан.<br>Шалгалтын үр дүн: 12 ААНБ буюу 27% нь "Зөрчилгүй" буюу хууль сахилт сайн, 33 ААН буюу 73% нь "Зөрчилтэй" гарсан.<br>Нийт зөрчил илэрсэн 33 ААНБ-ын 30 ААНБ-д холбогдох зөрчлийг Зөрчлийн тухай хуулиар шалган шийдвэрлэж, 1,804,325,227.67 төгрөгийн нөхөн татвар, торгуулийг оногдуулсан. Үлдсэн 3 ААНБ-д 19,495,794,744.04 төгрөгийн зөрчил илэрсэн бөгөөд эдгээр зөрчлийг харьяаллын дагуу шалган шийдвэрлүүлэхээр Цагдаагийн байгууллагад шилжүүлсэн |
| | | 24.1.1 | Гаалийн хяналт шалгалтын үйл ажиллагааг эрчимжүүлж, бүрдүүлэлтэд зарцуулах хугацааг бууруулна. | 24.1.1.3 | Бараанд хийх гаалийн шалгалтаас чөлөөлөх | хувь | 2023 | 64 | 65 | 66 | 26,004,261.60 | 22,120,421.50 | 85.1% | Гаалийн бүрдүүлэлт: Тайлант хугацаанд нийт 1,133,797 гаалийн бүрдүүлэлт хийгдсэнээс:<br>-Импортын гаалийн бүрдүүлэлт 352,811 буюу 31.12 хувь;<br>-Экспортын гаалийн бүрдүүлэлт 780,986 буюу 68.88 хувь тус тус ээлж байна.<br>Үр дүн: Тайлант хугацаанд гаалийн хяналтын төлөвийн мэдээллийг 7 хоног, сар, улирал, хагас жил, бүтэн жилээр нэгтгэн боловсруулж, гаалийн байгууллагын бүх түвшний албан хаагчдыг тогтмол мэдээллээр ханган ажиллав. Бичиг баримтын болон бараанд хийх шалгалтаас нийт гаалийн мэдүүлгийн 66% нь чөлөөлөгдсөн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3%-аар өссөн үзүүлэлттэй байна. |

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч | Хөтөлбөр | Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 24 | 24.1 | | | 24.1.1.4 | Гаалийн хяналт шалгалтад рентген, тоног төхөөрөмжийн ашиглалт | хувь | 2023 | 30 | 50 | 66 | 33,801,561.60 | 29,881,451.20 | 88.4% | Хилийн болон гүний гаалийн хяналтын бүсэд суурилуулсан хяналтын тоног төхөөрөмжийн ашиглалтыг нэмэгдүүлж, үр дүнг тооцох зорилгоор 2025 онд CERP-д өдөр бүр оруулсан мэдээнд хяналт тавьж ажиллаж байна. Үүнд:<br>-Замын-Үүд, Алтанбулаг, Булган, Боршоо, Гашуунсухайт боомтод хилээр орох талд суурилуулсан чингэлэг, ачааны тээврийн хэрэгсэл шалгах рентгенээр хилээр нэвтрүүлсэн 461,918 тээврийн хэрэгслийн 127,240 буюу 22.5 хувь;<br>-Замын-Үүд, Шивээхүрэн, Гашуунсухайт боомтод гарах чиглэлд суурилуулсан болон Алтанбулаг боомт дахь рентгенээр хилээр нэвтрүүлсэн 676,186 тээврийн хэрэгслийн 96,536 буюу 14.3 хувь;<br>-хилийн боомтуудад суурилуулсан 100*100, 75*55 туннельтэй рентгенээр хилээр нэвтэрсэн 6,628,496 зорчигчийн 4,318,846 гар тээш, дагалдах ачаа буюу 65.1 хувь;<br>-улс хоорондын шуудан илгээмжээр илгээсэн 1,678,637 илгээмжийг 100 хувь;<br>-346 ш энгэрийн камераар эрсдэлтэй бараа, тээврийн хэрэгсэл шалгах, зөрчилд холбогдсон бараанаас дээж авах, эсхүл эрсдэлтэй хэсэгт ажиллахдаа 63,445 удаа бичлэг хийж 100 хувь ашигласан.<br>Гаалийн хяналт, шалгалтын үр дүнг нэмэгдүүлэх зорилгоор 2025 оны жилийн эцсийн байдлаар дээрх тоног төхөөрөмжийн ашиглалтыг 60.3 хувьд хүргэсэн.<br>2.Гаалийн бүрдүүлэлтэд зарцуулах хугацааг бууруулахад нөлөөлөх гол хүчин зүйл нь барааг гаалийн байгууллагад мэдүүлсэн өдөрт нь багтаан “Гааль зөвшөөрөв” төлөвт оруулах үйл ажиллагаа юм. Иймд гаалийн бүрдүүлэлт хийхэд зарцуулсан хугацааг тодорхойлох зорилгоор нийт бүрдүүлэлт хийсэн мэдүүлгийн тоонд гаалийн байгууллагад мэдүүлсэн тухайн өдөртөө багтаж "Гааль зөвшөөрөв" төлөвт оруулсан мэдүүлгийн эзлэх хувийн жинг 2025 оны 01 дүгээр сараас эхлэн сар бүрээр, гаалийн газар, хороодоор гарган, судалгаа дүн шинжилгээ хийж ажилласан.<br>-Судалгааны дүнгээс үзвэл 2025 оны эхнээс өссөн дүнгээр жилийн эцсийн байдлаар нийт 1,175,199 мэдүүлгээр бүрдүүлэлт хийснээс 48.45 хувь буюу 569,397 мэдүүлэг нь мэдүүлсэн өдөртөө “Гааль зөвшөөрөв” төлөвт орсон байгаа нь оны эхний 1 дүгээр сард мэдүүлсэн өдөртөө “Гааль зөвшөөрөв” төлөвт орсон мэдүүлгийн хувь хэмжээнээс 0.82 хувиар өссөн байна. |
| | | 24.1.2 | Татвар хураалтыг сайжруулж, татварын өрийг бууруулна. | 24.1.2.1 | Өмнөх онуудын тайлангаар ногдуулсан татварын өр барагдуулалт | хувь | 2023 | 64.8 | 60 | 63.6 | 24,574,708.83 | 24,468,413.78 | 99.6% | 2025 онд 8.5 их наяд төгрөгийн өрийн 70% буюу 5.9 их наяд төгрөгийн өрийг барагдуулж, барагдуулалт төсвийн хуулийн хавсралтад заасан шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан байна. |
| | | | | 24.1.2.2 | Өмнөх онуудын хяналт шалгалтаар ногдуулсан өр барагдуулалт | хувь | 2023 | 16 | 50 | 33.9 | 20,478,924.02 | 13,034,952.89 | 63.6% | 2025 онд 776.1 тэрбум төгрөгийн өрийн 64.4% буюу 499.4 их наяд төгрөгийн өрийг барагдуулж барагдуулалт төсвийн хуулийн хавсралтад заасан шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан байна. |
| | | | | 24.1.2.3 | Тайлант хугацааны татварын тайлангийн ногдол, өр барагдуулалт | хувь | 2023 | 76.6 | 80 | 81.9 | 32,766,278.44 | 31,491,523.36 | 96.1% | 2025 онд тайлангаар ногдуулсан 13.6 их наяд төгрөгийн өрийн 83.8% буюу 11.4 ихнаяд төгрөгийн ногдлыг барагдуулж, барагдуулалт төсвийн хуулийн хавсралтад заасан шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан байна. |
| | | | | 24.1.2.4 | Татварын цахим тайлан авалт | хувь | 2023 | 74.4 | 80 | 82.8 | 39,648,614.84 | 38,617,903.95 | 97.4% | 2025 онд 21,480 хуулийн этгээдийн татвар төлөгчөөс хасах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. 2025 оны жилийн эцсийн тайлангийн ирц 76.5 байгаа нь тухайн жилийн төсвийн тухай хуулийн зорилтод түвшин 80 хувьд харьцуулбал 95.7 хувийн биелэлттэй байна. |
| | | | | 24.1.2.5 | Алдагдалтай буюу "Х" тайлан тушаалтын бууралт | хувь | 2023 | 1 | 1 | 0.4 | 409,578.48 | 165,340.11 | 40.4% | 2025 оны жилийн эцсийн тайлангаар Алдагдалтай буюу Х тайлангийн эзлэх хувь өмнөх оноос 2 хувиар өссөн байна. Энэ нь аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа эдийн засгийн нөхцөл байдал зэрэг хүчин зүйлийн нөлөөлөл үүссэн байна. |
| | | **71106 Хилийн боомтын үйлчилгээ** | | | | | | | | | | | | |
| | 24.2 | 24.2.1 | Голлох боомтуудын төмөр замын нарийн царигийн холболтын ажлыг дуусгаж, экспортын хүчин чадлын хэмжээг нэмэгдүүлнэ. | 24.2.1.1 | Авто зам, төмөр зам, төмөр замын холболтын төслүүдийн явц | хувь | 2021 | 20 | 40 | 1 | 2,978,325.40 | 2,772,584.36 | 93.1% | Гашуунсухайт - Ганцмод боомтыг төмөр замаар холбох талаар МУ-ын Засгийн газраас БНХАУ-ын Засгийн газартай санамж бичиг харилцан байгуулсан. Холбогдох ажлын гүйцэтгэл 30 орчим хувьтай байна. |
| | | 24.2.2 | Боомтуудын усан хангамж, цахилгаан эрчим хүчний хүчин чадлыг нэмэгдүүлнэ. | 24.2.2.1 | Боомтын үндсэн байгууламжийн бүтээн байгуулалт | тоо | 2021 | Т | 3 | 3 | 223,374.41 | 207,943.83 | 93.1% | Боомтын үндсэн байгууламжийн бүтээн байгуулалтууд хийгдэж 2024 онд иж бүрэн ашиглалтад оруулсан. /Замын үүд, Гашуунсухайт, Алтанбулаг/ |
| | | 24.2.3 | Олон улсын болон 2 талын зэрэглэлтэй боомтуудын нэвтрэх хүчин чадлыг нэмэгдүүлнэ. | 24.2.3.1 | Бичигт, Хавирга, Булган, Ханги хилийн боомтын үндсэн байгууламжийн бүтээн байгуулалтын явц | тоо | 2021 | Т | 25 | 12 | 1,861,453.38 | 1,732,865.22 | 93.1% | Бичигт, Хавирга, Булган, Ханги хилийн боомтын бүтээн байгуулалтын ажил 2024-2027 онд хийгдэж дуусахаар төлөвлөсөн байна. /Бичигт 2026-2028 онд, Хавирга 2027-2029 онд/ |
| | | | | 24.2.3.2 | Тоног төхөөрөмжөөр хангагдсан гаалийн шалган нэвтрүүлэх цэг | тоо | 2021 | Т | 16 | 4 | 1,191,330.16 | 1,110,910.74 | 93.1% | Гашуунсухайт, Алтанбулаг, Замын-Үүд, Шивээхүрэн, Боршоо боомтуудын хяналт шалгалтын тоног төхөөрөмж бүрэн шинэчлэгдсэн. |
| | | | | 24.2.3.3 | Цагаандэл-Уул хилийн боомтын байгууламжийн бүтээн байгуулалтын явц | хувь | 2021 | Т | 50 | 15 | 3,722,906.75 | 3,465,730.45 | 93.1% | Бүтээн байгуулалтын ажилд 91,012.25 сая төгрөг шаардлагатай бөгөөд үүнээс 2026, 2027 онд 6,943.12 сая төгрөг нь буцалтгүй тусламжийн барилга байгууламжийг ус, дулаан, эрчим хүчээр хангахад шаардах юм. |
| | **ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД** | | | | | | | | | | | | | |
| | | | | **70704 Цагдаа** | | | | | | | | | | |
| | | | | 25.1.1.1 | Хэргийг хэрэг бүртгэлт явуулж эхэлснээс хойш хуулийн хугацаанд шийдвэрлэлт | хувь | 2023 | 80 | 80 | 93.8 | | | | Цагдаагийн байгууллагаас нийт 109,671 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж 71,654 хэрэг буюу 65.3 хувийг, нийт шийдвэрлэсэн хэргийн 93.8 хувийг хуулийн анхны хугацаанд тус тус шийдвэрлэсэн байна. |

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч | Хөтөлбөр | Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 25.1 | 25.1.1 | Хэргийг хэрэг бүртгэлт явуулж эхэлснээс хойш хуулийн хугацаанд шийдвэрлэхийг 80, эрэн сурвалжлагдаж байгаа хүн, эд зүйлийн илрүүлэлтийг 85.5, хэргийн илрүүлэлтийг 58, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авсан арга хэмжээг 92 хувьд хүргэсэн байна. | 25.1.1.2 | Эрэн сурвалжлагдаж байгаа хүн, эд зүйлийн илрүүлэлт | хувь | 2023 | 84.6 | 85.5 | 85.5 | 651,975,934.90 | 635,720,188.40 | 97.5% | 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 36,556 мэдээллийг бүртгэн, зарлан мэдээлснээс 31,270 эрэн сурвалжлалтыг зогсоож, үлдэгдэл 5,286 мэдээлэлтэй, сангийн ашиглалт 85.5 хувьтай байгаа нь суурь түвшнээс 0.9 хувиар өссөн байна. |
| | | | | 25.1.1.3 | Хэрэг илрүүлэлт | хувь | 2023 | 57.1 | 58 | 48.2 | | | | Улсын хэмжээнд 2025 онд 48.2 хувь, нийслэлд 43.7 хувь, орон нутагт 60.0 хувь байгаа нь өмнөх оноос улсын хэмжээнд 1.2 нэгжээр, нийслэлд 1.6 нэгжээр тус тус өсөж, орон нутагт 2.5 нэгжээр буурсан байна.<br>Гэмт хэргийн гаралт цаг үеэ даган жилээс жилд нэмэгдэж байгаа нь хэргийн илрүүлэлтэд шууд нөлөөлж байгаа боловч түүнийгээ дагаад эрүүгийн хэрэг үүсгэн, яллагдагчаар татаж байгаа хэргүүд нэмэгдэж байна. |
| | | | | 25.1.1.4 | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авсан арга хэмжээ | хувь | 2023 | 90 | 92 | 98.3 | | | | “Ухаалаг ногоон бүс” төслийн хүрээнд 2023 онд “Теле камерын хяналтын нэгдсэн болон дэд төв” 3-ыг байгуулж, 10199 хяналтын камер ашиглаж байснаас 2025 онд 21 аймаг, 9 дүүргийн нийт 30 нэгдсэн болон дэд төвийг 100 хувьтай байгуулж, хүний нүүр царай, автомашины дугаар таних ухаалаг программ хангамжийг нэвтрүүлж, нийт 92,958 ухаалаг камерыг суурилуулж, 12,209 камерыг системд холбон ашиглаж байна.<br>Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгах, урьдчилан сэргийлэх зорилгоор “Мэдэгдлийн нэгдсэн сан” (notice.police.gov)-г шинээр байгуулж, нийт 37976 мэдэгдэл, зөвлөмж, шаардлага хүргүүлснээс 36729 буюу 96,7 хувийг шийдвэрлэсэн байна. Үүний хүрээнд удаа дараа зөрчил гаргасан 191 аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг цуцлах санал хүргүүлж, 1,407 иргэн, хуулийн этгээдэд нийт 900.0 сая төгрөгийн торгууль ногдуулснаар хууль тогтоомжийн хэрэгжилт хоёр дахин нэмэгджээ.<br>Мэдээлэл, нөлөөллийн чиглэлээр “Хуулиа мөрдье”, “Анзаар-2”, “Амьдрал мөрий биш”, “Цахим орчныг зөв болгоё”, “Дансаа бүү ашиглуул”, “Дүрмээ мөрдье” зэрэг нийт 8 аян, арга хэмжээг зохион байгуулж, 2,665 мэдээллийг бэлтгэн, давхардсан тоогоор 239 сая цахим хэрэглэгчдэд хүргэсэн байна. 2025 оны 1–8 сард залилах гэмт хэрэг сар бүр дунджаар 507-оор өсөж, оны эцэст 22,791 хэрэг бүртгэгдэх эрсдэлтэй байсан боловч 9–12 сард хэрэгжүүлсэн мэдээлэл, нөлөөллийн ажлын үр дүнд оны эцэст 16,906 хэрэг бүртгэгдэж, нийт 5,885 гэмт хэргээс урьдчилан сэргийлсэн байна.<br>Аж ахуйн нэгж, байгууллагад холбогдох гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй дуудлага, мэдээллийг байгууллагын регистрийн дугаарыг “ХУР” системтэй уялдуулснаар дуудлага, мэдээлэлд шуурхай хариу арга хэмжээ авч, хуульд заасан хариуцлага ногдуулах нөхцөл бүрдсэн. Үүний үр дүнд дуудлага, мэдээллийн тоо орон нутагт 21,670 нэгжээр буюу 35.4 хувиар, нийслэлд 1,447 нэгжээр буюу 0.4 хувиар тус тус буурсан байна. |
| | 25.2 | **70711 Шүүгч болон гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах** | | | | | | | | | | | | |
| | | 25.2.1 | Гэрч, хохирогчийн хамгаалалтыг 72 хүн, шүүхийн байр, шүүх хурлын танхим, шүүгчийн хамгаалалтыг 100 хувь, шүүгчийн захирамжаар албадан авчрах хувийг 86.1 хувьд хүргэсэн байна. | 25.2.1.1 | Гэрч, хохирогчийн хамгаалалт | хүн | 2023 | 70 | 72 | 134 | 11,106,231.60 | 10,416,018.70 | 95.2% | Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан 135 хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлж, гэрч 2, хохирогч 129, шүүгч 1, прокурор 2, нийт 134 иргэний аюулгүй байдлыг хангах ажлыг эрсдэлгүй зохион байгуулж ажилласан. |
| | | | | 25.2.1.2 | Шүүхийн байрны хамгаалалт | хувь | 2023 | 100 | 100 | 100 | | | | Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2021 оны А/116/65 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан журмын хэрэгжилтийг хангах чиглэлээр тус албаны даргын “Мэдээлэл, үүрэг, ажлын чиглэл”-ийг 13/108 дугаартай албан бичгээр нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын хүргүүлж, удирдлагыг тухай бүр мэдээллээр ханган ажиллаж байна.<br>Улсын хэмжээнд 47 шүүхийн байрын аюулгүй байдлыг хамгаалах чиглэлээр 24 цагаар 15,274 алба хаагч 366,600 хүн/цагийн үүрэг гүйцэтгэн нийт 389.416 (нийслэлд 291.325, орон нутагт 98,091) иргэний бичиг, баримтыг зохих журмын дагуу шалган нэвтрүүлж ажилласан.<br>Үүрэг гүйцэтгэх хугацаанд шүүхийн байранд шүүгдэгч, яллагдагч нараас согтууруулах ундаа хэрэглэсэн байдалтай ирсэн 492, цагдаагийн байгууллагын АСАП санд эрэг сурвалжлагдсан этгээд 6, нийт 498 зөрчлийг илрүүлэн шүүх хуралдаан даргалагч шүүгчид илтгэх хуудсаар танилцуулан зөрчил гаргасан 60 яллагдагч, шүүгдэгчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авхуулж шүүхийн байранд үүсэж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж ажилласан. |
| | | | | 25.2.1.3 | Шүүх хурлын танхимын хамгаалалт | хувь | 2023 | 100 | 100 | 100 | | | | Улсын хэмжээнд 140 шүүх хуралдааны танхимд үзлэг шалгалтыг тогтмол хийж, нийт 111,270 (нийслэлд 63,498, орон нутагт 47,772) шүүх хурал товлогдон зохион байгуулагдаж үүнээс 83,322 (нийслэлд 39,410, орон нутаг 43,912) шүүх хуралд дэг сахиулан, 113,177 шүүгч, 301,697 шүүх хуралдаанд оролцогчдын аюулгүй байдлыг ханган шүүн таслах үйл ажиллагааны хэвийн нөхцөлийг бүрдүүлж ажилласан.<br>Мөн олны анхаарал татсан, олон оролцогчтой 307 удаагийн шүүх хурлын хамгаалалтад 2,675 алба хаагч 10,700 хүн/цагийн үүрэг гүйцэтгэсэн. |
| | | | | 25.2.1.4 | Шүүгчийн хамгаалалт | хувь | 2023 | 100 | 100 | 100 | | | | Шүүгчийн хараат бус байдал, аюулгүй байдлыг хамгаалах чиглэлээр явагдсан 111,270 шүүх хуралдаанд 113,177 шүүгч оролцсон ба үүнээс олны анхаарал татсан болон олон оролцогчтой 307 шүүх хурлын даргалагч болон бүрэлдэхүүний 277 шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр шүүхийн байрнаас гарах, гэртээ харих үеийн аюулгүй байдлыг хангах хамгаалалтыг эрсдэлгүй зохион байгуулсан.<br>Энэ онд шүүгч, түүний гэр бүлийн гишүүний амь нас, эрүүл мэндэд аюул занал учрах нөхцөл үүссэн тохиолдол бүртгэгдээгүй болно. |

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч | Хөтөлбөр | Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 25.2.1.5 | Шүүгчийн захирамжаар албадан авчрах | хувь | 2023 | 85 | 86.1 | 86.8 | | | | Улсын хэмжээнд эрүүгийн хэргийн анхан, давж заалдах шатны шүүгчийн захирамжийн дагуу цагдан хорих ангиас 3,038 (нийслэлд 1,671, орон нутагт 1,367) яллагдагч, шүүгдэгчийг шүүхэд, шүүхээс цагдан хорих ангид 4,110 (нийслэлд 2,179, орон нутагт 1,931) яллагдагч, шүүгдэгчийг хуяглан хүргэх ажиллагааг эрсдэлгүй гүйцэтгэсэн.<br>Мөн эрүү, иргэн, захиргааны хэргийн анхан шатны шүүхийн дуудсанаар ирэхгүй байгаа оролцогч, зохигч, хариуцагчийг албадан ирүүлэх ажиллагааны хүрээнд 6,926 (нийслэлд 5,972, орон нутагт 954) шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж хүлээн авч бүртгэн, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид дурдагдсан 6,018 (нийслэлд 5,320, орон нутагт 698) захирамж, тогтоолын биелэлтийг хангаж, биелэлт 86.8 хувийн гүйцэтгэлтэй байна. |
| | | **70602 Хил хамгаалах** | | | | | | | | | | | | |
| | | 25.3.1 | Улсын хил хамгаалалтын нэгдмэл тогтолцоог хангаж, бүсчилсэн хил хамгаалалтыг хөгжүүлэн, хилийн асуудлаар байгуулсан Монгол Улс, олон улсын гэрээ, хэлэлцээрийг хэрэгжүүлэх, хилийн боомтын аюулгүй байдлыг хангах, хил дамнасан гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор хил хамгаалалтад орчин үеийн холбоо, зэвсэглэл, техник, технологийн ололтыг нэвтрүүлнэ. | 25.3.1.1 | Улсын хил хамгаалалтад орчин үеийн техник, технологийг -нэвтрүүлэх | хувь | 2023 | 3 | 5 | 5 | | | | Монгол Улс, Оросын Холбооны Улсын хилийг хамтран шалгах ажлын хэсгийн техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх ажлын хүрээнд туулах чадвар сайтай жип 2, туулах чадвар сайтай микро автобус 2 нэгж, "Фрегат-480" моторт завь /жолооны хүрдтэй/ 2 нэгж, 4 дугуйт мотоцикл 31 нэгж, “Fuso Canter” /хөргүүртэй/ загварын автомашин 1 нэгж, нийт 38 нэгж автомашин, техникийг 2,801.8 сая төгрөгөөр худалдан авч хил хамгаалалтад ашиглаж байна. Хилийн цэргийн анги, салбаруудын тоног төхөөрөмжийг шинэчлэх ажлын хүрээнд “Fuso canter” загварын хөргүүртэй 10 нэгж, ачааны 2 нэгж , “HONGQI E-QM5" загварын 100 хувь цахилгаан хөдөлгүүртэй 5 нэгж, нийт 17 нэгж буюу 2,605 сая төгрөгөөр автомашин, техникийг хүлээн авч хилийн цэргийн 22 ангид хуваарилан олгож улсын хил хамгаалалтад ашиглаж байна. Matrice-4T загварын 16 ширхэг, DJI"Avata-2" загварын 3 ш дроныг худалдан авч хил хамгаалалтад тус тус ашиглаж байна. |
| | | 25.3.2 | Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хилийн торон саадыг шинэчилнэ. | 25.3.2.1 | Улсын хилийн торон саадыг шинэчлэх | хувь | 2023 | 6 | 10 | 10 | | | | Хилийн торон саад шинэчлэх хөтөлбөрийн хүрээнд хилийн хэсгийн торон саадыг шинэчлэхэд 2025 онд 4,274.4 сая төгрөг батлагдсан. Хилийн цэргийн 0119 дүгээр анги (ТӨААТҮГ)-тай торон саадын материал нийлүүлэх гэрээ байгуулан торны шон 16,783 ширхэг, гадсан шон 27000 ширхэгийг хүлээж авч, хилийн цэргийн 0129, 0168, дугаар ангиудад тээвэрлэн хүргэж нийт 300 км торон саадыг шинээр татсан. |
| | 25.3 | 25.3.3 | Дэд бүтцийг сайжруулах замаар хилчдийн нийгмийн баталгааг сайжруулна. | 25.3.3.1 | Улсын хил хамгаалалтын зориулалттай инженер, техникийн байгууламж, барилга, дэд бүтцийн 50-аас доошгүй хувийг шинэчлэх | хувь | 2023 | 8 | 12 | 8 | 460,910,458.90 | 450,038,598.40 | 97.6% | Хилийн цэргийн 8 ангийн хариуцсан хэсэгт Тоон радиорелейн систем байгуулах зорилгоор шаардлагатай 11 нэр төрлийн тоног төхөөрөмжийг 1190.90 сая төгрөгөөр худалдан авсан. Хилийн цэргийн 8 ангид Нарны самбарын суурь 87 ш, Нарны хавтан 522 ш, Холбогч кабелын самбар 29000м, Хайбрид станц JAXM-K-48 V 87 ш, Зай хураагуур LiFePo4 87 ш, Хайрцаг /дулаалгатай/ 87 ширхэгийг 843.76 сая төгрөгөөр худалдан авсан. Хилийн цэргийн 30 анги, хилийн цэргийн 3 тусгай салбаруудад 2 нэр төрлийн 919 ширхэг IP утсыг 396.63 төгрөгөөр худалдан авч ашиглаж байна. Хилийн цэргийн 0130 дугаар ангийн Штаб, Спорт заал, 12 айл, Ар тал, хангалтын байр, Эрүүл мэндийн төв, Ар тал, хангалтын байр, Эрүүл мэндийн төв, 12 айлын орон сууцны дээврийн төмөр солих ажлыг хийж дууссан.Хилийн цэргийн 0184 дүгээр ангийн Шалган, Штаб, Дотоод хяналтын байр, Ар тал, Сургалтын танхим, Соёлын төв, Спорт заал, Эрүүл мэндийн төв, Цэргийн байр, гал зуухны дээврийн төмөр солих ажил хийгдэж дуусан. Хилийн цэргийн 0131 дүгээр ангийн “Гурван зээрд” салбарын албаны 3 өрөө, гэрээт ахлагчийн 8 өрөө, хонгил, ариун цэврийн өрөөнд засвар хийж дууссан. Хилийн цэргийн 0146 дугаар ангийн 60 айлын орон сууцны 9 барилгын дээвэр, гадна фасадын дулаалгын ажил хийгдэж дууссан. Мөн ангийн төвд нөөцийн 70 кВт цахилгаан үүсгүүр худалдан авч, суурилуулсан. Хилийн цэргийн 0164 дүгээр ангийн соёлын төв, Хөгжмийн байр, Жолооны сургууль, 9 машины гараашны дээвэр засварлах материалыг татан авсан. Хөгжмийн байр, Жолооны сургуулийн дээврийн засвар хийж дууссан. Хилийн цэргийн 0303 дугаар ангийн халаалтын системийн сүлжээний 7.5 кВт-ын 2 ширхэг насос худалдан авч суурилуулсан. Хилийн цэргийн 0130 дугаар анги дэд станцын шинэчлэлийн ажлыг Аймгийн эрчим хүчний газартай хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Эрчим хүчний газраас хэмжилт зураг хийгдэж дууссан. |
| | | | | 25.3.3.2 | Хилийн салбаруудыг байнгын цахилгааны эх үүсвэрт холбох | тоо | 2023 | 6 | 4 | 2 | | | | Хилийн цэргийн 0165 дугаар ангийн (Арал толгой, Хотон нуур), 0130 дугаар ангийн (Гурван хүүхэд), 0285 дугаар ангийн (Хөх эрэг) салбаруудыг төвлөрсөн эрчим хүчинд холбосон. Хилийн цэргийн 0287 дугаар ангийн (Хөмөл), 0285 дугаар ангийн (Асгат) салбаруудад 60 кВт-ын нарны цахилгаан үүсгүүр суурилуулсан. Хилийн цэргийн 0277 дугаар ангийн (Арцсуурь) салбарыг төвлөрсөн эрчим хүчинд холбох ажил 62 хувь, 0245 дугаар ангийн (Сагил), 0311 дүгээр ангийн (Гадарт) салбаруудыг төвлөрсөн эрчим хүчинд холбох ажил 60 хувьтай тус тус хийгдсэн. Хилийн 20 салбарт 20 кВт, хилийн 2 салбарт 30кВт-н нарны цахилгаан үүсгүүр суурилуулсан.Хилийн цэргийн 0198 дугаар ангийн хилийн салбар (Эрс-Уул)-ыг төвлөрсөн эрчим хүчинд холбох шугамын 38 км газарт 392 ш тулгуур босгосон. |

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч | Хөтөлбөр | Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 25.3.4 | Хилийн боомтуудад "Дохиолол, хяналт, хамгаалалтын нэгдсэн систем"-ийг суурилуулж, улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх үйл ажиллагаанд "Ухаалаг цахим" технологийг нэвтрүүлж, орчин үеийн хяналт шалгалтын техник хэрэгслээр хангана. | 25.3.4.1 | Хилийн боомтууд орчин үеийн техник хэрэгслээр хангагдсан байх | тоо | 2023 | 1 | 3 | 3 | | | | 1.Чингис хаан (8), Алтанбулаг (4), Замын-Үүд (10) нийт 3 боомтод 22 цахим гарцыг суурилуулж, зорчигч өөрийгөө бүртгэх төхөөрөмжийг нэвтрүүлсэн<br>2.Иргэдэд цахимаар үзүүлэх төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, шуурхай байдлыг хангах, байгууллагын цаасан суурьтай үйл ажиллагаа багасгах ажлын хүрээнд E-MONGOLIA академи улсын төсөвд үйлчилгээний газартай хамтран улсын хил нэвтрэх эрхийн хоригийн мэдээллийг иргэд өөрсдөө E-MONGOLIA програмын улсын хил нэвтэрсэн иргэний лавлагаа хэсгээс авах нөхцлийг бүрдүүлсэн. Гаалийн ерөнхий газартай хамтран авто замын боомтоор зорчих иргэдийн урьдчилсан бүртгэлийн программыг “Е Монголиа” ХХК-аар хийлгэж байна.<br>3.Паспорт уншигч төхөөрөмж-10, хурууны хээ уншигч төхөөрөмж-10, паспорт нарийвчлан шалгах төхөөрөмж-10, гар паспорт шалгагч төхөөрөмж-50 ширхэгийг тус тус худалдан авч, хилийн боомтуудад хангах ажил хийгдэж байна. |
| | 25.4 | **70705 Шүүхийн шийдвэр гүйцэтгэл** | | | | | | | | | | | | |
| | | 25.4.1 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг хангана. | 25.4.1.1 | Хоригдлын хөдөлмөр эрхлэлт | хувь | 2023 | 73 | 75 | 74.4 | 233,132,403.90 | 237,652,406.29 | | Тайлант хугацаанд 4,731 хоригдол ял эдэлж байгаагаас хорих ангийн үйлдвэрт 834, аж ахуй үйлчилгээнд 2001, гэрээт хэсэгт 810 нийт 3,645 хоригдлыг хөдөлмөрөөр хангаж, өссөн дүнгээр нийт 3,348.1 сая төгрөгийн цалин бодогдсон ба нийт ял эдэлж буй хоригдлын 77 хувь нь ажлын байраар хангагдсан байна. Хөдөлмөрийн хөлснөөс гэмт хэргийн улмаас учирсан шүүхийн төлбөрт 523.0 сая төгрөгийг шилжүүлсэн. Цалинтай ажлын байраар 1,142 хоригдлыг хангасан. |
| | | | | 25.4.1.2 | Мэргэжлийн сургалтад хамрагдах хоригдол | тоо | 2023 | 489 | 490 | 1055 | | | | “Амгалан” мэргэжлийн боловсролын сургууль болон Аймаг орон нутгийн Мэргэжлийн боловсролын сургууль, Политехник коллежтой хамтран 13 төрлийн мэргэжлээр мэргэжлийн боловсрол олгох сургалт зохион байгуулж, 434 хоригдолд “Мэргэжлийн үнэмлэх”, 11 төрлийн мэргэжлээр 700 хоригдолд мэргэжлийн сургалт зохион байгуулж, “Чадамжийн гэрчилгээ” олгосон. 2025-2026 оны хичээлийн жилд мэргэжлийн боловсрол олгох сургалтад 450 хоригдол, 8 төрлийн мэргэжлээр амжилттай суралцаж байна. Тайлант хугацаанд мэргэжил олгох сургалтад 35 хоригдол 4 төрлийн мэргэжлээр суралцаж байна.Нийт ял эдэлж буй хоригдлын 560 нь дээд боловсролтой, 392 нь тусгай дунд боловсролтой, 1,595 нь бүрэн дунд боловсролтой, 944 нь бүрэн бус дунд боловсролтой, 564 нь бага боловсролтой, 517 нь боловсролгүй байгаагаас ерөнхий боловсролын сургалтад 198 хоригдол хамрагдсан. |
| | | | | 25.4.1.3 | Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа | хувь | 2023 | 53.3 | 58 | 38.2 | | | | Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны нийт 3.6 их наяд төгрөгийн 40,067 гүйцэтгэх баримт бичгийг биелүүлэхээс 689.5 тэрбум төгрөгийн 17,617 гүйцэтгэх баримт бичгийг бодитой биелүүлж, 2.9 их наяд төгрөгийн 22450 гүйцэтгэх баримт бичгийн үлдэгдэлтэй, бодит биелэлт 44.0 хувь, мөнгөн дүн 18.8 хувийн үзүүлэлттэй байна. Эрүүгийн хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны нийт 376.3 тэрбум төгрөгийн 11692 гүйцэтгэх баримт бичгийг биелүүлэхээс 35.0 тэрбум төгрөгийн 6213 гүйцэтгэх баримт бичгийг бодитой биелүүлж, 341.3 тэрбум төгрөгийн 5,479 гүйцэтгэх баримт бичгийн үлдэгдэлтэй, бодит биелэлт 53.1 хувь, мөнгөн дүн 9.3 хувийн үзүүлэлттэй байна.Захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагааны нийт 7.7 тэрбум төгрөгийн 446 гүйцэтгэх баримт бичгийг биелүүлэхээс 1.3 тэрбум төгрөгийн 193 гүйцэтгэх баримт бичгийг бодитой биелүүлж, 6.4 тэрбум төгрөгийн 253 гүйцэтгэх баримт бичгийн үлдэгдэлтэй, бодит биелэлт 43.3 хувь, мөнгөн дүн 17.5 хувийн үзүүлэлттэй байна.Зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны нийт 21.2 тэрбум төгрөгийн 2911 гүйцэтгэх баримт бичгийг биелүүлэхээс 11.3 тэрбум төгрөгийн 2,314 гүйцэтгэх баримт бичгийг бодитой биелүүлж, 9.9 тэрбум төгрөгийн 597 гүйцэтгэх баримт бичгийн үлдэгдэлтэй, бодит биелэлт 79.5 хувь, мөнгөн дүн 53.3 хувийн үзүүлэлттэй байна.Бусад хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны нийт 1.1 их наяд төгрөгийн 2,874 гүйцэтгэх баримт бичгийг биелүүлэхээс 58.0 тэрбум төгрөгийн 1,150 гүйцэтгэх баримт бичгийг бодитой биелүүлж, 1.0 их наяд төгрөгийн 1,724 гүйцэтгэх баримт бичгийн үлдэгдэлтэй, бодит биелэлт 40.0 хувь, мөнгөн дүн 5.2 хувийн үзүүлэлттэй байна. |
| | | | | 25.4.1.4 | Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны бодит биелэлт | хувь | 2023 | 83.6 | 84 | 62.5 | | | | Хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн 23,074, албадлагын арга хэмжээ авагдсан 8,648, хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан 151 нийт 31873 ялтан, этгээдээс 16,837 ялтан, этгээд хасагдаж, 2025 оны жилийн эцсийн байдлаар 15036 ялтан, этгээдэд хяналт тавин ажилласан. 2025 оны жилийн эцсийн байдлаар торгох ялын гүйцэтгэх баримт бичгийн бодит биелэлт 71.9 хувьтай, мөнгөн дүнгийн биелэлт 57.3 хувьтай байна. Биелүүлсэн мөнгөн дүнг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад бодит биелэлт 3.2 тэрбум төгрөг буюу 24.6 хувиар өссөн байна. 2025 оны жилийн эцсийн байдлаар хөрөнгө орлого хураах албадлагын арга хэмжээ авагдсан 1,237 гүйцэтгэх баримт бичгийг дуусгавар болгон гүйцэтгэх хуудасны бодит биелэлт 56.8 хувьтай, мөнгөн дүнгийн биелэлт 15.8 хувьтай. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад гүйцэтгэх баримт бичгийн бодит биелэлт 0.3 хувиар өссөн, мөнгөн дүнгийн бодит биелэлт 3 хувиар буурсан үзүүлэлттэй байна. |

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч | Хөтөлбөр | Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 25.4.1.5 | Хорих ял эдлэгсэд болон сэжигтэн амбулаторийн үзлэгт, урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах | хувь | 2023 | 72.6 | 74 | 73.8 | | | | Амбулаторийн болон халдварт, халдварт бус өвчнийг илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэгт 2025 онд давхардсан тоогоор 17,133 хоригдол болон хоригдсон этгээдийг хамруулсан байна. |
| | | | | 25.4.1.6 | Зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамруулах | хувь | 2025 | - | 60 | 112 | | | | “Бясалгалын сургалтыг анхан болон дунд гүнзгийрүүлсэн хэлбэрээр “Харилцаа бусдыг сонсох, хүлээцтэй байх чадвар”, “Танд аль төрлийн бясалгал тохирох вэ?”, “Хайр энэрэл, нинжин сэтгэл, эрч хүч”, “Бясалгалд эхнээс нь суралцахуй”, “Амьдарлаа эергээр өөрчлөх бясалгал”, сургалтыг тус тус зохион байгуулж, сургалтад давхардсан тоогоор 1959 хоригдлыг; “Мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэх” гэмт хэргээр ял шийтгүүлсэн хоригдлын зан үйлд нөлөөлөх сургалтыг ганцаарчилсан болон бүлгийн хэлбэрээр “Мансууруулах бодисын хор нөлөө”, “Сэтгэлзүйн эрүүл мэнд”, “Хорт зуршлаас татгалзъя”, “Хар тамхи ”, зэрэг сэдвийн хүрээнд зохион байгуулж нийт 1,413 хоригдлыг; “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт ял шийтгэгдсэн хоригдлын зан үйлд нөлөөлөх сургалтыг ганцаарчилсан болон бүлгийн хэлбэрээр зохион байгуулж, “Олон улсын гэр бүлийн эрх зүйн зохицуулалт”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”, “Гэр бүлийн боловсрол олгох сургалт”, “Гэр бүл түүний нийгмийн үүрэг”, “Гэр бүлийн гишүүдийн эрх үүрэг”, зэрэг сэдвээр нийт давхардсан тоогоор 1,624 хоригдлыг; “Согтууруулах ундаа хэрэглэх зуршилтай хоригдлуудад согтууруулах ундааны хэрэглээнээс татгалзах”, “Согтууруулах ундааны харшил”, Согтууруулах ундааны эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөө”, “Алкохолын талаарх 10 баримт”, “Архины харшил гэж юу вэ”,“Согтууруулах ундаа таны биед тохирохгүйг илтгэх шинж”, “Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль”, “Архи согтууруулах ундааны хор уршиг”, “Архины хэрэглээ ба осол гэмтэл”, зэрэг сэдвээр сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 7,220 хоригдлыг тус тус хамруулсан. |
| | 25.5 | **70406 Улсын бүртгэл, мэдээлэл** | | | | | | | | | | | | |
| | | 25.5.1 | Төрийн үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгжид хүргэх, цахимжуулах ажлыг хийж гүйцэтгэнэ. | 25.5.1.1 | Иргэний үнэмлэх олголт | мян.хүн | 2023 | 250 | 300 | 248.3 | 69,662,748.90 | 63,178,318.80 | 90.7% | 2025 оны байдлаар 248,340 иргэнд иргэний үнэмлэх олгосон бөгөөд шинээр 16 нас хүрсэн 66,098 иргэн, дахин олгосон 90,003 иргэн, 25 насны сунгалт 46,679 иргэн, 45 насны сунгалт 45,560 иргэнд тус тус олгосон байна. |
| | | | | 25.5.1.2 | Гадаад паспорт олголт | мян.хүн | 2023 | 350 | 350 | 279.2 | | | | 2025 оны байдлаар 279,152 иргэнд гадаад паспорт олгосон бөгөөд энгийн гадаад паспорт 9,070, цахим гадаад паспорт 270,082 хүнд тус тус олгосон байна. |
| | | | | 25.5.1.3 | Бэлтгэсэн улсын бүртгэлийн маягт | мянгаар | 2023 | 980 | 1,246.10 | 1,204.40 | | | | ХЗДХ-ийн сайдын баталсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасны дагуу улсын мэдээллийн маягтыг бэлтгэдэг. |
| | | | | 25.5.1.4 | Цахим хэлбэрт шилжүүлсэн архивын баримтын тоо /мянгаар/ | тоо | 2023 | 460 | 480 | 9300.4 | | | | Иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн архивын цаасан баримтыг цахимжуулж хэрэглээнд нэвтрүүлж, нэмэлтээр хувийн хэрэгт орох баримтыг тухай бүр цахим санд оруулсан бөгөөд бүртгэлийн өдөр тутмын болон мэдээлэл, лавлагаанд ашиглаж байна. |
| | | | | 25.5.1.5 | Төсвийн орлогын төлөвлөгөөг батлагдсан хуваарийн дагуу төвлөрүүлэх | сая.төг | 2023 | 21,050.80 | 45,730.00 | 25,614.60 | | | | Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 230 тоот тогтоолоор батлагдсан үнэ хураамжаар төлбөрийг хураан иргэдэд бүртгэлийн үйлчилгээ үзүүлж, жилд дунджаар 30.0-40.0 тэрбум төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлэн ажилладаг байсан ч 2025 онд "Цахим гадаад паспортын бэлдэц" худалдан авах санхүүжилтыг тодотголоор хассантай холбоотойгоор "Төрийн үнэт цаас хэвлэл" ТӨОХХК-д орлогоосоо 17.6 тэрбум төгрөг шилжүүлсэн шалтгаанаар улсын төсөвт төвлөрүүлэх орлого буурсан харагдаж байна. |

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч | Хөтөлбөр | Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 25 | 25.6 | **70707 Шүүх шинжилгээ** | | | | | | | | | | | | |
| | | 25.6.1 | Шүүх шинжилгээний үйлчилгээг чирэгдэлгүйгээр шуурхай авах нөхцөл бүрдэж, үйлчилгээний чанар хүртээмж сайжирч, шинжээчийн дүгнэлтийн чанар, үр дүн дээшилж, бие даасан хараат бус байдал хангагдаж, иргэд, үйлчлүүлэгчийн төрд итгэх үнэмшил, сэтгэл ханамжийн баталгаа нэмэгдэнэ. | 25.6.1.1 | Эдийн засгийн шинжилгээний дүгнэлт | тоо | 2023 | 111 | 100 | 210 | 60,368,251.10 | 49,262,683.70 | 81.6% | Шүүх шинжилгээний байгууллага 2025 онд эдийн засгийн шинжилгээний 3,111 объекттой 210 шинжилгээ хийсэн байна. |
| | | | | 25.6.1.2 | Шүүх эмнэлгийн шинжилгээний дүгнэлт | тоо | 2023 | 39881 | 38000 | 57580 | | | | Шүүх шинжилгээний байгууллага 2025 онд шүүх эмнэлэг 119,783 объекттой 5,7580 шинжилгээ хийсэн байна. Шинжилгээний төрлөөр ангилбал: Хүний эрүүл мэндэд учирсан хохиролын зэрэг тогтоох шинжилгээ 27,600, хүний биед хийсэн бусад шинжилгээ(бэлгийн холбогдолтой, нас тогтоох) 2,115, цогцост хийсэн шинжилгээ 5,504, шарилд хийсэн шинжилгээ(эксгумаци) 6, хэргийн материалаар хийсэн шинжилгээ 7,402 объекттой 1832 шинжилгээ, эд эсийн шинжилгээ 4,752 секцийн 67,657 блок шинжилгээ, сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэл тогтоох шинжилгээ 17280 объекттой 5,380 шинжилгээ, бичил амь судлалын 4,669 объекттой 1,592 шинжилгээ хийсэн байна. |
| | | | | 25.6.1.3 | Криминалистикийн шинжилгээний дүгнэлт | тоо | 2023 | 7025 | 7000 | 6962 | | | | Шүүх шинжилгээний байгууллага 2025 онд криминалистик 6,962 шинжилгээ хийсэн байна. Шинжилгээний төрлөөр ангилбал: Гарын мөр 4,396, мөр судлал 1,444, бичиг баримт 534, галт зэвсэг 565, материал судлал 23, бусад 0 шинжилгээ хийсэн байна. |
| | | | | 25.6.1.4 | Инженер-техникийн шинжилгээ | тоо | 2023 | 852 | 800 | 1539 | | | | Шүүх шинжилгээний байгууллага 2025 онд инженер техникийн 2,766 оъекттой 1,539 шинжилгээ хийсэн байна. |
| | | | | 25.6.1.5 | Байгалийн ухааны шинжилгээ | тоо | 2023 | 16397 | 16000 | 18993 | | | | Шүүх шинжилгээний байгууллага 2025 онд байгалийн ухаан 46,160 оъекттой 18,993 шинжилгээ хийсэн байна. Шинжилгээний төрлөөр ангилбал: Хими 22,117 объекттой 9,088 шинжилгээ, физик 1,049 объекттой 206 шинжилгээ, Биологи 9183 объекттой 5,675 шинжилгээ, ДНХ 11262 объекттой 3,640 шинжилгээ, хүрээлэн буй орчны шинжилгээ, үнэлгээ 2,549 объекттой 384 шинжилгээ байна. |
| | 25.7 | **70420 Цагаачлал, гадаадын иргэний бүртгэлийн үйлчилгээ** | | | | | | | | | | | | |
| | | 25.7.1 | Гадаадын иргэн, харьяалалгүй хүн, цагаач иргэний тооны зохист түвшнийг хадгалж, бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно. | 25.7.1.1 | Гадаадын иргэнд олгох виз | тоо | 2023 | 7956 | 7000 | 112895 | 18,844,170.00 | 16,343,392.20 | 86.7% | Тайлант хугацаанд 112.9 мянган гадаадын иргэнд виз олгосон. |
| | | | | 25.7.1.2 | Хяналтад хамрагдах Монгол Улсад түр болон байнга оршин суух гадаад иргэн | тоо | 2023 | 2116 | 2500 | 6336 | | | | Тайлант хугацаанд 6.3 мянган гадаадын иргэнийг хяналтанд хамруулсан байна. |
| | 25.8 | **70712 Эрх зүй, нийгмийн хэв журам, аюулгүй байдлын удирдлага, зохицуулалт** | | | | | | | | | | | | |
| | | 25.8.1 | Монгол Улсад шударга ёс, хууль дээдлэх зарчмыг хэрэгжүүлж, төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль, эрх зүйн баталгааг бүрдүүлнэ. | 25.8.1.1 | Боловсруулах баримт бичиг, хуулийн төсөл | тоо | 2023 | 35 | 26 | 26 | 32,565,161.60 | 26,267,554.70 | 80.7% | Батлагдсан 1 хууль - Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Их Хурлын 2024 оны 18 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд/Өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /11/<br>Боловсруулж байгаа хуулийн төсөл /14/ Үүнээс Нийтийн эрх зүйн хүрээнд /12/, Хувийн эрх зүйн хүрээнд /2/ байна. Мөн УИХ-ын тогтоолын төсөл /2/ өргөн барьсан. |
| | | | | 25.8.1.2 | Хянах эрх зүйн акт | тоо | 2023 | 1000 | 1000 | 740 | | | | 2025 онд нийт 740 захиргааны хэм хэмжээний актыг хянасан. Үүнд шинээр бүртгэсэн нь:<br>1.Захиргааны ерөнхий хуулийн 60, 61, 62 дугаар зүйлд заасан шаардлага хангасан 417 актыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд шинээр бүртгэсэн.<br>2.Захиргааны ерөнхий хуулийн 68 дугаар зүйлд заасны дагуу бүртгэлтэй хэм хэмжээний актад нэмэлт, өөрчлөлт оруулсан 80 акт болон хүчингүй болгосон шийдвэр 59 актыг тус тус үндэслэн захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд холбогдох хөдөлгөөнийг хийсэн болно.<br>3.Захиргааны хэм хэмжээний акт нь Захиргааны ерөнхий хуульд заасан шаардлага хангаагүй шийдвэрийн зөрчлийг арилгуулах тухай үндэслэл, тайлбар бүхий 142 дүгнэлт гарган холбогдох байгууллагад нь хүргүүлсэн.<br>4.Захиргааны ерөнхий хуулийн 66.3.3-т заасан үндэслэлээр захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэх шаардлагагүй 42 актыг бичгээр мэдэгдэн буцаан хүргүүлсэн. |
| | 25.9 | **70713 Эрх зүй, нийгмийн хэв журам, аюулгүй байдлын судалгаа, шинжилгээ** | | | | | | | | | | | | |
| | | 25.9.1 | Цагдаа, Онцгой байдал, Хил хамгаалах, Шүүх шинжилгээ, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны хүний нөөц бэлтгэгдэнэ. | 25.9.1.1 | Хөтөлбөрт хамрагдах сонсогч | тоо | 2023 | 2200 | 2200 | 2677 | 46,308,818.80 | 42,251,886.20 | 91.2% | Цагдаа, онцгой байдал, хил хамгаалах, шүүх шинжилгээ, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх хөтөлбөрүүдэд 2,677 сонсогч хамрагдаж байна. |
| | | **71602 Эмнэлгийн тусламж, үйлчилгээ** | | | | | | | | | | | | |
| | | | Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн | 25.10.1.1 | Амбулаторийн тусламж, үйлчилгээ | мян.хүн | 2023 | 160 | 202.7 | 192.9 | | | | Амбулаторийн тусламж үйлчилгээг дотор, мэдрэлийн 12 кабинет, мэс заслын 9 кабинет, уламжлалт, сэргээн засах эмчилгээ гэсэн нийт 21 нэр төрлийн үзлэгийн кабинетаар нарийн мэргэжлийн эмч үзлэг, зөвлөгөө өгч ажилласан. Эмнэлгийн үйлчлүүлэгчийн хүлээгдлийн мэдээг 7 хоногийн даваа гариг бүр тооцон гаргаж, амбулаторийн хүлээгдэлтэй кабинетад зохион байгуулалт хийж, эмч нэмэлтээр гарган үзлэг хийлгэж хүлээгдлийг бууруулан ажилласан. Эмнэлгийн амбулаторит 1 эмч 1 үйлчлүүлэгчид үзлэг хийх хугацаа нь 10 минут ба нэг өдөрт 48 үйлчлүүлэгчид үзлэг хийх нормтой байдаг. Мөн харъяа байгууллагуудын төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх үзлэгийг хувирын дагуу хийдэг. |
| | | | | 25.10.1.2 | Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ | мян.хүн | 2023 | 10 | 11.4 | 9.4 | | | | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас оношийн хамааралын бүлгээр хязгаар тогтоож байгаа тул зорилтот түвшинд хүрээгүй байна. |
| | | | | 25.10.1.3 | Өдрийн эмчилгээ | мян.хүн | 2023 | 1 | 1.6 | 2.2 | | | | Тус эмнэлэг нь өдрийн эмчилгээний тусламж үйлчилгээгээ нэмэгдүүлэж сэргээн засах өдрийн эмчилгээ, өдрийн мэс засалын эмчилгээг нээн ажилсанаар суурь түвшин нэмэгдсэн байна. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас оношийн хамааралтай бүлгээр хязгаар тогтоож байгаа тул тусламж үйлчилгээний хүрээ хумигдаж байгаа. |

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч | Хөтөлбөр | Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 25.1 | 25.10.1 | эмнэлгийн үйлчлэх хүрээний иргэн, албан хаагчид үзүүлэх тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 25.10.1.4 | Оношилгоо, шинжилгээ | мян.хүн | 2023 | 195 | 250 | 111.8 | 26,630.70 | 25,405.00 | 94.3 | Тус эмнэлэг нь 105 нэр төрлийн 285 багаж тоног төхөөрөмжөөр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг чанартай хүртээмжтэй үзүүлж байна. 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдөр тус эмнэлгийн Эмнэлзүйн нэгдсэн лаборатори нь "Эрүүл мэндийн лабораторийн чанар ба чадавхи тавих шаардлага" MNS ISO 15189:2015 стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн "Итгэмжлэгдсэн лаборатори" болсон. |
| | | | | 25.10.1.5 | Хилийн хөдөлгөөнт бүлгийн үзлэг /мянган/ | тоо | 2023 | 4 | 14.4 | 25.6 | | | | Хилийн хөдөлгөөнт 3 бүлэг, цэрэг татлагад 2 бүлэг томидогдон үүрэг гүйцэтгэсэн.<br>1-р бүлэг: 6 эмчийн бүрэлдэхүүнтэй баг давхардсан тоогоор нийт 2,790 алба хаагчид эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг хийж үүнээс 350 алба хаагчид хэвлийн хэт авиан шинжилгээ хийсэн байна.<br>2-р бүлэг: 4 эмчийн бүрэлдэхүүнтэй давхардсан тоогоор нийт 3,312 алба хаагчид эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг хийж үүнээс 631 алба хаагчид хэвлийн хэт авиан шинжилгээ хийсэн байна.<br>3-р бүлэг 6 эмчийн бүрэлдэхүүнтэй давхардсан тоогоор нийт 2,999 алба хаагчид эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг хийж үүнээс 571 алба хаагчид хэвлийн хэт авиан шинжилгээ хийсэн байна. Мөн 5 дугаар сар,10 дугаар сард цэрэг татлын урьдчилан сэргийлэх үзлэгт 19 эмчийн бүрэлдэхүүнтэй баг давхардсан тоогоор 15,300 хүнд үзлэг хийж хүрэх үр дүнг давуулан биелүүлсэн байна. |
| | 25.11 | **70411 Төрийн архив, албан хэрэг хөтлөлт** | | | | | | | | | | | | |
| | | 25.11.1 | Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, эрх зүйн таатай орчин бүрдүүлэх, архивын үйлчилгээ авч байгаа аж, ахуйн нэгж байгууллага, иргэнд үйлчлэх таатай орчин бүрдэнэ. | 25.11.1.1 | Стандартын дагуу бүрдүүлсэн хадгаламжийн нэгжийн тоо /мянгаар/ | тоо | 2023 | 15 | 5 | 8.3 | 7,102,181.40 | 6,986,760.50 | 98.40% | Нийт 18 хөмрөгийн 16 данс, 8 бүртгэлийн 1225-2024 оны 8,340 хадгаламжийн нэгжийн 806,286 хуудас баримтад эрдэм шинжилгээ, техник боловсруулалтын ажлыг хийсэн. боловсруулалт хийсэн. |
| | | | | 25.11.1.2 | Хэвлүүлсэн эрдэм шинжилгээ, судалгааны эмхэтгэл | тоо | 2023 | 6 | 6 | 6 | | | | “БНМАУ ЭЗХТЗ-д: евразийн эдийн засгийнинтеграцчилалд хүрэх замд. (1962-1991)” архивын баримтын эмхэтгэлийг орчуулж 300 ширхэг номыг 15,4 сая төгрөгөөр, “Монгол-Зөвлөлтийн улс төрийн харилцаа. 1953-1964” сэдэвт эмхэтгэлийг орчуулж 300 ширхэг эмхэтгэл 13 сая төгрөгөөр хэвлүүлсэн. |
| | | | | 25.11.1.3 | Стандартын дагуу дахин боловсруулалт, нөхөн сэргээлт хийсэн хадгаламжийн нэгж /мянгаар/ | тоо | 2023 | 13.5 | 15 | 8.8 | | | | Үндэсний төв архивын сан хөмрөгийн баримтаас нийт 8,864 хуудсыг сэргээн засварласан. |
| | | | | 25.11.1.4 | Стандартын дагуу баяжуулсан архивын сан хөмрөг /мянгаар/ | тоо | 2023 | 10 | 10 | 3.3 | | | | Нийт 33 байгууллагын 38 дансны 1225-2025 оны 20,778 хадгаламжийн нэгжийн 2,994,235 хуудас, 2025 онд ашиглалтад орсон 800 объектын 9,888 хавтаст хэрэг зураг төсөл, техникийн баримт бичиг, кино баримт-11, дүрс бичлэн -275, дуу авиа-180, гэрэл зураг-3,325 хадгаламжийн нэгж тус тус бүрдүүлэлтээр авсан. |
| | 25.12 | **70710 Төлбөрийн чадваргүй яллагдагч, сэжигтэнд эрх зүйн туслалцаа үзүүлэх** | | | | | | | | | | | | |
| | | 25.12.1 | Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн, хөндөгдсөн хүний хууль зүйн туслалцаа авах эрхийг хангаж, төрөөс хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх үйл ажиллагааг хууль зүйн зөвлөгөө өгөх, өмгөөллийн | 25.12.1.1 | Хууль зүйн зөвлөгөө, мэдээлэл авсан үйлчлүүлэгч | тоо | 2023 | 7687 | 14000 | 12617 | 9,393,725.40 | 6,816,936.50 | 72.6% | ХЗТТХуулийн 5.1.1 дахь туслалцааны төрлөөр үйлчилгээ үзүүлсэн хүний тоо 12,617 |
| | | | | 25.12.1.2 | Өмгөөллийн үйлчилгээ үзүүлсэн төлбөрийн чадваргүй үйлчлүүлэгч | тоо | 2023 | 7582 | 14000 | 12925 | | | | ХЗТТХуулийн 5.1.3 дахь туслалцааны төрлөөр 10,065 иргэнд үйлчилгээ, хуулийн 5.1.2 дахь туслалцааны төрлөөр 2,860 иргэнд үйлчилгээ тус тус үзүүлсэн |
| | 25.13 | **70713 Эрх зүй, нийгмийн хэв журам, аюулгүй байдлын судалгаа, шинжилгээ** | | | | | | | | | | | | |
| | | 25.13.1 | Хууль сахиулах салбарын судалгаа, шинжилгээний чиглэлийг оновчтой болгон, судлаачийн чадавхыг дээшлүүлж, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг нэмэгдүүлнэ. | 25.13.1.1 | Эрх зүйн сургалт, сурталчилгаа зохион байгуулах | тоо | 2023 | 200 | 220 | 215 | 3,595,434.20 | 3,562,384.60 | 99.10% | 1.Залуу судлаачдыг чадавхжуулах сургалт 1 /Залуу судлаачийг чадавхжуулах ажлын хүрээнд хууль зүйн англи хэлний сургалт зохион байгуулах ажлыг эрдэм шинжилгээний ажилтнуудын дунд 2025 оны 12 дугаар сарын 10-аас 13-ны өдрүүдэд зохион байгуулсан. 2.Дотоод сургалтыг 15 зохион байгуулсан. 3.Эрдэм шинжилгээний ажилтныг 5 удаагийн дотоод сургалт, 10 удаагийн гадаад сургалт, 43 удаагийн эрдэм шинжилгээний хуралд хамруулсан. 4.Хууль эрх зүйн чиглэлээр 59 сэдвээр мэдээ, мэдээлэл бэлтгэн түгээсэн, 13 зурагт хуудас болон 43 “reels” богино дүрс бичлэг”, 8 төрлийн подкаст хийж хүргэсэн байна. 5.Эрх зүйн албан бус сургалтыг 18 удаа зохион байгуулж 1,783 хүн хамрагдсан. |
| | | | | 25.13.1.2 | Эмхэтгэсэн эрдэм шинжилгээний судалгааны ажил | тоо | 2023 | 30 | 45 | 45 | | | | "Хууль дээдлэх ёс" сэтгүүлийг улиралд 1 удаа буюу 4 удаа хэвлэн гаргасан. Захиргааны хэм хэмжээний акт 37 дугаар хэвлэсэн. Судалгааны тайлан 4 удаа гаргасан. |
| | | **70709 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх** | | | | | | | | | | | | |
| | | 25.14.1 | Хамтарсан багийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ. | 25.14.1.1 | Суурь оны хэрэгжилтийн үр дүнг дараа оны хэрэгжилттэй харьцуулсан өсөлт | тоо | 2023 | 5000 | 7000 | 7000 | | | | Монгол Улсын Их Хурлаас Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр эцэслэн баталсан.Энэ хуулийн зохицуулалтаар хамтарсан багийн үйл ажиллагааг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар удирдлага, зохион байгуулалтаар хангах нэмэлт өөрчлөлт орсонтой холбоотойгоор Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зардлаас хамтарсан багуудад санхүүжилт олгох боломжгүй болсон. Энэ талаарх мэдээллийг Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хорооны 2026 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанд Хууль зүй, дотоод хэргийн сайд танилцуулсан. |

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч | Хөтөлбөр | Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 25.14.2 | Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдлэг, ойлголтыг сайжруулна. | 25.14.2.1 | Суурь оны сургалтад хамрагдсан хүүхдийн тоог дараа оны хамрагдах хүүхдийн тоотой харьцуулсан өсөлт | тоо | 2023 | 5000 | 7000 | 7000 | | | | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны даргын 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн А/16 дугаар тушаалаар Хүүхдээс үйлдсэн болон хүүхдийн эсрэг үйлдсэн гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, аливаа гэмт хэргийн хохирогч болсон хүүхдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр тодорхой ажил, арга хэмжээ зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Цагдаагийн ерөнхий газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газар, Боловсролын ерөнхий газар, Шүүх шинжилгээний ерөнхий газар, Дотоод хэргийн их сургууль, Монголын өмгөөлөгчдийн холбоо болон төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан байгуулсан. Тус ажлын хэсгээс:<br>-НҮБ-ын Хүн амын сантай хамтран Дотоод хэргийн их сургуулийн "Цагдаа судлал" бакалаврын сургалтын хөтөлбөрийн агуулгад бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийг хохирогч төвтэй, хүний эрхийн мэдрэмжтэй, үндэсний болон олон улсын удирдамж, зааварт нийцсэн аргачлалаар мөрдөн шалгах ур чадварыг тусгаж, “Сургагч багш бэлтгэх сургалтын хөтөлбөр”-ийг боловсруулсан.<br>-Насанд хүрээгүй хүнийг гэмт хэрэг, зөрчил, үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн болон хувийн өмчийн ерөнхий боловсролын сургуульд 146 өсвөрийн сэргийлэгч бүлгэмийг шинэчлэн байгуулж, 1,594 гишүүдийг “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх” сэдэвт сургалтад хамруулан, харьяа нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын хүүхдийн асуудал хариуцсан алба хаагч нар мэргэжил арга зүйгээр хангаж ажиллаж байна.<br>-“Өөрийн бодлоо чөлөөтэй илэрхийлэх чадварт суралцах”, “Өөрийгөө хамгаалах чадварт суралцах” сэдвээр 6 төрөл, бага насны хүүхдийн эрхийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах, эцэг, эх, асран хамгаалагчийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр “Аюул занал, сэтгэцийн гэмтэл дагуулсан үйл явдлын дараах хүүхдийн хариу үйлдэл, хамгаалах хүчин зүйл”, “ Аюул занал, сэтгэцийн гэмтэл дагуулсан үйл явдлын дараа илрэх үр дагавар”, “Хүүхэд бухимдлаа яаж гаргадаг вэ?”, “Хүүхдэд зүй бус хандсанаас үүсэх сөрөг үр дагавар” сэдвээр 4, нийт 12 төрлийн 250 ширхэг зөвлөмжийг зурагт хуудас хэлбэрээр бэлтгэн албаны мэдүүлэг авах өрөө, хүлээлгийн танхимд байршуулан иргэд, хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч нарт хүргэсэн.<br>-Хүүхдийг хүүхдээр нь дамжуулж гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон Өсвөрийн сэргийлэгч бүлгэмийн ажиллах журмын хэрэгжилтийг хангах, Өсвөрийн сэргийлэгч бүлгэмийн үйл ажиллагааг идэвхжүүлж, сургууль орчмын бүсэд тодорхой арга хэмжээ зохион байгуулах зорилгоор “Өсвөрийн сэргийлэгч-2025” аймаг, бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг 2025 оны 05 дугаар сард тус тус зохион байгууллаа. 2025 оны эхний хагас жилийн байдлаар улсын хэмжээнд төрийн 547, хувийн 25 ерөнхий боловсролын сургуульд 5909 гишүүнтэй Өсвөрийн сэргийлэгч бүлгэм |
| | | 25.14.3 | Малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар малчны мэдлэг, ойлголтыг сайжруулна. | 25.14.3.1 | Сургалт, сурталчилгаа хүрэх хүн | тоо | 2023 | 400 | 520 | 400 | | | | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дэргэдэх Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг нийт 19 заалттай баталсан. Нийт төлөвлөсөн 19 ажлын 1 ажил 30 хувь,11 ажил 85 хувь, 7 ажил 75 хувьтай бөгөөд нийт гүйцэтгэлийн дундаж 86.6 хувьтай буюу "үр дүнтэй" гэж дүгнэж байна. Мал бүхий 400 орчим иргэд энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар сургалт, мэдээлэл өгсөн байна. |
| | | 25.14.4 | Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гэмт хэргийн хор уршгийн талаарх иргэний хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлнэ. | 25.14.4.1 | Сургалт, сурталчилгаа хүрэх хүн | тоо | 2023 | 10000 | 30000 | 30000 | | | | Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөл 2025.02.19-ний өдөр 2025 оны анхдугаар хурлыг хийж, төлөвлөгөөний төслийг баталсан. Нийт 3 бүлэг , 23 ажил төлөвлөснөөс гүйцэтгэлийн биелэлт 93.5 хувьтай байна. Эрх зүйн мэдлэг дээшлүүлэх чиглэлээр 40,000 хүнийг хамруулсан байна. |
| | | 25.14.5 | Олон нийтийн телевиз, радио, сонин сэтгүүл, цахим хуудас зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллаж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийг өргөн хүрээнд сурталчилж, иргэний хууль, эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлнэ. | 25.14.5.1 | Сургалт, сурталчилгаа хүрэх хүн | тоо | 2023 | 50000 | 80000 | 80000 | | | | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн www.cccp.gov.mn www.familycenter.mn цахим хуудас болон фэйсбүүк, инстаграм, юүтүб сувагт 2025 онд нийт 65 контент, 58 рийл бичлэг оруулж, нийтэд түгээлээ. |
| | 25.14 | 25.14.6 | Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, төрийн болон төрийн бус, олон улсын байгууллагын хамтын ажиллагааг сайжруулна. | 25.14.6.1 | Суурь оны хэрэгжилтийн үр дүнг дараа оны үр дүнтэй харьцуулсан өсөлт | тоо | 2023 | 2000 | 7000 | 6300 | 2,404,428.90 | 1,873,149.60 | 77.9% | Бүгд Найрамдах Казахстан Улсын Ерөнхий прокурорын байгууллагын дэргэдэх Хууль сахиулах байгууллагын академийн багш нарыг урьж, “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг цахим орчинд худалдан борлуулж байгаа гэмт үйлдлийг илрүүлэх, сүүлийн үеийн нөхцөл байдал, цаашдын чиг хандлага, анхаарах асуудал” сэдэвт сургалтыг 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр зохион байгуулж, нийт 45 алба хаагчид хамрагдсан.<br>Америкийн Нэгдсэн Улсын Нэгдсэн Улсын Калифорни мужийн Сан Диего хотод үйл ажиллагаа явуулдаг “Сентир Глобал” олон улсын байгууллагын мэргэжилтнүүд энэ оны 06 дугаар сарын 09-13-ны өдрүүдэд Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх чиг үүргийн 52 алба хаагчдад “Хүний зан үйлээр аюул заналхийллийг таньж мэдэх” сэдэвт сургалтыг зохион байгуулсан.<br>Япон улсын донтох эмгэгийн салбар, анагаахын шинжлэх ухааны салбарын доктор, профессор, сэтгэл засалч эмч, нийгмийн ажилтан, мэргэжилтнүүдийг урьж, “Донтох эмгэгтэй хүнд үзүүлэх сэтгэц-нийгмийн сэргээн засах тусламж, үйлчилгээ” сэдвээр 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр сургалт зохион байгуулж, сургалтад холбогдох байгууллагуудын 25 алба хаагч хамрагдсан. |

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч | Хөтөлбөр | Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 25.14.7 | Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчилд холбогдох эрсдэл бүхий зорилтот бүлгийн талаар мэдээлэл солилцох дундын мэдээллийн санг үйл ажиллагаандаа ашиглана. | 25.14.7.1 | Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий байгууллагаас дундын мэдээллийн санд хамрагдах байгууллага | тоо | 2023 | 2 | 5 | 5 | | | | Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх Үндэсний хорооны 2025 оны I хуралдаанаар Хууль зүй, дотоод хэргийн яамнаас боловсруулсан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай” хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанд танилцуулж, Улсын Их Хуралд өргөн барих, мансууруулах үйлчилгээтэй зэрлэг олсны /каннабис/ ургамлын тархац тогтоогдсон нэр бүхий аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт “Устгал” нэгдсэн арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах, Согтуурах, мансуурах донтой иргэдийг албадан болон сайн дурын эмчилгээний дараа нөхөх сэргээх, бататгах эмчилгээнд хамруулах “Төвийг” байгуулах, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2018 оны “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай” 06/05 дугаар зөвлөмжийн хэрэгжилтийг анхаарч ажиллахыг үүрэг болгосон. Нийт 8 дундын мэдээллийн сангаас мэдээлэл авч байгаа. |
| | | 25.14.8 | Согтуурах, мансуурах донтой хүнийг албадан болон сайн дурын үндсэн дээр эмчлэх эмчилгээний байгууллага, төвийн тоог нэмэгдүүлнэ. | 25.14.8.1 | Сайн дураар эмчлэх төв | тоо | 2023 | 1 | 3 | 2 | | | | Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А/142 дугаар тушаалаар "Сэргээн засах төв" байгуулах ажлыг судалж, жишиг төв байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан, хурлыг 2 удаа зохион байгуулж, Согтуурах мансуурах донтой хүнд тусламж үйлчилгээ үзүүлэх сэргээн засах төвийг эхний ээлжинд Баянзүрх дүүргийн “Энэрэл эмнэлэг”, Сонгинохайрхан дүүргийн “Нийгэм хамгааллын тусгай төв”, Налайх дүүргийн “Эрүүл мэндийн төв”-ийг түшиглэн байгуулахаар судлан ажиллаж байна. |
| | | 25.14.9 | Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт ургамлын тархцыг хязгаарлаж, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх ажилд ахиц гаргана. | 25.14.9.1 | Суурь оны хэрэгжилтийн үр дүнг дараа оны үр дүнтэй харьцуулсан өсөлт | тоо | 2023 | 3000 | 5000 | 4000 | | | | Хууль зүй, дотоод хэргийн сайд, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын энэ оны 05 дугаар сарын 06-ны өдрийн “Нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах тухай” А/154, А/276 дугаартай хамтарсан тушаалаар улсын хэмжээнд “Устгал-2025” нэгдсэн арга хэмжээг зохион явуулах төлөвлөгөө, удирдамжийг батлуулж, Ажлын албанаас устгал арга хэмжээнд ажиллах алба хаагчдын томилолтын зардлыг шийдвэрлэж, Нийслэл, олсны ургамлын тархац бүхий аймгуудын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Засаг даргын нөөц хөрөнгөөс нийт 201.0 сая төгрөгийг шийдвэрлүүлэн нэгдсэн арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулсан.<br>Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгээс дрон ашиглан хор цацах, хиймэл дагуулын мэдээн дээр үндэслэн уг ургамлын тархцыг хянах, жалга судаг, эвдэгдсэн газар ургах орчинд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэхийг зөвлөсөн. Улаанбаатар хот, тархац бүхий 11 аймгийн 51 сумын 1,923.9 га талбайд зэрлэг байдлаар ургасан олсны ургамлыг химийн хор цацах, гараар түүх, хадах, шатаах, хөрс эргүүлэх зэрэг аргаар устгасан. Мөн Увс аймгийн нутаг дэвсгэрт байрлах тархац бүхий 0.7 га газрыг нөхөн сэргээж, мод тарих (бургас) аргыг нэвтрүүлсэн байна. |
| | | 25.14.10 | Иргэн гэр бүлдээ амар тайван, аюулгүй амьдрах орчин нөхцөлийг олгох, хүүхэд эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулна. | 25.14.10.1 | Сургалт, сурталчилгаа хүрэх хүн | тоо | 2023 | 100000 | 120000 | 120000 | | | | 1. “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь” төслийн хүрээнд “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн Зорчигч тээврийн албаны албан хаагчдын хүн худалдаалах гэмт хэргийн талаарх мэдлэг, ойлголтыг нь дээшлүүлэх зорилгоор “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг таньж, илрүүлэх нь” сургалтыг энэ сарын 28-30-ны өдрүүдэд зохион байгууллаа. Сургалтад УБТЗ ХНН-ийн 135 (эр-16, эм-116) албан хаагч хамрагдсан.<br>2.“Кибер орчныг ашиглаж үйлдсэн хүн худалдаалах гэмт хэрэг (ХХГХ)-ийн мөрдөн шалгах ажиллагаа” бүсчилсэн сургалтыг 2025 онд улсын хэмжээнд зохион байгуулж, нийт 356 (эр-277, эм-79) мөрдөгч, прокурорыг хамрууллаа.<br>3.Хилийн боомт дахь хилийн хяналтын байгууллагын албан хаагчдад зориулсан сургалтыг 2025 оны 01 дүгээр сарын 09, 10-ны өдөр Дорноговь аймгийн Замын-Үүд боомтод, 2025 оны 06 дугаар сарын 26, 27-ны өдөр Баян-Өлгий аймгийн Цагааннуур боомтод, 2025 оны 08 дугаар сарын 17, 18-ны өдөр Өмнөговь аймгийн Гашуунсухайт боомтод тус тус зохион байгуулж, хүн худалдаалах гэмт хэргийн нөхцөл байдал, чиг хандлага, урьдчилан сэргийлэх, илрүүлэх, хилийн боомтуудын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага, Монгол Улсын хилээр хүүхэд нэвтрүүлэхэд анхаарах асуудал болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хэрэглэсэн хүнд илрэх шинж тэмдгийн талаар ойлголт мэдлэг эзэмшүүллээ. Сургалтад хилийн боомтын байгууллагуудын 227 (эрэгтэй-119, эмэгтэй-108) алба хаагчийг хамрууллаа.<br>4.“Зорчигчийг хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд хамтын ажиллагааг бэхжүүлэх” сургалтыг 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдөр Сэлэнгэ аймагт зохион байгуулж, сургалтад тус аймгийн цагдаа, гааль, гадаадын иргэн харьяат, хилийн цэргийн 0101 дүгээр анги, тагнуулын хэлтсийн төлөөллөөс бүрдсэн нийт 40 ажилтан, алба хаагч хамрагдлаа.<br>5.Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй, хүүхдэд ээлжтэй форензик ярилцлагын арга зүй” сэдэвт сургалтыг 2025 оны 06 дугаар сарын 16, 17-ны өдрүүдэд зохион байгуулж, сургалтад Мөрдөн байцаах албаны Хүүхдийн эсрэг болон хүүхдээс үйлдсэн гэмт хэргийн мөрдөх хэлтэс, Кибер гэмт хэрэгтэй газар, төв, орон нутгийн цагдаагийн газрын хүүхдийн гэмт хэрэг мөрдөх чиг үүргийн 86 албан хаагч хамрагдлаа.<br>6.Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг даган гарсан шинэчлэн найруулан батлуулсан журмуудыг танилцуулах, гадаад харилцааны болон гадаадын иргэн, харьяатын газрын алба хаагч, мэргэжилтнүүдийн ур чадварыг дээшлүүлэх сургалтыг 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр зохион байгууллаа. Сургалтад гадаад харилцааны болон гадаадын иргэн, харьяатын газрын хяналтын 32 байцаагч танхимаар оролцож, хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газрын 30 алба хаагч цахимаар хамрагдлаа.<br>7.Гадаад улсын дипломат төлөөлөгчийн газар, консулын газарт шинээр томилогдсон ажилтнуудын хүн худалдаалах гэмт хэргийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг 2025 оны |
| | ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД | | | | | | | | | | | | | |
| | | 71107 Зам тээврийн бодлого, удирдлага | | | | | | | | | | | | |
| | | 26.1.1 | Товлолт хугацаанд техникийн үзлэгт хамрагдах байдлыг нэмэгдүүлнэ. | 26.1.1.1 | Авто тээврийн хэрэгслийн үзлэг оношилгооны хамрагдалт | хувь | 2024 | 55 | 75 | 71.3 | | | | Авто тээврийн хэрэгслийн үзлэг оношилгооны хамрагдалт 2024 онд 55 хувийн гүйцэтгэлтэй байсан бол 2025 онд 71.3 хувь болж нэмэгдсэн. |

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч | Хөтөлбөр | Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 26 | 26.1 | 26.1.2 | Авто тээврийн үйлчилгээний эргэлтийг нэмэгдүүлнэ. | 26.1.2.1 | Зорчигч эргэлт | мянган хүн | 2024 | 142,800.00 | 145,000.00 | 175,508.70 | 929,712,297.00 | 678,710,141.00 | 73% | Нийслэлийн нийтийн тээвэрт парк шинэчлэлт хийж маршрутыг оновчтой болгосонтой холбогдуулан нийслэлийн нийтийн зорчигч тээврийн эргэлт нэмэгдсэн. |
| | | | | 26.1.2.2 | Ачаа эргэлт | мянган тонн | 2024 | 71,200.00 | 80,000.00 | 96,526.50 | | | | Хилийн боомтууд руу чиглэсэн дэд бүтэц болон нэвтрүүлэх хүчин чанадал нэмэгдсэнээр Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын хэмжээ өсч үүнтэй холбогдуулан ачаа тээврийн эргэлт 96 сая тоннд хүрсэн. |
| | | 26.1.3 | Байнгын ашиглалтад оруулах авто замын нийт хүчин чадлыг нэмэгдүүлнэ. | 26.1.3.1 | Ашиглалтад оруулах олон улс, улсын болон орон нутгийн чанартай авто зам | км | 2024 | 1,100 | 1245.61 | 1430.3 | | | | Ховд-Алтай чиглэлийн авто замаас Чандмань сум хүртэлх 56.9 км хатуу хучилттай авто зам, Чойр-Мандалговь-Арвайхээр чиглэлийн хэвтээ тэнхлэгийн авто зам, Арвайхээр-Мандалговь чиглэлийн хатуу хучилттай авто зам, Ховд аймгийн Булган, Буянт сумын 2.5 км авто зам, Баян-Өлгий аймгийн Бугат сумын 5.8 км авто зам, Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 4.8 км авто зам, Жаргалтхаан-Дэлгэрхаан чиглэлийн 59.2 км авто зам, Хужирт-Бат-Өлзий чиглэлийн 49 км авто зам, Хамрын хийдийн 3 замын уулзвараас Зүүнбаян чиглэлийн 20 км авто зам, Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замаас Дуган хад чиглэлийн 8.5 км авто зам, Булган-Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг чиглэлийн авто зам, Өндөрхаан-Норовлин чиглэлийн 130 км авто зам, Хөвсгөл аймгийн Тариалан сумын 6.3 км авто замуудыг тус тус барьж ашиглалтад оруулсан. |
| | | 26.1.4 | Байнгын ашиглалтад оруулах гүүрний нийт хүчин чадлыг нэмэгдүүлнэ. | 26.1.4.1 | Байнгын ашиглалтад оруулах гүүрний нийт хүчин чадал | урт/метр | 2024 | 283.69 | 274.45 | 217 | | | | Улсын төсвийн 8,913,635,418 төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баян-Өлгий аймгийн Алтанцөгц сумын Ховд голын 217 у/м төмөрбетон гүүрийг барьж ашиглалтад оруулсан. |
| | | 26.1.5 | Улсын чанартай авто замын сүлжээнд эзлэх хатуу хучилттай авто замын уртыг нэмэгдүүлнэ. | 26.1.5.1 | Хатуу хучилттай авто замын нийт авто замын сүлжээнд эзлэх хувь | хувь | 2024 | 53 | 57.7 | 53.4 | | | | Дээрх улсын болон орон нутгийн чанартай авто замуудыг барьж байгуулснаар хатуу хучилттай авто замын сүлжээнд эзлэх хувь нэмэгдсэн. |
| | 26.2 | **71101 Авто зам** | | | | | | | | | | | | |
| | | 26.2.1 | Авто зам, гүүрний аюулгүй байдлыг хангана. | 26.2.1.1 | Урсгал засвар, арчлалт хийх авто замын нийт хүчин чадал | км | 2024 | 14,921.30 | 14,921.30 | 14,909.00 | 78,150,975.00 | 78,150,975.00 | 100% | Олон улсын болон улсын чанартай нийт 14909 км авто замын урсгал засварын ажлыг нийт 30 төрийн болон хувийн өмчийн зам засвар арчлалтын компаниудаар гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн. |
| | | | | 26.2.1.2 | Урсгал засвар, арчлалт хийх гүүрний нийт хүчин чадал | урт/метр | 2024 | 16,098.60 | 16,098.60 | 17,590.90 | | | | Олон улсын болон улсын чанартай авто замын дагуух нийт 17590 у/м гүүрийн урсгал засварын ажлыг нийт 30 төрийн болон хувийн өмчийн зам засвар арчлалтын компаниудаар гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн. |
| | | 26.2.2 | Авто замын байгууламж болон засварын үр ашгийг нэмэгдүүлнэ. | 26.2.2.1 | Эрдэм шинжилгээ, туршилт, судалгаа | тоо | 2024 | 2 | 4 | 0 | | | | Авто замын норм, нормативийн сангийн хөрөнгөөр авто замын эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хийж гүйцэтгэж байна. |
| | | | | 26.2.2.2 | Лабораторийн туршилт, шинжилгээний дүгнэлт | тоо | 2024 | 1,100 | 1,350 | 0 | | | | Зам, тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын итгэмжлэгдсэн лабораторид авто зам, гүүрийн материалын туршилт шинжилгээг тогтмол хийж гүйцэтгэн дүгнэлтийг тухай бүрт гаргаж ажилладаг. |
| | 26.3 | **71103 Төмөр зам** | | | | | | | | | | | | |
| | | 26.3.1 | Төмөр замын байгууллагын галт тэрэгний хөдөлгөөний зохицуулалт, уялдаа холбоог сайжруулна. | 26.3.1.1 | Үйл ажиллагааны гүйцэтгэл | хувь | 2024 | 98 | 100 | 96.4 | 1,581,501.00 | 1,535,811.00 | 97% | Төмөр замын хөдөлгөөний нэгдсэн удирдлагын төвийн барилгын ажлыг бүрэн дуусгаж ашиглалтад оруулсан. |
| | | 26.3.2 | Төмөр замын бүтээн байгуулалтыг эрчимжүүлнэ. | 26.3.2.1 | Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын төслийн ажлын гүйцэтгэл | хувь | 2024 | 75 | 100 | 100 | | | | Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замыг бүрэн ашиглалтад хүлээн авч, тээврийн үйл ажиллагаа эхлүүлсэн. |
| | | | | 26.3.2.2 | Гашуунсухайт-Ганцмод чиглэлийн хил дамнасан төмөр замын төслийн ажлын гүйцэтгэл | хувь | 2024 | 1 | 10 | 8 | | | | Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл 31.95 хувьтай байна. |
| | | | | 26.3.2.3 | Арцсуурь боомт-Шивээхүрэн боомт чиглэлийн баруун босоо 1255 км төмөр замын төслийн ажлын гүйцэтгэл | хувь | 2024 | 1 | 10 | 1 | | | | Арцсуурь-Шивээхүрэн-Нарийнсухайт чиглэлийн төмөр замын төслийн урьдчилсан үнэлгээг боловсруулан ЭЗХЯ-нд хүргүүлсэн. Урьдчилсан үнэлгээг үндэслэн ЭЗХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2026 оны А/61 дугаар тушаалаар төслийн бүрэн шинжилгээний багт томилогдон ажиллаж байна. |
| | | | | 26.3.2.4 | Шивээхүрэн-Сэхээ боомтын хил дамнасан 6.9 км төмөр замын холболтын ажлын гүйцэтгэл | хувь | 2024 | 99 | 100 | 100 | | | | Шивээхүрэн-Сэхээ боомтын хил дамнасан 6.9 км төмөр замын төслийг бүрэн ашиглалтад оруулсан. Хил холболтыг эрчимжүүлэх, хятадын талтай яриа хэлэлцээ хийх, хэлэлцээр байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг ЭЗХС-ын 2026 оны А/60 дугаар тушаалаар байгуулсан бөгөөд ажлын хэсэгт орж ажиллаж байна. |
| | | | | 26.3.2.5 | Шинэ төмөр замуудаар тээвэрлэх ачаа | мянган тонн | 2024 | 9,000.00 | 10,000.00 | 11,726.00 | | | | Төмөр замын тээврийн салбарт энэ оны эхний 4 сарын байдлаар нийт 19.9 сая тонн ачаа тээвэрлэсэн бөгөөд үүнээс шинэ төмөр замуудаар 7.4 сая тонн ачаа тээвэрлээд байна. |
| | 26.4 | **71104 Агаарын тээвэр** | | | | | | | | | | | | |
| | | 26.4.1 | Агаарын тээврийн үйлчилгээг нэмэгдүүлнэ. | 26.4.1.1 | Олон улсын өнгөрөлтийн нислэг | мян.нислэг | 2024 | 39.7 | 41.2 | 81.1 | 4,057,256.00 | 3,468,532.00 | 85% | Зам, тээврийн сайдын 2025.02.12-ны өдрийн "Агаарын зам шинэчлэн тогтоох тухай" А/36-р тушаалаар нийт 49 (33 чиг шулуун агаарын зам, үзүүлэлтэд тулгуурласан 16 RNAV5) агаарын замыг шинэчлэн тогтоосон. Үүний үр дүнд 2025 онд 81.1 мянган өнгөрөлтийн нислэг үйлдэгдсэн нь өмнөх оноос 20%-иар өссөн үзүүлэлт юм. |
| | | | | 26.4.1.2 | Буулт, хөөрөлт | мян.нислэг | 2024 | 20.8 | 29.1 | 27.6 | | | | 2025 онд олон улсын 15,352, орон нутгийн 12.228 буюу нийт 27,580 буулт, хөөрөлт үйлдэгдсэн нь 2024 оноос 17%-иар өссөн байна. |
| | | | | 26.4.1.3 | Ачаа тээвэрлэлт | мян.тонн | 2024 | 12 | 10 | 12.5 | | | | 2025 онд нийт 12,505 тн ачаа шуудан тээвэрлэсэн нь 2024 оноос 20%-иар өссөн байна. |
| | | | | 26.4.1.4 | Зорчигч тээвэрлэлт | мян.хүн | 2024 | 1,845 | 1,931 | 2,448 | | | | Агаарын тээврийн либералчлалыг үргэлжлүүлж, 2025 онд 4 улстай агаарын харилцааны хэлэлцээр шинээр байгуулж, Шанхай, Эрээн, Сингапур чиглэлд шинээр нислэг гүйцэтгэж эхэлсэнтэй холбогдуулан 2025 онд зорчигчийн тоо 2,448,415 болж, 2024 оноос 13%-иар өссөн. |
| | **БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД** | | | | | | | | | | | | | |
| | | **70601 Зэвсэгт хүчний үйл ажиллагаа** | | | | | | | | | | | | |

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч | Хөтөлбөр | Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 27 | 27.1 | 27.1.1 | Зэвсэгт хүчнийг "Нисгэгчгүй нисэх хэрэгсэл", "Дрон", "Хиймэл оюун ухаан"-д суурилсан дэвшилтэт техник, хэрэгслээр хангана. | 27.1.1.1 | Техник хэрэгслийн хангалт | хувь | 2023 | 9 | 20 | 20 | 784,565,524.60 | 769,890,625.85 | 98.13% | |
| | | 27.1.2 | Энхийг дэмжих ажиллагааны чадавхыг нэмэгдүүлэх, зэвсэглэл, цэргийн техникийг шинэчилнэ. | 27.1.2.1 | Бэлэн байдлын түвшин | хувь | 2023 | 18 | 28 | 26.5 | | | | |
| | | 27.1.3 | Иргэний эх орноо хамгаалах бэлтгэлжилтийг дээшлүүлэх, цэргийн сургалт бэлтгэл, хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлнэ. | 27.1.3.1 | Хэрэгжилтийн хувь | хувь | 2023 | 25 | 30 | 29.7 | | | | |
| | | 27.1.4 | Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бүрдүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 27.1.4.1 | Арга хэмжээний хэрэгжилт | хувь | 2023 | 10 | 15 | 15 | | | | |
| | **БОЛОВСРОЛЫН САЙД** | | | | | | | | | | | | | |
| | | **71801 Сургуулийн өмнөх боловсрол** | | | | | | | | | | | | |
| | 28.1 | 28.1.1 | Сургуулийн өмнөх боловсролын чанартай үйлчилгээгээр бага насны хүүхдийн цогц хөгжлийн суурийг тавина. | 28.1.1.1 | 5 настай хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлын улсын дундаж гүйцэтгэл | хувь | 2023 | 70.2 | 71 | 69.5 | 1,112,709,885.50 | 1,053,589,835.17 | 95% | Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээгээр хүүхдийн сургуульд суралцахад шаардлагатай мэдлэг, чадвар, хандлагын түвшинг тогтоодог. 2021 оноос хойш авч байгаа. 2021-2022 оны хичээлийн жилд сургуульд бэлтгэгдсэн байдлын улсын дундаж 60.7 байсан. Боловсролын үнэлгээний төвийн 2024 оны "Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээ"-ний улсын дундаж гүйцэтгэлээр тооцсон. 2025 онд тус үнэлгээг хийгээгүй тул 2024 оны үр дүнгээр гүйцэтгэлийг тооцов. |
| | | 28.1.2 | Сургуулийн өмнөх боловсролд бүх хүүхэд хамрагдах тэгш боломж бүрдүүлнэ. | 28.1.2.1 | Сургуульд элсэн орохын өмнөх 1 жилд сургуулийн өмнөх боловсролын зохион байгуулалттай сургалтад хамрагдсан суралцагч | хувь | 2023 | 96.8 | 97 | 98.5 | | | | Тогтвортой хөгжлийн зорилт 4, Боловсролын ерөнхий хуульд хүүхдийг таван настайд нь сургуулийн өмнөх боловсролд заавал хамруулахаар заасан.<br>Таван настай хүүхдийн хамран сургалтыг 2025-2026 оны хичээлийн жилд 96 хувьд хүргэсэн, 2022 онтой харьцуулахад 5 настай хүүхдийн хамран сургалт 2.6 пунктээр өссөн (5 настай 76,380 хүүхдээс 73,344 нь СӨБ-д хамрагдаж байгаа). 2030 онд 100 хувь хамруулах зорилт тавин ажиллаж байна. |
| | | | | 28.1.2.2 | Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт | хувь | 2023 | 93.4 | 94 | 93 | | | | 2024 оны байдлаар Монгол Улсын нийт хүн ам 3,5 сая хүн байгаагаас 7.8 хувь (278,290) нь 2-5 насны хүүхэд эзэлж байсан бол Улсын хэмжээнд төрөлт 2019 оноос хойш буурч байгаа статистик үзүүлэлт гарсан ба 2025 онд 56,695 хүүхэд мэндэлсэн нь сүүлийн 7 жилийн хамгийн доод үзүүлэлт буюу 28.7(22885) хувиар буурсан. Засгийн газраас сургуулийн өмнөх боловсролын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр үе шаттай арга хэмжээ авч хэрэгжүүлсний үр дүнд 2021 (80.5%) оноос 2025 (93 хувь) онд 12,5 хувиар сургуулийн өмнөх боловсролын хамрагдалт өссөн.<br>Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд сургуулийн өмнөх боловсролд хоёроос таван насны хүүхдийг хамруулах, сургуулийн өмнөх боловсролыг таван настай хүүхэд заавал эзэмших, 200-аас доошгүй цагийн сургалтад хамрагдсан байхаар туссан.<br>2025-2026 оны хичээлийн жилд улсын хэмжээнд сургуулийн өмнөх боловсролын 1,399 байгууллагад (орон нутгийн өмчийн 1046(75%), хувийн өмчийн 353 (25 хувь) 2-5 насны 278,290 хүүхэд байгаагаас 258,849 (93 хувь) нь цэцэрлэгт хамрагдаж байгаа нь өмнөх оноос 2,4 хувиар, 5 настай хүүхдийн хамран сургалт 96% буюу 1.9 хувиар тус тус өссөн.<br>2022 онтой харьцуулбал 2025 онд сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан малчдын хүүхдийн тоо 677-оор нэмэгдсэн бол нийт 2,175 хүүхэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшиж байна.<br>Хувилбарт сургалтад нийт 10,048 хүүхэд /нүүдлийн бүлэг-7,098, явуулын багшийн сургалтад-2,950/ хамрагдаж байна. |
| | | | | 28.1.2.3 | Сургуулийн өмнөх боловсролын стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан цэцэрлэг | хувь | 2021 | 60 | 66 | 66 | | | | Монгол Улсын хэмжээнд “Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчин ерөнхий шаардлага"" /MNS 6558:2015/ хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.Улсын хэмжээнд сургалтын орчны стандарт өөрийн үнэлгээний дундаж 84.4 хувьтай байна. Үүнээс 21 аймгийн дундаж 83.5 хувь, нийслэлийн дундаж 85.2 хувьтай үнэлэгдсэн байна. Стандартын шаардлага хангасан цэцэрлэгийн барилгын эзлэх хувь 2020 онд 87.2 хувь байсан бол 2025 онд 90.2 хувь болж нэмэгдсэн. |
| | | **71802 Ерөнхий боловсрол** | | | | | | | | | | | | |
| | | 28.2.1 | Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, | 28.2.1.1 | Унших суурь чадвар эзэмшсэн 9 дүгээр ангийн суралцагчийн гүйцэтгэлийн дундаж /монгол хэлний шалгалтын гүйцэтгэлийн дундаж/ | хувь | 2021 | 41.1 | 52 | 57.8 | | | | Монгол Улс 2022 онд анх удаагаа Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-аас зохион байгуулдаг PISA (Programme for International Student Assessment) нь суурь боловсрол эзэмшсэн 15 настай суралцагчид танхимаар олж авсан мэдлэг, чадвараа амьдрал дээр хэрхэн хэрэглэж байгаа, тухайн улсын боловсролын тогтолцоо энэ чадварыг ямар хэмжээнд олгож байгааг тандан судалдаг сурлагын амжилтын олон улсын үнэлгээнд хамрагдсан. 2022 оны үнэлгээнд OECD-ийн орнуудын математикийн чиглэлээр дундаж оноо 472, Азийн орнуудын дундаж 451 оноо байсан нь Монгол Улс дундаж гүйцэтгэл 425 оноогоор 81 орноос 47-рт жагсаад байна. Математикийн энэ үзүүлэлт нь PISA-аас тухайн улсын орлогод суурилж таамагласан хүлээлтээс өндөр гарсан. Унших чадварын хувьд OECD-ийн орнуудын дундаж 476 оноо, Азийн орнуудын дундаж 427 ононоос Монгол Улс 378 оноо авсан. Ерөнхий боловсролын сургуулийн багшийн гүйцэтгэлийн үнэлгээний хүрээнд суралцагчдаас авдаг бичгийн шалгалтын дунджаар тооцоход 9 дүгээр анги төгсөгчдөөс авдаг монгол хэлний шалгалтын гүйцэтгэлийн дундаж 56.8 болж өнгөрсөн жилээс 4.8 хувиар ахисан, математикийн хичээлээр суурь чадвар эзэмшсэн 9 дүгээр ангийн суралцагч (математикийн шалгалтын гүйцэтгэлийн дундаж 48.1 болж) өнгөрсөн хичээлийн жилээс 13.1 хувиар ахисан үзүүлэлэлттэй байна. |

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч | Хөтөлбөр | Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 28 | 28.2 | 28.2.1 | чадварыг дээшлүүлнэ. | 28.2.1.2 | Математикийн хичээлээр суурь чадвар эзэмшсэн 9 дүгээр ангийн суралцагчийн гүйцэтгэлийн дундаж | хувь | 2021 | 33.7 | 35 | 48.1 | 2,257,582,738.50 | 2,134,215,371.35 | 94.5% | Багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд хамрагдсан 1-9 ангийн суралцагчдын математикийн гүйцэтгэл нийслэлд 61.3, орон нутагт 54.6, монгол хэлний хичээлийн гүйцэтгэл нийслэлд 55.8, орон нутагт 53.8 байгаа нь хот хөдөөгийн боловсролын чанарын ялгаа байгааг илтгэж байгаа. Цаашид энэ зөрүүг бууруулахад “Монгол хүүхэд бүрийг мэдлэгийн хоцрогдлоос чөлөөлөх” арга хэмжээ чиглэнэ. |
| | | | | 28.2.1.3 | Элсэлтийн шалгалтын хэмжээст онооны дундаж | тоо | 2023 | 461.4 | 500 | 504 | | | | Дээд боловсролын тухай хууль (2023)-д дээд боловсролын сургалтын байгууллагын дэд бакалавр, бакалаврын хөтөлбөрт бүрэн дунд боловсрол эзэмшсэн, элсэлтийн шаардлага хангасан хүнийг элсүүлж, элсэлтийн шалгалтын босго оноог шинэчлэхэд өмнөх босго оноог бууруулахгүйгээр тогтоохоор хуульчилсан.<br>Элсэлтийн шалгалтын  хэмжээст оноо нь шалгуулагчийн мэдлэгийн түвшинг улсын хэмжээнд харьцуулан үнэлэх зорилгоор 200-800 онооны хооронд тооцдог үзүүлэлт юм. Энэ оноо нь зөвхөн гүйцэтгэлийн хувиас гадна тухайн шалгалтын хүндэвтэр байдал болон бусад шалгуулагчдын үр дүн дээр үндэслэн стандартчилагдаж гарч, шалгуулагчдын эрэмбэд суурилдаг. Элсэлтийн шалгалтын  хэмжээст онооны үндэсний дундаж нь 2024, 2025 онуудад бүх хичээл дээр тогтмол 500 оноо байсан. |
| | | 28.2.2 | Хүн бүрд ерөнхий боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлнэ. | 28.2.2.1 | Сургуульд хамрагдаагүй хүүхдийн эзлэх хувь, суурь боловсрол /1-9 дүгээр анги/ | хувь | 2022 | 3.2 | 3 | 2.4 | | | | Шинэчлэн батлагдсан Боловсролын хууль тогтоомжийн дагуу ялгаатай хэрэгцээтэй (хөгжлийн бэрхшээл, онцгой авьяас, хэл, соёл, жендэр, нийгэм, эдийн засаг, байршлын ялгаанаас үүдэлтэй хэрэгцээ) 2025-2026 оны хичээлийн статистик мэдээгээр суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин 97.3 хувь болж өмнөх оноос 0.3 хувиар нэмэгдэж, суурь боловсрол эзэмшихгүй байгаа суралцагчийн эзлэх хувь 2.4 болж буурсан. Тухайлбал, 2025-2026 оны хичээлийн жилд суурь боловсролд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо 131-ээр нэмэгдсэн. |
| | | | | 28.2.2.2 | Найман хичээлийн жилийн өмнө 1 дүгээр ангид элссэн суралцагчдаас суурь боловсрол эзэмшсэн хувь | хувь | 2021 | 94.8 | 97 | 96.8 | | | | Шинэчлэн батлагдсан Боловсролын хууль тогтоомжийн дагуу ялгаатай хэрэгцээтэй (хөгжлийн бэрхшээл, онцгой авьяас, хэл, соёл, жендэр, нийгэм, эдийн засаг, байршлын ялгаанаас үүдэлтэй хэрэгцээ) 2025-2026 оны хичээлийн статистик мэдээгээр суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин 97.3 хувь болж өмнөх оноос 0.3 хувиар нэмэгдэж, суурь боловсрол эзэмшихгүй байгаа суралцагчийн эзлэх хувь 2.4 болж буурсан. Ерөнхий боловсролын сургуулийн гадна байгаа 6-14 насны хүүхдийн тоо энэ хичээлийн жилд 304 байгаа боль 2022 онд 656 байсан. |
| | | | | 28.2.2.3 | Тухайн жилд бүрэн дунд боловсрол эзэмшсэн 18 настай хүн ам | хувь | 2021 | 77.1 | 82 | 82.8 | | | | Ерөнхий боловсролын сургуулийг төгссөн 18 настай суралцагч 38,107, ерөнхий боловсрол нөхөн эзэмшсэн 314, Мэргэжлийн боловсролын сургуульд 3 жилээр суралцан бүрэн дунд боловсрол эзэмшин төгссөн 6,566, 18 настай нийт 44,987 суралцагч тухайн онд бүрэн дунд боловсрол эзэмшсэн нь 18 настай нийт 54,357 хүн амын 82.8 хувийг эзэлж байна. |
| | | | | 28.2.2.4 | Нэг ээлжээр хичээллэх боломжтой төрийн өмчийн сургууль | хувь | 2023 | 50.2 | 60 | 64.4 | | | | Хүн амын өсөлтийн динамиктай хамааралтайгаар хүүхдийн тооны ачаалал бага ангиас дунд анги руу, дунд ангиас ахлах анги руу шилжих төлөв байдал ойрын 5 жилд үргэлжлэхээр байна. Тухайлбал,  2022-2023 оны хичээлийн жилийг авч үзвэл энэ тоо өссөн, тухайлбал, нийт 859 сургуулийн 351 (40.9 хувь) нь 1 ээлжээр, 502 (58.4 хувь) нь 2 ээлжээр, 6 (0.7 хувь) нь 3 ээлжээр хичээллэж байсан бол 2025-2026 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 900 сургуулийн 384 (42.7 хувь) нь нэг ээлжээр, 513 (57.0 хувь) нь хоёр ээлжээр, 3 (0.3 хувь) нь гурван элжээр хичээллэж байна. Салбарын хэмжээнд 2025 онд боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн "Гэр ойрхон сургууль, хамгийн сайн сургууль" арга хэмжээ зэргийг улсын төсвөөс гадна төр, хувийн түншлэлийн хэрэгжүүлсэн. НҮБ-ийн Хүүхдийн сан, ХААН банк, Номин холдинг групп зэрэг төлөөллөл оролцсон "Багийн бага сургууль" санаачилгыг хэрэгжүүлж, 5 байршил хүүхдэд ээлтэй ногоон бага сургуулийг барьж, нийт 4.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг салбарт хийсэн. |
| | | | | 28.2.2.5 | Сургалтын орчны стандарт шаардлага хангасан сургууль | хувь | 2022 | 71 | 76 | 80 | | | | "Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага" MNS 6782:2019 стандартаар Сургуулийн гадаад орчинд тавих аюулгүй байдлын шаардлага, Сургуулийн дотоод орчинд тавих аюулгүй байдлын шаардлага, Сургуулийн орчны аюулгүй байдалд тавих шаардлага, Сургуулийн орчны аюулгүй байдлын менежментийн шаардлага зэргийг багтаадаг. 2025 онд хийсэн хяналт шалгалтаар 576 сургуулийн барилга нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд зорчих, хөдөлгөөний аюулгүй байдал, тэдний хэрэгцээ шаардлагад нийцсэн, стандартын шаардлагыг хангасан. Тухайлбал, сургуулийн барилга байгууламжийн хувьд төрийн өмчийн ерөнхий боловсролын 705 сургуулийн 1,134 хичээлийн байрны 1,027 нь буюу 90.6 хувь стандартын барилга байгууламж эзэлж байна. |
| | | | | 28.2.2.6 | Суурь боловсрол эзэмшигчээс 10 дугаар ангид элссэн хувь | хувь | 2023 | 81.7 | 83 | 83.9 | | | | Боловсролын ерөнхий хуульд хүүхдийг таван настайд нь сургуулийн өмнөх боловсролд, цаашид ерөнхий боловсролд (бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшин бүхий нийт 12 жилийн хугацаанд эзэмших боловсрол) заавал хамруулахаар хуульчилсан. 2024-2025 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн 9 дүгээр ангид 60,089 суралцагч суралцаж байснаас 2025-2026 оны хичээлийн жилд 50,574 нь ерөнхий боловсролын сургуулийн 10 дугаар ангид, 9,106 нь мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад бүрэн дунд |
| | | | | 28.2.2.7 | Хүчин чадал ашиглалтын дундаж | хувь | 2023 | 139 | 130 | 145.3 | | | | |
| | | 71803 Дээд боловсрол | | | | | | | | | | | | |
| | | 28.3.1 | Иргэдэд дээд боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлнэ. | 28.3.1.1 | Дотоодын их, дээд сургуульд зээл, тэтгэлэг, буцалтгүй тусламжид хамрагдсан суралцагч | тоо | 2024 | 27,088 | 23,055 | 15,515 | | | | 2025 онд Боловсролын зээлийн сангаас нийт 14 арга хэмжээнд 157.9 тэрбум (улсын төсөв 124.3 тэрбум төгрөг, бусад эх үүсвэр 33.6 тэрбум) төгрөгийн төсөв батлагдаж 108.3 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан. Дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад нийт 15,515 суралцагчид 37.6 тэрбум төгрөгийн сургалтын төлбөрийн дэмжлэг, 1,033 суралцагчид 2.2 тэрбум төгрөгийн сургалтын төлбөрийн зээл олгосон. |
| | | | | 28.3.1.2 | Гадаадад суралцагчдад олгож байгаа зээл, тэтгэлэг, буцалтгүй тусламжид хамрагдсан суралцагч | тоо | 2024 | 1,554 | 2,268 | 1,254 | | | | Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад Засгийн газар хоорондын гэрээгээр, Засгийн газрын 346, 102, 215 дугаар тогтоолын дагуу Ерөнхийлөгч болон Засгийн газрын тэтгэлгээр 1,088 суралцагчид 52.9 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон бол дэлхийн шилдэг их сургуульд 166 суралцагчдад 13.96 тэрбум төгрөгийн зээл олгосон. |

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч | Хөтөлбөр | Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 28.3 | 28.3.2 | Үндэсний өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ. | 28.3.2.1 | Байгалийн шинжлэх ухааны чиглэлээр их, дээд сургуулийн хэвлэж байгаа -өгүүлэл | тоо | 2022 | 20 | 30 | 40 | 139,933,038.00 | 96,548,125.24 | 69.0% | “Инженер, технологийн дээд боловсрол” төслийн хүрээнд МУИС, ШУТИС, ХААИС-д байгалийн ухааны чиглэлийн хамтарсан судалгаа, эрдэм шинжилгээний ажлын үр дүнд олон улсын түвшинд 570 /Impact Factor-339/, үндэсний хэмжээнд 472 өгүүлэл хэвлүүлж, 836 илтгэл /гадаад-473, дотоод-363/ хэлэлцүүлсэн. Түүнчлэн 46 оюуны өмч бүртгүүлж, 36 ашигтай загварын гэрчилгээ авч, 20 шинэ технологийг боловсруулан, 27 технологи дамжуулалтыг нэвтрүүлсэн. Мөн хэрэгжүүлсэн судалгааны ажлын үр дүнд 6 гарааны компани байгуулагдан амжилттай ажиллаж байна. Mongolian Journal of Biological Sciences сэтгүүл Scopus-д бүртгүүлэх хүсэлт илгээсэн байгаа. Энэхүү сэтгүүлд төрийн өмчийн бусад их сургуулийн профессор багш, судлаачид өөрсдийн судалгааны үр дүнг хэвлүүлдэг. Төрийн өмчийн сургуулиудын судлаачид Springer, Scopus, Ebsco, Web of Science, Ardi, JCR, JSTOR зэрэг бусад платформуудыг МУИС-ийн IP хаягаас ашиглах боломжтой. |
| | | | | 28.3.2.2 | Ахисан түвшний сургалтад хамрагдаж байгаа оюутны нийт оюутны тоонд эзлэх хувь | хувь | 2023 | 20.1 | 25 | 20.6 | | | | 2025-2026 оны хичээлийн жилд 68 дээд боловсролын сургалтын байгууллагад нийт 161,891 суралцагч суралцаж байгаагаас 27,450 нь магистр, 5,943 нь докторын зэрэг олгох ахисан түвшний сургалтад хамрагдаж байна. Сүүлийн 3 жилийн статистик мэдээ ахисан түвшний сургалтад хамрагдаж байгаа оюутны тоо тогтвортой 20 орчим хувьтай байна. |
| | | | | 28.3.2.3 | Байгалийн шинжлэх ухааны чиглэлээр хэвлүүлж байгаа -өгүүлэл | тоо | 2024 | Т | 20 | 30 | | | | ЭЗХЯ-аас гаргадаг шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны үр дүнгийн мэдээгээр 2025 онд байгалийн ухааны чиглэлээр улсын хэмжээнд нийт 5,716 өгүүлэл нийтлэгдсэн. |
| | 28.4 | **71804 Мэргэжлийн боловсрол** | | | | | | | | | | | | |
| | | 28.4.1 | Мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх замаар иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ. | 28.4.1.1 | Ажилгүй иргэдээс мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад элсэгчийн эзлэх хувь | хувь | 2023 | 4.4 | 6 | 7.2 | 222,549,938.80 | 213,339,197.07 | 95.9% | Ажилгүй иргэдээс мэргэжлийн болон техникийн боловсролы сургалтын байгууллагад элсэн суралцаж байгаа байдлыг үзвэл 2023-2024 оны хичээлийн жилд нийт элсэгчдийн 28.7 хувь, 2024-2025 оны хичээлийн жилд 26.55 хувь, 2025-2026 оны хичээлийн жилд 28.3 хувийг ажилгүй иргэн эзэлж байна. |
| | | | | 28.4.1.2 | Тухайн жилд суурь боловсрол эзэмшигчдээс мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад элсэгчийн эзлэх хувь | хувь | 2023 | 15.3 | 15.5 | 15.1 | | | | 2023-2024 оны хичээлийн жилд 9 дүгээр анги төгсөгчдийн 14.58 хувь, 2024-2025 оны хичээлийн жилд 16.49 хувь нь мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтыг байгууллагыг сонгон элссэн. Дээд боловсролын сургалтын байгууллагын элсэлт жилд 2 удаа явагдаж байгаа, иргэдийн дээд боловсрол эзэмших сонирхол өндөр байгаа зэрэг нь мэргэжлийн болон техникийн боловсролыг сонгоход нөлөөлж байна. |
| | | 28.4.2 | Төгсөгчийн чадамжийг хөдөлмөрийн зах зээл, ур чадварын эрэлт, шаардлагад нийцүүлнэ. | 28.4.2.1 | Мэргэжлийн болон техникийн боловсролын нийт төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн хувь | хувь | 2022 | 63.2 | 64 | 68.9 | | | | Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, шаардлагад нийцсэн мэргэжилтэй ажилтныг бэлтгэх, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшнийг нэмэгдүүлэх зорилгоор мэргэжлийн болон техникийн боловсролын хос сургалтыг нэвтрүүлэх, ажлын байран дээр дадлагажуулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.<br>Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааг төгссөнөөс хойш жилийн дараагаас мөшгөн, 2 жил нэг удаа судлан гаргадаг.<br>2021-2022 оны хичээлийн жилд 22,251 суралцагч мэргэжил, ур чадвар эзэмшин төгссөн бөгөөд эдгээр төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн талаарх судалгааг төгссөнөөс хойш 1 жил 6 сарын дараа буюу 2023 оны 12 дугаар сард нийт 72 сургалтын байгууллагын 19,681 төгсөгчийг хамруулсан судалгааг хийсэн. Судалгаанд 2022 оны нийт төгсөгчдийн 88.4 хувь нь хамрагдсан байна. Эдгээр судалгаанд хамрагдсан төгсөгчдийн 65.9 хувь нь хөдөлмөр эрхэлж, 9.0 хувь нь дараагийн боловсролын түвшинд элсэн суралцсан байна. Ийнхүү 2022 оны төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт өмнөх хичээлийн жилийн хөдөлмөр эрхэлж байгаа төгсөгчдөөс 14.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна. 2022-2023 оны хичээлийн жилд нийт 38,034 суралцагч сурч 19,941 төгсөгч төгсөж үүнээс 12,593 буюу 63.2 хувь хөдөлмөр эрхэлж байгаа нь судалгаагаар гарсан. 2023-2024 оны хичээлийн жилд нийт 38,294 суралцагч сурч 18,530 төгссөн байна. 2023-2024 оны хичээлийн жилийн статистик мэдээгээр 18,530 төгсөгчөөс төгсөлтийн дараа шууд ажлын байртай болсон 7,523 төгсөгч байсан. Тус хичээлийн жилийн нийт төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн байдлыг 2024 онд мөшгөн судлахад 18,530 төгсөгчийн 11,822 буюу 63.7 хувь нь хөдөлмөр эрхэлж байгаа нь судалгаагаар гарсан.<br>2024-2025 оны хичээлийн жилд 40,906 суралцагчийн 20,681 суралцагч төгссөн бол, 2025-2026 оны хичээлийн жил 20,864 суралцагч төгсөх төлөвтэй байна. 2026 оны эхний улирлын байдлаар 2024-2025 оны хичээлийн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн мөшгөх судалгааг нэгтгэж байгаа бөгөөд өдөлмөр эрхлэлтийн мөшгих судалгааны үр дүн 2027 онд гарна. |
| | 28.5 | **71806 Насан туршийн боловсрол** | | | | | | | | | | | | |
| | | 28.5.1 | Хүн амд албан, албан бус боловсролд хамрагдах, ажиллангаа суралцах боломжийг нэмэгдүүлнэ. | 28.5.1.1 | Насан туршийн сургалтын төвийн зохион байгуулсан, зуучилсан сургалтад хамрагдсан хүн амын 18-аас дээш насны хүн амд эзлэх хувь | хувь | 2023 | 16.6 | 17 | 33.2 | 12,872,854.80 | 12,189,372.00 | 94.7% | 2025 оны байдлаар аймаг, нийслэлийн дүүргийн Насан туршийн суралцахуйн 30 төвөөс зохион байгуулсан амьдрах ухаан, гэр бүлийн боловсрол, ёс суртахууны төлөвшил, иргэний боловсрол, гоо зүйн боловсрол, гадаад хэл, санхүүгийн боловсрол, эрүүл мэндийн, мэдээлэл харилцааны зэрэг танхимын болон цахим 17,694 сургалтад давхардсан тоогоор нийт 565,904 иргэн хамрагдсан. |
| | 28.6 | **71808 Боловсрол, шинжлэх ухааны бодлого удирдлага** | | | | | | | | | | | | |
| | | 28.6.1 | Боловсролын бодлого, удирдлага, хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулна. | 28.6.1.1 | Боловсролын салбарын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн тухайн жилийн хэрэгжилт | хувь | 2023 | - | 99 | 92.4 | 495,025,426.90 | 388,904,626.40 | 78.6% | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн боловсролын салбарт хийж хэрэгжүүлэхээр тусгасан нийт 9 зорилго 46 зорилтын хүрээнд 86 арга хэмжээний хэрэгжилтийг 2025 оны жилийн эцсийн байдлаар тайлагнаж, хяналт-шинжилгээ үнэлгээ хийв. Төсөл арга хэмжээний хэрэгжилтийн дундаж хувь 92.41%-тай үнэлэгдсэн. |
| | | **71809 Боловсрол, шинжлэх ухааны судалгаа шинжилгээ** | | | | | | | | | | | | |

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч | Хөтөлбөр | Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 28.7 | 28.7.1 | Боловсролын бодлого, шийдвэрийг салбарын хөгжлийн хэрэгцээ, тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд чиглүүлнэ. | 28.7.1.1 | Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн хийсэн судалгаа, шинжилгээ | тоо | 2023 | - | 56 | 78 | 22,825,116.70 | 19,560,608.73 | 85.7% | Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгээс 2025 онд боловсролын салбарын хэрэглэгч, захиалагчид нийт 16 эрдэм шинжилгээ, судалгааны үр дүн хүлээлгэж өгсөн, эрдэм шинжилгээ, судалгааны 56 бүтээлийг дотоодод, 6 бүтээлийг гадаадад хэвлүүлсэн. |
| | **АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН САЙД** | | | | | | | | | | | | | |
| | | **70905 Олборлолт, уул уурхай** | | | | | | | | | | | | |
| 29 | 29.1 | 29.1.1 | Хайгуулын нэгжид цахимаар ирүүлсэн хайгуулын ажлын "тайлан илгээсэн" төлөвөөс "баталгаажсан" төлөвт бүрэн шилжинэ. | 29.1.1.1 | Хувийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологи хайгуулын ажлын батлагдсан жилийн тайлан | тоо | 2023 | 925 | 900 | 707 | 46,858,542.10 | 37,503,403.70 | 80% | 2024 онд хувийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын нийт 1100 тайлан ирүүлсэн байна. Үүнээс 707 тайлан батлагдсан төлөвт, хяналтын шатанд 393 тайлан байна. |
| | | | Хайгуулын нэгжид цахимаар ирүүлсэн хайгуулын ажлын "төлөвлөгөө илгээсэн" төлөвөөс "баталгаажсан" төлөвт бүрэн шилжинэ. | 29.1.1.2 | Хувийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологи хайгуулын ажлын батлагдсан жилийн төлөвлөгөө | тоо | 2023 | 1100 | 1120 | 1173 | | | | 2025 онд хувийн хөрөнгөөр геологи хайгуулын ажил хийх 1,307 төлөвлөгөө ирүүлсэн бөгөөд 1,173 төлөвлөгөөг хянаж дууссан, 80 төлөвлөгөө хяналтын шатанд, 54 төлөвлөгөө татгалзсан төлөвт байна. |
| | | 29.1.2 | Хувийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологи хайгуулын ажлын тайланд шуурхай хяналт хийж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | 29.1.2.1 | Төлөвлөгдсөн хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд хувийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологи хайгуулын ажлын тайлан | тоо | 2023 | 60 | 65 | 21 | | | | Ашигт малтмалын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3-т заасан дагуу "Төрийн захиргааны байгууллага шаардлагатай тохиолдолд хайгуулын ажилд зарцуулсан зардлын хэмжээг газар дээр нь шалгана" гэсний дагуу удирдамжийн төслийг боловсруулж батлуулан 2025 оны 06 дугаар сарын 28-ны өдөр хээрийн шуурхайн томилолтоор Ашигт малтмалын хайгуулын хэлтсийн 2 мэргэжилтэн явсан бөгөөд томилолтын хугацаанд 21 талбайгаар шалгалт хийсэн байна. |
| | | 29.1.3 | Ашигт малтмалын ордын ашиглалтыг нэмэгдүүлнэ. | 29.1.3.1 | Уулын ажлын тайлангийн хяналт, зөвшөөрөл | тоо | 2023 | 215 | 220 | 307 | | | | Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон баяжуулах үйлдвэрүүдээс уулын ажлын 307 тайлан ирүүлснээс 169 тайлан хянагдаж баталгаажсан байна. |
| | | | | 29.1.3.2 | Уулын ажлын төлөвлөгөөний хяналт, зөвшөөрөл | тоо | 2023 | 360 | 360 | 543 | | | | Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон баяжуулах үйлдвэрүүдээс уулын ажлын 543 төлөвлөгөө ирүүлснээс 479 төлөвлөгөө хянагдаж баталгаажсан байна. |
| | | | | 29.1.3.3 | Уулын ажлын хэрэгжилтэд хяналт шалгалт хийх аж ахуйн нэгж | тоо | 2023 | 190 | 100 | 13 | | | | Уул уурхайн ажлын хэрэгжилтэд хяналт, шалгалт хийх зорилгоор Баянхонгор, Говь-Алтай, Завхан зэрэг аймгуудын алтны үндсэн ордуудад шалгалт зохион байгуулсан. Шалгалтад нийт 10 уурхай хамрагдсан байна. Харин 2025 онд шалгалтын чиглэлээр томилолтоор ажилласан тоо харьцангуй бага байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой болно. |
| | | | | 29.1.3.4 | Нүүрсний экспортын хэмжээ | сая тонн | 2023 | 69.6 | 83.3 | 89.9 | | | | Гаалийн ерөнхий газрын мэдээгээр уг тайлан гарсан ба АМГТГийн зүгээс нүүрсний уурхайнуудын хүчин чадлыг нэмэгдүүлэхэд холбогдох бичиг баримтыг баталгаажуулахад дэмжлэгийг шуурхай үзүүлж ажилласан. Мөн БНХАУ-ын Монгол улсаас нүүрс авах нүүрсний хэмжээ нэмэгдсэн. |
| | | | | 29.1.3.5 | Зэсийн баяжмалын экспортын хэмжээ | сая тонн | 2023 | 1.5 | 1.78 | 2.2 | | | | Гаалийн ерөнхий газрын мэдээгээр уг тайлан гарсан ба цэвэр эрчим хүчний шилжилттэй холбоотойгоор дэлхий нийтэд зэсийн эрэлт нэмэгдсэн нь зорилтот түвшинг даван биелүүлэхэд нөлөөлсөн байна. |
| | | | | 29.1.3.6 | Төмрийн хүдэр, баяжмалын экспортын хэмжээ | сая тонн | 2023 | 5.7 | 9 | 8.8 | | | | Гаалийн ерөнхий газрын мэдээгээр уг тайлан гарсан ба БНХАУ-ын ган үйлдвэрлэлийн салбарын уналттай холбоотойгоор эрэлт буурсан шалтгаанаар зорилтот түвшинд хүрээгүй байна. |
| | | | | 29.1.3.7 | Алт тушаалтын хэмжээ | тонн | 2023 | 12.4 | 18 | 11.36 | | | | Стандарт хэмжил зүйн газрын сорьцын хяналтын газраас ирүүлсэн мэдээгээр 2025 оны жилийн эцсийн байдлаар хүрсэн түвшинг боловсруулсан ба олборлолтын хэмжээ буурсан, шороон ордын нөөц багассан, шинэ ордын бэлтгэл хангалтгүй байсан хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй, зарим аж ахуйн нэгжүүд алтыг албан бус сувгаар борлуулах зэрэг шалтгаануудаас тус тус хамааран зорилтот түвшинд хүрээгүй хэмээн үзэж байна. |
| | | | | 29.1.3.8 | Газрын тосны экспортын хэмжээ | сая баррель | 2023 | 4.7 | 5.4 | 3.7 | | | | 2025 онд нийт 4,248,850 баррель буюу 579,000 тонн түүхий тос олборлож, экспортлохоос 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар газрын тосны ашиглалтын 4 талбайгаас нийт 3,779,873 баррель буюу 512,981 тонн түүхий тос олборлож, 3,540,785 баррель буюу 482,210 тонн түүхий тос экспортлоод байна. Үүнээс Тосон-Уул XIX талбайгаас Баянхошуу хилийн боомтоор 1,561,410 баррель буюу 207,242 тонн түүхий тос, Тамсаг XXI талбайгаас Баянхошуу хилийн боомтоор 1,669,821 баррель буюу 230,673 тонн түүхий тос, БХГ-97 талбайгаас Замын-Үүд хилийн боомтоор 309,555 баррель буюу 43,294 тонн түүхий газрын тосыг түүхий тос БНХАУ-д экспортолсон байна. Олборлолтын гүйцэтгэл 88.96 хувь, экспортын төлөвлөгөөний гүйцэтгэл 83.34 хувьтай байна. |
| | | 29.1.4 | Нийт нутаг дэвсгэрийн 48.1% 1:50000 масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн судалгаанд хамрагдсан байна. | 29.1.4.1 | Үр дүнг хүлээн авсан талбайн хэмжээ /ашигт малтмалын хэтийн төлөвтэй талбай/ | км2-аар | 2023 | 24,000 | 16,983 | 16,983 | | | | Геологийн 1:50 000-ны масштабтай зураглал, ерөнхий эрлийн Ямаат уул-50, Их Бэрх Уул-50, Индэртийн нуруу-50, Цагаан-Овоо-50, Борхайрхан-50, Буйлстхүрэн-50 төслийн үр дүнгийн тайланг 2025 онд ЭБМЗ-өөр хэлэлцэн шаардлага хангасан тул хүлээн авсан. Үүний үр дүнд 9 төрлийн ашигт малтмалын буюу зэс, алт, гянтболд, молибдени, хар тугалга, мөнгө болон холимог болон хар металл, 3 төрлийн барилгын материал, нүүрсний хувьд хэтийн төлөвтэй илрэл бүхий 154 кв.км талбайг хамарсан 54 эрлийн талбайг ялган нарийвчлан судалсан. Мөн ашигт малтмалын 701 эрдэсжсэн цэг, шлихийн сарнилын 356 хүрээ, геохимийн сарнилын 426 хүрээг илрүүлэн тэмдэглэсэн байна. |
| | | 29.1.5 | Аж үйлдвэрийн салбарт нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ. | 29.1.5.1 | Аж үйлдвэрийн салбарт хэрэгжүүлэх төслийн техник, эдийн засгийн үндэслэл | тоо | 2023 | 15 | 15 | 4 | | | | 2025 оны жилийн эцсийн байдлаар Эрдэс баялаг мэргэжлийн зөвлөлийн Боловсруулах үйлдвэрийн салбар зөвлөл өргөтгөсөн болон салбар зөвлөлийн хурлаар техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)-ийн төслүүдийг хэлэлцсэн. Хэлэлцсэн төслүүдээс 3 ТЭЗҮ-ийг хүлээн авч, 1 төслийг буцаахаар шийдвэрлэсэн байна. Харин 2025 оны 7-р сарын байдлаар нийт 3 ТЭЗҮ-ийн төсөл хэлэлцүүлэгт оруулахаар бэлэн болсон байна. |

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч | Хөтөлбөр | Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 29.1.6 | Хууль тогтоомжийн дагуу улсын төсвийн орлого бүрдүүлсэн байна. | 29.1.6.1 | Улсын төсөвт төвлөрүүлсэн ашигт малтмалын ашиглалт болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийн хэмжээ | тэрбум төгрөг | 2023 | 36.6 | 30 | 44.8 | | | | 2025 онд нийт 30 тэрбум төгрөг улсын төсөвт төвлөрүүлэхээс жилийн эцсийн байдлаар, хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн, 2,725 тусгай зөвшөөрлүүдийн ээлжит жилийн төлбөрүүдийг Ашигт малтмалын тухай хуулийн 11.1.20 дугаар зүйл, 32 дугаар зүйл, 34 дүгээр зүйлд нийцүүлэн уул уурхайн кадастрын системд бүртгэж, хавсралтуудад тэмдэглэгээ хийж, улсын төсөвт нийт 44.8 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байна. Энэ нь 149.3% хувийн биелэлтийн үзүүлэлтэй байна. |
| | | | | 29.1.6.2 | Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөрийн хэмжээ | тэрбум төгрөг | 2023 | 2.6 | 2.1 | 3.2 | | | | 2025 онд улсын төсөвт 2.1 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 12 сарын 31-ний байдлаар 3.2 тэрбум төгрөг төвлөрүүлж, гүйцэтгэл 152.4 хувийн биелэлтэд хүрсэн байна. |
| | **ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД** | | | | | | | | | | | | | |
| | 30.1 | **70801 Мал аж ахуйг хөгжүүлэх** | | | | | | | | | | | | |
| | | 30.1.1 | Бэлчээрийн тэжээлийн нөөцийг нэмэгдүүлж, тэжээл үйлдвэрлэлийг сайжруулна. | 30.1.1.1 | Нийт бэлчээрт даац хэтэрсэн бэлчээрийн эзлэх хувийн жин | хувь | 2023 | 60 | 57.5 | 54.4 | 67,365,726.50 | 41,545,132.26 | 62% | Бэлчээрийн ургамал хамгааллын арга хэмжээг 7 аймгийн 45 сумын 151 багийн 119.2 мянган га бэлчээрийн талбайд зохион байгуулж, бэлчээрийн ургамлыг ургаж эхлэх үед нь мэрэгч амьтдын хөнөөлд өртөхөөс сэргийлж, бэлчээрийн ургамлын нөөцийг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлсэн. 2025-2026 оны өвөл, хаврын бэлчээрийн даацыг баг бүрийн бэлчээрийн ургац, малын тоо, бэлчээрийн талбайн хэмжээ, бэлчээр ашиглах хугацаа зэрэг мэдээлэлд үндэслэн багийн нутгаар тооцоолоход нийт нутгийн 54 хувьд хэвийн, нутгийн 46 хувьд гантай болон гандуу байсан. Өөрөөр хэлбэл өвөл, хаврын бэлчээрийн даац нутгийн 60 орчим хувьд хүрэлцээтэй, харин 40 гаруй хувьд хэтэрч гарсан. |
| | | 30.1.2 | Малын халдварт өвчний гаралтыг бууруулна. | 30.1.2.1 | Гоц халдварт өвчний голомт | тоо | 2023 | 128 | 100 | 34 | | | | Мал, амьтны халдварт өвчний голомтыг тоог 27 хувиар, гоц халдварт өвчний голомтын тоон 63 хувиар тус тус бууруулсан. Гоц халдварт өвчнийг хяналтад авснаар махны экспортыг 2025 онд махны экспортын хэмжээ 70.0 мянган тн гаруй мах экспортлогдсон байна. |
| | | | | 30.1.2.2 | Халдварт өвчний голомт | тоо | 2023 | 685 | 648 | 430 | | | | Мал, амьтны халдварт өвчний голомтыг тоог 27 хувиар, гоц халдварт өвчний голомтын тоон 63 хувиар тус тус бууруулсан. Гоц халдварт өвчнийг хяналтад авснаар махны экспортыг 2025 онд махны экспортын хэмжээ 70.0 мянган тн гаруй мах экспортлогдсон байна. |
| | | 30.1.3 | Нийт мал сүрэгт өндөр ашиг шимт малын эзлэх хувийг нэмэгдүүлнэ. | 30.1.3.1 | Нийт мал сүрэгт цөм сүргийн эзлэх хувийн жин | хувь | 2023 | 8.7 | 9 | 9 | | | | Шинэ хоршоо хүрээнд нийт 7,647 хоршоо байгуулагдаж 825.1 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгогдсон. Дээрхи зээлийн 67.9 хувийн санхүүжилтээр малчид 917.7 мянган толгой үржлийн мал худалдаж авсан. Үүний үр дүнд стандартын шаардлага хангасан үржлийн малын тоо нэмэгдсэн. |
| | | | | 30.1.3.2 | Өндөр ашиг шимт малын эзлэх хувь | хувь | 2023 | 0.5 | 1 | 1 | | | | УИХ-ын 36-р тогтоолын хүрээнд Махны үхрийн аж ахуй эрхэлж байгаа 7 аж ахуйн нэгж эргэлтийн хөрөнгийн зээл 10.3 тэрбум, 6 аж ахуйн нэгж хөрөнгө оруулалтын зээл 7.24 тэрбум нийт 17.54 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл авсан. Мөн сүүний үхрийн аж ахуй эрхэлж байгаа 7 аж ахуйн нэгж нийт 9.24 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын хөнгөлөлттэй зээл авсан. Эдгээр зээлийн үр дүнд өндөр ашиг шимтэй цэвэр үүлдэр болон 1 дүгээр үеийн эрлийз үхрийн тоо 2,000 толгойгоор нэмэгдсэн. |
| | | 30.1.4 | Бэлчээрийн тэжээлийн нөөцийг нэмэгдүүлж, тэжээл үйлдвэрлэлийг сайжруулна. | 30.1.4.1 | Нийт бэлтгэсэн тэжээлийн хэмжээ /мян.тн/ | тн | 2023 | 1604 | 1650 | 1800 | | | | Монгол орны хадлан бүхий нутгуудаас нийт 1.49 сая тн хадлан, 29.3 тн гар тэжээл, 82.9 тн хужир шүү бэлтгэж, 236.8 тн ногоон тэжээл, 146.5 мянган тонн малын тэжээлийн ургамал хураан авснаар нийт 2,023.1 мянган тонн малын тэжээл бэлтгэв. Түүнчлэн 2025 онд гадаад улсаас 104.1 (Овьёос (кг), 18,9 мянган тонн, хивэг,хүчит тэжээл55.2 мянган тонн бусад тэжээл 29,8 мянган тонн тэжээл) мянган тн малын тэжээл импортоор авч малын тэжээлийн хангамжийг нэмэгдүүллээ. |
| | 30.2 | **70802 Газар тариаланг хөгжүүлэх** | | | | | | | | | | | | |
| | | 30.2.1 | Нэгж талбайн ургацыг нэмэгдүүлнэ. | 30.2.1.1 | 1 га талбайгаас хураан авах улаан буудайн хэмжээ | цн/га | 2023 | 13.2 | 14 | 9.6 | 102,391,822.50 | 55,750,406.10 | 54% | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 47 дугаар тогтоолоор тариалангийн үйлдвэрлэлд дэвшилтэт технологийг нэвтрүүлж, ухаалаг технологид суурилсан газар тариаланг хөгжүүлэх, хөрсний үржил шимийг хамгаалж, сайжруулах зорилгоор "Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян"-ыг 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 4 жилийн хугацаатай өрнүүлж байна. 2025 он хөтөлбөрийн хувьд эхний жил бөгөөд энэхүү дунд хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд засгийн газраас хариуцан төлөх хүүгийн дэмжлэгтэй “Хөдөө аж ахуйн тогтвортой үйлдвэрлэлийг дэмжих” хөнгөлөлттэй зээлийг тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдэд арилжааны 10 банкны эх үүсвэрээр олгосноор хаврын тариалалт, уринш боловсруулалт, ургамал хамгаалал зэрэг тариалангийн үйлдвэрлэлийг технологит ажлуудыг цаг алдалгүй хийж гүйцэтгэх |
| | | | | 30.2.1.2 | 1 га талбайгаас хураан авах төмсний хэмжээ | цн/га | 2023 | 92.3 | 120 | 85.1 | | | | |
| | | | | 30.2.1.3 | 1 га талбайгаас хураан авах хүнсний ногооны хэмжээ | цн/га | 2023 | 120 | 122 | 146.2 | | | | |
| | 30.3 | **70803 Хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх** | | | | | | | | | | | | |
| | | 30.3.1 | Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ. | 30.3.1.1 | Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ | мян.тн | 2023 | 2,123.10 | 2,229.30 | 2,838.70 | 16,731,679.70 | 16,342,852.43 | 98% | УИХ-ын 2022 оны "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" 36 дугаар тогтоолоор 2027 он хүрэхэд гол нэр төрлийн 19 бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангах зорилт тавьсан. Хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн салбарт 2022 онд 2,028 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байсан бол 2025 онд 2,724 болж, 696 аж ахуйн нэгжээр буюу 34.3%-иар, 2022 онд 35,117 ажиллагсад ажиллаж байсан бол 2025 онд 35,810 ажиллагсдаар буюу 2%-иар тус тус нэмэгдсэн байна. Хүнсний үйлдвэр шинээр барих, өргөтгөх, хүчин чадлыг нэмэгдүүлэх, тоног төхөөрөмжийг сайжруулах, хөнгөлөлт олгох зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлсний хүрээнд хүнсний шинэ 53 үйлдвэр, үүнээс сүү, сүүн бүтээгдэхүүний 11, мал төхөөрөх 10, мах боловсруулах 7, гурилан бүтээгдэхүүний 16, ургамлын гаралтай бүтээгдэхүүний 3, шингэн хүнс бүтээгдэхүүний 3, давсны 1, сав баглаа боодлын 2 үйлдвэр тус тус байгуулагдсан төдийгүй 1,000 орчим нэр төрлийн хүнсний |
| | | | | 30.3.1.2 | Хүнсний ногооны дотоодын үйлдвэрлэлийн хэмжээ | мян.тн | 2022 | 149.8 | 159.8 | 239.8 | | | | |
| | | | | 30.3.1.3 | Жимс, жимсгэнийн дотоодын үйлдвэрлэлийн хэмжээ | мян.тн | 2022 | 2.7 | 3 | 4.5 | | | | |
| | | | | 30.3.1.4 | Сүүний дотоодын үйлдвэрлэлийн хэмжээ | мян.тн | 2022 | 936 | 937.5 | 260.5 | | | | Энэ хүрээнд 2020 оны 11 дүгээр сараас 2026 оны 03 дугаар сарыг хүртэлх хугацаанд нийт 37 үйлдвэр, цехэд 82.8 сая литр сүү нийлүүлсэн 51,399 малчин, фермерт 64.9 тэрбум төгрөгийн мөнгөн урамшууллыг олгоод байна. Энэ нь сэрүүний улиралд нийлүүлсэн түүхий сүүний (2021 онд 22.5 сая.литр, 2022 онд 19.5 сая.литр, 2023 онд 24.8 сая.литр, 2024 онд 29.2 сая.литр) 50 орчим хувийг эзэлдэг ба сүүний урамшуулал өгснөөр сүүлийн 3 жилийн хугацаанд сэрүүний улиралд нийт 66.8 сая литр түүхий сүү бэлтгэж, дунджаар жилд 22,3 сая литр түүхий сүүг үйлдвэрт нийлүүлж, түүхий сүүний нийлүүлэлт 3 дахин нэмэгдсэн зэрэг үзүүлэлт гарсан тул сүүний урамшууллыг тодорхой хугацаагаар үргэлжлүүлэн олгох шаардлагатай байна. |

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч | Хөтөлбөр | Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 30 | | 30.3.2 | Хүн амын хоол, хүнсний зохистой хэрэглээг хэвшүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. | 30.3.2.1 | Дотоодын баталгаажсан хүнсний органик бүтээгдэхүүний хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнд эзлэх хэмжээ | хувь | 2023 | 0.5 | 1.5 | 0.1 | | | | Органик хүнсний бүртгэл мэдээллийн сайтад нийт 294 дотоодын органик бүтээгдэхүүнээр, шилжилтийн үеийн органик бүтээгдэхүүнээр 85 бүтээгдэхүүн тус тус бүртгэгдсэн байна. Органик бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өсөлтийг илэрхийлэхдээ системд бүртгэгдэж органикаар баталгаажсан бүтээгдэхүүний нэр төрлийн тоогоор тооцох нь зүйтэй байна. |
| | 30.4 | **70804** | **Хөнгөн үйлдвэрийг хөгжүүлэх** | | | | | | | | | | | |
| | | 30.4.1 | Хөнгөн үйлдвэрийн түүхий эдийн боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлнэ. | 30.4.1.1 | Арьс ширний гүн боловсруулалтын түвшин | хувь | 2023 | 30 | 35 | 33 | 81,773,870.10 | 15,774,748.12 | 19% | 2025 онд арьс шир боловсруулах үйлдвэрүүд 6.1 сая арьс ширэн түүхий эд худалдан авч, 2 сая арьс ширэн түүхий эдийг гүн боловсруулж савхи үйлдвэрлэн гутал, савхин хувцас, цүнх, бээлийний үйлдвэрт нийлүүлсэн байна. |
| | | | | 30.4.1.2 | Ноос, ноолуурын бүрэн боловсруулалтын түвшин | хувь | 2023 | 20 | 25 | 25 | | | | Ноолуурын үйлдвэрлэлийн салбарт:<br>Эргэлтийн хөрөнгө: “Цагаан алт” хөдөлгөөний үр дүнд ноолуурын үйлдвэрлэлийн салбарт 6,000 тн ноолуур бэлтгэсэн. Мөн ээрэх хүчин чадлыг 400.0 тн, сүлжих хүчин чадлыг 200 мянган ширхэгээр нэмэгдүүлэх боломж бүрдүүлээд байна.<br>Хөрөнгө оруулалт: Ээрэхийн хөрөнгө оруулалтын зориулалтаар одоогийн байдлаар 12.0 тэрбум төгрөгийн зээл олгогдсон нь ээрэх хүчин чадлыг 400.0 тн, сүлжих, нэхэх, гүйцэтгэн боловсруулах хөрөнгө оруулалтын зориулалтаар 23.2 тэрбум төгрөгийн зээл олгогдсон нь сүлжих хүчин чадлыг 200 мянган ширхгээр нэмэгдүүлэх боломж бүрдүүлээд байна.<br>Ноосны үйлдвэрлэлийн салбарт:<br>Эргэлтийн хөрөнгө: Ноосны үйлдвэрлэлийн салбарт эргэлийн хөрөнгийн зориулалтаар 35.0 тэрбум төгрөгийн зээл олгогдож, 20,000 тн ноос бэлтгэхээр төлөвлөж байна.<br>Хөрөнгө оруулалт: Одоогийн байдлаар Ээрэхийн хөрөнгө оруулалтын зориулалтаар 8.5 тэрбум төгрөгийн зээл олгогдсон нь хүчин чадлыг 300 тн, хялгас ялгахын хөрөнгө оруулалтын зориулалтаар 9.3 тэрбум төгрөгийн зээл олгогдсон нь хүчин чадлыг 530 тн, сүлжих, нэхэх, гүйцэтгэн боловсруулах хөрөнгө оруулалтын зориулалтаар 21.1 тэрбум төгрөгийн зээл олгогдсон нь нэхэх /хивс/ хүчин чадлыг 200 мянган м.кв, сүлжих хүчин чадлыг 50 мянган ширхэгээр, ноосон дулаалгын тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын зориулалтаар 297.0 сая төгрөгийн зээл олгогдсон нь 3 мянган м.кв нэмэгдүүлэх боломж бүрдүүлээд байна. |
| | | | | 30.4.1.3 | Ээрэхээс дээш түвшинд ноос, ноолуурын боловсруулалт хийх үйлдвэрийн хүчин чадал /сүлжих сая.шир/ | сая.ширхэг | 2023 | 5.3 | 5.83 | 5.8 | | | | Ноолуурын салбарт сүлжих, нэхэх, гүйцэтгэн боловсруулах хөрөнгө оруулалтын зориулалтаар 23.2 тэрбум төгрөгийн зээл олгогдсон нь сүлжих хүчин чадлыг 200 мянган ширхэгээр нэмэгдүүлэх боломж бүрдүүлээд байна, Ноосны салбарт сүлжих, нэхэх, гүйцэтгэн боловсруулах хөрөнгө оруулалтын зориулалтаар 21.1 тэрбум төгрөгийн зээл олгогдсон нь нэхэх /хивс/ хүчин чадлыг 200 мянган м.кв, сүлжих хүчин чадлыг 50 мянган ширхгээр нэмэгдүүлэх боломж бүрдүүлээд байна. |
| | 30.5 | **70805** | **Хөдөө аж ахуй, газар тариалан, хүнс, хөнгөн үйлдвэрийн бодлого удирдлага** | | | | | | | | | | | |
| | | 30.5.1 | Салбарын бодлого, удирдлага, үйл ажиллагааны хэрэгжилтийг сайжруулна. | 30.5.1.1 | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийн хувь /өссөн дүнгээр/ | хувь | 2024 | Т | 25 | 21.83 | 288,028,080.50 | 235,333,299.70 | 82% | Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах 4 бодлогын хүрээнд хэрэгжүүлэх 12 зорилго 47 зорилтын 129 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Бодлогын хэрэгжилтийг 2025 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийхэд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах үндсэн хэрэгжүүлэх 129 төсөл, арга хэмжээний хэрэгжилт 76.29%-тай хэрэгжиж байна |
| | 30.6 | **70806** | **Хөдөө аж ахуй, газар тариалан, хөнгөн үйлдвэрийн судалгаа шинжилгээ** | | | | | | | | | | | |
| | | 30.6.1 | Салбарын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн судалгаа, шинжилгээ, туршилтыг хөгжүүлнэ. | 30.6.1.1 | Дэмжлэг үзүүлсэн инновацын төсөл | тоо | 2023 | 12 | 15 | - | 858,834.20 | 496,083.30 | 58% | Инновацын төсөл сонгон шалгаруулалт нь ЭЗХЯам дээр хийгдэн хөтөлбөрийн хүрээнд 5 хуулийн төслийн тандан судалгаа, үр нөлөөний үнэлгээ, үзэл баримтлал, шинэчилсэн найруулгын төсөл, зардлын тооцоо зэрэг хийгдсэн ба 4 журмын төсөл боловсруулах судалгаа, шинжилгээний ажил хийгдсэн. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төсвийн судалгаа, шинжилгээний ажлуудыг дэмжин ажилласан байна. УИХ-ын 2022 оны 36 тогтоолоор батлагдсан Хүнсний хувьсгал, УИХ-н 2024 оны 63 дугаар тогтоолоор батлагдсан Цагаан алт хөдөлгөөний хүрээнд хийгдэх шаардлагатай хууль эрх зүйн болон судалгаа шинжилгээний ажлууд хийгдэн, хуулийн төслүүдийг батлуулан ажиллаж байна. |
| | 30.7 | **72101** | **Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих** | | | | | | | | | | | |
| | | 30.7.1 | Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зээлд хамрагдсан аж ахуйн нэгжээр дамжуулан шинээр бий болгох ажлын байрны тоог нэмэгдүүлнэ. | 30.7.1.1 | Шинээр бий болгох ажлын байрны тоо | тоо | 2023 | 1000 | 3000 | 2394 | 9,726,546.10 | 50,536,132.21 | 527% | ЖДҮХС-аас 343 төсөлд хөнгөлөлттэй зээл олгож, 1536 ажлын байрыг шинээр, Хоршоог хөгжүүлэх сангаас 498 төсөлд зээл олгож, 858 ажлын байрыг шинээр бий болж, 133 үйлдвэр шинээр байгуулагдаж, төсөл хэрэгжүүлсэн. |
| | | | | 30.7.1.2 | Идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж | тоо | 2022 | 69539 | 70000 | 82471 | | | | ЖДҮ салбарт хөнгөлөлттэй зээл олгосноор 16.2 тэрбум төгрөгийн татвар, 22.4 тэрбум төгрөгийн НДШ төвлөрүүлэх боломжийг бүрдүүлсэн. |
| | 30.8 | **70808** | **Шинэ хоршоо хөдөлгөөн** | | | | | | | | | | | |
| | | 30.8.1 | Хоршоодод шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэнэ. | 30.8.1.1 | Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, хоршоо | тоо | 2023 | 25457 | 26000 | 24983 | 95,759,716.80 | 59,436,211.89 | 62% | Зээлийн үр дүнд малын үүлдэрлэг байдал 57.7-63.9 хувь, өвс, тэжээл бэлтгэлийн хүрэлцээ 34.-37.9 хувь, малын хашаа, саравчийн хүрэлцээ 31.3-34.5 хувь, тоног төхөөрөмжийн хангалт 19.6-23.2 хувь, МАА-н үйлдвэрлэлийн талаарх сургалт, мэдлэг 15.3-19.7 хувь, ажиллах хүчний хангамж 9.8-11.6 хувь, малын тэжээл тариалах газрын хүртээмж 9.7-9.9 хувиар өссөн үр дүнтэй байна. |
| | | | | 30.8.1.2 | Санхүүжилт авсан хоршоодын орлогын өсөлт | хувь | - | - | 10 | 23 | | | | ТЕГ-аас 2025-09-26-ны өдрийн байдлаар ирүүлсэн мэдээлэлд үндэслэн орлогын тооцоход үйл ажиллагаа явуулж буй 3568 хоршоод /ҮСХ-2025 мэдээ/ нь 185.1 тэрбум төгрөгийн орлого олж, 4,0 тэрбум төгрөгийн татвар төлсөн байна. Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд 2025 онд 4,694 хоршоонд зээл олгосон ба албан ёсны бүртгэлээр үйл ажиллагаа явуулж буй хоршоодын тоо 1083-аар өссөн байна. |
| | **ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД** | | | | | | | | | | | | | |
| | | **71901** | **Нийгмийн даатгал** | | | | | | | | | | | |

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч | Хөтөлбөр | Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 31.1 | 31.1.1 | Нийгмийн даатгалын ач холбогдлын талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлнэ. | 31.1.1.1 | Албан журмын даатгуулагчийн ажиллагсдын тоонд эзлэх хувь | хувь | 2023 | 94.6 | 93.4 | 96.3 | 1,566,523,600.80 | 1,561,929,062.04 | 99.7% | 2025 онд ажиллагчдын тоо 1,383.6 мянга байсан бөгөөд нийгмийн даатгалын сангийн 2025 оны 12 дугаар сарын мэдээгээр нийгмийн даатгалд хамрагдсан даатгуулагчдын тоо 1,332.9 мянга байна. (Уг үзүүлэлтийн суурь түвшин нь 2025 он байгаа тул уг оны үзүүлэлттэй харьцуулж тооцов.) Уг үзүүлэлтийг Монгол улсын 2026 оны төсвийн тухай хуулиар зөвхөн албан журмын даатгуулагчдын тоонд үндэслэн 82.7 хувиар баталсан болно. |
| | | | | 31.1.1.2 | Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад нийгмийн даатгал төлөгч аж ахуйн нэгж, байгууллагын эзлэх хувь | хувь | 2023 | 60.6 | 61.75 | 54.5 | | | | 2025 онд үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдийн тоо 116.8 мянга байсан бөгөөд нийгмийн даатгалын сангийн 2025 оны 12 дугаар сарын мэдээгээр нийгмийн даатгалд хамрагдсан ажил олгогчийн тоо 63.7 мянга байна. (Уг үзүүлэлтийн суурь түвшин нь 2023 он байгаа тул уг оны үзүүлэлттэй харьцуулж тооцов.) |
| | | | | 31.1.1.3 | Малчдын сайн дурын даатгалд хамрагдалт | хувь | 2023 | 21 | 24 | 24 | | | | 2025 онд нийт малчдын тоо 313.2 мянга байсан бөгөөд үүнээс 2018 оноос өмнө эрэгтэй 60, эмэгтэй 55 насандаа өндөр насны тэтгэвэр тогтоолгосон 43.0 мянга, 2018 оноос хойш эрэгтэй 55, эмэгтэй 50 насандаа тогтоолгосон 34.5 мянган тэтгэвэр авагч байна. Эдгээр иргэд нь нийгмийн даатгалд хамрагдахгүй тул нийгмийн даатгалд хамрагдвал зохих 235.7 мянган малчнаас нийгмийн даатгалын сангийн 2025 оны 12 дугаар сарын мэдээгээр малчин даатгуулагчдын тоо 56.5 мянга байна. (Уг үзүүлэлтийн суурь түвшин нь 2023 он байгаа тул уг оны үзүүлэлттэй харьцуулж тооцов.) Уг үзүүлэлтийг Монгол улсын 2026 оны төсвийн тухай хуулиар хүний тоогоор буюу 60.0 мянган хүнээр баталсан болно. |
| | 31.2 | **71902 Нийгмийн халамж** | | | | | | | | | | | | |
| | | 31.2.1 | Нийгмийн халамж зайлшгүй шаардлагатай иргэнд хүргэж байгаа дэмжлэгийн хэмжээ амьжиргаанд хүрэлцэхүйц болно. | 31.2.1.1 | Нийгмийн халамжийн тэтгэврийг хүн амын амьжиргааны доод түвшний бүсүүдийн дундажтай харьцуулсан харьцаа | хувь | 2023 | 80 | 85 | 85.8 | 2,592,889,350.10 | 2,487,867,402.54 | 95.9% | Засгийн газрын 2025.12.31-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох тэтгэврийн хэмжээг 478.0 мянган төгрөг, бусад тэтгэврийн хэмжээг 432.0 мянган төгрөг болгон нэмэгдүүлсэн. ҮСХ-ны даргын 2026.01.19-ний өдрийн А/11 дүгээр тушаалаар бүсүүдийн амьжиргааны доод түвшингийн хэмжээг шинэчлэн тогтоосон бөгөөд 5 бүсийн дундаж 530.0 мянган төгрөг байна. Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээ нь хүн амын амьжиргааны доод түвшний бүсүүдийн дундажтай харьцуулахад 85.8%-тай тэнцэж байна. |
| | | | | 31.2.1.2 | Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн сэтгэл ханамжийн түвшин | хувь | 2023 | - | 50 | 83.3 | | | | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн сэтгэл ханамжийн түвшинг үнэлэх судалгааг хийж 2025.12.15-ны өдөр нэгтгэн танилцуулсан. Үйлчилгээнд хамрагдсан иргэдийн 83.3% нь сайн, маш сайн гэж үнэлсэн бол 15.3% дунд, 1.4% муу гэж үнэлжээ. |
| | 31.3 | **71903 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын бодлого, удирдлага** | | | | | | | | | | | | |
| | | 31.3.1 | Нийгмийн хамгааллын салбарын бодлого, удирдлага, үйл ажиллагааны хэрэгжилтийг сайжруулна. | 31.3.1.1 | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан нийгмийн хамгааллын салбарын бодлогын хэрэгжилтийн биелэлт | хувь | 2023 | 70.7 | 85 | 66.2 | 22,339,327.50 | 19,422,187.74 | 86.9% | Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Нийгмийн хамгааллын чиглэлээр туссан зорилт, арга хэмжээний 2025 оны жилийн эцсийн хэрэгжилтэд Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас 66.2 хувийн биелэлттэй байна гэсэн үнэлгээ өгсөн. |
| | | 31.3.2 | Хөдөлмөрийн салбарын бодлого, удирдлага, үйл ажиллагааны хэрэгжилтийг сайжруулна. | 31.3.2.1 | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан хөдөлмөрийн салбарын бодлогын хэрэгжилтийн биелэлт | хувь | 2023 | 83.5 | 85 | 64 | | | | Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Хөдөлмөрийн салбарын бодлогын чиглэлээр туссан зорилт, арга хэмжээний 2025 оны жилийн эцсийн хэрэгжилтэд Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас 64.0 хувийн биелэлттэй байна гэсэн үнэлгээ өгсөн. |
| | 31.4 | **72102 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих** | | | | | | | | | | | | |
| | | 31.4.1 | Хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлнэ. | 31.4.1.1 | Бага цалинтай ажиллагсдын хувь | хувь | 2023 | 11.2 | 11 | 8.4 | 152,498,672.00 | 69,307,550.93 | 45.5% | Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуульд заасан хүчин зүйлс болон талуудын саналыг харгалзан Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 03 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн цагт 4,715 төгрөг буюу сард 792,000 төгрөг байхаар шинэчлэн тогтоосон. ҮСХ-ны 2025 оны 4 дүгээр улирлын мэдээгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинждаг буюу бага цалинтай ажиллагсдын эзлэх хувь 8.4 байна. |
| | | 31.4.2 | Хөдөлмөрийн харилцааны хүрээнд гарч байгаа зөрчил, маргааныг бууруулна. | 31.4.2.1 | Хөдөлмөрийн харилцааны хүрээнд гарч байгаа маргаан | тоо | 2023 | 797 | 650 | 978 | | | | Төрийн албан хаагчдын тоог үе шаттайгаар бууруулах арга хэмжээг бууруулах бодлого, төрийн өмчит компани, үйлдвэрийн газруудад бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөд орсноор ажлаас чөлөөлөгдсөн ажилтнуудаас хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах хороонд хандах асуудал нэмэгдсэн. Мөн ажил олгогчдын хөдөлмөрийн хууль тогтоомжийн мэдлэг дутмаг (ялангуяа хөдөлмөрийн аюулгүй байдал, гэрээ цуцлах, цалин хөлс) байх нь ажилтны эрх ашгийг зөрчих, хөдөлмөрийн маргаан үүсэх үндсэн шалтгаан болдог. |
| | | 31.4.3 | Эрүүл, аюулгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ. | 31.4.3.1 | Ажлын байран дахь үйлдвэрлэлийн осол | тоо | 2023 | 408 | 380 | 809 | | | | 2025 онд нийт 809 хүн үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртөж, үүнээс 73 хүн нас барсан, 736 хүн гэмтэж, бэртэж, хордлогод өртсөн байна. 2025 онд 10,000 хүнд ногдох хүндрэлийн коэффицент 0.54, ослын коэффицент 5.96, 100,000 хүнд оногдох нас баралт 5.3 байна. 2023 оны мөн үетэй харьцуулахад хүндрэлийн коэффициент 0.2, нас баралт 1.6 пунктээр тус тус өссөн сөрөг үзүүлэлттэй байна. 2024 оны 1 дүгээр сараас үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын актыг бүртгэх цахим систем шинэчлэгдэн улсын байцаагч өөрөө ослын актыг системд бүртгэж оруулдаг болсноор байцаагчийн баталгаажуулсан ослын акт системд бүрэн ордог болсон. https://inspection.hudulmur-halamj.gov.mn/ |

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч | Хөтөлбөр | Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 31 | | 31.4.4 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээний хүрээнд тогтвортой хөдөлмөр эрхэлж байгаа иргэний тоог нэмэгдүүлнэ. | 31.4.4.1 | Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, арга хэмжээнд хамрагдсан иргэдээс 3 ба түүнээс дээш сарын хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлсөн иргэн | тоо | 2023 | 14,426 | 14,564 | 18,835 | | | | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын хөдөлмөрийн зах зээлийн тоон мэдээнээс харахад, улсын хэмжээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 25,964, үүнээс байнгын 18,835, улирлын 2,821, түр 4,308 шинэ ажлын байр бий болсон. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд 2024 онд 1.7 тэрбум төгрөгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зарцуулсан байна. |
| | | | | 31.4.4.2 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамрагдаж ажилтай болсон хүнсний тусламж, дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагддаг иргэн | тоо | 2023 | 35,281 | 35,633 | 22,884 | | | | Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар 103856 иргэнийг хамруулж, 11,4 тэрбум төгрөгийг олгосон.<br>Үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэдийг хүн амын бүлгээр авч үзвэл 0-18 хүртэлх насны 51,774 хүүхэд, 52,082 насанд хүрсэн иргэн хамрагдаж байгаагаас ахмад настан 4,002, хөгжлийн бэрхшээлтэй иргэн 6,825, өрх толгойлсон эмэгтэй 2,218, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд 864 тус байна.<br>Хүнсний эрхийн бичиг олгох журмын дагуу хөдөлмөрийн нөхцөл хангасан иргэдийн мэдээллийг авч үзвэл хөдөлмөрийн нөхцөл хамаарахгүй 21,515 /ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, өрх толгойлсон эх, эцэг, жирэмсэн, бага насны хүүхдээ асарч байгаа/, хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай 22,884 иргэн байна. Үүнээс ажил хөдөлмөр эрхэлдэг 14,346 иргэн байна. Хөдөлмөрийн нөхцөл шалгуур зайлшгүй биелүүлэх шаардлагатай 8,492 иргэнээс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нөхцөл шаардлага хангасан буюу “ажил хайж аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлсэн” 3,059 иргэн, “ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээнд хамрагдаж, зөвлөгөө авсан” 1,732 иргэн тус тус байна. |
| | | **72206 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, хамгаалал** | | | | | | | | | | | | |
| | | 31.5.1 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэний төрөлхийн болон алдагдсан чадамжийг боломжит дээд хэмжээнд сэргээнэ. | 31.5.1.1 | Хөгжлийн бэрхшээлтэй нийт иргэнээс биеийн үйлдэл, үйл ажиллагааны олон улсын стандарт ангиллын дагуу үнэлгээ хийлгэсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн | хувь | 2023 | - | 5 | 9.3 | | | | 2025 онд Биеийн үйлдэл, үйл ажиллагааны олон улсын стандарт ангилал буюу ICF-ийг үйл ажиллагаа, үнэлгээнд нэвтрүүлэхээр ажиллаж байгаа бөгөөд үүний хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв нь Үйлдлийн Олон улсын ангилал (ICF)-д суурилан хөгжлийн бэрхшээлийн 4 төрөл /Хараа, сонсгол, хөдөлгөөн, оюун ухаан/-д хөдөлмөр эрхлэлтийн чадварын үнэлгээний хуудас, арга аргачлалыг боловсруулсан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийн төв нь хөдөлмөрийн насны хөгжлийн бэрхшээлтэй 48748 иргэдийг бүртгэж, уг бүртгэлд хамрагдсан, хөдөлмөр эрхлэх хүсэлтээ илэрхийлсэн 10.076 хүнээс хөдөлмөрийн суурь чадамжийн хэв шинж буюу ICF агуулгыг тусгасан асуумжаар судалгаа авч мэдээллийн сан бүрдүүлээд байна. Энэхүү бүртгэл судалгааны үр дүнд хөдөлмөрийн насны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 48 хувийг бүртгэсэн, мөн ажил хийх сонирхолтой иргэдийн хөдөлмөрийн чадамж, ямар ажиллах эрхлэх хүсэлтээ байгаа, өрхийн орлого, хүртээмж зэргийг нарийвчлан судалсан бөгөөд цаашид ур чадварт нь нийцсэн ажлын байранд зуучлахаар ажиллаж байна. |
| | | | | 31.5.1.2 | Төрөлхийн болон алдагдсан чадварыг нь сэргээсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн | хувь | 2023 | 12 | 16 | 14 | | | | 2025 онд аймаг, дүүргийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн хурлын шийдвэрээр хөдөлмөрийн чадвар нь сэргээгдсэн гэх үндэслэлээр хөдөлмөрийн чадвар алдалтаа цуцлуулсан 18 дээс насны 2000 гаруй иргэн, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын хурлын шийдвэрээр хөгжлийн бэрхшээлээ цуцлуулсан 0-18 насны 572 хүүхэд байгаа бөгөөд энэ нь 2025 онд нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоотой харьцуулахад 2 хувиар буурсан үзүүлэлттэй байна. |
| | | | | 31.5.1.3 | Урт хугацааны идэвхтэй давтан хяналтад хамрагддаг хүүхэд | тоо | 2023 | 48 | 95 | 83 | | | | 2025 онд 21 аймаг, 9 дүүргийн 30 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс 653 удаагийн хурлыг зохион байгуулж, 13,387 хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг тогтоох, цуцлах, сунгах шийдвэр гаргах, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээнд холбон жуулчлах ажлыг хийсэн. Үүнээс 12,053 хүүхдийн байнгын асаргааны тэтгэмжийг сунган, хөгжлийн дэмжлэгийн төлөвлөгөөг боловсруулан тогтмол хяналт тавин ажилласан байна. |
| | | 31.5.2 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэний талаарх хэвшмэл ойлголтыг бууруулна. | 31.5.2.1 | Их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсрол сургалтын төвд сурч байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэн | тоо | 2023 | 9386 | 10500 | 0 | | | | 2025-2026 оны хичээлийн жилд боловсролын үйлчилгээнд нийт 9890 хөгжлийн бэрхшээлтэй иргэн хамрагдаж байгаа бөгөөд үүнээс их дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсрол сургалтын төвд 980 иргэн хамрагдаж байна. Өмнөх 2024 онд 1090 хөгжлийн бэрхшээлтэй иргэн их дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсрол сургалтын төвд суралцаж байсан. /Тус хэрэгжилт Боловсролын яамнаас гарах боломжтой./ |
| | 31.5 | | | 31.5.3.1 | Хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настан, хүүхэд зэрэг хүн амын бүлэгт ээлтэй, хүртээмжтэй болгосон иргэний барилга байгууламж | хувь | 2023 | 12 | 13 | 13 | 46,161,551.70 | 32,171,050.94 | 69.7% | Хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настан, хүүхэд зэрэг хүн амын бүлэгт ээлтэй, хүртээмжтэй болгосон иргэний барилга байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын харьяа байгууллагуудад чиглэл, зөвлөмж хүргүүлж ажилласан. Үүний хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газар, түүний харьяа байгууллагууд хүртээмжийг сайжруулах чиглэлээр 53 арга хэмжээ, Хүүхэд гэр бүлийн хөгжлийн ерөнхий газар, түүний харьяа байгууллагууд 67 арга хэмжээг хэрэгжүүлж, мэдээллийн болон орчны хүртээмжийг нэмэгдүүлсэн тохижилт, тохируулгат орчныг хийж ажилласан байна. Мөн 2025 онд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр олон улсын жишигт нийцсэн Архангай, Дархан-Уул, Дорнод, Дундговь, Хөвсгөл, Ховд аймагт Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг барьж ашиглалтад оруулсан. Мөн 2027 онд БЗД, Завхан аймагт барихаар барилгын ажил эхэлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн барилгын зураг төсөлд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ, техникийн шаардлагууд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг зорчих, хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангах зарчмууд тусгагдсан, олон улсын стандартын дагуу түгээмэл загвараар бүхий, нийт 2000 гаруй м.кв талбайтай, цогц үйлчилгээ үзүүлэх 24 өрөө тасалгаатай, дэвшилтэт техник, технологи бүхий тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон. |

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч | Хөтөлбөр | Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 31.5.3 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг нийгмийн амьдралд саадгүй оролцох хүртээмжийг сайжруулна. | 31.5.3.2 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийн түвшин | хувь | 2023 | 36 | 40 | 40 | | | | Салбарын хэмжээнд 2025 оныг “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил” болгон зарлан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн. Үүнд:<br>1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар, аймгийн ЗДТГ-тай хамтран Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жилийн хүрээнд салбар дундын уялдааг сайжруулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөдөлмөр эрхлэлтийн цогц үйлчилгээг хүргэх, иргэд, ажил олгогчдын ойлголт, хандлагыг сайжруулах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээг Хөвсгөл , Дундговь Баян-Өлгий аймгуудад зохион байгуулав. Тус арга хэмжээнд нийт 4172 иргэн тус тус хамрагдсан байна.<br>2.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих цогц арга хэмжээний хүрээнд дараах шинэ үйлчилгээг нэвтрүүлсэн:<br>-ажил эрхлэх боломжгүй, хөгжлийн бэрхшээлтэй нийт 100 иргэнийг тохируулгат ажлын байраар хангаж, ур чадварт нь нийцсэн халамжийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг үзүүлсэн;<br>-хөдөлмөрийн чадвараа түр болон бүрэн алдсан 100 иргэнийг дахин ажил эрхлэх боломжоор хангаж, ур чадварыг нь сэргээн нөхөн сэргээлтийн үйлчилгээг үзүүлсэн,<br>-ажил олоход хүндрэлтэй, хөгжлийн бэрхшээлтэй 100 иргэнийг хөдөлмөрийн зах зээл дээр ажиллахад дэмжлэг үзүүлэх, ажлын байраа хадгалах, хөдөлмөрийн шинэ дадал олгох хөтөлбөрийг хэрэгжүүлж, төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлсэн.<br>3.Бизнес инкубацын үйлчилгээ үзүүлэх 9 байгууллагатай гэрээ байгуулснаар хөгжлийн бэрхшээлтэй 85 иргэн бизнес инкубацын үйлчилгээ авч, бизнесээ өргөжүүлэх боломж бүрдсэн.<br>4.Хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй 50 иргэнд хувийн туслах үйлчилгээг үзүүлж, эдгээр иргэдийг хөдөлмөр эрхлэх боломжоор хангасан хувийн туслахуудад санхүүжилтийг сар бүр олгон ажилласан.<br>5.Ажлын байрны дадлагажуулагчийн үйл ажиллагааны хэрэгжилтийг зохицуулах ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан 13 байгууллагын ажлын байрны 18 дадлагажуулагч 10 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангасан.<br>6.“Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээний хүрээнд нийт 32 аж ахуй нэгж байгууллагатай гэрээ байгуулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 1.2 тэрбум төгрөгийг олгон 120 ажлын байрыг шинээр бий болгосон.<br>7.“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн Чадамжид суурилсан мэргэжлийн сургалтын 14 байгууллагатай гэрээ хийж, хөгжлийн бэрхшээлтэй 218 иргэн хамрагдаж 75.7 сая төгрөгийг олгосон. |
| | 31.6 | **72207 Хүүхдийн хөгжил, хамгаалал** | | | | | | | | | | | | |
| | | 31.6.1 | Гэр бүлийн боловсролыг дээшлүүлнэ. | 31.6.1.1 | Нийт гэр бүлд гэрлэлт цуцлалтын эзлэх хувь | хувь | 2023 | 2.2 | ≤2.2 буурна | 2.1 | | | | 2025 оны жилийн эцсийн байдлаар ХГБХХЕГ-ын харьяа газар, хэлтсээр дамжуулан гэр бүлийн боловсрол, хөгжил оролцоонд чиглэсэн 8 модуль сургалтын хүрээнд нийт 376,433 иргэнийг хамруулж, гэр бүл төлөвлөлт, санхүү, хууль зүй зэрэг сэдвээр сургалтад хамруулсан. ҮСХ-ны 2024 оны мэдээгээр гэр бүл салалтын түвшин 2.1 хувь болж буурсан байна. |
| | | 31.6.2 | Хүүхдийн эрхийн баталгааг сайжруулна. | 31.6.2.1 | Хүүхэд хамгааллын үйлчилгээ авахаар хандсан хүүхдийн нийт хүүхдэд эзлэх хувь | хувь | 2023 | 5.2 | 4.95 | 1.3 | 114,236,169.30 | 90,391,814.10 | 79.1% | 2025 оны байдлаар Монгол Улсад оршин суугаа 18 нас хүртэлх хүүхдийн тоо 1,261,317 байна. Энэ онд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ авахаар хандсан хүүхдийн тоо 16,720 байна. Энэ нь нийт хүүхдийн 1.3 хувийг эзэлж байна. Суурь түвшин 5.2 хувь байсан бол 1.3 хувь болж 3.9 хувиар буурсан үр дүнд хүрсэн байна. |
| | | | | 31.6.2.2 | Хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн нийт хүүхдэд эзлэх хувь | хувь | 2023 | 34.1 | 70 | 7.6 | | | | 2025 оны байдлаар Монгол Улсад оршин суугаа 0-18 нас хүртэлх хүүхдийн тоо 1,261,317 байна. 2025 оны байдлаар жилийн эцсийн байдлаар урьдчилан сэргийлэх үйлчилгээнд 96,751 хүүхэд хамрагдсан ба нийт хүүхдийн 7.6 хувийг эзэлж байна. |
| | **ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД** | | | | | | | | | | | | | |
| | 32.1 | **71601 Нийгмийн эрүүл мэнд** | | | | | | | | | | | | |
| | | 32.1.1 | Товлолт дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлж, дархлаажуулалттай халдварт өвчний тохиолдлыг бууруулна. | 32.1.1.1 | Тавт вакцины 3 дахь тунгийн хамралт /хүйсээр, бүсээр/ | хувь | 2023 | 96.5 | 96.9 | 96.3 | | | | Тайлант онд эхний тунд хамрагдвал зохих 53,236 хүүхдээс 51,873 хүүхэд хамрагдан 1,363 хүүхэд хоцорсон, II тунд 52,892 хүүхэд хамрагдахаас 50,907 хүүхэд хамрагдан 1,985 хүүхдэд хоцорсон, III тунд 52,342 хүүхэд хамрагдахаас 50,402 хүүхэд хамрагдан 1,940 хүүхэд хоцорч хамрагдалтын хувь 96.3 байна. |
| | | | | 32.1.1.2 | А вируст гепатитын эсрэг сэргийлэх тарилгын 2 дахь тунгийн хамралт | хувь | 2023 | 95.6 | 95.9 | 96.7 | | | | Эхний тунд 56103 хүүхэд хамрагдахаас 53892 хүүхэд, II тунд 66025 хүүхэд хамрагдахаас 53828 хүүхэд хамрагдаж хамрагдалтын хувь 96.7 боллоо. |
| | | | | 32.1.1.3 | Пневмококкийн эсрэг сэргийлэх тарилгын 3 дахь тунгийн хамралт /хүйсээр, бүсээр/ | хувь | 2023 | 96.1 | 96.5 | 96 | | | | Тайлант онд I тунд хамрагдвал зохих 53,183 хүүхдээс 51,829 хүүхэд хамрагдан 1,354 хүүхэд хоцорсон, II тунд 52,424 хүүхэд хамрагдахаас 50,402 хүүхэд хамрагдан 2022 хүүхдэд хоцорсон, III тунд 54,089 хүүхэд хамрагдахаас 51,925 хүүхэд хамрагдан 2,164 хүүхэд хоцорч хамрагдалтын хувь 96.0 байна. |
| | | 32.1.2 | Товлолт дархлаажуулалтад хүний папиллома вирусийн эсрэг вакциныг нэвтрүүлнэ. | 32.1.2.1 | Хүний папиллома вирусийн эсрэг тарилгад хамрагдах зорилтот бүлгийн хамралт | хувь | 2023 | - | 75 | 73.4 | 92,740,379.50 | 84,133,093.02 | 90.7% | Хамрагдвал зохих зорилтот бүлгийн 136,862 хүүхдээс 100,401 хүүхдийг хамрууллаа. 36,461 хүүхэд хамрагдаагүй, хамрагдалтын хувь 73.4 байна. |
| | | 32.1.3 | Эрүүл мэндийн даатгалд хамрагддаг эмчилгээ, үйлчилгээний хамрах хүрээг нэмэгдүүлж, зонхилон тохиолдох өвчнийг эрт илрүүлж, өвчлөл, нас баралтын | 32.1.3.1 | Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэг үзлэгт хамрагдалт | хувь | 2023 | 61.9 | 62 | 72 | | | | Улсын хэмжээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэг үзлэгт 18-аас дээш насны нийт 1,561,831 (72.0%) хүн хамрагдсан бөгөөд 40.6 хувь нь эрэгтэй, 59.4 хувь нь эмэгтэй байна. Үр дүнгийн үзүүлэлтээр нийт үзлэгийн 0.6 хувь нь артерийн гипертензи онош батлагдсан байна. |
| | | | | 32.1.3.2 | Чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгт хамрагдалт | хувь | 2023 | 79.1 | 80 | 85.9 | | | | Улсын хэмжээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгт 35-аас дээш насны нийт 1,196,468 (85.9%) хүн хамрагдсанаас 40.5 хувь нь эрэгтэй, 59.5 хувь нь эмэгтэй байна. Үр дүнгийн үзүүлэлтээр 0.2 хувьд нь чихрийн шижин өвчний онош батлагдсан байна. Зорилтот түвшиндээ хүрсэн үзүүлэлттэй байна. |

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч | Хөтөлбөр | Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 32 | | | эрсдэлт хүчин зүйлийг бууруулна. | 32.1.3.3 | Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт хамрагдалт | хувь | 2023 | 37.8 | 38 | 33.3 | | | | Улсын хэмжээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар умайн хүзүүний хорт хавдрын эсийн шинжилгээнд суурилсан илрүүлэг үзлэгт зорилтот насны нийт 81,993 (33.3%) эмэгтэй хамрагдсан байна. Үр дүнгийн үзүүлэлтээр нийт эсийн шинжилгээний 4.4 хувь нь Пап эерэг буюу эсийн түвшинд өөрчлөлттэй, үүнээс хорт хавдрын шинэ өвчлөлийн 28 тохиолдол бүртгэгдсэн байна. |
| | 32.2 | **71602 Эмнэлгийн тусламж, үйлчилгээ** | | | | | | | | | | | | |
| | | 32.2.1 | Сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, эх, нялхсын болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшнийг бууруулна. | 32.2.1.1 | Эхийн эндэгдлийн харьцаа /100000 амьд төрөлтөд, бүсээр/ | промиль | 2023 | 26.4 | 25 | 31.4 | 1,353,800,203.70 | 1,335,981,130.99 | 98.7% | Улсын хэмжээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар эхийн эндэгдлийн 17 тохиолдол бүртгэгдэж, 100,000 амьд төрөлтөд 31.4 ногдож байна. Сүүлийн 10 жилийн дунджаар 100,000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдэл 36.6 байна. |
| | | | | 32.2.1.2 | Нялхсын эндэгдлийн түвшин /1000 амьд төрөлтөд, хүйсээр, бүсээр/ | промиль | 2023 | 12.3 | 12 | 13.6 | | | | Улсын хэмжээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар нялхсын эндэгдлийн 738 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 13.6 ногдож байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 36 тохиолдлоор нэмэгдсэн үзүүлэлттэй байна.<br>Нялхсын эндэгдлийн 55.4 хувь нь эрэгтэй, 44.6 хувь нь эмэгтэй хүүхэд байна. |
| | | | | 32.2.1.3 | Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин /1000 амьд төрөлтөд, хүйсээр, бүсээр/ | промиль | 2023 | 14.9 | 14 | 16.9 | | | | Улсын хэмжээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 914 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 16.9 ногдож байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 37 тохиолдлоор нэмэгдсэн байна. |
| | | 32.2.2 | Товлолт дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлж, вируст гепатитын тохиолдлыг бууруулна. | 32.2.2.1 | В вируст гепатит өвчний тохиолдлын түвшин /100000 хүн амд ногдох, хүйсээр, бүсээр/ | промиль | 2023 | 3.6 | 2 | 2 | | | | Улсын хэмжээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар В вируст өвчний тохиолдлын түвшин сүүлийн жилүүдэд харьцангуй буурч байгаа ба 100,000 хүнд харьцуулахад 2 байгаа нь өмнөх онтой ижил байна. |
| | 32.3 | **71603 Эрүүл мэндийн бодлого, удирдлага** | | | | | | | | | | | | |
| | | 32.3.1 | Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлж байгаа иргэний сэтгэл ханамжийн үнэлгээнд үндэслэн эмнэлгийн тусламж, үйлчилгээг сайжруулж, иргэдэд ээлтэй болгоно. | 32.3.1.1 | Амбулаториор үйлчлүүлсэн үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж | хувь | 2023 | 83 | 85 | 86 | 273,294,131.30 | 201,831,171.38 | 73.9% | Амбулаториор үйлчлүүлсэн иргэдийн 86.0% тусламж, үйлчилгээний талаар эерэг сэтгэгдэлтэй, үйлчилгээг ”Маш сайн” болон “Сайн” гэж үнэлсэн байна. |
| | | | | 32.3.1.2 | Эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж | хувь | 2023 | 92.1 | 95 | 88 | | | | Амбулаторийн тусламж, үйлчилгээтэй харьцуулахад хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний эерэг сэтгэл ханамж харьцангуй илүү, дунджаар 88.0%-тай байна. |
| | 32.4 | **71605 Эрүүл мэндийн даатгал** | | | | | | | | | | | | |
| | | 32.4.1 | Эрүүл мэндийн үйлчилгээнд даатгалын, улсын төсвийн болон хувь хүний санхүүжилтийн зохистой харьцааг бий болгож, хүн амын эрүүл амьдралын хэвшлийг төлөвшүүлнэ. | 32.4.1.1 | Эрүүл мэндийн даатгалын сангийн хамрагдалт /хүйсээр/ | хувь | 2023 | 92.5 | 94 | 93.1 | 2,242,447,278,600.00 | 2,241,637,894,618.28 | 99.9 | Эрүүл мэндийн даатгалын хамралт өмнөх оны мөн үеэс 2.6 хувиар нэмэгдсэн байна. Үүнд төрөөс шимтгэлийг нь хариуцдаг иргэдийн хамралт 4.3 хувиар, ажил олгогч-даатгуулагчийн хамралт 1.6 хувиар өссөн бол шимтгэлээ өөрөө төлөгч иргэдийн хамралт 18.8 хувиар буурсан байна. |
| | | | | 32.4.1.2 | Эрүүл мэндийн нийт зардалд Эрүүл мэндийн даатгалын сангийн эзлэх хувь | хувь | 2023 | 36 | 37 | 36 | | | | Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага өмнөх оны мөн үеэс 13.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь төсвийн хөрөнгийг илүү үр ашигтай зарцуулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, тусламж үйлчилгээний тэргүүлэх чиглэлийг оновчтой тодорхойлсон, түүнчлэн гэрээт хувийн эрүүл мэндийн байгууллагын тоо буурсантай холбоотой байна. |
| | **ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД** | | | | | | | | | | | | | |
| | | **70901 Дулаан, цахилгаан эрчим хүч** | | | | | | | | | | | | |
| | | 33.1.1 | Дулаан, цахилгааны шинэ эх үүсвэр нэмэгдүүлнэ. | 33.1.1.1 | Эх үүсвэр нэмэгдсэн байх | гкал/цаг | 2023 | 230 | 271 | 358.9 | | | | Эрчим хүчний хэрэглээ сүүлийн жилүүдийн эдийн засгийн өсөлттэй уялдан жил бүр 6-7 хувиар нэмэгдэж байгаа боловч шинэ эх үүсвэр нэмэгдэхгүй байгаатай холбогдуулан дотоодын ДЦС-уудын хүчин чадал дутагдаж, импортын эрчим хүчний хараат байдал улам нэмэгдэж байна. Цахилгаан, дулааны эх үүсвэрүүд нэмэгдсэнээр бүс нутгийн хэрэглэгчид найдвартай эрчим хүчний эх үүсвэртэй болж амьдрах тухтай орчин бүрдэх, өвлийн оргил ачааллын үед төвийн бүсийн чадал хөнгөвчлөх, үйлдвэрлэл, үйлчилгээний газрууд шинээр байгуулагдах зэрэг бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд чухал ач холбогдолтой юм. Дулаан хангамжийн системийн, үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр Улаанбаатар хот, аймгийн төв, суурин газрын дулааны хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээг шинэчлэх, шинээр төлөвлөгдөж байгаа барилга орон сууцнуудыг дулаанаар хангах, дулааны ачаалал хүлээгдэж байгаа хэрэглээг хангахаас гадна агаарын бохирдлыг бууруулах зорилгоор 28 км дулааны шугамыг ашиглалтанд оруулсан бөгөөд техникийн шаардлагад нийцүүлэн инженерийн бусад шугам сүлжээний шилжилт, өргөтгөл шинэчлэлт 43.1 км хийгдсэн байна. 1. ӨРГӨТГӨЛ ХИЙСЭН ЭХ ҮҮСВЭРҮҮД: -Улсын төсвөөр: I.Ховд дулааны станцын өргөтгөл, 23 МВт<br>II. Дулааны станцын өргөтгөл, /Хөвсгөл, Мөрөн сум/ 21 МВт<br>III. Дорноговь аймгийн дулааны станцын өргөтгөл /Дорноговь, Сайншанд сум/ 23МВт-ын зуухны өргөтгөл (2*23=46 МВт буюу 20Гкал/ц*2)<br>IV.Уурын зуухны халаалтын тогоо 2 ширхэг /Хөвсгөл, Их-Уул сум/,<br>V. Дулаан хангамжийн шугам сүлжээ, зуухны барилга /Сүхбаатар, Асгат сум/ 1.6 МВт<br>VI. Дулааны станцын шинэчлэл /Ховд, Жаргалант сум/, 0.4 МВт<br>VII. Нарны цахилгаан станцын шинэчлэл /Хөвсгөл, Галт сум, Зүрх баг/ ажил 2.7 МВт<br>-Зээл, тусламж болон бусад эх үүсвэрээр:<br>VII. Бөөрөлжүүтийн ЦС 300 МВт<br>IX. Тосонцэнгэл ДС 22 МВт |

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч | Хөтөлбөр | Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 33 | 33.1 | 33.1.2 | Дулааны шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлт хийнэ. | 33.1.2.1 | Өргөтгөл, шинэчлэлтийг хийх | км | 2023 | 66.5 | 60.4 | 71.1 | 365,420,747.00 | 267,278,253.46 | 73.1% | 2. ДУЛААНЫ ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ШИНЭЧЛЭЛ: -Улсын төсвөөр: I.Дулааны 1 дүгээр гол шугам ТК-1 худгаас ТК-3 худаг хүртэлх 2Ø400 мм голчтой дулааны магистраль шугамыг 2Ø800 мм голчтой болгох өргөтгөл /Дорнод, Хэрлэн сум/ 3 км II.Хорооллын дулаан хангамж /Дархан-Уул, Дархан сум, 31 дүгээр хороолол/ 2.9 км III."Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станцын 2 дугаар хэлхээ, дэд бүтэц" -Төсөл арга хэмжээний хүрээнд 2025 онд:<br>Завхан, Улиастай сум 0.5 км, Сүхбаатар, Баруун-Урт сум 0.6 км, Төв 0.5 км, Өвөрхангай 3.4 км, Говь-Алтай 3.8 км, Говьсүмбэр 1.7 км, Баянхонгор 1.6 км IV."Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станц төслийн цахилгаан хангамж, дэд бүтэц" төсөл арга хэмжээний хүрээнд техникийн шаардлагаас шалтгаалан инженерийн бусад шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлт 2025 онд : Завхан, Улиастай сум 6.5 км, Сүхбаатар, Баруун-Урт сум 0.3 км, Төв аймаг 11.7 км, Хэнтий 4,6 км, Өвөрхангай 5.9 км, Говь-Алтай 9 км, Говьсүмбэр 3.6 км, Баянхонгор 1.0 км<br>-Зээл, тусламж болон бусад эх үүсвэрээр: I.Улаанбаатар хотын дулаан хангамжийн төсөл 2.8 км<br>II.Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг дээшлүүлэх төсөл 3.65 км |
| | | 33.1.3 | Улаанбаатар хотын цахилгаан хангамжийн дамжуулах, түгээх сүлжээний өргөтгөл шинэчлэл хийнэ. | 33.1.3.1 | Өргөтгөл, шинэчлэлд хамрагдсан айл өрх | тоо | 2023 | 9062 | 4970 | 4970 | | | | Төвлөрсөн эрчим хүчинд холбогдсон ч хүчдэлийн уналттай, тасралт ихтэй, ашиглалтын хугацаа дуусч солих шаардлагатай, нэмж хэрэглэгч холбох боломжгүй цахилгаан дамжуулах агаарын шугам болон дэд станцуудыг өргөтгөх, шинэчлэлтийг хийх улмаар цахилгаан дамжуулах агаарын шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэн алдагдлыг бууруулж, суурин газруудыг шинээр холбох ажлуудыг 15 аймгийн 53 сум, суурин газарт хэрэгжүүлээд байна. 1. ЦАХИЛГААН ХАНГАМЖИЙН ӨРГӨТГӨЛ, ШИНЭЧЛЭЛИЙН ЭХ ҮҮСВЭР: Улсын төсвөөр:<br>I. Хожуулын ам, Шивэртийн ам-1, Шар хоолойн Их амны цахилгаангүй айл өрхийн гадна цахилгаан хангамж, дэд станц /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 20 дугаар хороо/ 516 айл<br>II.Хөлийн гол-2, 3, Хонхор нуур-2 орчмын цахилгаангүй айл өрхүүдийг цахилгаан эрчим хүчээр хангах /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 11 дүгээр хороо/ 30 айл. III. Бүс нутгийн найдвартай цахилгаан хангамж, 1 дүгээр үе шат /Бүсүүд/, БАГЦ 17: Гэр хорооллын хүчдлийн уналттай болон гэрэл цахилгаангүй айл, өрхийн цахилгаан хангамж / Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг 1, 21 хороо 10 байршилд/ 660 айл. IV. Бүс нутгийн найдвартай цахилгаан хангамж, 1 дүгээр үе шат /Бүсүүд/, БАГЦ 18: Гэр хорооллын хүчдлийн уналттай болон гэрэл цахилгаангүй айл, өрхийн цахилгаан хангамж / Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг 24, 32, 33, 34, 36, 40, 42 хороо 12 байршилд/ 918 айл V.Бүс нутгийн найдвартай цахилгаан хангамж, 1 дүгээр үе шат /Бүсүүд/, БАГЦ 19: Булагтай, Нарийн нуур хэсгийн айл өрхийн цахилгаан хангамж /Улаанбаатар, Багануур дүүрэг/ 162 айл<br>VI. Улаанбаатар хотын гэр хорооллын цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй, хүчдэлийн уналттай айл өрхүүдийн цахилгаан хангамж /Улаанбаатар/ Багц-11 284 айл. VII. Улаанбаатар хотын гэр хорооллын цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй, хүчдэлийн уналттай айл өрхүүдийн цахилгаан хангамж /Улаанбаатар/ Багц-3 Баянзүрх 28, 23, 20 хорооны 9 байршилд 765 айл<br>Харьяа байгууллагуудад өөрийн хөрөнгө, бусад эх үүсвэр: "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК I. "Ухаалаг тоолуурын систем төслийн II үе шат" төслийн хүрээнд Хан-Уул ХҮТ, Баянгол ХҮТ, Чингэлтэй ХҮТ, Сүхбаатар ХҮТ, Зуслан ХҮТ, Налайх, Зуун мод төвд 151,219 ширхэг ухаалаг тооллуур, 2,051 ширхэг концентратор суурилуулах ажил хийгдсэн байна.<br>"Цахилгаан дамжуулах сүлжээ" ТӨХК<br>II. Богд дэд станц (110/10КВ-ын 2Х25 МВА чадалтай) 2025-2027 онд хэрэгжих<br>III. Дамба даржаа дэд станц (110/35/10 КВ-ын 2х40 МВА чадалтай) 2025-2026 онд хэрэгжих |
| | | 33.1.4 | Орон нутгийн цахилгаан хангамж дамжуулах, түгээх сүлжээний өргөтгөл, шинэчлэл хийнэ. | 33.1.4.1 | Өргөтгөл, шинэчлэлийг хийх | тоо | 2023 | 28 | 31 | 53 | | | | 1. ӨРГӨТГӨЛ, ШИНЭЧЛЭЛ ХИЙСЭН ЭХ ҮҮСВЭРҮҮД: Улсын төсвөөр:<br>I. Бүс нутгийн найдвартай цахилгаан хангамж, 1 дүгээр үе шат /Бүсүүд/ II. Шинэ Зуунмод хотын 110 кВ-ын 2 хэлхээт ЦДАШ, 110/35/10 кВ "Аэросити" дэд станцын барилга угсралтын ажлын үргэлжлэл /Төв, Сэргэлэн сум/ III. Аймгийн төвд баригдаж байгаа дулааны станц төслийн цахилгаан хангамж, дэд бүтэц/ Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Сүхбаатар, Завхан, Хэнтий, Төв, Өвөрхангай, Дундговь аймгийн төвийн сумдад/ IV. Багийн төвийн цахилгаан хангамж /Баян-Өлгий, Булган сум, Шүвтэрт, Улаанхус баг/ V. Бичигт, Алагтолгой, Баатархайрхан, Тахилт, Бугат, Буянт, Хайрхан багуудын цахилгаан хангамж /Ховд, Жаргалант сум/ VI. Хөшөөт-Үенч чиглэлийн 35 кВ цахилгаан дамжуулах агаарын шугамаас Алтай сум хүртэлх 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц /Ховд, Алтай сум/ VII. Цахилгаан хангамж/ Баян-өлгий, Бугат, Алтанцөгц сум/ VIII. Алтай Таван Богдын байгалийн цогцолборт газрын цахилгаан хангамж /Баян-Өлгий, Цэнгэл сум/ IX. Хилийн цэргийн 0165 дугаар ангийн 1, 2 дугаар заставын цахилгаан хангамж /Баян-Өлгий, Цэнгэл сум/ X. Хөшөөтийн уурхайгаас Ховд аймгийн Үенч сум хүртэл 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, Үенч дэд станцын өргөтгөл /Ховд, Үенч сум/ XI.Хөшөөтийн нүүрсний уурхайг түшиглэсэн сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийн цахилгаан хангамж /Ховд, Дарви сум/ |
| | | 33.1.5 | Гэр хорооллын өрхэд цахилгааны хөнгөлөлт үзүүлнэ. | 33.1.5.1 | Шөнийн цагт хэрэглэсэн цахилгааны тарифт хөнгөлөлт үзүүлсэн өрх | тоо | 2023 | 210569 | 223227 | 234136 | | | | 16 төрийн өмчит хувьцаат компаниудад 82.1 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож, 234,136 айл өрхөд шөнийн цахилгааны тарифын хөнгөлөлт үзүүлсэн. |
| | **ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН САЙД** | | | | | | | | | | | | | |
| | | **71509 Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн бодлого, удирдлага** | | | | | | | | | | | | |

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч | Хөтөлбөр | Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 34 | 34.1 | 34.1.1 | Барилга, хот байгуулалтын салбарын Улсын Их Хурлаар батлуулах төсөл-2, Засгийн газрын тогтоол-1 боловсруулж, техникийн зохицуулалтын төсөл, эрх зүйн орчин бүрдэнэ. | 34.1.1.1 | Улсын Их Хурал болон Засгийн газраар батлуулах барилга, хот байгуулалтын салбарын холбогдох дүрэм, журам | тоо | 2024 | - | 3 | 3 | 408,160,455.40 | 268,434,324.20 | 65.80% | 2025 онд Засгийн газраар дараах гурван тогтоолыг батлуулан ажиллалаа. Үүнд:<br>1.“1008 айлын орон сууцны төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 137 дугаар тогтоол,<br>2.“Барилгын материал, бүтээгдэхүүний аюулгүй байдлын техникийн зохицуулалт”-ыг батлах тухай 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 210 дугаар тогтоол,<br>3.“Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийг батлах Засгийн газрын 211 дүгээр тогтоолууд болно. Мөн “Хууль тогтоомжийн тухай хууль”-ийн шаардлагын дагуу “Орон сууцны санхүүжилтийн банкны тухай” болон “Орон сууцжуулалтын тухай” хуулийн төслүүдийн бүрдэл хэсэг болох тандан судалгаа, харьцуулсан судалгаа, олон улсын туршлагын судалгаа, үзэл баримтлал, хуулийн төсөл болон дагалдах хуулийн төслүүдийг боловсрууллаа. Эдгээр хуулийн төслүүдийг олон нийтэд нээлттэйгээр танилцуулж, иргэд, холбогдох төрийн |
| | | 34.1.2 | Шинээр барих болон шинэчлэх цэвэр, бохир усны шугам сүлжээний хэмжээг нэмэгдүүлнэ. | 34.1.2.1 | Шинээр барих болон шинэчлэх цэвэр усны шугам сүлжээний хэмжээ | Км | 2024 | 30 | 50 | 97.2 | | | | 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 97.16 км цэвэр усны шугам сүлжээ, 57.34 км бохир усны шугам сүлжээний барилга угсралтын ажлыг тус тус гүйцэтгэсэн байна. |
| | | | | 34.1.2.2 | Шинээр барих болон шинэчлэх бохир усны шугам сүлжээний хэмжээ | км | 2024 | 20 | 50 | 57.3 | | | | |
| | | 34.1.3 | Шинээр барих цэвэрлэх байгууламжийн бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэлийг нэмэгдүүлнэ. | 34.1.3.1 | Шинээр барих цэвэрлэх байгууламжийн бүтээн байгуулалтын явц | хувь | 2024 | 70 | 60 | 67 | | | | Төлөвлөгдсөн хөтөлбөрийн хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Говь-Алтай, Ховд, Сэлэнгэ, Өвөрхангай аймгуудын 6 сум болон Багануур дүүрэгт ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн нийт 7 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлээд байна. Ажлын гүйцэтгэл дараах байдалтай байна. Үүнд:<br>1. Өвөрхангай аймгийн Төгрөг суманд 100 м³ багтаамжтай ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажил 100 хувь бүрэн дууссан,<br>2. Өвөрхангай аймгийн Уянга суманд 70м³ болон Бат-Өлзий суманд 250м³ багтаамжтай цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажил 65–80 хувийн гүйцэтгэлтэй,<br>3. Ховд аймгийн Үенч суманд 150м³ багтаамжтай ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажил 80 хувийн гүйцэтгэлтэй,<br>4. Говь-Алтай аймгийн Есөнбулаг суманд хоногт 3000м³ хүчин чадалтай “Ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн өргөтгөл, шинэчлэлийн ажил” 25 хувийн гүйцэтгэлтэй,<br>5. Багануур дүүрэгт “Ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж”-ийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл 50 хувь,<br>6. Сэлэнгэ аймгийн Баянгол сумын ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийн ажил 70 хувийн гүйцэтгэлтэйгээр тус тус хэрэгжлээ. |
| | | 34.1.4 | Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламж, бусад эх үүсвэрийн хөрөнгө оруулалтаар шинээр болон өргөтгөл, шинэчлэл хийж байгаа төсөл, арга хэмжээний барилга, байгууламжийн ажлын чанар, аюулгүй байдалд гарч байгаа зөрчил дутагдлыг арилгана. | 34.1.4.1 | Барилга, байгууламжийн чанар, аюулгүй байдал | хувь | 2024 | 10 | 15 | 15 | | | | 2025 онд улсын хэмжээнд нийт 155 иргэн, 870 аж ахуйн нэгж, байгууллагын 1,025 барилга байгууламжийг хяналт шалгалтад хамруулсан байна. Хяналт шалгалтын явцад нийт 4,595 зөрчил илрүүлснээс 2,552 зөрчлийг бүрэн арилгуулж, зөрчлийн хэрэгжилт 55.5 хувьтай гүйцэтгэгдлээ.<br>Хяналт шалгалтын хүрээнд улсын байцаагчийн 170 албан шаардлага, 50 акт, 127 дүгнэлт, 3,609 заалт бүхий 259 зөвлөмж тус тус боловсруулан хэрэгжилтийг хангуулж ажиллав.<br>Мөн нийт 731,550.0 сая төгрөгийн торгууль ногдуулж, 60 барилга байгууламж, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг бүрэн зогсоон, эрх бүхий албан тушаалтанд албан даалгавар өгч, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүллээ. |
| | | 34.1.5 | Үндэсний орон сууцны хөтөлбөр хэрэгжүүлнэ. | 34.1.5.1 | Үндэсний орон сууцны хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл | тоо | 2024 | - | 1 | 0 | | | | “Үндэсний орон сууцжуулалтын тухай” хуулийн төслийг боловсруулах явцад Монгол Улсын Ерөнхий сайдын 45 дугаар захирамж гарч, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх, орлогод нийцсэн орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд орон сууцны санхүүжилтийн тусгай чиг үүрэг бүхий банк байгуулах асуудлыг судлах Ажлын хэсгийг байгуулсан. Уг Ажлын хэсгийн хүрээнд “Орон сууцжуулалтын тухай” хууль болон “Орон сууцны санхүүжилтийн банкны тухай” хуулийн төслийг тус тус боловсруулах шийдвэр гарч, холбогдох судалгаа, шинжилгээг хийж гүйцэтгэсэн байна.<br>Одоогийн байдлаар эдгээр хуулийн төслийг боловсруулж дуусган, олон нийтэд нээлттэйгээр танилцуулан, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага болон мэргэжлийн холбоодоос санал, зөвлөмж |
| | | | | 34.1.5.2 | Түрээсийн орон сууцны нэг маягийн зураг төсөл | тоо | 2024 | - | 4 | 12 | | | | Орон нутаг дахь төрийн үйлчилгээг сайжруулах, төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллах таатай орчныг бүрдүүлэх, тэдний нийгмийн баталгааг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд “Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах цогц хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж байна.<br>Хөтөлбөрийн хүрээнд орон нутагт мэргэжлээрээ ажиллаж, амьдрах төрийн албан хаагчдад зориулсан, холбогдох норм, стандартын шаардлагад нийцсэн, эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй, ногоон барилгын шаардлагыг хангасан орон сууцны загвар зураг төслүүдийг боловсруулж байна.<br>Инженерийн хангамжийг тухайн байршлын онцлогт тохируулан: бие даасан, төвлөрсөн (зарим суманд), хэсэгчилсэн шийдлээр тус тус төлөвлөсөн бөгөөд 2024–2025 онд аймаг, сумдын Засаг дарга нартай хамтран эхний ээлжийн 12 байршилд амжилттай хэрэгжүүлж, уг төслийн хүрээнд боловсруулсан 12 барилгын зураг төсөл магадлалын дүгнэлтээр баталгаажсан байна.<br>Мөн цаашид 8 болон 15 айлын орон сууцны иж бүрэн зураг төслийг Ногоон барилгын үнэлгээний BESTGER аргачлалын шаардлагад нийцүүлэн боловсруулж, ногоон, тогтвортой хөгжлийн шалгуураар баталгаажсан зураг төсөлтэй болох чиглэлээр ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна. |
| | | | | 34.1.5.3 | Төрийн албан хаагчдын орон сууцны барилгын нэг маягийн зураг төсөл | тоо | 2024 | - | 2 | | | | | |
| | | **71503 Хот суурингийн ерөнхий төлөвлөлт** | | | | | | | | | | | | |

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч | Хөтөлбөр | Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 34.2 | 34.2.1 | "Шинэ Хархорум" хотын 2 дугаар ээлжийн инженерийн шугам сүлжээний зураг төслийг боловсруулна. | 34.2.1.1 | "Шинэ Хархорум" хотын 2 дугаар ээлжийн инженерийн шугам сүлжээний зураг төсөл | хувь | 2024 | - | 50 | 80.5 | 2,800,992.90 | 2,166,489.80 | 77.3% | 2025 онд дараах зураг төсөл, судалгааны ажлууд гэрээний дагуу амжилттай хэрэгжиж, нийт 80.5 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнд:<br>1. “Шинэ Хархорум” хотын II ээлжийн авто зам, замын байгууламжийн техник эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ) – 70%, Инженерийн нарийвчилсан зураг төсөл – 70% ,<br>2. “Хэлтгий цагаан” нуурыг сэргээх, бохирдолт болон ширгэлтээс хамгаалах Судалгаа, зураг төсөл – 90% ,<br>3. Хархорум хотын унд ахуйн зориулалттай ундны усны эх үүсвэр 1 дүгээр талбайн эхний ээлжийн ашиглалтын худаг болон Холбогдох барилга байгууламжийн зураг төсөл – 85%,<br>4. Арвайхээр–Хархорум хот чиглэлийн 220 кВ-ийн цахилгаан дамжуулах агаарын шугмын ажлын зураг төсөл – 77%-гаар тус тус хийгдэж нийт ажлын гүйцэтгэл 80.5%-тай хэрэгжсэн байна. |
| | | 34.2.2 | Улаанбаатар хотын хэт төвлөрлийг сааруулна. | 34.2.2.1 | Нийслэл Улаанбаатар хотын дагуул хотуудын бүтээн байгуулалт | хувь | 2024 | Т | 10 | 10 | | | | Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар Эрчим хүчний сайдын багцад батлагдсан төслийн арга хэмжээний хүрээнд:<br>1. “Шинэ Зуунмод хотын 110 кВ-ын 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугам, 110/35/10 кВ ‘Аэросити’ дэд станцын барилга угсралтын ажлын үргэлжлэл” төсөл /Төв аймаг, Сэргэлэн сум/,<br>2. “Хөшигийн хөндийн шинэ хотын инженерийн дэд бүтэц” төсөл /Төв аймаг/ зэрэг төслүүд батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байна.<br>Мөн Азийн хөгжлийн банк (АХБ)-ны техник туслалцааны хүрээнд хэрэгжиж буй “Хөшигийн хөндийд байгуулагдах даван туулах чадвартай, ногоон шинэ хотын дэд бүтцийг хөгжүүлэх бэлтгэл хангах төсөл” (TA-10059 MON)-ийн техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)-ийн эцсийн шатны тайланг хүлээн авсан бөгөөд уг төслийн “Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт”-ийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамаар батлуулсан болно. |
| | 34.3 | **71105 Авто тээврийн хяналт, зохицуулалт, үйлчилгээ, нийтийн тээвэр** | | | | | | | | | | | | |
| | | 34.3.1 | Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлд нөлөөлж байгаа хүчин зүйлийг тогтоож, эрх зүйн орчныг сайжруулна. | 34.3.1.1 | Зорчилтын судалгаа | хувь | 2022 | Т | 100 | 100 | - | - | - | Хөтөлбөрийн хүрээнд “20 минутын хот – Үндэсний хороо” байх үед Улаанбаатар хотын авто замын түгжрэлд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, холбогдох эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгоор “Хууль тогтоомжийн тухай” хуулийн 8 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн “Зорчилтын судалгаа” болон “Тандан судалгаа”-г нийт 19 сая төгрөгөөр хийсэн.<br>Судалгааны үр дүнд нийслэлийн хэмжээнд авто замын 176 уулзвар, гарц болон авто замын дагуу нийт 2,606 ширхэг камер суурилуулсан байна.<br>Хиймэл оюунд суурилсан системийг ашиглан замын хөдөлгөөний зөрчлийг илрүүлэх, шийдвэрлэх үйл ажиллагааг нэвтрүүлснээр шүүх, прокурор, эрх бүхий албан тушаалтнууд болон замын хөдөлгөөнд оролцогчдод тулгарч буй хүндрэл, чирэгдлийг бууруулах, зөрчлийн хэргийг автоматжуулсан системээр цахим хэлбэрээр бүртгэх, шалгах, хянан шийдвэрлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлага үүссэн. Уг шаардлагыг үндэслэн “Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хурлаар хэлэлцүүлсний үр дүнд хуулийн нэмэлт, өөрчлөлтийг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор баталсан болно. |
| | | | | 34.3.1.2 | Тандан судалгаа | хувь | 2022 | 50 | 100 | 100 | - | - | - | |
| | | 34.3.2 | Хүүхдэд замын хөдөлгөөнд оролцох мэдлэг, дадал, хэвшлийг суулгаж, хүүхэд өртсөн зам, тээврийн ослын тоог бууруулна. | 34.3.2.1 | Төхөөрөмж, хэрэглүүр нийлүүлэлтийн биелэлт | хувь | 2022 | Т | 100 | 100 | - | - | - | |
| | | | | 34.3.2.2 | Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай урьдчилан сэргийлэх сургалтыг ерөнхий боловсролын сургуульд зохион байгуулах | тоо | 2023 | - | 200 | 0 | - | - | - | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 22 дугаар тогтоолын дагуу төрийн байгууллагын чиг үүргийн давхардлыг арилгах, зохион байгуулалтыг оновчтой болгох зорилгоор “20 минутын хот – Үндэсний хороо”-г татан буулгаж, түүний хэрэгжүүлж байсан чиг үүргийг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын багцад харьяалагдах “20 минутын хот хөгжлийн төв”-д шилжүүлсэн бөгөөд 34.3.2.2 - 34.4.1.2-т заасан шалгуур үзүүлэлтүүд тус төвд хамааралгүй болно. |
| | | | | 34.3.2.3 | Зам тээврийн осолд өртсөн хүүхдийн тоог бууруулах | тоо | 2023 | 780 | 300 | 0 | | | | |
| | 34.4 | **70427 Төрийн нийтлэг бусад үйлчилгээний судалгаа шинжилгээ** | | | | | | | | | | | | |
| | | 34.3.2 | Хүүхдэд замын хөдөлгөөнд оролцох мэдлэг, дадал, хэвшлийг суулгаж, хүүхэд өртсөн зам, тээврийн ослын тоог бууруулна. | 34.4.1.1 | Бодлогын бичиг баримт | тоо | 2024 | Т | 2 | | | | | |
| | | | | 34.4.1.2 | Дүрэм, журам | тоо | 2024 | Т | 2 | | | | | |
| | **СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН САЙД** | | | | | | | | | | | | | |
| | 35.1 | **71702 Соёл, урлаг** | | | | | | | | | | | | |
| | | 35.1.1 | Соёл, урлагийн үйлчилгээнд хамрагдах иргэдийн хамрагдалтыг нэмэгдүүлнэ. | 35.1.1.1 | Соёл, урлагийн үйлчилгээний хүртээмж | хувь | 2018 | 47.1 | 50 | 38.7 | 275,718,173.60 | 251,416,812.33 | 91% | Урлагийн тоглолтод хамрагдсан үзэгчдийн тоонд: Концерт, циркийн тоглолт, жүжиг үзсэн үзэгчдийн тоог хамруулахад 2025 оны статистик мэдээгээр мэргэжлийн урлагийн байгууллага буюу урлагийн байгууллагын нийт үйлчлүүлэгч 2,018,751, үүнээс тоглолт үзсэн үзэгчдийн тоо-1,425,359, нийт үзвэр үйлчилгээний тоо 5,325, үүнээс урлагийн тоглолтын тоо 3,676 байна. Оршин суугаа жилийн дундаж хүн ам 2024 оноор-3,419,193 байна. Монгол Улсын ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн олон улсад хийсэн төрийн айлчлалын хүрээнд “Монголын сайхан орон” урлагийн тоглолт болон гэрэл зургийн үзэсгэлэнг Турк, Чех, Польш, Киргиз, Тажикстан, Энэтхэг, Итали болон Гэгээн ширээт улсуудад тус тус зохион байгууллаа. Тус арга хэмжээнд Монгол Улсаа төлөөлж Монголын Үндэсний урлагийн их театрын Үндэсний их найрал хөгжим бүрэн бүрэлдэхүүнээрээ болон Монгол Улсын филармонийн Морин хуурын чуулгын нийт уран бүтээлчид оролцон үндэсний урлагийн шилдэг дээжис, урын сангаас толилуулж, үндэсний урлагаа таниулж, Монгол Улсаа сурталчилан таниулж, соёлын хүртээмжийг нэмэгдүүлсэн. |

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч | Хөтөлбөр | Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 35 | | 35.1.2 | Соёлын дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 35.1.2.1 | 1000 хүн тутамд ногдох соёл, урлагийн байгууллагын суудал | тоо | 2018 | 32 | 35 | 36.5 | [illegible] | [illegible] | [illegible] | Нийт соёл урлагийн байгууллагын суудлын тоонд: Урлагийн байгууллагын суудлын тоо-14,788, Кино театрын суудлын тоо-8,958, Соёлын төв(ордон)-ийн суудлын тоо-89,533, Нийтийн номын сангийн суудлын тоо-11,565 орно. Нийт суудлын тоо 124,844. Дээрх тооон үзүүлэлтийг үзвэл 1000 хүн тутамд ногдох соёл, урлагийн байгууллагын суудал хүртээмжтэй байна. |
| | | | | 35.1.2.2 | Технологийн бүтээгдэхүүн, хөгжүүлэлтэд оруулсан төсөл | тоо | 2023 | 10 | 15 | - | | | | Технологийн бүтээгдэхүүн, хөгжүүлэлтэд оруулсан төсөл |
| | | | | 35.1.2.3 | Нийтийн эзэмшлийн талбайд соёлын зориулалттай задгай талбайн хэмжээ | мкв | 2023 | 500 | 1,000 | 800 | | | | Улсыг болон хувийн хэвшлийн соёлын байгууллагууд соёлын орон зайг нэмэгдүүлэж нийтийн эзэмшлийн болон задгай талбайг соёл, үйлчилгээний зориулалтай болгон тохижуулах ажлын хүрээнд Нийслэлийн Баянзүрх дүүрэг, Монгол Кино Нэгтгэл ТӨҮГ-ийн хамтран хэрэгжүүлсэн “Кино гудамж” төслийн талбай 800 м.кв. болсон. |
| | 35.2 | **71701 Биеийн тамир, спорт** | | | | | | | | | | | | |
| | | 35.2.1 | Тив, дэлхийн спортын амжилтыг нэмэгдүүлнэ. | 35.2.1.1 | Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс авсан медаль | тоо | 2023 | 16 | 16 | 23 | 59,972,674.00 | 44,041,206.40 | 73% | Жүдо бөхийн ДАШТ-ээс 2 хүрэл, чөлөөт бөхийн ДАШТ-ээс 1 мөнгө, 3 хүрэл, боксын ДАШТ-ээс 1 мөнгө, 1 хүрэл, 3х3 сагсан бөмбөгийн ДАШТ-ээс эмэгтэй баг мөнгөн медаль, пара жүдо бөхийн ДАШТ-ээс 2 хүрэл, пара байт харвааны ДАШТ-ээс 2 алтан медаль, пара пауэрлифтингийн ДАШТ-ээс 1 мөнгө, нийт 14 медаль хүртсэн. |
| | | | | 35.2.1.2 | Тивийн аварга шалгаруулах тэмцээн /тивийн наадам/-ээс авсан медаль | тоо | 2023 | 57 | 32 | 139 | | | | Итали улсын Турин хотод 2025 оны 3-р сарын 8-16-ны хооронд зохион байгуулагдсан тусгай олимпын өвлийн дэлхийн VII наадамд (Special Olympics World Winter Games) Монгол улсаас спортын 6 төрөлд 24 тамирчин 9 дасгалжуулагч оролцож 5 алт, 10 мөнгө, 6 хүрэл медаль хүртсэн.<br>2025 онд Үндэсний шигшээ баг багийн Азийн АШТ, Залуучуудын Тивийн аварга шалгаруулах тэмцээн, Их дуулга, Гран при, Дэлхийн цом, Эрх олгох олон улсын тэмцээн, Оюутны Универсиад зэрэг тэмцээнээс 118 медаль хүртсэн байна. |
| | | 35.2.2 | Идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэний тоог нэмэгдүүлнэ. | 35.2.2.1 | 6-64 насны бие бялдрын түвшин тогтоох сорилд хамрагдаж А, В, С үнэлгээ авсан хүний эзлэх хувь | хувь | 2023 | 68.3 | 69 | 70.7 | | | | Хүн амын бие бялдрын түвшин тогтоох сорилд 2025 оны жилийн эцсийн байдлаар 142,226 иргэн хамрагдсан. Үүнээс: эмэгтэйчүүд 70,749 иргэн буюу 50.2 хувийг эзэлж байгаа ба 3-5 нас 45394, 6-17 нас 79,672, 20-24 нас 1497, 25-44 нас 10,418, 45-54 нас 4,050, 55-64 насны 1,195 иргэн сорилд хамрагдсан байна. Сорилд хамрагдсан иргэд А үнэлгээтэй 30,053 буюу 21,1% үүнээс эмэгтэйчүүд 70,751 буюу 49.7 %, В үнэлгээтэй -41,801 буюу 29,3% үүнээс эмэгтэйчүүд 9,617 иргэн 27,8 % С үнэлгээтэй 28,835 буюу 20,2 % үүнээс эмэгтэйчүүд 12,961 буюу 18,3 % байна. Нийт А, В, С үнэлгээтэй 100,689 иргэн буюу 70,7 хувийг эзэлж байна. |
| | 35.3 | **71703 Аялал жуулчлал** | | | | | | | | | | | | |
| | | 35.3.1 | Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгчийн тоог нэмэгдүүлнэ. | 35.3.1.1 | Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг чадавхжуулах сургалтад | тоо | 2022 | 10,000 | 15,000 | 900 | 10,065,567.90 | 4,526,191.50 | 45% | Салбарын менежмент, хөтөч, жолооч болон бизнес эрхлэгчдэд зориулсан цуврал сургалтуудыг инновац, үйлчилгээний технологийн чиглэлээр зохион байгуулж, нийт 900 хүнийг хамруулан чадавхижуулж ажилласан. |
| | | | | 35.3.1.2 | Монгол Улсыг сонирхсон гадаадын жуулчны цахим хандалт /нэмэгдэлтийн хувь/ | хувь | 2019 | 10 | 30 | 20 | | | | 1. Гадаадын жуулчдын цахим хандалтыг нэмэгдүүлсэн үзүүлэлтүүд:<br>- 2025 онд "Go Mongolia" брэндийг хэрэгжүүлснээр гадаад сурталчилгаа эрчимжиж, дэлхий даяар 432 сая гаруй хүнд хүрч 20 хувь өссөн үзүүлэлттэй байна.<br>- 2025 онд БНСУ болон Япон улсын 17 хүний бүрэлдэхүүнтэй инфлюенсерүүдийн баг ажиллаж, "Тик Ток" платформоор дамжуулсан контентууд нь 41 саяас 102 саяын лайкын хандалт авсан байна. |
| | | | | 35.3.1.3 | Гадаад, дотоодод зохион байгуулах арга хэмжээ | тоо | 2023 | 73 | 83 | 30 | | | | Монгол Улс олон улсын түвшинд “ITB Berlin”, “WTM London” зэрэг аялал жуулчлалын 12 үзэсгэлэнд оролцсон бол дотооддоо “Мазаалай”, “Хөх сувд” зэрэг өвөл, зуны 18 томоохон арга хэмжээг зохион байгуулж, санхүүгийн болон бодлогын дэмжлэг үзүүлэн ажилласан. Монгол, Хятад, Орос гурван улсын аялал жуулчлалын сайд нарын нэгдсэн хуралдааныг Дархан-Уул аймгийн Дархан хотод 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр зохион байгуулж, тус хуралдаанаар гурван улсын аялал жуулчлалын тэргүүлэх чиг хандлага “Цайны зам”-ын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр хамтран хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээ, бүтээн байгуулалт, дэд бүтэц, аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгох, хамтарсан туршлага солилцох хөтөлбөр хэрэгжүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх боломж, нөхцөлийг бүрдүүлэх зэрэг асуудлуудыг хэлэлцэж, Монгол, Хятад, Оросын “Цайны зам”-ын аялал жуулчлалын хамтын ажиллагааг хөгжүүлэх төлөвлөгөөнд гарын үсэг зурсан. Энэ хүрээнд “ЦАЙНЫ ЗАМ” авто аяллын хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр болсон ба Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Оросын Холбооны Улсын бүс нутгийн аялал жуулчлалын урсгалыг тогтворжуулах, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, соёлын харилцааг өргөжүүлэх ач холбогдол бүхий гурван улсын хамтын ажиллагааны шинэ төсөл хэрэгжих болсон. |
| | | | | 35.3.1.4 | Хүлээн авах гадаадын жуулчин /өссөн дүнгээр/ | тоо | 2022 | 290,000 | 500,000 | 727,386 | | | | Монгол Улсад 2025 онд 846,103 мянган жуулчин хүрэлцэн ирж, өмнөх жилүүдээс өндөр өндөр түүхэн дээд хэмжээнд хүрч өссөн бөгөөд аялал жуулчлалын салбарын орлого 1,6 тэрбум төгрөгт хүрсэн. Жуулчдын тоо өмнө оны мөн үеэс 14 хувийн өсөлттэй байгаа бөгөөд тухайлбал БНХАУ-аас 15,604 жуулчин, ОХУ-аас 13,260 жуулчин, БНСУ-аас 2,905 жуулчин тус тус ирсэн байна. Соёл, спорт, аялал жуулчлалын яамнаас Монгол Улсын аялал жуулчлалыг сурталчлах, жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх шат дараатай арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа бөгөөд цаашид жуулчдын тоо тогтмол өсөх хандлагатай байна. |
| | | **72209 Залуучууд** | | | | | | | | | | | | |

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч | Хөтөлбөр | Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 35.4 | 35.4.1 | Зорилтот бүлгийн залуучуудын нийгмийн оролцоо, үйлчилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлнэ. | 35.4.1.1 | Залуучуудын хөгжлийн төвөөр үйлчлүүлсэн залуучуудын нийт залуучуудад эзлэх хувь | хувь | 2022 | 40.3 | 30 | 30.8 | 943,799.90 | 552,953.90 | 58.6% | 2025 оны жилийн эцсийн байдлаар Залуучуудын хөгжлийн төвөөр үйлчлүүлсэн залуучуудын тоо -312,483 байна. 2024 оны байдлаар 15-34 насны залуучуудын тоо 1,014,402 байна. Залуучуудад олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн цахим ур чадварыг олгох “Google with grow” хөтөлбөрийг “Гэү Лаб” ХХК хамтран 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдрөөс 08 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл зохион байгуулав. “Google with grow” хөтөлбөрт нийт 1781 оролцогч бүртгүүлж, 350 оролцогчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулан, 3 сарын хугацаанд Google компанийн албан ёсны “Google Career Certificates” олгох цахим, танхим хосолсон хөтөлбөрт хамруулж, 200 цагийн цахим сургалт, 40 цагийн танхимын сургалт, 30 цагийн карьерын бэлтгэл хичээлүүдийг хамарсан 6 чиглэлийн мэргэжлийн ур чадварыг олгосон. |
| | 35.5 | **71704 Соёл, урлаг, спорт, аялал жуулчлалын бодлого, удирдлага** | | | | | | | | | | | | |
| | | 35.5.1 | Соёлын салбарын бодлого, удирдлага, үйл ажиллагааны хэрэгжилтийг сайжруулна. | 35.5.1.1 | Соёлын салбарын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт | хувь | 2023 | 90 | 100 | 86 | 57,474,755.30 | 49,050,625.20 | 85.3% | Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрын 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 86 хувьтай байна. Нийт Соёл, урлаг, спорт, аялал жуулчлалын бодлого, удирдлагын хөтөлбөр зориулалтаар 85.3 хувийн биелэлттэй байна. |
| | | 35.5.2 | Биеийн тамир, спортын салбарын бодлого, удирдлага, үйл ажиллагааны хэрэгжилтийг сайжруулна. | 35.5.2.1 | Биеийн тамир, спортын салбарын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт | хувь | 2023 | 85.9 | 90 | 91 | | | | Биеийн тамир, спортын улсын хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 91 хувьтай байна. |
| | 35.6 | **71706 Соёлын өв** | | | | | | | | | | | | |
| | | 35.6.1 | Соёлын дурсгалт газрыг дэлхийн өвд бүртгүүлж, үнэ цэнийг нэмэгдүүлнэ. | 35.6.1.1 | Дэлхийн өвийн жагсаалтад бүртгүүлсэн дурсгалт газар | тоо | 2023 | 2 | 2 | 1 | 36,661,426.60 | 34,448,236.12 | 94.0% | Соёлын дурсгалт газрыг дэлхийн өвд бүртгүүлж, үнэ цэнийг нэмэгдүүлэхээр 2025 онд "Хүннүгийн язгууртны оршуулгын цогцолбор дурсгалууд" өвийг нэр дэвшүүлсэн. |
| | | 35.6.2 | Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн тоог 10 хувиар нэмэгдүүлнэ. | 35.6.2.1 | Шинээр нэмж бүртгэгдсэн өвлөн уламжлагч | тоо | 2023 | 10 | 10 | 176 | | | | Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч 176 хүнийг Соёлын өвийн Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд бүртгэсэн. 140 хүн нас барсан. 182 хүн шилжилт хөдөлгөөн хийж, бүртгэлээс хасагдсан. |
| | | 35.6.3 | Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг сэргээн засварлаж, хадгалалт хамгаалалтыг сайжруулна. | 35.6.3.1 | Сэргээн засварласан дурсгалт зүйл | тоо | 2023 | 50 | 20 | 204 | | | | Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг сэргээн засварлаж, хадгалалт хамгаалалтыг сайжруулж, 2025 онд Соёлын өвийн үндэсний төв, төв болон орон нутгийн музейнүүп 204 ширхэг түүх соёлын хөдлөх дурсгалт зүйлийг сэргээн засварласан. |
| | 35.7 | **71707 Соёлын бүтээлч үйлдвэрлэл** | | | | | | | | | | | | |
| | | 35.7.1 | Соёлын салбарыг эдийн засгийн эргэлтэд оруулж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ. | 35.7.1.1 | Нийт хөдөлмөр эрхлэгчдэд соёлын салбарт ажиллагчдын эзлэх хувь | хувь | 2023 | 20 | 20 | 0.9 | 30,000.00 | 30,000.00 | 100% | Соёлын салбарыг эдийн засгийн эргэлтэд оруулж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, 2025 оны байдлаар салбарт 1,355,667 соёлын салбарын ажиллагчдын тоог эдийн засгийн эргэлтэд оруулж, Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэн салбарт ажиллах хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлсэн. |
| | **ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД** | | | | | | | | | | | | | |
| | | **71302 Мэдээллийн нэгдсэн тогтолцооны дэд бүтэц** | | | | | | | | | | | | |
| | | 36.1.1 | Зөв засаглалын үзүүлэлтээр эхний 100 орны нэг болно. | 36.1.1.1 | Цахим хэлбэрт шилжүүлсэн төрийн үйлчилгээ | тоо | 2021 | 606 | 1200 | 1268 | | | | Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-mongolia.mn)-ийн үйл ажиллагаанд нэмэлт хөгжүүлэлт хийж, 2025 онд “e-mongolia 5.0” хувилбарыг хэрэглээнд нэвтрүүлсэн бөгөөд e-Mongolia (иргэн), e-business.mn (хуулийн этгээд), lavlagaa.e-mongolia.mn (үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд), operator.e-mongolia.mn (ХУРДАН төрийн үйлчилгээ), kiosk.e-mongolia.mn (ХУРДАН төрийн үйлчилгээ), мобайл аппликейшн гэсэн 6 сувгаар 88 байгууллагын 1268 үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд 94,386,484 удаа амжилттай үзүүлсэн. |
| | | | | 36.1.1.2 | Албан бичиг солилцооны дундын системд байгууллагыг холбох | тоо | 2022 | 1500 | 1800 | 3058 | | | | Төрийн байгууллага хоорондоо төрийн болон албаны нууцад хамаарахаас бусад албан бичгийг илгээх, хүлээн авахдаа албан бичиг солилцооны дундын систем (Docx)-ийг ашиглаж байна. Тус дундын системд 17 систем холбогдож, 3,054 байгууллага холболт хийгдсэн байна. |
| | | | | 36.1.1.3 | Тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх | тоо, мянгаар | 2022 | 1029 | 1131 | 1738 | | | | Улсын хэмжээнд 1738 мянган иргэн тоон гарын үсгийн гэрчилгээг авч, төрийн үйлчилгээ авахад ашиглаж байна. Мөн тус яамнаас тоон гарын үсгийн гэрчилгээ олгох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 5 байгууллагад олгосон бөгөөд 191 мянган тоон гарын үсгийн гэрчилгээг хүн, хуулийн этгээдэд олгосон байна. |
| | | | | 36.1.1.4 | Төрийн мэдээлэл солилцооны "ХУР" системд төрийн байгууллагыг холбох | тоо | 2022 | 107 | 140 | 190 | | | | Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам-ын дагуу 2025 оны жилийн эцсийн байдлаар “ХУР” системд төрийн 190 байгууллага холбогдсон. |
| | | | | 36.1.1.5 | Төрийн мэдээлэл солилцооны "ХУР" системд хувийн хэвшлийн байгууллагыг холбох | тоо | 2022 | 269 | 350 | 534 | | | | Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам-ын дагуу 2025 оны жилийн эцсийн байдлаар “ХУР” системд хувийн хэвшлийн 534 байгууллага холбогдсон. |
| | | | | 36.1.1.6 | Төрийн үйлчилгээнд дахин загварчлал хийсэн байгууллага | тоо | 2022 | Т | 1 | 1 | | | | Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, хувийн хэвшилтэй хамтран Стандарт, хэмжил зүйн газрын үйл ажиллагаанд процессын дахин инженерчлэл хийж тайланг хүлээлгэн өгсөн. Стандарт, хэмжил зүйн газрын үндсэн үйл ажиллагаанд процессын дахин инженерчлэл хийсэн тайланг олон нийтэд танилцуулах, харилцагч байгууллагуудтай илүү өргөн хүрээнд хамтрах, цахим үйлчилгээг нэвтрүүлэх, өргөжүүлэх ажлуудыг шат дараатай хэрэгжүүлж байна. |
| 36 | 36.1 | | | 36.1.2.1 | Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийн ажлын албаны үйл ажиллагааны платформ хөгжүүлэх | тоо | 2022 | Т | 1 | 1 | | | | Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн 98 дугаар тогтоолоор “Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийн ажиллах журам”, "Виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдэд татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх журам"-ыг батлуулан Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийг байгуулсан. Үүний дагуу төрийн үйлчилгээний нэгдсэн систем e-business.mn-д виртуал бүсийн бүртгэлийн модулийг хөгжүүлэн 2026 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн бүртгэж байна. |

| № | Төсвийн ерөнхийлөн захирагч | Хөтөлбөр | Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлтийн дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | 2025 оны зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Батлагдсан төсөв | Төсвийн гүйцэтгэл | Төсвийн гүйцэтгэлийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 36.1 | 36.1.2 | Бизнес эрхлэхэд таатай 93 орны нэг болно. | 36.1.2.2 | Мэдээллийн технологийн үйлдвэрлэлээс төсөвт төвлөрүүлсэн орлогын талаарх болон салбарын зах зээл, хөрөнгө оруулалтын талаарх үүсгэсэн статистик мэдээллийн өгөгдлийн сан | тоо | 2022 | Т | 1 | 0 | 81,974,230.90 | 63,372,880.50 | 77.30% | Мэдээллийн технологийн салбарын үйлдвэрлэгчдийн бүртгэлийн нэгдсэн платформ хөгжүүлэн мэдээээллийн сан үүсгэж, статистик мэдээллийн дашбоард хөгжүүлэх зорилгоор “Мэдээллийн технологийн салбарын үйлдвэрлэгчдийн бүртгэлийн нэгдсэн платформ хөгжүүлэх” худалдан авах ажиллагааг 2025 онд төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр 2 удаа зарласан боловч шаардлагад нийцсэн тендер ирээгүй. Виртуал бүсийн үйл ажиллагааг цахимжуулах, мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийн үйл ажиллагааны платформ хөгжүүлэх ажлыг ЦХИХХЯ-ны 2026 оны төлөвлөгөөнд туссан. |
| | | | | 36.1.2.3 | Мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хүн, хуулийн этгээдээс худалдан авах нэг цонхны бүртгэлийн системийн хэвийн үйл ажиллагааг ханган ажиллах-Mindgolia.mn | тоо | 2022 | Т | 1 | 0 | | | | Үндэсний программ хангамжийн их дэлгүүр “Mindgolia” системийн техникийн нөхцөл шаардлага, заавар, аргачлалыг боловсруулах суурь судалгааг хийж гүйцэтгэсэн. Системийн хэвийн найдвартай ажиллагааг хангах зорилгоор системийн хөгжүүлэгч “Монголын программ хангамж үйлдвэрлэгчдийн холбоо” ТББ-тай Хамтран ажиллах, харилцан ойлголцолын санамж бичиг, 2024 оны 1 дүгээр сард Хамтран ажиллах гэрээг тус тус байгуулсан. |
| | | 36.1.3 | Инновацын тогтолцооны хөгжлөөр эхний 85 орны нэг болно. | 36.1.3.1 | Өндөр технологи, инновац бизнес хөгжлийн төв байгуулах | тоо | 2024 | - | 1 | 1 | | | | Монгол улс нь Стартап-Блинкийн гаргасан судалгааны Гарааны бизнесийн экосистемийн индексээр 2024 онд 81 дүгээр байранд байсан бол 2025 онд 80 дугаар байрт эрэмбэлэгдсэн бөгөөд бүс, орон нутагт инновацын дэд бүтцийг хөгжүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлж байна. Тухайлбал: "Мэдээллийн технологийн төрөлжсөн хаб/хамтын оффис байгуулах ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлын худалдан авах ажиллагааг зарлан гүйцэтгүүлж, бүс орон нутгийг үнэлэх судалгааны ажил бүхий эхлэлийн тайланг үндэслэн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн А/80 дугаар тушаалаар төрөлжсөн ХАБ-уудыг байгуулах бүсийн байршлыг тогтоосон. Мөн Хэнтий, Орхон, Архангай, Дархан-Уул, Ховд, Өмнөговь аймгуудын Засаг дарга нартай хамтран ажиллаж, хаб байгуулах нөхцөл шаардлага, эскиз зургийг батлуулан дундын тайланг хүлээн авсан. Мэдээллийн технологийн төрөлжсөн хаб/хамтын оффис байгуулах ТЭЗҮ боловсруулах, зураг төсөл батлуулах ажил хийгдэж байна. |
| | | 36.1.4 | Үүрэн холбооны хөдөлгөөнт өргөн зурвасын хэрэглэгчийн тоог нэмэгдүүлнэ. | 36.1.4.1 | Алслагдсан бүс нутагт хөдөлгөөнт холбооны үйлчилгээ хүргэх | тоо | 2022 | 15 | 29 | 40 | | | | Увс аймгийн Бөхмөрөн, Өмнөговь, Баруунтуруун, Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган, Галт, Түнэл, Жаргалант, Баянзүрх, Баян-Өлгий аймгийн Буянт, Дэлүүн сумдын алслагдсан 9 багт хөдөлгөөнт холбооны үйлчилгээ хүргэсэн. Мөн Архангай аймгийн Хайрхан, Цэцэрлэг сум, Баянхонгор аймгийн Өлзийт сум, Булган аймгийн Сайхан, Тэшиг сум, Говь-Алтай аймгийн Цогт сум, Дундговь аймгийн Дэлгэрхангай, Гурвансайхан сум, Завхан аймгийн Тосонцэнгэл, Идэр, Асгат сум, Өвөрхангай аймгийн Баянгол сум, Төв аймгийн Баянцогт, Дэлгэрхаан, Бүрэн сумдын алслагдсан 16 багуудад үүрэн холбооны сүлжээ нэвтрүүлсэн. Нийт 25 багт сүлжээ үйлчилгээ нэвтэрсэн. |